

ХРИСТЭЧ ИТГЭЛ ҮНЭМШИЛ



Shepherds Global Classroom нь дэлхий даяар өсөн нэмэгдэж буй Христэч удирдагчдад зориулсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Христийн Биенийг сургаж бэлтгэх зорилготой үйлчлэл юм. Бид дэлхийн улс орон бүрийн сүнслэг сургагч багш нарын гар дээр 20 курс хөтөлбөрийг хүргэх замаар тухайн орон нутаг, уугуул иргэдийн сургалтын хөтөлбөрийг олшруулж нэмэгдүүлэхийг зорьж байна.

Энэхүү хичээлийг дараах холбоосоор үнэгүй татаж авах боломжтой: <https://www.shepherdsglobal.org/courses>

Курс хичээлийг боловсруулсан: Др. Стефен К. Гибсон

Тус хичээлийн зарим материалыг АНУ-ын Охайо муж дахь Бурханы Библийн Сургууль ба Коллежийн багш нарын бичсэн “Би итгэдэг” номоос авсан болно.

Зохиогчийн эрх © 2023 Shepherds Global Classroom

Англи хэл дээрх 3 дахь хувилбараас монгол хэлнээ орчуулсан Л. Амартүвшин, А. Ариунаа

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Гуравдагч талын материалууд нь тус тусын зохиогчийн эрх болон зөвшөөрөлтэй.

Бүх эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи 2013 хувилбараас ашиглав.

Зөвшөөрөлтэй холбоотой заавар:

Дараах зааврын дагуу энэхүү курс хичээлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр хэвлэж, тараах боломжтой. Үүнд: (1) Хичээлийн агуулгыг ямар ч байдлаар өөрчилж болохгүй; (2) Олшруулж хэвлэхдээ ашгийн төлөө зарж болохгүй; (3) Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр авч болох ч энэхүү хичээлийг үнэгүй ашиглах/олшруулж хэвлэх боломжтой; (4) Shepherds Global Classroom байгууллагын зөвшөөрөл, удирдамжгүйгээр хичээлийг орчуулж болохгүй.

Гарчиг

Курсын тойм	5
(1) Бурханы ном.....	9
(2) Бурханы шинж чанарууд.....	23
(3) Гурвал.....	31
(4) Хүн төрөлхтөн.....	39
(5) Нүгэл	47
(6) Сүнснүүд	55
(7) Христ	63
(8) Аврал.....	75
(9) Авралын асуудлууд	85
(10) Ариун Сүнс	97
(11) Христитгэлийн ариун байдал	107
(12) Чуулган.....	119
(13) Мөнхийн хувь тавилан	127
(14) Эцсийн үйл явдал.....	133
(15) Эртний тунхгууд.....	141
Санал болгож буй эх сурвалжууд	149
Даалгаврын тэмдэглэл.....	153

Курсын тойм

Курсын агуулга

Энэхүү курс нь Христитгэлийн теологийн гол ухагдахуун болох Бурхан, Христ, нүгэл, аврал болон бусад үндсэн онол сургаалын тухай ойлголтыг өгнө. Суралцагч нь онол сургаалын алдаанаас хэрхэн зайлсхийх талаар суралцаж, Христитгэлийн онол сургаалыг бусдад заахад бэлтгэгдэнэ.

Курсын зорилго

- (1) Христитгэлийн үндсэн онол сургаалд суралцах.
- (2) Библийг онол сургаалын эх сурвалж, эрх мэдэл болгон зөв зохистой ашиглах.
- (3) Онол сургаалтэй холбоотой томоохон алдааг таних.
- (4) Бурхантай харилцах харилцаагаа гүнзгийрүүлэхэд тустай ойлголтыг олж авах.
- (5) Бусдад заах агуулга, арга барилтай болох.

Ангийн удирдагчид зориулсан заавар

Эдгээр заавар нь ангийг хэрхэн дээд зэргийн чанартай явуулахыг тайлбарладаг. Ангийн удирдагч нь Shepherds Global Classroom эсвэл түүний харьяа газраас гэрчилгээ авсан суралцагчдын төлөө энэхүү жишгийг баримтлах ёстой. Эдгээр шаардлагыг хангаж чадахгүй байгаа бусад ангийн хувьд багшийн зүгээс шаардлагад тохируулан өөр гэрчилгээ олгох боломжтой.

Бидний тооцоолсноор хичээлд 90 минут ба түүнээс дээш хугацаа шаардагдана. Хичээл бүрээр нэг анги хоёр удаа уулзах нь илүү өгөөжтэй. Хэрэв анги ийнхүү хоёр удаа уулзвал зарим зааврыг тохиролцож болно. Жишээлбэл, хоёр удаа сорил өгөхгүй гэх мэт.

Суралцагч бүрд энэ номын хуулбар хэрэгтэй.

Ангийн удирдагчид зориулсан тэмдэглэлийг хичээлийн тодорхой хэсгүүдэд зааврын хамт оруулсан. *Тэдгээр нь налуу хэлбэрээр бичигдсэн.*

Хичээлийн эхэнд өмнөх хичээлийн **сорилыг** өгнө. Суралцагч бүр өөр тусламжгүйгээр өөрийн санаж байгаагаар хариулж бичнэ. Хэрэв суралцагч сорилд хариулж чадахгүй байвал та түүнд дахин оролдох боломж өгч болно (хугацаа: 10 минут). Сорилын хариултыг ShepherdsGlobal.org цахим хуудаснаас татаж авах боломжтой.

Сорилын дараа өмнөх хичээлийн зорилгуудаа давтах асуулт болгон ашиглаарай. Зорилго тус бүр дээр асуулт асууж, суралцагчдад тайлбарлах боломж олгоно (хугацаа: 15 минут).

Суралцагчдын нэгээр өгөгдсөн багц эшлэлийг уншуулж, шинэ хичээлээ эхлээрэй. Хичээлийн сэдэвтэй холбоотой багц эшлэл юу гэж хэлснийг суралцагчидтай ярилцана (хугацаа: 10 минут).

Хэсэг бүрийг уншиж, тайлбарлах замаар хичээлийн материалтай танилцана уу. Ангийн гишүүд зарим хэсгийг заах боломжтой (хугацаа: 45 минут).

Хичээлд **Бичвэрийг** маш өргөн ашигладаг. Хаалтанд *унших* гэж тэмдэглэсэн Бичвэрийн эшлэлүүдийг ангид чангаар унших хэрэгтэй. Бусад эшлэлүүд нь текстэд өгүүлж буй санааг дэмжих бөгөөд эдгээрийг хичээлийн явцад заавал унших шаардлагагүй.

Хэлэлцүүлгийн асуултууд болон **ангид явагдах үйл ажиллагааг** ► тэмдгээр тэмдэглэсэн. Хэлэлцүүлгийн асуултууд нь заримдаа тухайн хэсгийг танилцуулдаг бол зарим тохиолдолд саяхан үзсэн хэсгийг бататгаж өгдөг. Ангийн удирдагч асуулт асууж, суралцагчдад хариулан ярилцах цагийг гаргаж өгнө. Тухайн үед хариултыг бүрэн тайлбарлах шаардлагагүй, ялангуяа асуулт нь тухайн хэсгийг танилцуулж байгаа бол.

Анги хичээл бүрийн төгсгөлд **“Итгэлээ шалгах”** хэсгийг хамтдаа хоёр удаа унших ёстой.

Хичээл бүрийн төгсгөлд Бичвэрийн эшлэлийн жагсаалтаас суралцагч бүрд эшлэл хуваарилж өгнө. Дараагийн хичээлээс өмнө тэд тухайн хэсгийг уншиж, тэнд юу гэж хэлэгдсэнийг багцалж бичих хэрэгтэй. Дараагийн хичээл дээр суралцагчид бичсэн хэсгээ ангийн удирдагчид үзүүлнэ.

Энэхүү курсын туршид суралцагч хамгийн багадаа гурван удаа сурсан хичээлээ эсвэл хичээлийн хэсгээс ангид хамрагдаагүй бусад хүмүүст зааж өгөх хэрэгтэй. Үүнийг чуулганыхаа анги, Библи судлалын гэрийн бүлэг эсвэл өөр орчинд хийх боломжтой. Хичээл бүрийн төгсгөлд энэ даалгаврын талаар суралцагчдад сануулж, сүүлийн хичээлээс хойш ямар хичээлийг заасан талаар тайлагнах боломж олгоорой.

Хичээлийн төгсгөлд дараагийн хичээл эхлэхээс өмнө унших материалыг суралцагчдад сануулна (зарлал болон даалгаварт зарцуулах хугацаа: 10 минут).

Хэрэв суралцагч **Shepherds Global Classroom** эсвэл **түүний харьяа газраас гэрчилгээ авахыг** хүсвэл, ангийн хичээлд хамрагдаж, даалгавруудаа бүрэн хийсэн байх шаардлагатай. Суралцагч хичээлээ тасалсан тохиолдолд тухайн хичээлийг нөхөж үзэн, сорил өгч, бичгийн даалгавраа хийх ёстой. Курсын төгсгөлд даалгавруудыг бүрэн хийснийг бүртгэх маягт олгоно.

Суралцагчдад зориулсан заавар

Та анги цуглахаас өмнө тухайн хичээлийн материалыг унших хэрэгтэй бөгөөд ингэснээр хэлэлцүүлэгт илүү сайн ойлголттой оролцох боломжтой болно.

Хичээл бүрийн эхэнд өмнөх хичээлтэй холбоотой сорил өгөхөд бэлэн байгаарай. Өгөгдсөн сорилын асуултуудыг судалж үзсэн байна.

Библи, тухайн хичээлийг хэвлэсэн хуулбар, тэмдэглэл хийхийн тулд бал үзэг зэргийг үргэлж авчирна.

Бичвэрийн эшлэлүүдийг хайж олох, хэлэлцүүлгийн асуултуудад хариулах, ангийн удирдагчийн зааврын дагуу оролцох зэрэгт бэлэн байгаарай.

Хичээл бүрийн төгсгөлд танд Бичвэрийн эшлэл оногдох болно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө уг хэсгийг уншиж, хичээлийн сэдэвтэй холбоотой тухайн хэсэгт юу өгүүлсэн талаар багцалж бичнэ. Ангийн удирдагчид бичсэн хэсгээ үзүүлээрэй.

Энэ курсын туршид та хамгийн багадаа гурван удаа ангиас гадуур хүмүүст нэг хичээлийг эсвэл хичээлийн хэсгээс зааж өгөх ёстой. Үүнийг чуулганыхаа анги, Библи судлалын гэрийн бүлэг эсвэл өөр орчинд хийх боломжтой. Хэн нэгэнд хичээлийг заах бүрдээ ангийн удирдагчид тайлагнана.

1-р хичээл

Бурханы ном

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Ерөнхий илчлэл ба Онцгой илчлэл.
- Библи бол Бурханы Үг гэдгийн баримт нотолгоо.
- Бичвэр дэх Бурханы амьсгал (онгод).
- Бичвэрийн онгод нь яагаад алдаа мадаггүй болох талаар.
- *Онгод оруулагдсан, алдаа мадаггүй, үг бүрчлэн хэмээх нэр томъёо.*
- Яагаад Библи бүрэн дуусгавар болсон, үүнийг нэмж өргөжүүлэх боломжгүй талаар.
- Библи хэрхэн онол сургаалын үндсэн эх сурвалж, эцсийн эрх мэдэл болох талаар.
- Библи нь Христэд итгэгч хүний өдөр тутмын амьдралд хэр чухал вэ?
- Библийн талаарх христэд итгэл үнэмшил

(2) Суралцагч нь буруу эрх мэдлийг сонсохоос эсвэл явцуу зорилгоор Библийг судлахаас зайлсхийж сурна.

Танилцуулга

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Хичээл нь ихэвчлэн өмнөх хичээлийн сорил болон өмнөх хичээлийн зорилгыг давтах байдлаар эхэлнэ. Энэ нь анхны хичээл учраас дараах Бичвэрийг уншина уу.

► Дуулал 119:1-16-г хамтдаа унших. Энэ багц эшлэлд Библийн талаар юу гэж хэлсэн бэ?

Дэлхий ертөнцийг бүтээгч Бурхан ийнхүү хэлж байна. Тэрээр Өөрийгөө болон бүтээлийнхээ зорилгыг илчилсэн. Бурханы бидэнд илчилсэн үнэнийг илчлэл гэж нэрлэдэг. Библид “Илчлэл” хэмээх ном байдаг ч Бурханы илчилсэн бүх үнэнийг илэрхийлэхдээ илчлэл гэдэг үгийг мөн ашигладаг.

► Бурхан ямар арга замуудаар бидэнд үнэнийг илчилсэн бэ?

Олон төрлийн илчлэл

Бурхан үнэнийг өөр өөр аргаар илчилсэн учраас бид Ерөнхий илчлэл ба Онцгой илчлэл гэсэн хоёр ангиллын талаар ярьдаг.

Ерөнхий илчлэл

Бурхан бүтээлээрээ дамжуулан Өөрийнхөө тухай бидэнд харуулсныг Ерөнхий илчлэл гэдэг. Орчлон ертөнцийн зүй тогтлоос бид Бурханы гайхалтай оюун ухаан, хүчийг олж хардаг.

Бурханы хамгийн дээд бүтээл бол хүн төрөлхтөн юм. Хүмүүс хэрхэн бүтээгдсэнийг харахдаа бид Бурханы талаар зарим зүйлийг мэдэж авдаг. Бид сэтгэн бодож, гоо сайхныг үнэлж, зөв бурууг ялгаж чаддаг нь (төгс биш ч гэсэн) Бүтээгч маань эдгээр чадваруудыг илүү өндөр түвшинд эзэмшсэн байх ёстойг харуулдаг. Бидэнд ийм чадварууд байгаа учраас Бурхан сэтгэж, харилцах чадвартай нэгэн байх ёстой гэдгийг бид мэддэг.

Бурхан ярих боломжтой гэдгийг Ерөнхий илчлэл харуулдаг тул Онцгой илчлэл ч байх боломжтойг бид ойлгож чадна. Бурхан ярьж чаддаг учраас Түүнээс ирсэн үг мэдээ, цаашлаад Бурханы ном хүртэл байх боломжтой юм.

Ерөнхий илчлэлээр дамжуулан хүмүүс Бурхан байгааг, Түүнд дуулгавартай байх ёстойг, мөн тэд аль хэдийн дуулгаваргүй болсон гэдгээ ч мэддэг (Ром 1:20-21, унших). Гэвч Ерөнхий илчлэл бидэнд Бурхантай хэрхэн зөв харилцаатай болохыг зааж хэлээгүй. Ерөнхий илчлэл нь хүмүүс Бүтээгчийнхээ өмнө аймшиггүйгээр нүгэл үйлдсэн учраас Онцгой илчлэл хэрэгтэй болсныг харуулдаг ч, үүний шийдлийг бидэнд хэлдэггүй.

Онцгой илчлэл

Бурхан бидэнд онгод оруулагдсан бичвэрүүд болон Түүний хүү Есүсээр дамжуулан Онцгой илчлэл өгсөн.

Онцгой илчлэл нь бидний унасан болон гэм буруутай болохыг харуулдаг Ерөнхий илчлэлийн нөхцөл байдлыг тайлбарладаг. Онцгой илчлэл нь Бурханыг тодорхойлж, уналт болон нүглийг тайлбарлан, Бурхантай эвлэрэх арга замыг харуулдаг.

Та Библи байдаг гэдгийг мэдэхгүй амьдарч байна гээд төсөөлөөд үз дээ. Бурхан байдаг гэж та ойлгодог. Бурханы өмнө асуудалтай байгаагаа ч мэддэг. Амьдралын зорилгоо, үхлийн дараа юу тохиолдохыг та мэдэхгүй. Та Бурханд хэрхэн хандахаа мэдэхгүй байна гэж бодъё.

Гэтэл хэн нэгэн танд нэгэн номыг үзүүлж, энэ бүх асуултад хариулахын тулд Бурханаас ирсэн ном гэж хэлж байна гээд төсөөлж үзье. Тэгвэл энэ ном таны хувьд ямар үнэ цэнтэй байх бол?

“Хуулийг номлодоггүй
хүн сайнмэдээг
тунхаглаж чадна гэдэгт
би итгэдэггүй. Хуулийг
дорд үзэх тусам гэм
буруугаа ухаарах хүний
гэрэл бүдгэрсээр
байдаг.”
– Чарльз Спержион

Библийн үндэслэл

► Библи өөрийнхөө талаар юу гэж хэлсэн бэ? Библи нь Бурханаас ирсэн гэж тэмдэглэсэн зарим жишээг хэлнэ үү.

Библи өөрийнхөө талаар юу хэлснийг ярилцъя. Дараа нь бид Библи үнэн гэдгийг нотлох баримтуудыг авч үзэх болно. Библи бол Бурханы Үг гэж хэлэгдсэн. Хуучин гэрээнд Бурханаас үг мэдээ ирсэн талаар 3000 гаруй удаа тэмдэглэсэн бөгөөд үүнийг ихэвчлэн "ЭЗЭН... хэлсэн"¹ хэмээн энгийнээр илэрхийлжээ. Есүс Хуучин гэрээг Бурханы амьсгалаар бичигдсэн хэмээн үзсэн байдаг (Матай 5:17-18; Иохан 10:35; Марк 12:36, унших). Шинэ гэрээг бичигчид Хуучин гэрээг Бурханаас ирсэн гэж итгэдэг (Үйлс 3:18; 2 Тимот 3:16; 2 Петр 1:20-21, унших). Түүнчлэн Шинэ гэрээний бичигчид Шинэ гэрээний бичвэрүүдийг Бурханы амьсгалаар бичигдсэн гэж тэмдэглэжээ (1 Коринт 14:37; 2 Петр 3:16, унших).

Хэрэв хүн Библи өөрийгөө нотлон хэлж байгааг хүлээн зөвшөөрөхгүй бол бусад нотлох баримтыг харах хэрэгтэй. Та Библийн талаар мэдэхгүй байсан гэж дахин төсөөлж үзье. Бурхан бодгаль болохын хувьд ярьж чадна гэдгийг та мэднэ. Тэгэхээр Бурханаас ирсэн ном байх боломжтойг ч та мэдэж болно. Тэгээд хэн нэгэн танд нэгэн номыг үзүүлээд энэ Бурханаас ирсэн ном гэж хэлж байна.

► Библи нь үнэхээр Бурханы Үг гэдгийг та яаж мэдэх вэ? Энэ нь ямар байгаасай гэж та бодох бол?

Дэлхийн хаана ч байсан, сайнмэдээ номлогдох үед хүмүүс Библийн үнэнийг дотоод итгэл үнэмшлээрээ мэдэрдэг. Тэд сайнмэдээнд итгэж, гэмших үедээ Бурханы өршөөл болон өөрчлөгдсөн амьдралыг амсаж мэддэг. Ихэнх хүмүүсийн хувьд энэ нь Библид итгэх тэдний анхны шалтгаан байдаг (1 Тесалоник 1:5, унших).

"Хууль нь өвчнийг илрүүлдэг бол, сайнмэдээ нь эмчилгээг өгдөг."
—Мартин Лютер

Улмаар Бурхантай харилцаатай болсон хүмүүсийн хувьд Бурханы Сүнс бичвэрээр дамжуулан ярьж, ойлголт, итгэл үнэмшлийг өгдөг. Ариун Сүнс Библийг ашиглаж байгаа арга зам нь энэ бол Бурханы Үг гэдгийг баталж байгаа юм (Ефес 6:17, унших).

Бид Бурхантай харилцах харилцаан дотор алхахдаа Библи Түүний мөн чанарыг болон Тэр бидэнтэй ажилладаг арга замыг зөвөөр илчилдэг болохыг олж хардаг. Библи бидэнд Бурхантай харилцах харилцааг эхлүүлэх болон Түүнтэй үргэлжлүүлэн харилцах арга замыг зааж өгдөг. Энэ нь Библи бол Бурханы Үг гэдгийн нотолгоо юм (Дуулал 119:1-2, унших).

Гэхдээ та өөрийн сүнслэг туршлага дээр үндэслээгүй нотлох баримтыг хүсэж байвал яах вэ? Бусад шашны хүмүүст мөн сүнслэг туршлага байгаа хэдий ч тэдний энэхүү

¹ Жишээлбэл, Тооллого 34:1; Тооллого 35:1; 9, үз.

туршлага нь үнэнд тулгуурладаггүй. Тэгвэл бидний туршлага үнэн дээр үндэслэсэн гэдгийг бид яаж мэдэх вэ?

► Библид бичсэн зүйлс нь үнэн зөв гэдгийг батлах нотолгоо бий юу?

Библийг 1500 жилийн хугацаанд 40 гаруй бичигчид бичсэн бөгөөд тэдгээр хүмүүсийн ихэнх нь бие биеэ танихгүй хүмүүс байв. Ийм номоос бид ихэвчлэн юу хүлээх вэ? Энэ нь бүх төрлийн алдаа, зөрчилтэй ном байх нь гарцаагүй гэж таамаглах болов уу. Гэвч Библийн талаарх дараах баримтууд өөр зүйлийг өгүүлдэг. Библид дурдагдсан мянга мянган газарзүйн байрлал, газруудыг нээж олсон; Библид тэмдэглэгдсэн олон мянган түүхэн үйл явдал, хувь хүмүүс бодит түүхэн байсан нь батлагдсан; Библийн мэдэгдлийг үгүйсгэсэн ямар ч нээлт хэзээ ч болж байсангүй; Түүнчлэн Библи өөртэйгөө хэзээ ч зөрчилддөггүй. Ийм бичвэрийг агуулсан ном урьд өмнө хэзээ ч байгаагүй юм. Тэгэхээр баримт нотолгоо нь Библи Бурханы амьсгалаар бичигдсэн гэдгийг баталж байна.

Библи нь Бурханы Үг гэдгийг батлах нотолгоог бид дараах зургаан санаагаар дүгнэх боломжтой. Библи бол үнэхээр Бурханы Үг гэдгийг бид мэддэг. Учир нь:

- Библийн мянга мянган баримтууд батлагдсан.
- Библийн ямар ч мэдэгдэл үгүйсгэгдэж байгаагүй.
- Библи өөртэйгөө зөрчилддөггүй.
- Сайнмэдээ нь түүний нөлөөгөөр нотлогддог.
- Бурханы Сүнс Библиэр дамжуулан ярьдаг.
- Бурхантай харилцах бидний харилцааг Библи чиглүүлдэг.

Библи дэх Бурханы амьсгал (онгод) гэдгийг тодруулах нь

► Библи Бурханы амьсгалаар бичигдсэн гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Бурханы амьсгал гэдгээр Бурхан Өөрийгөө илчилснийг, тэрхүү илчлэлийг бичгийн хэлбэрт оруулсан ер бусын ажлыг хэлж байна. Библи нь онгод оруулагдсан эцсийн бүтээгдэхүүн юм. Библи нь бусад номтой адил онгодоор бичигдээгүй. **Библи дэх Бурханы амьсгал нь Библийн үг бүр нь, бүхэлдээ Бурханы Үг гэсэн утгатай.**

Заримдаа хүмүүс, тэдэнд гайхалтай санаа төрөх үед онгодоор хөглөгдсөн мэт мэдэрдэг. Гэхдээ Библи нь Бурханы амьсгалаар бичигдсэн гэдэг нь үүнээс илүү утга учиртай.

Бичвэр бүр Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай (2 Тимот 3:16).

Хэдийгээр бичвэр нь хүний гар дахь бэхээр урсаж байсан ч Библи нь Бурханаас ирсэн болохыг энэ эшлэлд онцолжээ. Библи нь Бурханаас ирсэн учраас онол сургаалын хувьд найдвартай. Энэ нь хүний хийж чадах хамгийн сайн зүйлээс ч илүү дээр юм.

Бичвэрийн нэг ч эш үзүүлэгч эш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүйг юуны түрүүнд мэдэгтүн. Учир нь нэг ч эш үзүүлэгч хэзээ ч хүний хүслээр

гарсангүй, харин Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс Бурханаас айлджээ (2 Петр 1:20-21).

2 Петр захидлын эдгээр эшлэлд бичигчдийг Ариун Сүнс дагуулсан талаар хэлж байна. Библийг бичигчдийн алдаагүй зөв байдал нь тэдний мэдлэгээс хамаардаггүй. Тэднийг Ариун Сүнс хөдөлгөж, дагуулсан нь бичвэрийн найдвартай байдал эцсийн дүндээ Бурханаас хамаарч байсныг харуулдаг. Библи нь Бурхан адил найдвартай.

Бурханы амьсгал нь юутай адил байсан бэ?

► Бурханы үгийг бичихээсээ өмнө Библийг бичигчид ямар арга замаар Түүний үнэнийг хүлээн авсан бэ?

Заримдаа хүмүүс энэхүү онгод хэрхэн ажиллаж буйд гайхдаг. Бурхан Өөрийн үнэнийг хэрхэн таниулж, тэдгээр нь үнэн зөв тэмдэглэгдсэн эсэхийг баталгаажуулсан бэ? Бурханы илчлэлийн хэв маягийн талаар бидний анхаарах ёстой хамгийн эхний баримт бол энэ нь олон янз байдаг юм. Тэр тодорхой арга барилаар хязгаарлагддаггүй (Еврей 1:1, унших).

Заримдаа Бурхан Мосетэй ярьж байсны адил сонсогдохуйц дуу хоолойгоор ярьдаг байсан (Гэтлэл 33:11). Бусад үед Тэрээр зүүд эсвэл үзэгдэл өгсөн бөгөөд бичигчид тэдгээрийг дүрсэлсэн байдаг.² Бурханаас шууд ирсэн Бичвэрийн хэсэг нь Бурханы мутраар бичигдсэн Израилтай хийсэн гэрээ байх боломжтой (Дэд хууль 9:10). Гэтлэл, Леви, Тооллого номын гол хэсгүүдэд “Тэгээд ЭЗЭН, Мосетэй ярин...” гэснээс үзвэл Бичвэрийн зарим хэсгүүдийг хэлж бичүүлжээ.

Бичвэрийн онгод нь Бурхан тэдгээр үгсийг бичигчид сонсогдохуйц байдлаар хэлсэн гэсэн үг биш юм. Бид янз бүрийн бичигчдийн бодгаль чанар, бичлэгийн хэв маягийн ялгааг олж хардаг. Жишээлбэл, Паулын бичлэгийн хэв маяг Петрийнхээс эрс ялгагддаг. Бид Бичвэрийн онгод гэдэг ойлголтод Бурхан хүмүүн бичээчдийн бодгаль чанар, үгсийн сан, бичлэгийн хэв маяг, боловсрол, түүхийн судалгаа зэргийг хэрхэн ашигладаг болохыг хамааруулж үздэг.

Бичвэрийн онгодын талаарх зөв үзэл баримтлал нь Бурхан хүмүүн бичээчийн төсөөлөл, бодгаль чанарыг ашиглан тэнгэрлэг үнэнийг илэрхийлэхдээ зөвхөн үнэнийг илчлээд зогсохгүй энэхүү бүх үйл явц алдаагүй зөв явагдахад хүмүүн бичээчийг хөтөлж, түүнийг бүхэлд нь онгодоор хөглөсөн явдал юм.

Зарим хүмүүс Бурхан зүгээр л хэлэхийг хүссэн санаагаа өгч, хүмүүн бичээч тэдгээрийг чадахаараа тайлбарласан бөгөөд энэ явцад хүн нарийн ширийн зүйлс дээр алдаа гаргах нь гарцаагүй гэж үздэг. Энэ үзэл нь Бурханы амьсгалын талаар Библид бичигдсэнтэй тохирдоггүй. Бичигч нарыг Библид Ариун Сүнсээр хөтлөгдсөн гэж тэмдэглэсэн тул тэд алдаа гаргаагүй, өөрсдийн дураар бичээгүй гэдгийг бид мэддэг.

² Үзэгдлээр ирсэн илчлэлийн жишээг Даниел бүл. 7; 8 болон Илчлэл номын ихэнх хэсгээс үзнэ үү.

Библи нь Бурханы Үг учраас энэ нь буруу зүйлийг хэлдэггүй. Учир нь Бурхан алдаа гаргадаггүй (Сургаалт үгс 30:5, унших). Бурхан Библид тэмдэглэгдсэн түүхэнд Өөрийгөө илчилсэн тул үүний нарийн ширийн зүйлс хүртэл алдаагүй, үнэн зөв байх ёстой. Ингэснээр Бурханы илчлэлд бид найдаж чадна. Иймд, Бичвэрийн онгодын талаарх Библийн тодорхойлолтоос Бурхан үүнийг бичих үйл явцыг бүхэлд нь үнэн зөв байхаар удирдан чиглүүлсэн болохыг бид мэддэг.

Библи бүхэлдээ үнэн зөв гэдгийг нотлоход ашигладаг хэллэгүүд

Онгод оруулагдсан (Бурханы амьсгал)

Библи нь Бурханы амьсгалаар бичигдсэн, бүхэлдээ Бурханы Үг бөгөөд үүнийг бичихэд ашиглагдсан үгс нь хүртэл тийм юм. Энэхүү хэллэг нь Библийг бүрэн найдвартай, үнэн зөв гэдгийг батлахад анх хангалттай байсан бол одоо Бичвэрийн онгодод итгэдэг гэж хэлдэг хүмүүсийн дунд үүнийг бүхэлдээ үнэн зөв биш хэмээн үгүйсгэж байна. Дараах үг хэллэгүүд нь Бичвэрийн онгодын чухал талуудыг хамгаалахад ашиглагддаг.

Алдаа мадаггүй

Энэ хэллэг нь “бүтэлгүйтэх боломжгүй” гэсэн утгатай. Библи алдаа мадаггүй гэж хэлэхдээ бид үүнд итгэж болно, хэзээ ч биднийг төөрөгдүүлэхгүй гэсэн утгыг агуулдаг. Библи нь зөвхөн онол сургаалын үгсээрээ төдийгүй үүнд хэлэгдсэн үг бүрээрээ алдаа мадаггүй юм.

Үг бүрчлэн

Энэ хэллэг нь “алдаагүй” гэсэн утгатай. Библид хэлэгдсэн үг бүр нь үнэн зөв байдаг. Бурхан хэзээ ч худал хэлдэггүй, алдаа гаргадаггүй тул (Тит 1:2, унших), мөн Библи нь Бурханы Үг учраас энэ нь алдаагүй гэдэгт бид итгэлтэй байж болно. Хэрэв хэн нэгэн Библийг бичихэд хүмүүс оролцсон учраас алдаатай байж магадгүй гэж хэлбэл тэр хүн 2 Петр 1:21-д бичигчид нь “Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн” гэдгийг мартсан байна. Бичвэрийн онгодын талаарх Библийн дагуух, түүхэн үзэл баримтлал нь Библи бүхэлдээ онгод оруулагдсан, тэр ч байтугай үг бүр нь хүртэл тийм гэж үздэг. Тиймээс алдаа мадаггүй байгаа юм (Матай 5:18, унших).

Хуулбарлах явцад гарсан алдааг юу гэх вэ?

Хэвлэх машин бий болохоос өмнө Бичвэрийг оролцуулаад бүх баримт бичгийг гараар хуулдаг байжээ. Мосе, Исаиа, Паул нарын бичсэн эх гар бичмэлүүд бидний гар дээр байхгүй. Грек, еврей хэл дээр буй олон мянган эртний гар бичмэл дунд бага зэргийн ялгаа байдаг бөгөөд анхны үг хэллэг нь ямар байсныг яг таг мэдэх боломжгүй юм. Гэсэн хэдий ч энэхүү ялгаа нь маш өчүүхэн тул тэдгээрийн улмаас аль нэг онол сургаал эргэлзээтэй байдалд орохгүй. Учир нь эх гар бичмэл зөв найдвартай байсан, түүнчлэн хуулбаруудын ялгаа маш бага байгаа зэргээс Библид бичигдсэн бүх зүйлсэд итгэж болно гэдгийг бид мэддэг.

► Библийг гараар олон удаа хуулсан ч энэ нь үнэн зөв байсан гэдгийг яаж мэдэх вэ?

► Библи алдаатай гэж боддог зарим хүмүүсийн гаргаж тавьдаг шалтгаанууд юу вэ?

Яагаад зарим хүмүүс Библи алдаатай гэж боддог вэ?

Заримдаа хүмүүс Библи алдаатай гэж хэлдэг. Учир нь тэд Библийн мөн чанарыг ойлгодоггүй.

Хүмүүсийн нийтлэг харилцааг Библид ашигласан. Тухайлбал, тэнгэрт нар хөөрч эргэлдэж буй талаар өгүүлсэн байдаг. Ихэнх эрдэмтэд нар эргэлдэж байгаа бус, харин дэлхий эргэж байна гэж үзэх нь ойлгомжтой ч тэд мөн нар мандлаа, жаргалаа хэмээн ярьдаг. Өөрөөр хэлбэл тэд зүгээр л харж байгаа шигээ дүрсэлж байна гэсэн үг.

Библид мөн шүлэг яруу найргийн хэллэг бий “Толгод хонины хурга мэт цовхсон” (Дуулал 114:4), “Талын бүх мод алга ташицгаана” (Исаиа 55:12). Энэ бол утга зохиолын хэв маяг бөгөөд мэдээж шууд утгаар нь ойлгох боломжгүй.

Заримдаа бичигчид бусад хүмүүс, тэр дундаа онгод оруулагдаагүй хүмүүсээс эш татсан нь бий (Жишээ нь, Иовын найзуудын талаар Бурхан тэд зөвийг ярьсангүй гэж хэлсэн ч тэдний хэлсэн үгсийг Бичвэрт тэмдэглэсэн байдаг (Иов 42:7)).

Эдгээрийн аль нь ч онгодын талаарх онол сургаалын хувьд асуудал биш юм. Эцсийн бүтээгдэхүүн нь Бурханы Үг байсан гэдгийг бататгахын тулд үүнийг бичих үйл явцыг Бурхан удирдан чиглүүлсэн.

Заримдаа хүмүүс Библид зөрчилддөг зүйлс бий гэж боддог. Харин үүнийг илүү нухацтай авч үзэх хэрэгтэй. Жишээлбэл, Марк 5:1-2 болон Лук 8:26-27-д чөтгөрт эзэмдүүлсэн хүнийг Есүс чөлөөлсөн тухай өгүүлдэг. Матай 8:28-д чөтгөрт эзэмдүүлсэн хоёр хүнийг чөлөөлсөн талаар хэлсэн байдаг. Энэ нь зөрчилдөх зүйл биш юм. Лук, Марк хоёр тэнд ганцхан хүн байсан гэж хэлээгүй. Харин тухайн газар оронд танигдсан, үүх түүхтэй нэг хүнийг онцолж бичсэн байдаг. Хэрэв хэн нэгэн Библи дэх өөр хоорондоо зөрчилдсөн хэсгүүдийг олж харвал яаран дүгнэлт хийлгүй, харин нөхцөл байдал, хам сэдвийг ойлгоход цаг зарцуулах хэрэгтэй юм.

Христэд итгэгчид зориулсан Библи

► Христэд итгэгчид Библийг ашиглах ямар арга замууд байдаг вэ?

Библи нь Бурханы хуулийг танилцуулдаг. Хуулийг сахиснаар бид аврагдахгүй ч Бурхан биднийг хэрхэн амьдраасай гэж хүсдэгийг хууль харуулдаг. Бурханы хууль нь Бурханы мөн чанарыг харуулдаг. Бид Бурхантай адил байхыг хүсдэг учраас үүнийг дагах ёстой. Бид Бурханыг хайрладаг учраас Түүний хуулийг хайрлах ёстой юм. Дуулал 119-д Бурханыг дээдлэн хүндэлдэг хүн хэрхэн Бурханы хуульд баярлах ёстой талаар дүрсэлсэн байдаг. Бурханыг хайрладаг хүн зүрх сэтгэлээ Бурханы хүсэлд нийцүүлэхийн тулд өөрчлөлтийн төлөө Бурханд залбирах болно. Бурханыг хайрладаг хүн Бурханыг баярлуулахгүй амьдрах боломжгүй.

Бурханы Үг бол гэрэл юм. Элч Петр, дэлхий ертөнц сүнслэг харанхуйд байгаа бөгөөд Бурханы Үг бидний явах ёстой замыг удирдан чиглүүлэх гэрэл мөн хэмээн хэлсэн (2 Петр 1:19-21, унших; мөн Дуулал 119:105-ыг үз). Хүн Бурханы Үгтэй зөрчилдөж буй санаа, мэдрэмжийг хэзээ ч дагах ёсгүй. Ариун Сүнс Библид буруу гэж хэлсэн зүйлийг хийлгэхээр хүнийг хэзээ ч хөтөлж дагуулахгүй.

Бурханы Үг бол бидний сүнслэг хоол юм. Хооллох дуршил сайтай байх нь эрүүл байгаагийн шинж бөгөөд Христэд итгэгч хүн нялх хүүхэд сүүг хүсдэг шиг Бурханы Үгийг хүсэх болно (1 Петр 2:2). Христэд итгэгч хүн төлөвших тусам хүүхэд бор хоол идэж сурдаг шиг Бурханы үнэнийг илүү ойлгож, шингээх чадвартай болдог (1 Коринт 3:2). Христэд итгэгч хүн өдөр бүр өөрийгөө Бурханы Үгээр сүнслэг байдлаар тэжээх ёстой.

“Өнөөдөр хоёр худал зүйлд бидний соёл итгэж үнэмшдэг. Эдгээр нь бид сайн хүмүүс, тийм учраас Бурхан биднийг хайрладаг, мөн нүглийг Тэр шийтгэхгүй гэж хэлэх нь юм.”
– Френсис Чан

Библи нь Сатаны эсрэг бидний хамгаалалт болдог. Өөрсдийгөө сүнслэг хуяг дуулгаар зэвсэглэхийг бидэнд тушаасан. Ариун Сүнсний бидэнд өгдөг сэлэм бол Бурханы Үг юм (Ефес 6:17). Есүс чөтгөрийн уруу татлагыг Бичвэрээр хариулсан байдаг (Матай 4:3-4).

Бурханы Үг нь биднээс хариу үйлдлийг шаарддаг үнэн юм. Есүс үүнийг таригдсан үртэй зүйрлэж хэлсэн (Лук 8:11-15). Хөрс нь бэлтгэгдээгүйгээс зарим үр нь сайн ургаагүй. Бид Библийг уншихдаа үүний үнэнд хариу үйлдэж, Бурханаас Үгээрээ бидний амьдралд үр жимс авчрахын төлөө залбирах ёстой.

Библи нь Бурханы Үг учраас...

Библи нь Бурханы Үг учраас...

- Энэ нь хэзээ ч хуучирч, ач холбогдолгүй болохгүй. Энэ нь бүх газар орон, бүх цаг үеийн, бүх хүмүүст хамаатай.
- Бурхан хэзээ ч бодлоо өөрчлөхгүй, Өөртэйгөө зөрчилдөхгүй тул энэ нь Түүний хүслийг ялган таних хөтөч юм.
- Биднийг Бүтээгч Бурхан үүнийг бидэнд заавар болгон өгсөн тул энэ нь амьдралаас хамгийн сайн сайхныг олж авах хөтөч болдог.
- Энэ нь аврагдаж, Бурхантай харилцаатай алхахын тулд бидний мэдэх ёстой бүх зүйлийг агуулдаг.

Хэдийгээр бид чуулганы уламжлал болон пастораасаа суралцдаг ч Бичвэртэй зөрчилдөх ямар нэгэн санаа, сургаал заагдвал эцсийн эрх мэдэл нь Бичвэр учраас бид үүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Ариун Сүнс Бурханы Үгийг бидэнд ойлгуулахын тулд гэрэлтүүлж, үүнийг дуулгавартай дагахад чиглүүлдэг.

► Бурхан ярьсаар байгаа нь бид Библи дээр юуг ч нэмж болно гэсэн үг үү?

Библи бүрэлдэж дууссан уу?

Сүүлчийн элч нас барсан цагаас Библийг дуусгавар болсон ном хэмээн чуулган үздэг. Чуулган Бичвэр гэж нэрлэхийн тулд л гар бичмэлүүдийг сонгосон юм биш, харин үүний оронд Бурхан онгод оруулсан, маш тодорхой эрх мэдэл үүнд байгаа гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Бичвэр хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн номууд нь хожмын өөр ямар ч зохиол бүтээлтэй тохируулах боломжгүй тийм шаардлагыг хангасан байдаг.

Израилчуудын хадгалж хамгаалж ирсэн Хуучин гэрээний бичвэрүүдийг чуулган хадгалсаар иржээ. Эцэст нь Шинэ гэрээний номуудыг дараах шалгуураар Бичвэр хэмээн хүлээн зөвшөөрсөн байдаг:

- Элч нартай түүхэн харилцаа хамааралтай эсэх
- Өөрийгөө нотлох чанар
- Чуулган санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн байдал
- Хуучин гэрээнд хүндэтгэлтэй хандсан (ашигласан)
- Тэрс үзэл, сургаалыг эсэргүүцэх ашиг тустай байдал

Бурхан ярьсан хэвээр байгаа ч хэн нэгэн өнөө цагт Библи дээр ямар нэг зүйлийг нэмж болох уу? Эх бичвэрт шинэ тэмдэглэл оруулах шаардлагыг хангахгүй тул энэ нь боломжгүй юм. Жишээлбэл, элч нар бидэнтэй хамт байхгүй тул ямар ч шинэ бичвэр тэдэнтэй хамааралтай байж чадахгүй нь ойлгомжтой. Түүнчлэн ямар ч шинэ бичвэрийг дэлхий даяар нэгэн зэрэг хүлээн зөвшөөрөх боломжгүй.

Бичвэр нь авралд болон христитгэлийн амьдралд хангалттай бөгөөд бүрэн дүүрэн юм (2 Тимот 3:14-17). Бичвэр нь бидэнд хэрэгтэй бүх зүйлийг нэгэнт агуулсан учраас чухал, шаардлагатай ямар ч зүйлийг үүнд нэмж оруулах боломжгүй. Шинэ илчлэл хүлээн авч байна гэж ярьдаг хүмүүс Бурханы аль хэдийн өгсөн илчлэлийг судлахад цаг заваа зориулах хэрэгтэй юм. Тэд тэндээс хэрэгтэй бүхнээ олж, алдаанаас хамгаалагдах болно.

Алдаанаас зайлсхийх

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ангийн хоёр гишүүн энэ болон дараагийн хэсгийг тайлбарлана уу.

Библийн эрх мэдлийг сулруулах

Таны хувьд эцсийн эрх мэдэл нь юу байдаг вэ? Олон Христэд итгэгчид Библи тэдний эрх мэдэл гэж хэлдэг ч үнэндээ тэд өөрсдийн мэдрэмждээ хамгийн их итгэдэг. Хүн аливаа үйлдлийг хийхдээ буруутай мэдрэмжийг тээхгүй л бол тухайн үйлдэл зүгээр гэж хэлдэг. Ийм хүний хувьд эцсийн эрх мэдэл нь Библи биш, харин түүний мэдрэмж байдаг.

Хүмүүс Библийг нухацтай авч үзэхгүй байх олон шалтгаан бий. Тэдний хүндэлж явдаг хэн нэгэн хүн Библийн илэрхий сургаалыг үл тоомсорлоход энэ нь тэднийг ч мөн адил үйлдэхэд өөгшүүлж байдаг. Магадгүй тэд Библид хориглодог зүйлийг хийсэн буруутай учраас өөрсдийнхөө үйлдлийг зөвтгөх арга замыг хайж байж болох юм. Магадгүй тэд зүгээр л Библийн сургаалыг мэддэггүй ч байж болно. Бид Библийг ойлгож, түүний эрх мэдэлд захирагдахын тулд бүх хүчин чармайлтыг гаргах ёстой юм.

Явцуу зорилгоор Библийг судлах

Библи бол онол сургаалын үндсэн эх сурвалж юм. Энэ нь аливаа онол сургаалтай холбоотой асуултын эцсийн эрх мэдэл байдаг. Гэсэн хэдий ч хүмүүс зөвхөн өөрсдийн онол сургаалдаа нотолгоо олохын тулд Библийг судлавал энэ нь асуудалтай. Тэд Библийг сүнслэг хоол хүнс болгон ашигладаггүй. Тэд зүгээр л өөр хэн нэгнийг буруутай гэдгийг харуулахыг зорьдог. Бид онол сургаалаа Бичвэрээр боловсруулж, хамгаалах нь мэдээж зөв зүйтэй. Гэхдээ, хэрэв энэ нь Библийг ашиглах цорын ганц зүйл болж хувирвал Бурхантай харилцах хувьчилсан харилцаандаа үүнийг хэрэглэдэг тэрхүү баяр хөөрөө алдах болно.

Зарим хүмүүс Библийг зөвхөн урам зориг авахын тулд уншдаг. Харин Библийн зорилгод заах, зэмлэх, залруулах зэрэг багтдаг гэдгийг бид санах хэрэгтэй (2 Тимот 3:16). Бид Библийн тушаалуудыг алгасаж, бидэнд илүү сайхан мэдрэмж өгдөг амлалтуудыг эрэлхийлэх ёсгүй юм. Магадгүй Бурхан өнөөдөр биднийг зэмлэх юм уу залруулахыг, эсвэл бидэнд ямар нэгэн зүйлийг зааж өгөхийг хүсэж байх боломжтой.

Гаж сургаалын алдаанууд

Зарим шашны бүлгүүд Библид итгэдэг гэж хэлдэг ч өөр зүйлийг өөрсдийн эцсийн эрх мэдэл болгодог. Тэд зөвхөн өөрт байгаа илчлэл эсвэл тусгай тогтолцоог ашиглан Библийг тайлбарлаж чадна гэж итгэдэг. Тэд хамгийн чухал онол сургаалыг Библиэс нотлох боломжгүй гэж үздэг.

Тэд Библиэс гадна бичвэр болгон ашигладаг өөр нэмэлт номтой байж ч магадгүй. Библийг орчуулах болон хуулбарлах явцад алдаа гарсан учраас найдвартай биш гэж тэд хэлж болох юм.

Эдгээр санаа нь Библи бол Бурханы Үг байхаар бүрэн гүйцэд биш гэсэн утгатай. Тэдгээр хүмүүсийн хувьд өөр зүйлс эцсийн эрх мэдэл нь болдог.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Библи бол Бурханы Үг юм. Библийг бичигчдийг алдаа гаргахгүйн тулд Бурхан тэднийг хөдөлгөсөн. Гэм нүглээс аврагдаж, Бурхантай харилцахын тулд бидний мэдэх ёстой бүх зүйлийг Библид багтаасан байдаг. Библи нь бидний онол сургаалын үндсэн эх сурвалж бөгөөд эцсийн эрх мэдэл юм. Христэд итгэгч хүн Бурханыг илүү танин мэдэж, Бурханаар удирдуулан, сүнслэгээр тэжээгдэж, утга учиртай, баяр хөөр дүүрэн амьдрахын тулд Библийг өдөр бүр судлах ёстой.

1-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Дуулал 119:33-40
- Дуулал 119:129-136
- Сургаалт үгс 30:5-6
- Матай 5:17-19
- 2 Тимот 3:15-17
- 2 Петр 3:15-16
- Илчлэл 22:18-19

(2) Сорил: Дараагийн хичээлийг 1-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Энэхүү курсын туршид та хамгийн багадаа гурван удаа ангиас гадуур хүмүүст нэг хичээлийг эсвэл хичээлийн хэсгээс заана. Хичээлийг чуулганы анги, Библи судлах гэрийн бүлэг, гэр бүлийн уулзалт эсвэр өөр орчинд заах боломжтой. Та эдгээр боломжийг бий болгож, ангийн удирдагчид тайлагнах үүрэгтэй.

(4) Дараагийн хичээлд бэлэн байхын тулд хичээлээ урьдчилж уншихаа битгий мартаарай.

1-р хичээлийн сорил

(1) Ерөнхий илчлэл гэж юу вэ?

(2) Бурханы Онцгой илчлэл нь ямар хоёр хэлбэрээр өгөгдсөн бэ?

(3) Ерөнхий илчлэлийн хийж чадахгүй ямар гурван зүйлийг Онцгой илчлэл хийдэг вэ?

(4) Библи өөрийнхөө талаар юу гэж хэлсэн бэ?

(5) Библи бол Бурханы Үг гэдгийг бид мэдэх зургаан шалтгааныг жагсаана уу.

(6) Библи нь яагаад заах, зэмлэх, залруулах, зөвд чиглүүлэхэд тустай вэ? (2 Тимот 3:16).

(7) Бичигчдийг алдаа гаргахаас хамгаалсан гэдгийг батлах онгодын талаар Библид юу гэж тодорхойлсон бэ?

(8) Бурхан онгод оруулахдаа ашигласан дөрвөн аргыг жагсаана уу?

(9) Библи дэх Бурханы амьсгал гэж юуг хэлэх вэ?

(10) Библи алдаа мадаггүй гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

(11) Библи зөв найдвартай гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

2-р хичээл

Бурханы шинж чанарууд

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Бурханы талаарх хүний үзэл баримтлал яагаад чухал болох тухай.
- Бурхан Бүтээгч болохын хувьд бусад бүх зүйлээс хэрхэн ялгардаг талаар.
- Бурханы шинж чанарууд гэдэг нь Тэр бодгаль, сүнс, мөнхийн, Гурвал, бүгдийг чаддаг, хаа сайгүй оршдог, өөрчлөгддөггүй, бүхнийг мэддэг, ариун, зөв шударга бөгөөд хайрладаг гэсэн утгатай.
- Бурханы шинж чанар бүр нь Түүнтэй харилцах бидний харилцаанд хэр чухал болох тухай.
- Бурханы хэмжээлшгүй эрх мэдлийн талаарх Библийн үзэл баримтлал.
- Бурханы талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Мөргөл хүндэтгэлийн ач холбогдол, тэдгээрийн хэлбэрүүдийн талаарх буруу ойлголтоос зайлсхийх.

Танилцуулга

► Исаиа 40-р бүлгийг хамтдаа унших. Энэхүү багц эшлэлд Бурханы талаар юу гэж хэлснийг ярилц.

► Хүн Бурханы талаар зөв эсвэл буруу үзэл баримтлалтай эсэх нь яагаад чухал вэ?

Бурхан гэж хэн бэ? А. В. Тозер энэхүү асуултад хариулахдаа “Би онол сургаалд бараг алдаа байхгүй гэж итгэдэг, хэрэв алдаа гарсан бол энэ нь христитгэлийн ёс зүйг хэрэгжүүлэхэд болон эцсийн дүндээ Бурханы талаарх төгс бус, эрээ цээргүй [доромж] бодлуудаас улбаатай” хэмээн ач холбогдлыг нь онцолжээ.³ Есүс худгийн дэргэд Самари аймгийн эмэгтэйд хандан самаричуудын мөргөл хүндэтгэлийн асуудал нь тэд хэнийг хүндэлж мөргөдгөө мэддэггүйнх хэмээн хэлсэн байдаг. Аливаа хүнийг тодорхойлох хамгийн чухал шинж нь Бурханы талаарх түүний үзэл баримтлал юм. Хүний Бурханы талаарх үзэл баримтлал түүний шашны үндэс суурь болдог. Бурханыг ямар Бурхан болохыг андуурахаас илүү ноцтой алдаа гэж үгүй.

³ А. В. Тозер (A. W. Tozer) *Ариун байдлын Мэдлэг (The Knowledge of the Holy)*, New York: Harper and Row, 1961, 10

Бурханыг бүрэн тодорхойлохын тулд харьцуулалт хангалтгүй. Учир нь Тэр хязгааргүй бөгөөд биднийг давсан, биднээс дээгүүр оршихуй юм. Библид Бурханы талаарх албан ёсны тодорхойлолтыг бидэнд хэлээгүй ч Түүний оршихуй ба хүч чадлын тухай хаа сайгүй өгүүлсэн байдаг. Эхлэл ном бидэнд Бурхан тэнгэр газрыг хэрхэн бүтээсэн тухай; ургамал; нар, сар, одод; амьтны ертөнц, эцэст нь хүн төрөлхтнийг бүтээсэн талаар өгүүлдэг. Бичвэрийн эхний хичээл нь маш тодорхой бөгөөд Бурхан бол оршин буй бүхний Бүтээгч юм. Иймд Тэрээр Өөрийн бүтээлийн нэг хэсэг биш тул оршин буй бүхнээс ялгаатай.

Библид Бурханы талаар өөр олон зүйлийг өгүүлсэн. Теологичид Библийн мэдээ баримтад үндэслэн Бурханы шинж чанаруудыг сайтар нэгтгэн дүгнэсэн байдаг. Бид өөрсдийн төгс бус ойлголтоороо эдгээрийг хэзээ ч бүрэн дүүрэн эзэмших боломжгүй. Хэдий тийм боловч Бурханы шинж чанаруудыг хүндэтгэн судлах нь үнэ цэнтэй, сүнслэг дасгал юм. Тиймээс бид Бурханы талаар өгүүлсэн дараах зүйлсийг авч үздэг. Эдгээр нь Өөрийнхөө талаар Библид өгүүлсэн Бурханы илчлэлд үндэслэгддэг учраас тэдгээр нь үнэн гэдгийг бид мэддэг.

Бурханы шинж чанарууд

Бидний авч үзэх Бурханы шинж чанарууд нь бүрэн жагсаалт биш бөгөөд харин бидний мэдэх ёстой хамгийн чухал зүйлс юм.

► Та Бурханы ямар шинж чанаруудыг жагсааж чадах вэ?

Бурхан бол бодгаль

Энэ нь оюун ухаан, мэдрэмж, хүсэл эрмэлзэлтэй жинхэнэ, амьд хүн гэсэн үг юм.⁴ Тэр байгалийн хуулиудын нийлбэр, эсвэл цахилгаан, таталцал адил зүгээр нэг хүч биш. Тэрээр бүтээдэг, үйлддэг, мэддэг, хүсдэг, төлөвлөдөг мөн ярьдаг.

► Хэрэв Бурхан бодгаль биш байсан бол биднээс хэрхэн ялгагдах бол?

Тэр бодгаль гэдэг нь бид Түүнтэй харилцах боломжийг олгодог. Хэрэв Тэр бодгаль биш байсан бол бид Түүнд залбирч чадахгүй. Хэрэв Тэр бодгаль биш байсан бол Түүнийг баярлуулах эсвэл Түүнд нийцүүлэхгүй байх зэрэг нь боломжгүй байх байв.

Бурхан бол Сүнс

“Бурхан бол сүнс, Түүнд мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой гэж айлдлаа” (Иохан 4:24).

Тэр Сүнс гэдэг нь бид Түүнтэй сүнслэг байдлаар харилцах, Түүнийг мөргөн хүндэтгэх үндэс суурь болдог. Залбирал ба мөргөл хүндэтгэл нь материаллаг зүйлс, бие махбодын тодорхой байрлал, төлөвлөсөн хөтөлбөр, барилга байгууламж зэргээс хамаардаггүй.

⁴ Эхлэл 6:6, Исаиа 42:21, Исаиа 46:10-11, Нахум 1:2, Зефаниа 3:17, Иаков 5:11, 1 Петр 5:7

Эдгээр зүйлс нь мөргөл хүндэтгэлд анхаарлаа төвлөрүүлэхэд тусалж болох ч мөргөл хүндэтгэл нь тэдгээрээс шалтгаалдаггүй.

Бурхан Сүнс гэдэг нь Түүнийг ямар нэгэн биет дүр төрх хэлбэрээр дүрслэн харуулахыг хориглосны нэг шалтгаан юм (Гэтлэл 20:4-6, унших). Бурхан Сүнс учраас нүдэнд үл үзэгдэх (1 Тимот 1:17) бөгөөд Тэр үзэгдэх хэлбэрийг сонгосон тохиолдлууд бий (Эхлэл 18:1; Исаиа 6:1, унших). Бурханы талаарх бидний ойлголт хязгаарлагдмал учраас хэдий Тэр үзэгдэх хэлбэрээр харагдсан ч бидний хэн нь ч Бурханыг бүрэн байдлаар хараагүй гэж хэлэх нь үнэн зөв юм (Гэтлэл 33:20; Иохан 1:18; Иохан 6:46).

Бурхан бол мөнхийн

Бурхан оршин байгаагүй цаг хугацаа гэж хэзээ ч байсангүй. Мөн Тэр оршин байхгүй байх цаг хугацаа ч гэж хэзээ ч үгүй. Бурханд эхлэл, төгсгөл гэж үгүй. Бурхан Өөрийгөө «Би байгаа» юм гэсэн нэрээр илчилсэн байдаг (Гэтлэл 3:14). Иохан Түүнийг Байгаа, байсан, мөн хожим ирэх Төгс хүчит Эзэн (Илчлэл 1:8) хэмээн тодорхойлсон. Өнө мөнхөөс өнө мөнх хүртэл Тэр бол Бурхан юм (Дуулал 90:2). Зарим шашинд бурхад нь хэзээ төрсөн талаар домог яриа байдаг ч жинхэнэ Бурхан бол мөнхийн юм.

Бурхан бол Гурвал

Библид нэг Бурхан байдаг гэж өгүүлдэг ч гурван тусдаа бодгалийг нэг Бурхан гэж үздэг. Цорын ганц Бурхан байгаа ч мөн чанарынхаа хувьд Тэрээр гурван бодгалиар оршдог. Хэдийгээр бид Гурвалыг бүрэн ойлгож чадахгүй ч энэ нь учир зүйгүй, зөрчилдөх зүйл биш юм. Учир нь бид яг адилхан нэг зүйл ба гурван зүйл байгаа гэж хэлээгүй, харин гурван бодгалиар оршдог нэг Бурхан байгаа гэж итгэдэг. Эцэг, Хүү, Ариун Сүнс нь бүх бурханлаг шинж чанарыг хамтад нь эзэмшдэг тул Тэднийг тус бүрд нь Бурхан гэж зүй ёсоор нэрлэж, Бурхан хэмээн мөргөн хүндэтгэх боломжтой (дараагийн хичээл дээр Гурвалын талаар илүү ихийг ярилцах болно).

Бурхан бүгдийг чаддаг

Тэр хүссэн бүхнээ хийх чадвартай. “Бурхан маань тэнгэрт байдаг. Тэр хүссэн бүхнээ үйлддэг” (Дуулал 115:3). Тэрээр ариун мөн чанартаа харшлах зүйлийг үйлддэггүй гэдгээс өөр хязгаар үгүй бөгөөд Тэр амласан зүйлээ үргэлж биелүүлдэг. Бурханы хувьд амаргүй, хэцүү зүйл гэж үгүй. “Төгс хүчит Эзэн Бурхан маань хаанчилж байна” (Илчлэл 19:6).

► Бурхан бүгдийг чаддаг гэдгийг мэдэх нь бидэнд ямар ялгаа заагийг харуулдаг вэ?

Бэрхшээл, тэмцлийн дунд “... ажилладаг хүчний дагуу гуйх буюу бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай” (Ефес 3:20) гэдгийг мэдэх нь бидэнд урам зоригийг өгдөг. Бүх зүйл хяналтаас гадуур мэт санагдаж байсан ч Бурханы агуу төлөвлөгөө биелнэ гэдгийг бид мэддэг. Бурхан ямар ч нөхцөл байдалд хөндлөнгөөс оролцох чадвартай гэдэгт бид итгэлтэйгээр залбирч чадна.

Бурхан хаа саагүй оршдог

Тэр байхгүй газар гэж үгүй. Түүний хараагүй зүйл гэж байдаггүй. “ЭЗЭН үүнийг айлдаж байна. Тэнгэр болбоос Миний сэнтий, газар болбоос Миний хөлийн гишгүүр билээ” (Исаиа 66:1). Тэрээр орчлон ертөнцийн Бурхан бөгөөд Түүний хүч чадал аль ч бүс нутгаар хязгаарлагдахгүй. “Надад харагдахгүй байхаар хүн далд газруудад нуугдаж чадах уу? гэж ЭЗЭН тунхаглаж байна. Би тэнгэрс хийгээд газрыг дүүргэдэггүй гэж үү?” (Иеремиа 23:24). Энэ нь Бурхан бидний нөхцөл байдал, асуудал бэрхшээлийг мэддэг гэдгийг баталдаг. Мөн энэ нь хэн ч Бурханаас нуугдаж, эсвэл харж чадахгүй газар нүгэл үйлдэх боломжгүй гэдгийг бидэнд хэлдэг. Бүх зүйл Түүний мэлхийн өмнө нүцгэн бөгөөд ил юм (Еврей 4:13, унших).

“Бид орон зайг туулан байхгүй Бурханд хандан хэзээ ч хашгирах хэрэггүй юм. Тэр бидний сүнс сэтгэлээс ч ойр, бидний хамгийн далд бодлуудаас ч илүү ойр байдаг.”

— А.В. Тозер

Бурхан өөрчлөгддөггүй

Тэр Бурхан болсон цаг үе гэж хэзээ ч байгаагүй бөгөөд Тэрээр хэзээ ч Бурхан байхаа болихгүй (Иаков 1:17, унших). Хөгжлийн үйл явцыг туулж Бурхан бий болсон гэх шашны үзэл байдаг ч Бурхан оршихуй ба мөн чанар, зорилго ба шинж чанарынхаа хувьд хэзээ ч өөрчлөгддөггүй гэж Библи заадаг (Малахи 3:6, унших). Тэр үргэлж зөвийг хайрлаж, бурууг үзэн яддаг. Мосед Өөрийгөө “БИ байгаа” гэж илчилсэн мөнхийн Бурхан бол өнөөдрийн “БИ байгаа” юм. Тэрээр Өөрийн оршихуй, мэргэн ухаан, хүч чадал, ариун байдал, шударга ёс, сайн сайхан, үнэн зөвийн хувьд хязгааргүй, мөнхийн бөгөөд хувиршгүй билээ. Тэр үргэлж хэвээрээ бөгөөд Түүний он жилүүдэд төгсгөл үгүй (Дуулал 102:27).

Бурхан бүхнийг мэддэг

“Оюун ухаан нь хязгааргүй” (Дуулал 147:5). Бурханд суралцах үйл явц гэж байхгүй, учир нь Тэр бүхнийг мэддэг. Бурхан хэзээ ч хэнээр ч заалгаагүй бөгөөд Түүнд зөвлөгөө өгөх хүн байхгүй (Исаиа 40:13-14, унших). Бурхан ирээдүйг мэддэг учраас юу ч тохиолдсон хэзээ ч гайхаж, бэлэн бус ханддаггүй (Дуулал 139:4).

► Бурхан бүхнийг мэддэг гэдгийг ойлгох нь бидэнд ямар ялгаа заагийг харуулдаг вэ?

Бурханы мэдлэгтэй холбоотой мэргэн ухаан нь бүтээлд, ялангуяа авралын төлөвлөгөөнд нь илэрдэг (Дуулал 104:24; Ром 11:33, унших). Тэр бүхнийг мэддэг, ойлгодог учраас зөвийг үйлдэхийг үргэлж мэддэг. Тэрээр нөхцөл байдал бүрийг бүрэн ойлгож, үйлдэл бүрийн үр дүн юу болохыг мэддэг учраас Бурханы хүсэл бидний хувьд үргэлж хамгийн сайн нь юм.

Бурхан бол ариун

Бурхан Өөрийгөө юуны түрүүнд ариун гэж тодорхойлсон. Эш үзүүлэгч Исаиа Бурханыг “Израилийн Ариун Нэгэн...” гэж дахин дахин дурджээ. Тэнгэрэлч нар Түүний өмнө “Ариун, ариун, ариун” хэмээн үргэлж хүндэлдэг (Илчлэл 4:8, Исаиа 6:3). Бурханы ариун байдал нь мөргөл хүндэтгэлийн сэдэв байсаар ирсэн “Таны аугаа, сүрдмээр нэрийг тэд магтан дуулаг. Тэр ариун” (Дуулал 99:3). Тэр бол бүх ёс суртахууны туйлын төгс жишиг мөн. Тэрээр бузар мууг үйлддэггүй, харин үйлс нь үргэлж сайн сайхан бөгөөд үүнээс өөрөөр байх боломжгүй юм. Бурханы ариун байдал нь хүн эхлээд нигүүлслээр хувьсан өөрчлөгдөхөөс нааш, Түүнийг мөргөн хүндэлж, Түүний үйлчлэлд тэнцэхгүй гэдгийг харуулдаг (Исаиа 6:5, унших). Бурхан биднийг Өөртэйгээ адил ариун байхыг хүсдэг. “Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм” (1 Петр 1:15-16).

Бурхан бол зөв шударга

Бурханы үйлс нь үргэлж зөв шударга юм. Түүний үйл хэрэг ариун мөн чанараас нь ундрэн гардаг (Дэд хууль 32:4, унших). Түүний мөн чанар нь юу зөв гэдгийн жишиг юм. Тэр үргэлж хэлсэн үгэндээ хүрдэг бөгөөд хэзээ ч худал ярьдаггүй (Тооллого 23:19; 2 Самуел 7:28).

► Бурхан зөв шударга байгаа нь яагаад бидний хувьд чухал вэ?

Бурханы зөвт байдал нь Түүний хуулийн үндэс бөгөөд Түүний болон бусдын өмнө хүлээсэн бидний үүрэг хариуцлагын төгс жишиг юм. Тэрээр Өөрийн хуулийг шударгаар хэрэгжүүлж, үүнийг дуулгавартай дагадаг хүмүүсийг шагнаж, зөрчигчдийг шийтгэдэг. Энэ нь зовж зүдэрсэн, дарлагдсан хүмүүсийг тайвшруулдаг бөгөөд мөн буруу зүйлийг хийсэн хэн ч үүнээс мултрахгүй гэдгийг бидэнд сануулдаг. “ЭЗЭНий шүүлтүүд үнэн Бүгд зөв шударга” (Дуулал 19:9). Тэр хүн бүрд хийсэн үйлсийнх нь дагуу хариу өгнө (Ром 2:6). “Бид бүгдээрээ Бурханы шүүх суудлын өмнө зогсох болно шүү дээ” (Ром 14:10).

Бурхан бол хайр

Энэхүү шинж чанар нь туйлын чухал юм. Бурхан биднийг хайрлаагүй бол Түүний бүхнийг мэддэг, бүгдийг чаддаг чанар нь ямар аймшигтай байх байсныг төсөөлөөд үз дээ! Хэрэв Тэр ариун бөгөөд зөв шударга байсан ч биднийг хайрлаагүй бол ямар байх байсан бол? Өөрийн туйлын хүч чадал, ариун байдлын зэрэгцээ Бурхан биднийг хайрладаг (Ром 5:8, унших). Бурхан бүтээлээ ерөнхий байдлаар ерөөдөг (Эхлэл 1:22, 28). Тэр газар дэлхийг хүмүүсийн баяр хөөртэй амьдрах газар байхаар бүтээж, хүн төрөлхтнийг амьдралын сайн сайхан зүйлсээр онцгойлон ерөөжээ.⁵ Түүнийг хайрлаж, Түүнд үйлчилдэг хүмүүсийн хувьд Бурхан амьдралынх нь бүх нарийн ширийн зүйлсийг

⁵ Дуулал 8:4-6; Дуулал 23; Дуулал 36:5-10; Дуулал 103

ерөөл болгон эргүүлдэг (Ром 8:28). Түүний нигүүлсэл, өршөөл, тэвчээр, амар тайван нь Түүний хайрын улмаас биднийг ивээж ерөөдөг (Гэтлэл 34:6; Ефес 1:7, Ефес 2:4-5, унших).

“Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн тул Хүүд итгэдэг бүхэн мөхөхгүй харин мөнх амьтай байх болно” (Иохан 3:16). Бид нүгэлтэй, тэрслүү байсан хэдий ч Тэр бидний нүглийн төлөөх тахил золиос болох Есүсээр дамжуулан Өөр рүү нь ирэхийг урьж, бидэнд өршөөнгүй хандсан билээ (1 Иохан 2:2). Бурхан биднийг хэрхэн хайрлаж, өрөвдөн өршөөсөн Түүний зүрх сэтгэлийг загалмай харуулдаг. “Бид Бурханыг хайрласан бус, харин Тэр биднийг хайрлаж, бидний нүглийн улмаас Хүүгээ эвлэрүүлэл болгон илгээсэнд л хайр байгаа юм” (1 Иохан 4:10). Бурхан бүх хүмүүсийг угсаа гарал, төрөлх чадвар, нийгмийн байр суурь зэргээс нь үл хамааран хайрладаг бөгөөд бүх хүнд өршөөлийг соёрхдог (Ром 2:11; Иаков 2:1-5, унших). Тиймээс Бурхан биднийг бүх хүнийг хайрлаж, бидэнд буруу зүйл хийсэн хэнийг ч болов уучлахад бэлэн байгаасай гэж хүсдэг. Хайр ба уучлал нь Бурханы хүүхдүүдийг таних шинж тэмдэг юм (Матай 5:43-45, унших).

“Түүний намайг хайрласан хайрыг мэдэх нь надад асар их тайвшрал өгдөг. Энэ нь үнэхээр бодитой бөгөөд миний талаарх хамгийн муу муухай бүхнийг урьдчилж мэдсэн учраас миний талаар дахин сөхөгдөх ямар ч зүйлээс болж Тэр сэтгэлээр унахгүй. Харин би өөрийнхөө талаар байнга сэтгэл дундуур явснаар намайг ерөөдөг Түүний шийдвэртэй байдалд тээг болдог.”

— Ж.И. Пакер, Бурханыг таньж мэдэх нь

Бурхан биднийг Өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Хэдийгээр бид хязгаарлагдмал, Тэр хязгааргүй ч, бид Түүний бүтээлүүд дотроос илүү Түүнтэй адил юм. Бурханыг мэдэж, хүндэлж, хайрлахын тулд Тэр биднийг бүтээжээ. Тэрээр биднийг Өөртөө зориулж бүтээсэн бөгөөд Августин бидэнд сануулж хэлсэнчлэн “Түүний дотор амралтыг олтоо бид хэзээ ч амарч чадахгүй.” Бурхантай харьцуулбал дэлхий дээрх бүх зүйл чухал биш бөгөөд зөвхөн Тэр л дангаараа бидний бүрэн дүүрэн, чин бишрэл хүндлэлийг авах зохистой Нэгэн. Байнгын сэтгэл хангалуун байдлыг бид Бурханаас өөр хаанаас ч олох боломжгүй. Бурханы нигүүлслээр бид золин аврагдаж, бүх зүйлээс дээгүүр Түүнийг мөргөн хүндэтгэж, Тэнгэрлэг Эцэгийн хувьд Түүнд итгэж, амьдралынхаа бүх талбарт Түүний хүслийг биелүүлж чадна.

“Та биднийг Өөрийнхөө төлөө бүтээсэн билээ. Өө Эзэн минь, Таны дотор тэд амралтыг олох хүртэл бидний зүрх сэтгэл амралтыг эс олно.”

- Августин Хиппо

Бурхан хэмжээлшгүй эрх мэдэлтэй

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ангийн нэг гишүүн энэ хэсгийг тайлбарлана уу.

Бурханд туйлын хүч чадал ба эрх мэдэл аль аль нь бий. Орчлон ертөнцийн захирагчийн хувьд Тэрээр хүссэн бүхнээ хийх чадвартай (Дуулал 115:3, Дуулал 135:5-6).

Тэр Өөрийн хүслийн дагуу бүхнийг хийхдээ хэн нэгэнд нийцүүлэх, захирагдах шаардлага Түүнд байхгүй (Ефес 1:11). Түүний хийхээр шийдсэн бүхэн биелэх нь гарцаагүй, учир нь Түүнийг зогсоож чадах хэн ч, ямар ч нөхцөл байдал байхгүй (Исаиа 46:9-11, унших). Тэрээр хүссэн үедээ дэлхийн удирдагчдын үйлдэлд хяналт тавьдаг (Эхлэл 50:20; Үйлс 4:27-28).

Гэсэн хэдий ч Бурхан хүмүүст сонголт хийх чадварыг өгсөн. Хүмүүс сайн зүйлсээс сонголт хийдэг төдийгүй сайн муугийн аль нэгийг ч сонгож чаддаг. Тэд Бурханыг дуулгавартай дагах, эс дагахаа сонгодог. Түүний бүтээсэн хамгийн анхны хүмүүс нүгэл үйлдэх сонголтыг хийсэн. Түүнээс хойш хүн бүр сонголт хийсэн бөгөөд хэдий зарим нь сайн сонголт гаргасан ч бүгд нүгэл үйлдэцгээжээ.

Хэрэв Бурхан бүхний Эзэн бол тэрбум тэрбумаар тоологдох бүтээл, амьтад тус тусын сонголт хийж байгаа энэ дэлхий ертөнцөд Тэр Өөрийн хүслээ хэрхэн биелүүлэх вэ?

Түүний бүтээлүүд жинхэнэ сонголт гаргах нь Бурханы хүсэл юм. Энэ нь Тэр тэдний төлөө бүх сонголтыг хийхгүй гэсэн үг. Түүнчлэн энэ нь тэдний хийж байгаа зүйлд бодит үр дагавар байх ёстойг хэлж байна. Хэрэв тийм биш байсан бол тэдний сонголт жинхэнэ байх боломжгүй болно. Хэрэв Бурхан ямар нэгэн байдлаар хүний үйлдлийн үр дүнг удирддаг бол ямар ч бузар муу үр дагавар бий болохгүй. Улмаар бузар мууг сонгох боломж ч хүнд байхгүй байж таарна.

Бурханы шударга ёс нь хүмүүсийг сайн дурын үйлдлийнх нь төлөө шүүх учраас жинхэнэ шударга ёс юм (Илчлэл 20:12-13, унших). Хэрэв Бурхан бүх үйлдлийг хянаж удирддаг байсан бол шагнаж, шийтгэх нь ч Түүнд утга учиргүй байх болно.

Бурхан хүмүүсийг зөвийг сонгоосой гэж хүсдэг ч хамгийн гол нь тэд жинхэнэ сонголт гаргахыг хүсдэг. Тийм ч учраас дэлхий ертөнц байгаагаараа байгаа билээ. Энэ дэлхий бол Бурханы сайн сайхан зүйлс, хүний сайн үйлсийн үр дүн төдийгүй хүний муу үйлсийн үр дагавар, энэхүү хүний муу үйлсээс Бурханы эргүүлж авчирдаг сайн сайхан бүгд цогцолсон газар юм.

Бид авралын төлөвлөгөөнөөс нь Бурханы хувьд юу чухал болохыг хардаг. Тэр бүх хүнд авралыг санал болгож, бүх хүн аврагдахыг хүсдэг (1 Тимот 2:3-4). Тэрээр хүн бүрд сайнмэдээнд хариу үйлдэл үзүүлэх хүчийг өгдөг ч хариу үйлдэл үзүүлэхийг албаддаггүй. Тийм ч учраас Бичвэрт урилга, ятгалгыг өргөн ашиглажээ.⁶ Бурхан хүмүүст сонголт хийх боломжийг санал болгож, үр дагаварыг нь тодорхойлж өгдөг.

Хүн бүр аврагдаж чадна гэсэн бүрэн итгэлтэйгээр бид сайнмэдээг номлодог. Бидний үүрэг даалгавар нь Ариун Сүнстэй хамтарч, хүмүүс Бурханд захирагдахыг ятгах нь юм (2 Коринт 5:11, унших).

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

⁶ Дэд хууль 30:15, 19; Иошуа 24:15; Исаиа 1:18; Исаиа 55:1; Езекиел 18:31; Илчлэл 3:20

Итгэлээ шалгах

Орчлон ертөнцийг бүтээсэн, бүхний Эзэн нэг Бурхан байдаг. Тэр бол мөнхийн, хувиршгүй Сүнс билээ. Тэрээр бүгдийг чаддаг, бүхнийг мэддэг бөгөөд хаа сайгүй оршдог. Тэрбээр зан чанараараа туйлын ариун бөгөөд үйлс бүр нь зөв шударга юм. Бурхан бүтээлээ ерөөж, хүн бүрийг хайрладаг бөгөөд Өөртэйгээ харилцах харилцаа ба уучлалыг санал болгодог.

2-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Дуулал 139:1-4
- Сургаалт үгс 9:10
- Исаиа 46-р бүлэг
- Илчлэл 4:9-11

(2) Сорил: Дараагийн хичээлийг 2-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

2-р хичээлийн сорил

(1) Хүнийг тодорхойлох хамгийн чухал шинж юу вэ?

(2) Бичвэрийн эхний хичээл юу вэ?

(3) Дараах өгүүлбэрт тохирох Бурханы шинж чанаруудыг нэрлэнэ үү:

- Бурхан ямар харагддагийг бид дүрслэх боломжгүй
- Бурхан үргэлж оршсоор байгаа
- Бурхан оюун ухаан, мэдрэмж, хүсэл эрмэлзэлтэй
- Бурхан үргэлж хэвээрээ
- Бурхан сонгосон бүхнээ хийх чадвартай
- Бурхан бүхнийг хардаг
- Бурхан Хүүгээ илгээсэн учраас бид өршөөлийг хүртсэн
- Бурхан мөн чанарынхаа хувьд гурван бодгалиар оршдог
- Бурхан туйлын төгс ёс суртахуунтай
- Бурхан хэнээр ч заалгахгүй
- Бурханы үйлс нь үргэлж зөв шударга юм

3-р хичээл

Гурвал

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Орчлон ертөнц нь Гурвалын мөн чанарыг харуулах зураглал болдог талаар
- Гурвалын талаарх онол сургаалын Библийн үндэс
- Гурвалын талаарх онол сургаал нь яагаад сайнмэдээний үндэс болдог тухай
- Гурвал хоорондын харилцааны бүтэц
- Гурвал нь хүмүүс хоорондын харилцааны жишээ загвар болдог талаар
- Гурвалд итгэх бидний итгэл үнэмшил хэрхэн мөргөл хүндэтгэлд дагуулдаг тухай
- Гурвалын талаарх христэч итгэл үнэмшил

(2) Суралцагч нь Гурвалыг тайлбарлахдаа хүмүүсийн гаргадаг нийтлэг алдаанаас зайлсхийж сурна.

Танилцуулга

► Иохан 14-р бүлгийг хамтдаа уншаарай. Бурхан Гурвал болохыг энэ багц эшлэлд хэрхэн харуулсныг ярилц.


Гурвалын талаарх онол сургаал нь нэг талаас Бурханыг ганц, нөгөө талаас гурав гэж хэлдэг учраас олон хүмүүс төөрөлддөг.

Гэхдээ бид **орчлон ертөнцийн** зүй тогтлоос нэг зүйл дотор буй гурвалын жишээг ажиглах боломжтой. Орчлон ертөнц нь орон зай, цаг хугацаа ба матери гэсэн гурван хэсгийг агуулдаг. Энэ гурвын аль нэг нь үгүй бол орчлон ертөнц байх боломжгүй юм.

Орчлон ертөнц



Орон зай



Энэхүү гурав нь тус бүрдээ гурван хэсгээс бүрдэх боломжтой.

Орон зай нь урт, өргөн, өндөр гэсэн нэгийн доторх гурвалыг багтаадаг. Энэхүү гурван чиглэлийн аль нэг нь үгүй бол орон зай байх боломжгүй.

Цаг хугацаа нь өнгөрсөн, одоо, ирээдүй хэмээх нэгийн доторх гурвалаас бүрддэг. Энэхүү гурван

хамрах хүрээний аль нэг нь үгүй бол цаг хугацааг тодорхойлох боломжгүй.

Цаг хугацаа



Матери нь үзэгдэл юмсыг бүтээдэг хөдөлгөөний энерги хэмээх нэгийн доторх гурвалаас мөн бүрддэг. Хэрэв энерги үгүй бол хөдөлгөөн болон үзэгдэл юмс байх боломжгүй. Хэрэв хөдөлгөөн үгүй бол энерги болон үзэгдэл юмс ч байх боломжгүй юм. Нөгөөтэйгүүр, үзэгдэл юмс байхгүй байгаа нь хөдөлгөөн болон энерги байгаагүйтэй холбогдох байсан болов уу.

Тэгэхээр орчлон ертөнцийн зүй тогтлыг харвал нэгийн доторх гурвалын загвараар бүтээгдсэн мэт харагддаг. Бурхан Өөрийн мөн чанарыг дүрслэн харуулахын тулд орчлон ертөнцийг загвар болгон ийнхүү бүтээсэн ч байх боломжтой.

Тэгвэл Библи Гурвалын талаар юуг өгүүлдэг вэ? Орчлон ертөнцийг бүтээсэн нэг Бурхан гурван өөр ялгаатай бодгаль байдлаар оршдог гэдгийг тодорхой тайлбарладаг. Бурхан бол нэг бодгаль төдийгүй гурван бодгаль ч мөн гэж хэлээгүй учраас энэ санаанд зөрчил байхгүй. Нөгөөтэйгүүр, Бурхан бол нэг Бурхан ба гурван Бурхад ч гэж бид хэлэх боломжгүй юм. Харин бид Бурханыг бодгаль байдлаараа гурав, мөн чанараараа нэг Бурхан хэмээн хэлэх боломжтой. Энэ нь нэг орчлон ертөнц орон зай, цаг хугацаа, матери байдлаар оршдог шиг нэг Бурхан Эцэг, Хүү, Ариун Сүнс байдлаар оршдог.

Гурвалын талаарх Библийн нотолгоо

Үндэслэл 1: Цорын ганц Бурхан байдаг.

Сонс, Израиль аа! ЭЗЭН бол бидний Бурхан бөгөөд ганц ЭЗЭН (Дэд хууль 6:4).

Учир нь Би Бурхан, өөр байхгүй. Би Бурхан. Надтай ижил нь үгүй (Исаиа 46:9).

Үндэслэл 2: Эцэг, Хүү, Ариун Сүнс бүгд Бурхан.

Эцэг Бурханаар (Галат 1:1).

Үг нь Бурхан байв... Үг нь махбод болж (Иохан 1:1, 14).

зүрх чинь яагаад Сатанд автаж... Ариун Сүнсэнд худал хэлэв? Чи хүнд биш харин Бурханд худал хэллээ гэв (Үйлс 5:3-4).

Үндэслэл 3: Гурвал нь ялгаатай бодгаль байдлаар бие биетэйгээ харилцдаг.

► Бид тэдгээрийг өөр өөр үүрэг оролцоо бүхий нэг бодгаль биш, харин гурван бодгаль гэдгийг хэрхэн мэдэж болох вэ?

Марк 1:10-11-д Есүсийг баптисм хийлгэх үед Ариун Сүнс Түүн дээр тагтаа мэт буун ирж, тэнгэрээс "Хайрт Хүү минь Чи билээ. Таалал минь Чамд оршдог" хэмээн хэлэх дуун сонсогддог. Бид эндээс Эцэг, Хүү, Ариун Сүнс нь нэг бодгаль байгаагүй болохыг, мөн нэг цаг хугацаанд өөр өөр үүргээр оролцоогүйг харж болно.


Үйлчлэлийнхээ эцэст Есүс, Эцэгээс өөр нэгэн Туслагч болох Ариун Сүнсийг бидний төлөө асуух болно гэж хэлсэн байдаг (Иохан 15:26). Энэхүү хүсэлтэд хоорондоо ялгаатай гурван бодгаль оролцож байгааг та анзаарч байна уу?

Хэрэв та Иохан 14-17-р бүлгийг уншвал тэндээс Эцэг, Хүү, Ариун Сүнс хоорондын харилцаа хамаарлын талаар ихийг харж болно.

Дүгнэлт: Библийн нэг үнэн Бурхан Өөрийгөө Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн ялгаатай гурвалаар оршдог болохоо илчилжээ. Бурхан мөн чанарын хувьд нэг, харин бодгалийн хувьд гурвал юм.

Иймд, хэдийгээр *Гурвал* гэдэг үг Библид байдаггүй ч Гурвалын талаарх онол сургаал нь тов тодорхой бичвэрийн хэсгүүдэд үндэслэгддэг. Энэхүү онол сургаалын талаар Библид заадаг бүхнийг бид хураангуйлж үзэхдээ *Гурвал* гэсэн нэр томъёог ашигладаг.

Библийн энэхүү онол сургаалыг чуулган элч нараас хойш заасаар иржээ. Зуун зууны туршид чуулган Гурвалыг тайлбарлахдаа ашиглаж ирсэн хүснэгтийг энд харуулсан байна.



Гурвалын талаарх онол сургаал нь үндсэн чухал ач холбогдолтой

► Гурвалд итгэх, итгэхгүй байх нь яагаад тийм чухал юм бэ?

Гурвалын талаарх онол сургаал нь сайнмэдээний үндсэн чухал сургаалын суурь болдог. Жишээлбэл, Гурвалыг үгүйсгэдэг зарим хүмүүс Есүс Бурхан гэдгийг үгүйсгэдэг. Гэвч, хэрэв таны итгэдэг Есүс Бурхан биш бол таныг аврах Есүс танд байхгүй гэсэн үг! Зөвхөн нүгэлгүй хүн л бүх хүмүүсийн нүглийн төлөө үхэж чадна. Бид хязгааргүй Бурханы эсрэг нүгэл үйлдсэн учраас Түүний золиос ч мөн хязгааргүй байх ёстой. Есүс Бурхан байсан учраас бүх цаг үеийн бүх хүмүүсийн нүглийн төлөөсийг нүгэлгүй, хязгааргүй золиосоороо хангаж өгсөн юм.

Хэрэв бид Эцэг, Хүү, Ариун Сүнс нь ялгаатай гэдгийг үгүйсгэвэл Бурханы төрөлхийн бодгаль шинж болон харилцааны шинж чанаруудыг нь ч үгүйсгэх болно. Жишээлбэл, Бурхан хэн нэгнийг хайрлахын тулд түүнийг бүтээх хүртлээ хүлээх хэрэгтэй байсансан бол өнө мөнхөд хайраар дүүрэн Бурхан байх боломжгүй болно. Харин Бурхан нэгээс олон бодгалиар оршиж байж тэдгээр бодгалиуд нь бие биенээ өнө мөнхөд хайрлаж чадна. Ийм харилцаанд байдаг Бурханд (өөрийгөө зориулдаг хайр дотор орших) итгэх нь их чухал юм. Учир нь энэ нь бидний бие биетэйгээ болон Бурхантай харилцах харилцаанд нөлөөлдөг.

Үүнтэй холбоотой магадгүй хамгийн нухацтай авч үзэх тал нь бид Бурханыг мөргөн хүндэтгэх ёстой гэсэн ойлголт. Гурвалыг үгүйсгэдэг хүмүүс ихэвчлэн Есүс болон Ариун Сүнс нь Бурхан гэдгийг үгүйсгэдэг учраас тэдэнд мөргөл хүндэтгэл өргөдөггүй. Хүний гаргаж болох хамгийн том алдаа бол Бурхан биш хэн нэгнийг хүндэтгэн мөргөх, эсвэл Бурхан нэгнийг хүндлэн мөргөхгүй байх нь юм.

Жон Стоттын өдөр бүрийн Гурвалд хандах залбирал

Тэнгэрлэг Эцэг минь, би энэ өдөр Таны оршихуйд амьдарч, Таныг улам ихээр баярлуулахыг хүсэн залбирч байна.

Эзэн Есүс ээ, би энэ өдөр загалмайгаа үүрч, Таныг дагахын төлөө залбирч байна.

Ариун Сүнс ээ, энэ өдөр Та намайг Өөрөөрөө дүүргэж, миний амьдралд хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайн сэтгэл, итгэмжит байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах Таны үр жимсийг ургуулж өгөхийг хүсэн залбирч байна.

Ариун, ерөөлт, суу алдарт, нэг Бурханы доторх гурван бодгаль Гурвал минь, намайг өршөөн соёрхооч.

Орчлон ертөнцийг бүтээгч, тэтгэгч, Төгс Хүчит Бурхан, би Таныг мөргөн хүндэтгэж байна.

Дэлхийн Аврагч, Эзэн Есүс Христ, би Таныг мөргөн хүндэтгэж байна.

Бурханы ард түмнийг ариусгагч Ариун Сүнс, би Таныг мөргөн хүндэтгэж байна.

Эцэг, Хүү, Ариун Сүнсэнд алдар нь эхэнд байсан шиг өдгөө ч, өнө мөнхөд байх болтугай, Амен.

Эцэг, Хүү, Ариун Сүнс бодгалиуд нь харилцаан дотор амьдардаг

Эцэг, Хүү, Ариун Сүнс нь тус бүрдээ бодгаль шинж чанартай бөгөөд бие биетэйгээ үргэлж хувийн харилцаатай байдаг. Тэд бие биетэйгээ холбоотой амьдардаг учраас бид тэднийг бодгаль гэж нэрлэдэг. Тэд бие биенээ хайрлаж, бие биедээ өгч, бие биетэйгээ ярилцаж, бие биенийхээ төлөө амьдардаг. Энэ нь тэд *бодгалиуд* гэдгийг харуулж байна.

Гурвал дахь бүтэц

Эцэг, Хүү, Ариун Сүнс үргэлж харилцааны бүтцэд оршсоор иржээ. Эцэг нь тэргүүн, дараа нь Хүү, тэгээд Сүнс юм. Энэхүү мөнхийн Гурвалын ижил тэнцүү бодгалиуд нь бие биетэйгээ харилцах харилцаандаа тулгуурласан эрх мэдэл, байр суурьтай. Энэхүү эрх мэдлийн бүтэц нь чуулганд болон гэр бүлд тусгагдсан байдаг. Гурвалын гишүүдийн нэгэн адил чуулганы болон гэр бүлийн бүх гишүүд нь ижил үнэ цэнтэй боловч бүгд адил хэмжээний эрх мэдэл, байр суурьтай байдаггүй.

Хүү Эцэгтэйгээ харилцах харилцаа

Хүү Эцэгтэйгээ хэрхэн харилцдаг вэ? “Эцэгт Өөрт нь амь байдгийн адил мөн Хүүд Өөрт нь амь байлгахыг Хүүдээ Тэр соёрхжээ” хэмээн Есүс хэлсэн байдаг (Иохан 5:26). Хүү нь өнө мөнхөөс Эцэгийн цорын ганц Хүү байсаар ирсэн (Иохан 3:16). Хүү нь Бурханы адил мөнхөд Өөрөөрөө оршдог бөгөөд Эцэгтэй ижил мөн чанартай хэдий ч Түүний оршин тогтнол нь Эцэгээс иржээ. Хүү нь өнө мөнхөд Эцэгтэйгээ Хүүгийн харилцаанд байдаг бол Эцэг нь бие махбодын хувьд биш ч гэсэн Хүүтэйгээ Эцэгийн харилцаанд

байдаг. Есүс мөн чанараараа Эцэгтэйгээ эн тэнцүү юм. Тэр Эцэгтэйгээ адил түвшинд алдар, хүндлэлийг авдаг. “Энэ нь бүгд Эцэгийг хүндэлдгийн адил Хүүг хүндлэхийн тулд юм” хэмээн Есүс хэлжээ (Иохан 5:23).

Ариун Сүнс Эцэгтэй болон Хүүтэй харилцах харилцаа

Иохан 15:26-д Есүс бидэнд Эцэгээс гарах Ариун Сүнсийг илгээнэ гэж хэлсэн байдаг. Сүнс хэдийгээр Эцэгээс гаралтай ч Тэр Эцэгтэй, Хүүтэй эн тэнцүү бөгөөд ижил алдар хүндтэй юм. Энэхүү гарал үүсэл болон илгээгдэж байгаа нь бие биетэйгээ хайрын харилцаанд оршдог гурван бодгалиудын хооронд болж байгааг анзаараарай.

Бурханы нэгдмэл байдлыг хамгаалах нь

Гурвалын гурван бодгалийг салангид тусдаа хувь хүмүүс гэж үзэх ёсгүй юм. Тэдний оршин байгаагийн нэгдмэл байдал гэдэг нь тэд ижил мөн чанартай бөгөөд гурван бодгаль бие биедээ нэвтэрч, оршин, өөр хоорондоо шинж чанаруудаа хуваалцдаг гэсэн утгатай. Эцэг, Хүү, Ариун Сүнс нь хүмүүн бидний хувьд боломжгүй тийм байдлаар бие биеийнхээ дотор оршдог.

Хүн бүр зөвхөн нэг бодгаль бөгөөд цорын ганц оршихуй юм. Харин Бурхан бол гурван бодгаль хэдий ч цор ганц оршихуй билээ. Бурханы нэгдмэл байдлын тухай Библийн үзэл баримтлалыг хамгаалахын тулд Гурвалын гишүүдийг бие биенээсээ салангид тусдаа (хүмүүс) биш, харин өөр ялгаатай (бодгалиуд) хэмээн бид ярьдаг.

Бурханы бодгаль шинж, харилцаа нь бидэнд тусгагдсан

Бурхан биднийг Өөрийн дүр төрхөөр, бие биетэйгээ болон Бурхантай харилцах чадвартайгаар бүтээсэн. Бидний хүн нэг бүрд харилцахын тулд оюун ухаан, хүсэл, сэтгэл хөдлөл бий.

Хувь хүнийхээ хувьд бид бүрэн бус

Бурхан Адамыг бүтээснийхээ дараа түүнд “Хүн ганцаараа байх нь сайн биш” хэмээн хэлжээ (Эхлэл 2:18). Дараа нь Тэр Еваг бүтээв. Адам Евагүйгээр бүрэн бус байв. Учир нь түүнгүйгээр Адамд өөр харилцах хүн байсангүй. Чухамдаа Адам болон Ева хамтдаа Бурханы дүр төрхийг тусган авсан гэсэн санааг бичвэрт “Ийнхүү Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр бүтээхдээ эр эмээр нь бүтээжээ” гэсэн байдаг (Эхлэл 1:27). Адамд өөрт нь байснаас ч илүү, Адам, Ева хоёрын харилцаанд хамтдаа Бурханы дүр төрхийг тусгасан ямар нэгэн зүйл байсан бололтой.

Энэ нь бидний хувьд ямар утгатай болохыг бодож үзээрэй. Гурвалын бодгалиуд шиг бусадтай харилцахгүй л бол бид бүхэл бүтэн хүн байж чадахгүй. Энэ нь бид заавал гэрлэх ёстой гэсэн үг биш (тэнгэрийн улсад хэн ч гэрлэхгүй, гэхдээ бид бодгаль хэвээр байх болно), харин бид бусадтай нөхөрлөх хэрэгтэй юм.

Бурханы дүр төрхийг тусгах талаар

Бурханы мөн чанар болон чуулганы мөн чанарыг хооронд нь харьцуулсан гайхалтай харьцуулалт байдаг. Бурхан болон чуулганы аль алинд нь нэгдмэл болон онцлог ялгаа бүхий талууд бий. 1 Коринт 12-р бүлэгт Христийн Биеийг зорилгынхоо төлөө хамтдаа ажилладаг олон хэсгээс бүрдсэн нэгдэл болохыг хэлсэн. Христийн Бие Бурханы дүр төрхийг хэрхэн тусган харуулж байгааг та харж байна уу? Паул чуулганы янз бүрийн гишүүд хамтдаа Христ дотор нэг болж өсөхийг хүсэмжилж байсан. Паул биднийг ийм байгаасай гэж залбирчээ:

үнэнийг барьж, ингэхдээ харин хайранд, тэргүүн болох Түүн өөд, Христ өөд бүх талаар өсцгөөе. Хэсэг нэг бүрийн зохистой үйл ажиллагааны дагуу холбоос болгоноос хангаж байдаг зүйлээр хамтдаа холбогдон нийлж буй бүхэл бие нь Христээр хайр дор өөрийгөө босгон барихын тулд биеийн өсөлтийг бий болгодог (Ефес 4:15-16).

Бид бүгдээрээ Христийн нэгдмэл байдалд өсөхөд бие биедээ туслахын тулд өөрсдийн бэлэг авъяас, чадвараа ашиглах ёстой. Нигүүлсэл дотор өсөхөд нь бие биедээ туслах байдлаар бид Түүний харилцааны мөн чанарыг тусган харуулахыг Бурхан хүсдэг. Сүнслэг өсөлт нь бусад итгэгчидтэй ойр дотно нөхөрлөлд өөрсдийгөө зориулж буй хамт олны дунд явагддаг. Энэ нь Бурханы нийтэч хамтын мөн чанарыг тусган харуулдаг.

Гурвалын гишүүд нь мөнхөд бие биедээ өөрсдийгөө зориулах хайр дотор амьдарч байгаа шиг бид ч бусадтай хайрын харилцаанд амьдрах учиртай юм. Бид Бурханы дүр төрхөөр нийгмийн харилцаанд байхаар бүтээгдсэн тул өөрөөсөө илүү бусдад анхаарал хандуулах хэрэгтэй. Бид хувийн онцлогоос илүүтэй хамт олныг чухалд тооцох ёстой. Бид бусадтай харилцах харилцаандаа Түүний Гурвалын дүр төрхийг тусгахыг хичээх үед Бурхан биднийг ерөөх болно.

Гурвалыг мөргөн хүндэтгэх

Гурвалыг мөргөн хүндэтгэх нь Ариун Сүнсний тусламжтайгаар, Хүүгийн эвлэрүүллийн ажлын үндсэн дээр Эцэгийн өмнө ирдэг гэдгийг бид хүлээн зөвшөөрдөг. Гурвалыг хүндлэгчдийн хувьд бид Хүүгээр дамжуулан, Сүнс дотор, Эцэгт залбирдаг.

Мөргөл хүндэтгэлийн чухал зорилго бол Гурвалын гишүүд бие биенээ хайрладаг тэрхүү хайрын харилцаанд орох явдал юм. Эцэг Хүүгийн хооронд байдаг хайрын талаар бодож үзээрэй. Энэхүү хайрыг таньж мэдэхийн тулд Христ загалмай дээр

“Төгс хүчит, мөнхийн Бурхан минь ээ, Та бидэнд, Өөрийн үйлчлэгч нартаа мөнхийн Гурвалын суу алдрыг хүлээн зөвшөөрөх жинхэнэ итгэлийн гэмшлийн тусламжтайгаар нигүүлслээ өгсөн билээ. Бид тэнгэрлэг сүр хүчээр тань Таны эв нэгдлийг дээдлэн хүндэтгэж байна. Дайсагнагч бүгдээс үүрд хамгаалах энэхүү итгэл дотор биднийг бат байлгаж өгөөч. Нэг Бурхан Тантай болон Ариун Сүнсстэй хамт байж захирдаг бидний Эзэн Есүс Христээр дамжуулан одоо ба үүрд мөнхөд тийм байх болтугай, Амен.”
- Нийтийн залбирлын ном

юу хийснийг эргэцүүлээрэй. Эцэг Хүү хоёр гайхалтай харилцаан дотор хамт амьдардаг бөгөөд Хүүгийн эвлэрүүллийн ажлын улмаас Сүнс биднийг тэрхүү дотно хайрын харилцаанд ороход тусалдаг.

Гурвалыг хүндлэгчдийн хувьд бид зөвхөн Эцэгт, Сүнс дотор, Хүүгээр дамжуулан залбираад зогсохгүй, Эцэгт, Хүүд, мөн Сүнсэнд хандан залбирдаг. Гурвалын гишүүн бүрийг хүндлэн биширч, алдаршуулах ёстой. Учир нь тэд бүгд Бурхан бөгөөд адил тэнцүү өргөмжлөгдөх зохистой. Гурвалыг мөргөн хүндэтгэх нь Гурвалын гишүүн бүрд адил тэнцүү алдар хүндлэлийг авчирах бөгөөд бидний авралд тэд ямар үүрэг гүйцэтгэдэг болохыг хүлээн зөвшөөрч буй хэрэг юм.

Гурвалын талаарх алдаатай онол сургаалаас зайлсхийх

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Бүлгийн нэг гишүүн энэхүү хэсгийг тайлбарлана уу.

Үр яагаад шороонд ургадаг, тархи хэрхэн ажилладаг, ямар хүч оддыг байранд нь байлгадаг зэргийг бид ойлгодоггүй. Эрдэмтэд юу болж байгааг ажигладаг ч яагаад, хэрхэн энэ бүхэн тохиолдож буйг тайлбарлаж чаддаггүй. Хүн Гурвалын талаарх онол сургаалыг бүрэн тайлбарлаж чадахгүй учраас үүнийг үгүйсгэх нь утгагүй юм. Бурханы талаарх онол сургаал бүр бидний тайлбарт баригдахгүй, үүнийг даван гардаг. Жишээлбэл, Бурхан хэрхэн хаа сайгүй байж, бүх зүйлийг мэддэг болохыг хэн ч тайлбарлаж чадахгүй. Гурвалын талаарх баримтууд нь огт логикгүй биш боловч тэдгээр нь хүний томъёолол болон мэдлэг туршлагыг ч давсан байдаг. Далайн загас хэдий ухаантай байгаад түүнд тайлбарлан хэлсэн ч, хүн байх ямар байдгийг хэзээ ч ойлгож чадахгүйтэй адил.

Гурвалын талаарх баримт нь мөн чанараараа болон бурхан чанараараа ижил тэнцүү гурван бодгаль дотор оршдог нэг Бурханы тухай юм. Хүмүүс үүнийг тайлбарлах гэж оролдсон боловч ихэнхдээ гол чухал хэсгийг нь орхигдуулдаг. Тэдгээр зарим алдааны жишээг энд дурдъя.

- 1. Бурхан бол өөр өөр үүрэг гүйцэтгэдэг үнэхээр нэг бодгаль юм.** Энэ онолын дагуу Бурхан тэнгэрт Эцэг, газар дээр Есүс байсан бөгөөд одоо Ариун Сүнс болон бидэнд ярьж байна гэж үздэг. Гэвч Иохан 14-16-р бүлэгт Есүс Өөрийгөө Эцэгтэй, Ариун Сүнстэй аль алинтай нь харилцаж байгаагаар дүрслэн өгүүлсэн байдаг. Хэрэв тэд гурван өөр бодгаль биш байсан бол энэ тайлбар утгагүй болно.
- 2. Эцэг, Хүү, Ариун Сүнс нь салангид тусдаа оршихуй юм.** Энэ онолын дагуу тэдний мөн чанар ялгаатай байж болно гэж үздэг. Жишээлбэл, Эцэг нь шүүхийг хүсдэг бол харин Хүү нь өршөөл үзүүлэхийг хүсдэг гэх мэт. Энэ санаа нь цорын ганц Бурхан байдаг гэсэн Библийн онол сургаалтай зөрчилддөг.
- 3. Гурвалын нэг нь нөгөөгөөсөө доогуур зэрэглэлд байдаг.** Энэ онолын дагуу Эцэгийг Бурхан, харин Хүү болон Ариун Сүнс нь арай дорд оршихуй гэж үздэг. Ингэж итгэдэг хүн Ариун Сүнсний бодгаль шинжийг үгүйсгэж, Хүүг Бурханд хэрэглэгдсэн онцгой нэгэн хүн байсан хэмээн боддог. Энэхүү алдаа нь хүмүүсийг

Хүү болон Ариун Сүнсийг Бурхан гэж мөргөн хүндэтгэхгүй байх шалтгаан болж, улмаар тэднийг хуурамч сайнмэдээ рүү дагуулж болзошгүй юм.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Бурхан бол Гурвал бөгөөд Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн гурван бодгалиар орших нэг Бурхан юм. Гурвал нь үүргийн хувьд ялгаатай ч, мөн чанараараа ижил, бурхан чанараараа эн тэнцүү, адил хэмжээнд мөргөл хүндэтгэлийг хүртэх зохистой Нэгэн мөн.

3-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Иохан 15:26
- Иохан 17:1-5
- Ефес 1:17-23
- Колоссай 1:12-19
- Еврей 1:1-3, 8

(2) Сорил: Дараагийн хичээлийг 3-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

3-р хичээлийн сорил

(1) Орчлон ертөнц хэрхэн Бурханы мөн чанарыг дүрслэн харуулдаг вэ?

(2) Гурвалын талаарх онол сургаалын суурь болсон гурван үндэслэл юу вэ?

(3) Гурвал хоорондын харилцааны бүтэц юу вэ?

(4) Гэр бүл болон чуулганы бүтцийг Гурвалын бүтэцтэй хэрхэн харьцуулж болох вэ?

(5) Гурвалд итгэгчдийн хувьд бид хэнд хандан залбирах ёстой вэ?

(6) Гурвалын талаарх нийтлэг гурван буруу онол сургаалыг нэрлэнэ үү?

4-р хичээл

Хүн төрөлхтөн

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Хүмүүний доторх Бурханы дүр төрх нь бие махбодтой төстэй биш гэдгийг бид хэрхэн мэдэх вэ?
- Хүмүүний доторх Бурханы дүр төрхийн найман шинж.
- Хүмүүс Бурхантай харилцахын тулд онцгой бүтээгдсэн.
- Хүмүүст байдаг чөлөөт сонголтын (хүсэл) мэдрэмж.
- Хүмүүс энэ дэлхийн амьдрал дахь практик үнэ цэнээсээ хязгааргүй үнэ цэнтэй.
- Хүн төрөлхтний талаарх христэч итгэл үнэмшил

(2) Суралцагч нь хүн Бурхантай харилцахгүйгээр бүрэн гүйцэд бодгаль байх боломжгүй гэдгийг ойлгох болно.

Хүн төрөлхтөн – Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн

► Дуулал 8-ыг хамтдаа унших. Энэ багц эшлэлд хүн төрөлхтний талаар юу гэж хэлсэн бэ?

► Дэлхий дээрх хүн бүрийн ижил төстэй тал нь юу вэ?

Биднийг тодорхойлох зүйл юу байж болох талаар бодож үзээрэй. Хүн байна гэдэг нь чухамдаа юу гэсэн утгатай вэ?

► Эхлэл 1:26-27-г хамтдаа унших.

Бидний мөн чанарт Бурхантай адил зүйл байдаг. Бид Бурхан биш хэдий ч, биднийг амьтны ертөнцөөс тусгаарлаж, өвөрмөц болгодог нэг зүйл бий. Дуулал 8:5-д биднийг тэнгэрлэг нэгнээс арай доогуур бүтээж, алдар хүндийн титэм өмсгөсөн хэмээн бичжээ.

Бурхан хүмүүнд газар дэлхий болон түүн дээр амьдрах амьтдыг удирдах онцгой үүрэг хариуцуулжээ (Дуулал 8:6). Хүмүүс бид хойч үедээ газар дэлхийг сайн сайхан нөхцөлд үлдээхийн тулд нөөц баялгийг зөв ашиглаж, амьд төрөл зүйлс устаж алга болохоос сэргийлж, эх дэлхийгээ анхаарал болгоомжтой удирдан авч явах учиртай юм.

Хүн төрөлхтний талаарх энэхүү дээд үзэл баримтлал нь хувьслын онолтой харьцуулбал бид өөртөө хүндэтгэлтэй хандах тал дээр илүү дээр байх нь гарцаагүй! Хувьслын онол

сургаалд хүний амьдралын зорилго, утга учир, хүн байхын ач холбогдол зэргийн талаар онцгой зүйл байдаггүй.

Эртний зарим домогт хүн санамсаргүйгээр, ямар ч зорилгогүй бий болж, ямар нэгэн бүтээгчээр хайрлуулж байгаагүй мэтээр дүрслэгддэг. Гэвч Библид биднийг Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн онцгой бүтээл хэмээн заасан байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ?

Хүмүүний доторх Бурханы дүр төрх нь бие махбодтой төстэй гэсэн үг биш юм.

► Хүмүүний доторх Бурханы дүр төрх нь бие махбодтой төстэй биш гэдгийг бид хэрхэн мэдэх вэ?

(1) Бурхан бол сүнс (Иохан 4:24). Бүх тэнгэр газар Бурханыг багтааж чадахгүй гэдгийг Соломон ухаарчээ (1 Хаад 8:27). Бурхан ямар ч дүр төрхөөр Өөрийгөө харуулж чадах ч яг Бурхан шиг харагдах нэг ч дүр төрх байхгүй. Энэ нь бид Бурханыг мөргөн хүндлэхийн тулд ямар нэгэн дүрс, төрхийг бүтээх ёсгүй гэдгийн нэг шалтгаан болдог.

(2) Бурханы дүр төрхийг хүн шиг болгох нь шүтээн шүтэх явдал юм (Ром 1:23, унших).

(3) Хүмүүс бие махбодын хувьд газар дэлхий дээр амьдрахаар бүтээгдсэн

Хөл нь алхахад, гар нь аливааг хөдөлгөхөд, харах болон сонсох эрхтэнтэй гэх мэт. Бурхан биднийг газар дэлхий дээр амьдрахаар бүтээсэн. Харин Бурхан бүхэл бүтэн орчлон ертөнцөд амьдардаг. Тэр Үгээрээ аливаа зүйлийг бүтээж, хөдөлгөж чаддаг. Биднийг хязгаарладаг ямар ч зүйл Түүнд үгүй. Түүнийг хүний бие махбодтой гэж үзэх үндэслэл байхгүй.

Хүн төрөлхтөнд өгөгдсөн Бурханы дүр төрхийн бүрэлдэхүүн хэсэг

► Бурханы дүр төрхийг тусган харуулдаг хүний зарим шинж юу вэ?

Теологичид хүн Бурханы дүр төрхийг тээдэг гэдэг нь юу гэсэн утгатай болох талаар маш их эргэцүүлж тунгаасан бөгөөд ихэнх нь дараах шалгуур дээр санал нэгддэг.

Бүтээлч инстинкт

Бурханы дүр төрхөөс улбаалан гарч ирдэг бүтээлч чанар бидэнд байдаг. Бүтээгч маань биднийг бүтээлч байхаар урлажээ! Заримдаа амьтдыг дохио зангаа хийхэд сургасан байдаг. Үүнийг нэг төрлийн урлаг гэж хүмүүс ярьдаг. Гэхдээ энэ нь санаагаа илэрхийлж байгаа хүний туурвих уран бүтээлээс тэс өөр. Эртний хадны сүг зургуудыг бид мэднэ. Тэдгээрийг зурсан хүмүүсийн талаар бид сайн мэдэхгүй ч амьтан биш, хүн эдгээрийг урласан гэдэгт эргэлздэггүй.

Бүтээлч байдал нь хөгжимд илэрдэг. Хөгжим нь бидний бодол санаа, мэдрэмжийг илэрхийлэх гайхалтай чадамжтай. Хөгжмөөр дамжуулан санаа бодлоо илэрхийлэх чадвар нь бидний доторх Бурханы дүр төрхөөс үүдэлтэй.

Сэтгэн бодох чадвар

Сэтгэн бодох чадвар бол Бурхантай адил төрлийн чадвар юм. Бидний мэдэж байгаагаар, амьтад бас тархитай ч тархины үйл ажиллагаа нь үндсэн хариу үйлдэл, зөн совингийн түвшинд явагддаг аж. Харин зөвхөн хүн л дүн шинжилгээ хийх, үнэлэх, эргэцүүлэн бодох, түүнчлэн бусдад нөлөөлөх байдлаар санаа бодлоо илэрхийлж чаддаг.

Бид дан ганц сэтгэн бодоод зогсохгүй, бодож байгаага ч бодох чадвартай. Бид сэтгэн бодох үйл явцаа ч дүгнэн шинжилж чаддаг. Бид зөвхөн логигоор сэтгээд зогсохгүй, логикийн талаар бодож чадна.

Харилцах чадвар

Хүмүүс харилцах чадвартай. Энэ нь санааг бусад хүмүүсийн ойлгох дуу авиа, дохио тэмдэг болгон хэлний тусламжтайгаар илэрхийлж байна гэсэн үг. Нохой, шувуу гэх мэт амьтад дуу авиагаар харилцаж болох ч тэдэнд хүний хэл ярианд байдаг шиг нарийн төвөгтэй зүйл үгүй юм. Амьтад өөр хоорондоо дайсагнах, газар орноо булаалдах, хоол хүнсээ хуваалцаж болох ч тэд амьдралын утга учрын талаар ярилцах боломжгүй.

Харилцах чадвар нь сэтгэн бодох, учир шалтгааныг тунгаах чадвараас хамаардаг. Амьтад үг хэлж чаддаггүй бөгөөд ингэж чадах байлаа ч тэдэнд ярих зүйл бараг байхгүй.

Нийгмийн мөн чанар

Хүн нийгмийн мөн чанартай. Бид бусад хүмүүстэй харилцах, бусдад зориулах, бусдаас хамааралтай байхаар бүтээгдсэн. Бидний амьдрал эхлэхдээ л бусдаас бүрэн хамааралтай эхэлдэг. Хүүхэд ахуй цагаас нас биед хүрэх хүртэл олон жил шаардагддаг. Бурхан харилцааг чухалчилдаг учраас тэр юм.

Өдөр тутмын хэрэгцээгээ хангахын тулд хүмүүс хамтран ажиллаж, харилцаагаа хадгалж байх замаар Бурхан хүний амьдралыг төлөвлөжээ. Хүн хоол хүнс, орон байраа хэний ч тусламжгүйгээр олж авч болох ч, бусадтай харилцах харилцаагаар л хангагдаж байдаг чухал хэрэгцээ хүнд бий. Хүн төрөлхтний нийгмийн мөн чанар Бурханы мөн чанарыг тусган харуулдаг. Бурхан Гурвал бөгөөд мөнхийн харилцаанд оршдог.

Хүний харилцаанд олон асуудал тулгардаг. Асуудлаас болоод зарим хүмүүс илүү бие даасан байх хэрэгтэй гэж боддог. Тэд хэнээс ч хамааралгүй амьдрахыг хүсдэг. Ганцаараа амьдрах нь шийдэл биш бөгөөд Бурханы бидэнд зориулж бүтээсэн амьдрал биш юм. Харин үүний оронд, харилцаан дотор амьдрах зарчмуудыг Тэр бидэнд өгсөн. Бид Бурханы загварыг дагахгүй байх үед асуудал үүсдэг.

Ёс суртахууны мэдрэмж

Мөн чанарын маань нэг хэсэг болох ёс суртахууны мэдрэмж бидэнд бий. Энэ нь бидний дотроос зарим зүйл зөв, зарим нь буруу гэдгийг хэлдэг (Ром 1:20, Ром 2:15, унших). Дур хүслээ хэзээ дагах нь зөв, хэзээ болохгүйг энэ нь хэлж өгдөг. Адам Ева хоёр ариунаар бүтээгдсэн бөгөөд Бурханы хүслийг төгс дагах чадвартай байв.

Хүн төрөлхтөн нүгэл үйлдэж, ёс суртахууны үндсэн ойлголт нь гэмтсэн учраас энэ нь бүрэн зөв биш хэдий ч, хүн бүрийн дотор зөв буруугийн талаарх үзэл баримтлалыг ойлгох чадвар байсаар иржээ.

Бид ёс суртахууны мэдрэмжтэй учраас зөвийг үйлдэх үүргээ ойлгож ухамсарладаг бөгөөд нүгэл хийх үед гэм буруутайг мэдэрдэг. Бид гэм буруугийн мэдрэмжгүй төрөлх зөнгөө (инстинкт) дагадаг амьтдаас ялгаатай.

Сонголт хийх чадвар

Чөлөөт хүсэл буюу сонгох чадвар нь хүний онцлог шинж юм. Үүний эсрэгээр, амьтдын сонголт нь агшин зуурын хариу үйлдэл инстинкт байдаг. Амьтад өөрсдийн үйлдлийнхээ ёс зүй, бодит үр дүнг харгалзсан, болгоомжтой сайтар тунгаасан шийдвэр гаргах боломжгүй. Харин хүн амьдралыг өөрчлөх хэмжээний утга учиртай сонголтыг гаргах чадвартай (Иошуа 24:15, унших).

► Яагаад чөлөөт хүсэл нь хүн төрөлхтний чухал хэсэг юм бэ?

Бид жинхэнэ сонголт хийдэг учраас Бурханы өмнө хариуцлага хүлээдэг. Тэрээр зөв шударгыг шагнаж, нүглийг шүүх болно (Илчлэл 20:12-13).

Бид төрөлхийн нүгэлт мөн чанартай учраас өөрсдийн чөлөөт хүслийг Бурханыг хүндэтгэх байдлаар ашигладаггүй. Хүн төрөлх чанараараа нүглийн боол (Ром 6:16-17, Ефес 2:1-3, унших) бөгөөд зөвийг үйлдэх чадваргүй боловч Бурханы нигүүлсэл хүн бүрд хүрч, сайнмэдээнд хариу үйлдэх хүсэл, чадварыг олгодог. Тийм ч учраас хүн гэмшиж, сайнмэдээнд итгэх сонголтыг хийж чаддаг (Марк 1:15, унших).

Үхэшгүй мөнх байдал

Үхэшгүй мөнх байдал нь Бурханы дүр төрхийн чухал шинж чанар юм. Бид оршин байгаагүй цаг үе байсан бол харин эхийн хэвлийд бүрэлдсэн цагаас хойш хүн бүр үүрд орших болно. Бид дан ганц бие махбод биш, харин мөнхөд орших сүнснүүд бөгөөд бидний бие хүртэл мөнхийн дүр төрхөөр амилах болно (1 Коринт 15:16-22, 52-54, унших). Бурхан бидний хүн нэг бүрийг мөнхийн зорилгоор бүтээсэн. Үхэшгүй мөнх байдал нь бидний сонголтыг мөнхийн ач холбогдолтой болгодог учраас бид нэг бол тэнгэрийн улсад, эс бөгөөс тамд мөнхөд амьдрах болно.

“Өнөө цагт хүмүүс хүн байх тухай, хүний жинхэнэ мөн чанарын талаар их ярих болсон. Гэсэн ч яагаад ийм байгаад хариулж мэддэггүй. Учир нь тэд хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдгийг ухаардаггүй... Эрчүүийг машин гэж олон давтан хэлэхэд энэ нь тэдний үйлдлээс төд удалгүй илэрч эхэлдэг. Бидний соёл хэрхэн бодитоор нөлөөлдөг жишээ бол энэ.”
– Френсис А. Шеффер

Хайрлах чадвар

Хайрлах чадвар нь Бурханы дүр төрхийн нэг хэсэг юм. Амьтад хоорондын харилцаа нь маш хязгаарлагдмал бөгөөд ихэвчлэн инстинктээр удирдуулдаг.

Хүн төрөлхтний бусад шинж чанарууд нь үүнд их чухал юм. Хэрэв бид харилцах чадваргүй, хайртай хүмүүсээ сонгох, тэдэнд зориулах чадваргүй, бусдаас хайрыг хүлээж авахдаа ойлгож, хариу үйлдэх чадваргүй байсан бол хайр нь ямар ч утга учиргүй байх байсан.

Хүний хайр нь харилцаанаас ирэх баяр хөөр, амлалт өгөх болон амлалтаа сахих, золиостойгоор өгөх болон үйлчлэх, уучилж өршөөх зэргээр илэрхийлэгддэг. Энэ бүхэн бүгд Бурханы хайрын илэрхийлэл юм.

Мөргөн хүндэтгэх чадвар

Энэ нь маш чухал шинж чанар юм. Өөрийнхөө дуртай хүндэтгэл магтаалын дуулал болон шүлгийг бодож үзээрэй. Бид “Бидний Бурхан бол агуу Бурхан” “Та ямар агуу юм бэ” гэж дуулдаг. Эдгээр нь бүх цаг үед бидний дуулдаг мөргөл хүндэтгэлийн дуулал юм. Дууллыг бичигч “ЭЗЭНийг магтагтун. Дотор минь байгаа бүгд Түүний ариун нэрийг магтагтун” (Дуулал 103:1) хэмээн илэрхийлж буй нь бидний доторх Бурханы дүр төрх дүр төрхөөр нь бүтээгдсэн Бурханаа таньж, ийнхүү хариу үйлдэх боломжтой учраас тэр юм!

Хүмүүний доторх Бурханы дүр төрхийн зорилго

Бурхан яагаад биднийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн талаар хэсэг хугацаанд бодох нь зүйтэй. Бид яагаад бусад бүтээлээс тийм их ялгаатай байна вэ? Хариулт нь бид Бурхантай харилцаж, Түүнийг мөргөн хүндлэхийн тулд онцгойлон бүтээгдсэн юм.

Бүтээл нь ерөнхий байдлаараа Бурханыг алдаршуулдаг гэж Библи өгүүлдэг. Бурханы бүтээсэн зүйлсээс Бурханы агуу байдлыг бид олж хардаг. Харин бусад амьтдын хувьд тэд Бурханы талаар ойлголтгүйгээр алдаршуулдаг. Тэд Бурханыг ямар болохыг ойлгож чадахгүй, учир нь тэдэнд Түүнтэй харилцах мөн чанар байхгүй.

Бидэнд зарим бүтээлч чадвар байгаа учраас Бурханы хязгааргүй бүтээлч байдлыг биширч чадна. Бид зөв бурууг мэдэрдэг учраас Түүний ариун, зөв шударга байдлыг мөргөн хүндэлж чадна. Бид хайрлах чадвартай учраас Түүний хязгааргүй хайрыг биширдэг.

Бид Бурханыг зөвхөн оюун ухааны мэдлэгээр төдийгүй харилцахдаа илүү сайн таньж мэддэг бөгөөд ингэснээр Түүнийг илүү хайрлаж, мөргөн хүндэлдэг. Бурхан биднийг ийм харилцаанд байхаар бүтээсэн учраас бид Бурхантай харилцахдаа баяр хөөр, сэтгэл хангалуун байдлыг олж авдаг.

Бусад чухал санаанууд

(1) Бүх хүн Бурханы дүр төрхтэй (Эхлэл 1:27). Сэтгэцийн хязгаарлагдмал байдлаас болоод зарим хүмүүс сэтгэх, өөрийгөө бүтээлчээр илэрхийлэх, чөлөөт хүслээ ашиглах боломжгүй байдаг. Бурханы дүр төрх тэдний дотор бүтээгдсэн хэдий ч энэ нь тэдний газар дэлхий дээрх амьдралд биеллээ олохгүй байж болох юм.

(2) Хүн бүрийн амьдрал мөнхийн бөгөөд хязгааргүй үнэ цэнтэй. Заримдаа бид хүний үнэ цэнийг түүний оюун ухаан, боловсрол, авьяас чадвар, хүч чадал зэрэг практик байдлаар тодорхойлдог. Харин хүн бүр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас энэхүү практик үнэ цэнээс хавьгүй чухал эрхэм юм. Тийм ч учраас хэдийгээр тухайн хүн практик үнэ цэн бүхий зүйлээр дутмаг, тэр ч бүү хэл хорон муу хүн байлаа ч хүн гэдгийн хувьд хүндлэл хүлээх зохистой. Хүүхэд болгон Бурханд үнэ цэнтэй гэдгийн шалтгаан нь энэхүү Бурханы дүр төрхтэй холбоотой юм. Тиймээс үр хөндөлт бол аймшигтай нүгэл мөн (Эхлэл 9:6, Дуулал 139:13-14, Исаиа 44:24).

(3) Тэнгэрэлч нар бүтээлийн дотор онцгой байр суурь эзэлдэг. Тэд оюуны өндөр чадамжтай, сэтгэн бодох, харилцах, мөргөн хүндлэх чадвартай. Тиймээс тэдэнд Бурханы дүр төрхийн зарим тал байдаг бөгөөд Бичвэрт тэднийг Бурханы хөвгүүд хэмээн нэрлэсэн байдаг (Иов 1:6). Бид одоохондоо тэнгэрэлч нараас арай доогуур (Дуулал 8:5) боловч тэд бидэнд үйлчилдэг (Еврей 1:14). Өнө мөнхийн цаг хугацаанд бид тэнгэрэлч нараас өндөр байр суурьтай байх болно (1 Коринт 6:3, унших). Түүнчлэн бид Христтэй хамт захирна. Энэ нь хүн тэнгэрэлчээс илүүтэй Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн болохыг харуулдаг.

(4) Газар дэлхий анх бүтээгдсэн хэлбэрээрээ байдаггүй. Авьяаслаг зураачийн зурсан сайхан бүтээл байна гэж төсөөлье. Уран зураг шалан дээр шидэгдсэн, хүмүүс шавхайтай гутлаар дээгүүр нь гишгэлсэн гэж бодъё. Ийм зургийг харахдаа та тухайн уран бүтээлчийн анх дуусгаж байсан үеийнхтэй нь адилгүй бүтээлийг харах ч, түүнийг урласан гайхамшигтай авьяасыг төвөггүй олж харна. Бүтээл гэдэг ийм л байдаг. Энэ нь Бурхан анх ямар байгаасай гэж зорьсонтой яг адилхан биш ч, Түүний алдрыг одоо ч тусган харуулсаар байдаг.

(5) Хүмүүсийн доторх “Бурхантай адил” чадварууд нь нүглээс болж гажуудсан. Жишээлбэл, Бурханаас бэлэг болон ирдэг уран сайхны илэрхийллүүд нь хорон муу зүрх сэтгэлийг илчилж болох ч энэ нь Сатаны хэрэгсэл байх боломжтой. Гэсэн хэдий ч, нигүүлсэл хөндлөнгөөс оролцсон тул нүгэл бидний доторх Бурханы дүр төрхийг бүрэн устгаагүй юм. Нигүүлслээр бидний доторх Бурханы дүр төрх Бүтээгчийн алдрын төлөө шинэчлэгдэж, хөгжиж, илэрхийлэгдэх боломжтой! (Колоссай 3:10; Ефес 4:22-24; 2 Коринт 3:18, унших)

(6) Бидний доторх Бурханы дүр төрх нь бидний хувьд хамгийн чухал зүйл юм. Бидний доторх Бурханы дүр төрх нь сайнмэдээнд хариу үйлдэх боломжийг бидэнд олгодог. Бидний ёс суртахууны мэдрэмж нь нигүүлсэл мөс чанарыг маань сэрээж, нүгэлд буруутгах боломжтой болгодог. Бидний дотор ажиллаж байгаа нигүүлслээр

сэргээгдсэн чөлөөт хүсэл нь хэнд үйлчлэхээ сонгох боломжийг бидэнд олгодог. Бүтээлч инстинктээр дамжуулан бид Бурханд алдар, хүндлэлийг авчрах боломжтой. Учир шалтгааныг тунгаах байдал маань нууцлагдсан үнэнийг эрэлхийлж, Бурханы тухай болон Түүний арга замуудыг ойлгоход тусалдаг. Бидэнд алдар, хүндэтгэлийн титмийг зүүх Бүтээгчийнхээ туйлын гайхамшигт чанарыг улам бүр ухаарах тусам Бурханыг таньж мэдэх эрэл хайгуул нь мөргөл хүндэтгэл болон хувирдаг!

Алдаанаас зайлсхийх:

Заримдаа хүмүүс Бурхантай харилцах харилцаа нь зөвхөн үхлийн дараах амьдралд л чухал ач холбогдолтой гэж ойлгодог. Хэрэв хүн газар дэлхий дээр л сайхан амьдарч байвал Христэд итгэгч байх үгүй нь хамаагүй гэж тэд боддог. Гэвч хэрэв бид хүн төрөлхтний мөн чанар нь Бурхантай харилцахад зориулагдсан гэдгийг ухаарвал Бурханыг таньж мэдэхгүй байх нь ихэнхдээ цаг хугацааг дэмий үрсэн амьдрал болохыг ойлгодог. Бидний дотор байж, биднийг чиглүүлж, чадавхийг маань гүйцэлдүүлэх, бидний хийж буй бүх зүйлд өнө мөнхийн хэтийн төлвийг өгөх Бурханы Сүнс бидэнд хэрэгтэй.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Хүн Бурханыг хайрлаж, Түүнийг мөргөн хүндлэхийн тулд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Бурхан хүмүүсийг сэтгэн бодох, харилцах, хайрлах чадвартай бүтээсэн. Хүнд ёс суртахууны мэдрэмж, хувийн хүсэл, үхэшгүй мөнхийн сүнс байдаг. Бурханы нигүүлсэл нь хүнд чөлөөтэй шийдвэр гаргах хүчийг өгдөг. Хүн бүрийн амьдрал мөнхийн бөгөөд хязгааргүй үнэ цэнтэй.

4-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Эхлэл 3:1-6
- Иошуа 24:14-18
- Ром 6:12-23
- Ром 8:22-26
- Ефес 2:1-9
- 1 Тесалоник 5:23
- Иаков 1:12-15

(2) Сорил: Дараагийн хичээлийг 4-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

4-р хичээлийн сорил

(1) Эхлэл 1:26-27-д хэлсний дагуу хүмүүс бусад бүтээлээс ямар байдлаараа өвөрмөц ялгаатай вэ?

(2) Хүмүүний доторх Бурханы дүр төрх нь бие махбодтой төстэй биш гэдгийг мэдэж болох гурван шалтгааныг нэрлэнэ үү?

(3) Хүмүүний доторх Бурханы дүр төрхийн бүрэлдэхүүн хэсгээс долоог жагсаана уу (аль ч долоог нэрлэж болно).

(4) Бурханы дүр төрхөөр биднийг бүтээсэн хоёр зорилго юу вэ?

(5) Ямар чадвар ёс суртахууны мэдрэмжээс гардаг вэ?

(6) Хүмүүс жинхэнэ сонголт гаргах чадвартай байх нь ямар ач холбогдолтой вэ? (аль нэгийг нэрлэнэ үү)

5-р хичээл

Нүгэл

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Нүглийн гарал үүсэл.
- Нүглийг Библид хэрхэн тодорхойлсон талаар.
- Удамшсан завхралын тодорхойлолт болон тайлбар.
- Санаатайгаар үйлдэх нүглийн талаарх Библийн ойлголт.
- Нүглийн талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь санаатай үйлдэх нүгэл юу болохыг тодорхойлсноор итгэлд ирэх талаар илүү ойлголттой болно.

Танилцуулга

► Эхлэл 3-р бүлгийг хамтдаа унших. Энэхүү багц эшлэлд нүглийн талаар юуг өгүүлсэн бэ?

► Бид яагаад нүглийн талаар ойлгож мэдэх шаардлагатай вэ?

Бид нүглийг ойлгох ёстой. Ингэснээр:

- 1. Дэлхий ертөнцийн нөхцөл байдлыг ойлгоно.** Хүний зовлонгийн шалтгааныг нүгэл гэж Библид хэлсэн. Нүглээс болж үхэл дэлхий ертөнцөд нүүрлэжээ (Ром 5:12, унших). Нүглийн үр дагавар хараалаас болж хүн өвдөж, зовж, хөгширөх болсон. Худал хэлэх, хулгай хийх, аллага, завхайр, архидан согтуурах, дарамтлах зэрэг нүглийн үйлс нь дэлхийг зовлонгоор дүүргэсэн. Нүглийн үйлс нь үзэн ядалт, тачаал, шунахайрал, бардамнал, хувиа хичээх зэрэг зүрх сэтгэл дэх нүглээс үүдэлтэй.
- 2. Нигүүлсэл ба авралыг ойлгоно.** Бурхан биднийг нүглээс аврах нигүүлслийг өгдөг (Матай 1:21; Ром 5:20-21).
- 3. Ариун байдлыг ойлгоно.** Нүгэлтэй байх нь ариун байдлын эсрэг юм. Энэ нь мөн Бурханд үнэнч байхын эсрэг зүйл. Хүн Бурханы хүсэж хүлээж байгаачлан ариун байхын тулд нүглээс салах ёстой (1 Петр 1:15-16).

Нүглийн гарал үүсэл

Бурханы бүтээл төгс байсан бөгөөд Түүний бүтээсэн бүхэн өө сэвгүй байв. Бурхан бүтээлээ дуусгаад энэ нь маш сайн байсныг харжээ (Эхлэл 1:31). Тиймээс нүгэл нь Бурханы буруугаас болоогүй гэдгийг бид мэддэг.

Адам Ева хоёр Бурхантай харилцаатай байсан. Тэд Бурханыг баярлуулахыг хүсэж, зөв бүхнийг хийх чадвартай байжээ. Еваг Бурханд дуулгаваргүй байхад уруу татахаар Сатан түүн дээр ирсэн. Үүгээр бид нүгэл орчлон ертөнцөд аль хэдийн оршиж байсныг мэдэх боломжтой. Түүнчлэн Сатан аль хэдийн нүгэл үйлдсэн байв. Гэсэн хэдий ч, нүгэл нь хүн төрөлхтөнд эсвэл хүний эрх мэдэлд байсан бүтээлийн хэсэгт хараахан орж ирээгүй байсан юм.

Адам Ева хоёрт чөлөөт хүсэл байв. Тэд жинхэнэ сонголт хийх чадвартай байсан учраас нүгэл үйлдэх боломжтой байжээ. Тэд Бурханы хуулийг зөрчихийг сонгосон бөгөөд энэ нь хүний нүглийн эхлэл байсан юм.

Нүглийн анхны үйлдэл нь хүн төрөлхтнийг Бурханаас салгасан. Түүнчлэн нүгэл хүн төрөлхтний мөн чанарыг завхруулжээ (Дуулал 51:5, унших). Үүнээс хойш хүүхэд бүр ялзарсан мөн чанартай төрж, нүгэл үйлддэг болжээ (Ром 5:12, 14, 18-19, унших).

Нүгэл бүх бүтээлд хараалыг авчирсан (Эхлэл 3:16-19). Нүглийн улмаас амьдрал өөрчлөгдөж, өвдөж, хөгширч, үхдэг болсон (1 Коринт 15:22, унших). Ажиллаж, амьд үлдэх нь хүнд хэцүү болжээ. Хүний харилцаа зөрчлөөр дүүрсэн. Он жилүүд улиран өнгөрөх тусам хүмүүс үржин олширч, нүглийн үр дагавар Адам Ева хоёрын төсөөлж байснаас ч илүү ихээр олшров.

Нүглийг илэрхийлдэг еврей, грек үгс

Ихэнх хэлэнд нүглийг ойролцоо утгатай өөр өөр үгээр илэрхийлдэг. Бичвэрийн эх хэл болох еврей, грек хэлэнд мөн нүглийг тодорхойлж, илэрхийлсэн ялгаатай олон үгс байдаг бөгөөд тэдгээрийг доор тайлбарлав. Эдгээр үгсийг хамтад нь авч үзвэл нүглийн талаар бүрэн дүүрэн зураглалтай болно.

- **Нүгэл нь эрх мэдлээс татгалзах – эсэргүүцэл, тэрслэл юм** (Дуулал 51:1). Иаков Лабанд хандан түүний эсрэг ямар гэмт үйлдэл хийснийг хэлэхийг шаардан уурсахдаа энэхүү еврей үгийг ашиглажээ (Эхлэл 31:36). Энэ үгээр мөн Моабын хаан Иехорам хааны эсрэг хийсэн үйлдлийг дүрсэлдэг (2 Хаад 3:7).
- **Нүгэл нь гажуудуулах, мушгин гуйвуулах буюу – муруйлгах эсвэл ээдрээтэй болгох явдал юм** (Дуулал 51:2а). Сатан юуг ч бүтээж чадахгүй бөгөөд бүх нүгэл нь Бурханы бүтээсэн сайн зүйлсийг гуйвуулсан гажуудал байдаг.
- **Нүгэл нь байгаа онохгүй байх, зорилгодоо хүрэхгүй байх явдал юм.** Дуулал 51:26-д хэлэгдсэн нүгэл гэдэг еврей үг ийм утгатай. Шүүгчид 20:16-д мөн адил үгийг үсний ширхэг бүрийг алдалгүй харвах чадвартай 700 солгой дайчдыг нэлээн хэтрүүлэгтэй байдлаар дүрслэхэд ашигласан байдаг. Нүгэл нь Бурханы зөв шударга, ариун байдал болон үнэний хэмжүүрт хэзээ ч хүрдэггүй.

“Нүгэл Бурханы хүүхэд хоёр хоорондоо тохирохгүй. Тэд хааяа уулзаж болох ч [гэхдээ] эв найртай амьдарч чадахгүй.”
– Жон Стотт

- Шинэ гэрээнд тэмдэглэгдсэн грек үг мөн ижил утгатай. Энэ үгээр бүх дэлхийн нүглийг (Матай 1:21) эсвэл тодорхой хүний нүглийг жишээлбэл, Есүсийн хөлийг угаасан эмэгтэйн нүгэл (Лук 7:48-50), түүнчлэн хувь хүний үйлдсэн нүглийг жишээлбэл, Стефаныг хөнөөсөн хэрэг явдал (Үйлс 7:60) зэргийг илэрхийлэхэд ашиглажээ. Нүгэл нь Бурханы хүслээс гажсан байдаг.
- **Нүгэл нь муу муухай бөгөөд сайны эсрэг юм** (Дуулал 51:4). Хуучин гэрээнд Фараоны зүүдэнд харагддаг долоон туранхай үхрийг (Эхлэл 41:19) болон Иеремиа 24:2-д гардаг идэж болохгүй инжрийг дүрслэхэд энэхүү еврей үгийг ашигласан байдаг.
- **Нүгэл нь уналт эсвэл сонсохыг хүсэхгүй байх, улмаар байнгын дуулгаваргүй байдалд хүргэдэг** (Ром 5:19). Ийм үйлдлийн жишээг Үйлс 7:57-д Стефаныг чулуугаар шидэж байсан хүмүүс чихээ таглаж байснаас харж болно. Энэхүү грек үгийн хамгийн сайн товчлол нь дуулгаваргүй байдал юм.
- **Нүгэл нь тодорхой хуулийг зөрчих буюу — Бурханы шаардсанаас эсрэгээр үйлдэх юм** (1 Иохан 3:4). Грек үг нь “хуульгүй” эсвэл “ёс бус” гэсэн утгатай хоёр үгнээс бүтдэг.
- **Нүгэл нь Бурханы мэдүүлсэн, шаарддаг зүйлээс санаатайгаар өөр зүгт эргэх буюу цааш явах юм** (Гэтлэл 32:7-8). Энэ хэсэгт Мосег Синаи уулан дээр байх үед хүмүүс Бурханаас татгалзаж эргэсэн талаар өгүүлдэг.
- **Санамсаргүй үйлдэх нүгэл** (Леви 4:2). Энэ төрлийн нүглийн талаар Хуучин болон Шинэ гэрээнд аль алинд нь өгүүлсэн байдаг. Еврей 9:7-д буй грек үг нь “мэдэлгүйгээр” эсвэл “ойлгоогүйгээр” гэсэн утгатай үйл үгнээс гаралтай тул “мэдэлгүйгээр үйлдэх нүгэл” юм. Энэ эшлэлд тэргүүн тахилчийн хүмүүсийн мэдэлгүйгээр үйлдсэн нүглийн төлөөх эвлэрүүллийн ажлын талаар өгүүлсэн.

Эдгээр үгс бидэнд нүгэл нь олон талыг хамарсан асуудал гэдгийг харуулж байна. Зарим үгс нүглийг хамгийн ерөнхий байдлаар илэрхийлдэг бол бусад нь Бурханы Үгийг сонсоогүйгээс үүдсэн уналт, хэм хэмжээнд хүрэхгүй унах, зориудаар төлөвлөсөн нүглүүд, мэдээгүйгээр болон санамсаргүй байдлаар үйлдсэн нүгэл зэргийг илэрхийлдэг. Аль ч тохиолдол нь бай, Есүс хүмүүсийг нүглээс нь аврахын тулд загалмай дээр үхсэн гэдгийг санах нь ерөөлтэй юм (Матай 1:21).

Санаатайгаар үйлдэх нүгэл

► Санаатайгаар үйлдэх нүгэл гэж юу вэ?

Санаатайгаар үйлдэх нүгэл нь Бурханы мэдүүлсэн хүслийг зориудаар зөрчих явдал юм (1 Иохан 3:4; Иаков 4:17, унших). Энэ нь хувь хүн буруу гэж мэддэг зүйлээ хийх, үргэлжлүүлэн хийх эсвэл зөвийг хийхгүй байх сонголт юм. Энэ бол санаатай буруу үйлдэл мөн.

1 Иохан 3:5-6-д Элч Иохан ийн бичжээ.

Нүглийг зайлуулахын тулд Тэр илчлэгдсэнийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй.

Энд санаатайгаар үйлддэг нүглээ үргэлжлүүлэн хийсээр байх талаар ярьж байна. Энэ эшлэлийг жаахан дэлгэрүүлж орчуулбал: Есүсийн дотор **байнга байгч** хэн ч **байнга** эсвэл **үргэлжлүүлэн** нүгэл үйлдэхгүй, мөн **байнга** эсвэл **үргэлжлүүлэн** нүгэл үйлдсээр байгч хэн ч Түүнийг үзээгүй, Түүнийг мэдээгүй юм.

Хэрэв үүнийг хамгийн ерөнхий утгаар нь нүгэл гэж тайлбарлавал (санамсаргүй үйлдсэн болон мэдэлгүй үйлдсэн нүглүүдийг оруулаад) энэ нь маш ойлгомжгүй байдлыг үүсгэнэ. Христэд итгэгчид санаатай биш бүтэлгүйтэлдээ хэвээр байсаар байна. Харин энэ *нүглийг* (энэ эшлэлд буй) "Бурханы хуулиас санаатайгаар татгалзах" гэсэн утгатай гэж ойлговол энэ эшлэлийн утга бүрэн төгс илэрхийлэгдэнэ.

Удамшсан завхрал гажуудал

► Хүн төрөхдөө нүгэлт мөн чанартай төрдгийг та хэрхэн тайлбарлах вэ?

Удамшсан завхрал гажуудал нь хүн төрснөөс эхлээд нүгэлд татагддаг ёс суртахууны мөн чанарын гажуудал юм. Үүнийг заримдаа анхдагч нүгэл гэж нэрлэдэг. Энэ нь Адамын нүглийн улмаас бидэнтэй хамт төрдөг нүгэлт мөн чанар юм.

Бүх хүн төрсөн цагаасаа ёс бус зүйлд татагдах дур сонирхолтой байдаг (Дуулал 58:3, унших). Хүний мөн чанар нь төрөлх нүгэлт дур сонирхлоос болж аль хэдийн гажуудсан байдаг. Хүн сонголт хийж эхэлмэгцээ л нүгэл үйлдэж эхэлдэг. Хүн эргэн тойрон орчноосоо энэхүү нүгэлт дур сонирхлыг суралцаж авдаггүй.

Давид өөрийнхөө талаар нүгэл дотор эх минь намайг олж тээсэн, хилэнц дунд би төрсөн (Дуулал 51:5, унших) гэж хэлсэн байдаг. Тэр энд ээжийгээ ямар нэгэн буруу зүйл хийсэн гэсэн утгаар хэлээгүй. Харин хүүхэд эхийн хэвлийд бүрэлдэж байх тэр үед түүний мөн чанар нь аль хэдийн нүглээр ялзарсан байдаг гэсэн санаа юм.

Ялзарсан мөн чанараас болж хүмүүсийн доторх Бурханы дүр төрх гэмтсэн. Хүн бүр хувиа хичээсэн, нүглийг хүсэж, тэмүүлсэн төрдөг (Ром 3:10-12). Бурхан бидэнд хүсэл, хүч чадлыг өгөхөөс нааш бидний хүсэл нь зөвийг сонгох боломжгүй (Ром 6:16-17, унших).

Удамшсан завхрал гажуудал нь бардам зан, атаа жөтөө, үзэн ядалт, үл уучлал зэрэг дотоод нүглийг өдөөж байдаг. Мөн энэ нь нүглийн үйлсийг ч өдөөдөг.

Хүмүүс төрөлхийн, Бурханы эрх мэдэлд тэрслэх хандлагатай байдаг бөгөөд Түүний хуульд дургүйцдэг. Нүгэлтнүүд зөвхөн нүгэлт үйлсээрээ шүүгдээд зогсохгүй Бурханыг эсэргүүцсэн хандлагаараа ч шүүгдэх болно (Иуда 15, унших).

Нүгэлт мөн чанартай хүн угаасаа өөртөө төвлөрсөн, Бурханы болон бусдын эрх мэдэлд захирагдахын оронд өөрийн хүслийг нотлохыг оролдсоор байдаг. Тэр Бурханыг

баярлуулахаас илүүтэй өөрийн хүслүүддээ сэтгэл хангалуун байхыг зорьдог. Тэр өөртөө итгэлтэй бөгөөд Бурханд найдахыг хүсдэггүй. Бурханы алдраас илүүтэй өөрийнх нь амжилт түүнд илүү чухал.

Хүмүүсийн оюун бодол харанхуйлсан учраас тэд сайн мууг нарийн ялгаж чаддаггүй (Ефес 4:17-18, унших). Тэд тэрслүү ертөнцөөр удирдуулж, Сатаны хяналт болон өөрсдийн нүгэлт хүслээ дагадаг. Ийнхүү тэд өөрсдийгөө Бурханы уур хилэнгийн дор авчирдаг (Ефес 2:2-3, унших). Тэдний төрөлх дур сонирхол нь хором бүрд нүгэл үйлдэх юм (Эхлэл 6:5).

Бурханы нигүүлсэлгүйгээр хүмүүс ямар ч сайн зүйлийг хийж чадахгүй, сайныг хийхийг хүсэх ч боломжгүй байв. Тэд гэмшиж, Бурханыг хайх ч чадваргүй (Иохан 6:44, унших), нүгэл, алдаа зөрчил дотроо үхсэн юм (Ефес 2:1). Теологичид энэ байдлыг “бүрэн завхрал гажуудал” гэж тодорхойлдог.

Удамшсан завхрал гажуудалд Бурханы нигүүлсэл хэрхэн хариу үйлдсэнийг мэдэх нь чухал юм. Нэгд, Бурханы хүч нь сайнмэдээний үг сургаалтай хамт ирдэг бөгөөд алдагдсан хүнд сайнмэдээнд хариу үйлдэх хүсэл, чадварыг өгдөг (Ром 1:16, унших). Улмаар хүн аврагдахдаа нүглийн хяналтаас чөлөөлөгддөг (Ром 6:11-14). Гэсэн хэдий ч шинэхэн Христэд итгэгчийн дотор удамшсан завхрал гажуудлын нөлөө үргэлжлэн байсаар байдаг.

Христэд итгэгч хүний доторх удамшсан завхрал гажуудлын нөлөө дараах байдлаар харагддаг.

1. Шинэхэн итгэгч заримдаа уруу таталтын үед өөрийн хүсэлтэй тэмцэлддэг.
2. Шинэхэн итгэгчийн хувьд эсэргүүцэх ёстой гэсэн буруу сэдлийг мэдрэх болно.
3. Шинэхэн итгэгч эдгээрийг ухамсарлахаасаа өмнө буруу хандлага, хариу үйлдэлтэй байж болно.

Шинэхэн итгэгч хүнд итгэлээ орхихгүй байхад нь урам зориг их хэрэгтэй байдаг. Учир нь түүний хувьд нүгэлт дур хүслүүд нь түүний дотор хэвээр байсаар байна гэж мэдэрсээр байгаа. Тэрээр Бурханы Сүнсээр хийгдсэн хүч ба өөрчлөлтийг үргэлжлүүлэн эрэлхийлэх ёстой болдог.

Пастор хүн шинэ итгэгчид тэвчээртэй хандах нь зүйтэй. Тэдний ярьдаг хийдэг зүйл нь үргэлж тогтвортой байдаггүй гэдгийг пастор ойлгох хэрэгтэй юм. Тэд асуудлаа шууд олж харахгүй ч байж болно.

Санамсаргүй алдаа зөрчлүүд

Заримдаа хүн санаандгүй эсвэл мэдэлгүйгээр Бурханы Үгийг **санамсаргүйгээр зөрчдөг**. Леви 4:2-3-д энэ тохиолдолд хүн ямар нэг буруу зүйл хийснээ мэдмэгцээ тахил өргөх шаардлагатай гэдгийг хэлсэн. Христийн үхэл Хуучин гэрээний бүх тахил

золиосыг орлодог тул Христэд итгэгч хүн санамсаргүй алдаа зөрчлөөс гэтэлгэгддэг гэдгийг бид мэднэ.

Бидний ойлгох ухаарах чадвар нэгэнт хязгаарлагдмал учраас санамсаргүй байдлаар алдаа зөрчил гаргах нь гарцаагүй. Алдаа зөрчлүүд нь бидний Бурхантай харилцах харилцааг тасалдуулдаггүй, учир нь тэдгээр нь Бурханыг гэсэн бидний хайртай зөрчилддөггүй юм. Түүний шаарддаг зүйлийг биелүүлэх нь Бурханыг бүрэн хайрлаж байгаа явдал гэж Тэр хэлсэн (Матай 22:37-40; Ром 13:8-10, унших). Бид мэдэхгүй зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээдэггүй (Иаков 4:17, унших).

“Бурханы хаанчлалд агуу байдал нь дуулгавартай байдлаар хэмжигддэг.”
– Жон Стотт

Бид гэрэлд алхахдаа (бидний мэддэг үнэний дагуу амьдрах) бүх нүглээс цэвэрлэгдэж байдаг (1 Иохан 1:7, унших). Бид Христийн эвлэрүүлэлд итгэдэг учраас үл мэдэх алдаа зөрчлүүд бидний Бурхантай харилцах харилцааг тасална гэж айх хэрэггүй.

Бид санамсаргүй буруу зүйл хийснээ ухаарах үедээ гэмшиж, Бурханы уучлалыг асуун, амьдралаа Бурханы хүсэж байгаачлан засах ёстой юм. Үүнийг Леви ном заадаг. Бурханы Үгийг судалж, Ариун Сүнснийг дагаж, бусад итгэгчидтэй нөхөрлөн, төлөвших замаар бид Бурханы хүслийг санамсаргүй байдлаар зөрчдөг зан байдлаа өөрчлөх ёстой.

► Бид яагаад Бурханы хүслийг ойлгож, үүнийг илүү сайнаар үйлдэх ёстой вэ?

Бид Бурханы хүслийг илүү сайн ойлгож, бүрэн дагахыг хүсэх ёстой шалтгаанууд нь:

1. Бурханыг баярлуулдаггүй зүйлсийг хийхийг бид хүсдэггүй.
2. Буруу зүйл хийх нь муу үр дагавартай. Энэ нь санамсаргүй байсан ч мөн адил.
3. Бид Христэд итгэгч хүнийхээ хувьд сайн үлгэр дуурайл байх хэрэгтэй.
4. Хэрэв бид Бурханы хүслээс зайлсхийхийг оролдвол санаатай үйлдэх нүглийн буруутан болно.

Бид Бурханы хүслийг илүү ойлгож ухаарах тусам бидний амьдралд буруу зүйлс байгааг ойр ойрхон таньж хүлээн зөвшөөрдөг. Хэрэв тэрхүү буруу зүйлийг буруу гэдгийг нь мэдсэн хэрнээ хийхээр сонгож л байгаа бол энэ нь мэдэлгүйгээр үйлдэх нүгэл байхаа больдог. Хэрэв бид үүнийг өөрчлөхөөс татгалзвал тэрхүү буруу үйлдэл нь санаатай нүгэл болж хувирдаг.

Дүгнэлт

Заримдаа теологичид нүглийн төрлүүдийг ялгадаггүй. Тэдний хувьд төгс төгөлдөр байдлаас доогуур бол бүх зүйлийг нүгэл, эсвэл зөвхөн санаатай үйлдлийг л нүгэл гэж хэлж болох юм. Харин бид нүглийн төрлүүдийг ойлговол Бурхан нигүүлслээрээ бидний төлөө юу хийхийг хүсдэгийг илүү сайн ухаарч чадна.

- Хүн дахин төрөх үедээ **санаатайгаар үйлдэх нүглийг** ялан дийлдэг. Дахин төрсөн хүн байнгын зуршил болгон нүгэл үйлддэггүй гэж Иохан тунхаглажээ (1 Иохан 3:4-9). Санаатай нүгэл нь христитгэлтэй нийцдэггүй. Санаатай тэрслэл жирийн итгэгч хүний зуршлын нэг хэсэг байж таарахгүй.
- Ариусгал нь **хүний мөн чанар дахь нүглүүдийг** шийдвэрлэх Бурханы ажил бөгөөд ингэснээр итгэгчид бүрэн дүүрэн ариун болдог (1 Тесалоник 5:23). Тэдний сүнс, сэтгэл, бие бүхэлдээ гэм зэмгүй болдог. Ариусгал нь хүний мөн чанар дахь нүглүүдийг ялан дийлдэг.
- **Мэдэлгүй үйлдэх нүглүүд нь** санаа зорилготойгоор дуулгаваргүй байх байдал биш бөгөөд нүгэлт мөн чанараас биш, харин унасан бие, оюун бодлоос гардаг. Газар дэлхий дээр амьдарч байгаа л бол энэ төрлийн нүглээс бүрэн чөлөөлөгдөх боломжгүй юм. Алдаршуулагдсан ариун хүмүүс амилуулагдахдаа бүх төрлийн нүглүүдээс бүрмөсөн, мөнхөд тусгаарлагдана.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Хүний нүгэл нь анх-бүтээгдсэн хүмүүс Бурханд дуулгаваргүй хандах чөлөөт шийдвэр гаргаснаар үүсчээ. Есүсийг оролцуулахгүйгээр бүх хүн Адамын завхрал гажуудлыг өвлөн авсан бөгөөд нүгэл үйлдсэн гэм буруутай. Хүний алдаа зөрчлүүд нь Бурханы хуулийг зөрчиж болох ч Бурхантай харилцах бидний харилцааг тасалдуулдаггүй. Эцсийн шүүлтийн өмнө Бурханы уучлалыг хүлээн аваагүй нүгэлтэн бүр мөнхөд яллагдах болно.

5-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Ром 1:21-32
- Ром 3:10-20
- Галат 5:16-21
- Ефес 5:1-8
- Тит 1:10-16
- Иаков 4:1-4
- 2 Петр 2:9-17

(2) Сорил: Дараагийн хичээлийг 5-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

5-р хичээлийн сорил

(1) Бид нүглийг ойлгох ёстой гурван шалтгааныг жагсаана уу.

(2) Нүгэл Бурханы буруугаас болоогүй гэдгийг бид хэрхэн мэдэх вэ?

(3) Дараах нүглүүдийг нэг өгүүлбэрээр тодорхойлно уу: санаатайгаар үйлдэх нүгэл, удамшсан завхрал гажуудал, санамсаргүй алдаа зөрчлүүд

(4) Бид яагаад Бурханы хүслийг ойлгож, үүнийг илүү сайнаар үйлдэх ёстой вэ?

6-р хичээл

Сүнснүүд

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Тэнгэрэлч нарын мөн чанарын талаарх нарийн ширийн зүйлс.
- Итгэгч хүний амьдрал дахь тэнгэрэлч нарын оролцоо.
- Сатан болон бусад бузар муу сүнснүүдийн уналт.
- Сүнсний ертөнц дэх сүнслэг зөрчилдөөн.
- Бузар муугийн хүчийг ялах Бурхан ба итгэгчдийн эцсийн ялалт.
- Сүнснүүдийн талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь сүнсний ертөнцийг буруу байдлаар сонирхохоос зайлсхийх болно.

Тэнгэрэлч нар ямархуу байдаг вэ?

► Матай 4:1-11-ийг хамтдаа унших. Энэхүү багц эшлэлд бузар муу сүнснүүдийн талаар юу гэж хэлсэн бэ?

Хүмүүс тэнгэрэлч нарын талаар ярихдаа “Тэд яг ямархуу харагддаг бол” гэсэн асуултыг хамгийн түрүүнд асуудаг. Олон уран бүтээлчид тэднийг бүтээл туурвилдаа дүрслэхийг оролдсон байдаг.

► Тэнгэрэлч нар яг ямархуу харагддаг бол?

Тэнгэрэлч нар далавчтай юу? Исаиагийн харсан серафууд зургаан далавчтай байжээ (Исаиа 6:2). Гэрээний авдар дээр байрлуул гэж Бурхан Мосед хэлсэн херубуудын дүрс далавчтай байсан (Гэтлэл 25:20). Езекиелийн харсан херубууд дөрвөн далавчтай байв (Езекиел 1:6, Езекиел 10:15).

Тэнгэрэлч далавчтай эсэхийг бид нарийн сайн мэдэхгүй. Тэднийг аялан явахад далавч хэрэг болохгүй болов уу. Учир нь тэд сүнснүүд бөгөөд далавчтай нисэхээс хавьгүй илүү хурдаар явах боломжтой. Тэд сүнснүүд тул бие махбодгүй. Тэнгэрэлч нарын хувьд далавч тийм ч шаардлагатай биш юм.

Бидний ихэвчлэн хардаг урлагийн бүтээлүүдээс ялгаатай нь Библид тэнгэрэлч нарыг хүүхэд эсвэл эмэгтэйчүүдээр хэзээ ч дүрсэлдэггүй. Тэд эрэгтэй хүн шиг үзэгдсэн байдаг ч хүнд байдаг шиг хүйс тэдэнд байхгүй. Тэдэнд гэр бүлийн харилцаа, хамаатан садан гэх зүйл байдаггүй (Матай 22:30, унших). Тэнгэрэлч бүр тусдаа бүтээгдсэн.

Тэнгэрэлч нар ихэвчлэн хүмүүст үл үзэгдэх боловч тодорхой шалтгаан зорилгын улмаас гарч ирдэг. Заримдаа тэднийг үзэгдэхэд хүмүүс жирийн хүн гэж боддог байжээ (Эхлэл 19:1-2). Мөн зарим тохиолдолд тэнгэрэлч нар хүмүүсийг айж, газар унахуйц хүчтэй

туяа цацруулан үзэгдсэн (Матай 28:2-4). Тэнгэрэлч хэн нэгэнд үзэгдэхдээ тухайн хүнтэй ихэвчлэн “бүү ай” гэж мэндчилдэг байв (Лук 1:13, 30; Лук 2:10, унших).

Тэнгэрэлч нар сүнснүүд (Еврей 1:14)⁷ боловч үүнээс нь болж бид тэднийг бодит бус гэж үзэх ёсгүй юм. Библид сүнс нь бие махбодоос илүү хүчтэй гэдгийг хэлсэн байдаг (Исаиа 31:1, 3, унших).

Тэнгэрэлч нарыг тэнгэрлэг биес (Иов 1:6) гэж нэрлэдэг ба Бурханы мөн чанарын зарим зүйлс тэдэнд байдаг ч харин хүмүүстэй адилгүй юм. Одоогоор тэнгэрэлч нар оюун ухаан, хүч чадлын хувьд хүмүүсээс хавьгүй илүү байгаа ч хүмүүс нэгэн цагт тэднээс дээгүүр байх болно (1 Коринт 6:3, унших).

Тэнгэрэлч нарыг бүтээсэн талаар Эхлэл номд дурдаагүй. Тэд газар дэлхийгээс өмнө бүтээгдсэн бөгөөд Бурхан үүнийг бүтээж байгааг хараад тэд баярлан бахдаж байсан (Иов 38:4-7).

Тэнгэрэлч нар хэзээ ч үхдэггүй (Лук 20:36). Тэд газар дэлхийгээс өмнө бүтээгдсэн гэдэг нь бүх тэнгэрэлч нар олон мянган жилийн турш амьдарч, хүн төрөлхтний түүхийг бүхэлд нь ажигласаар ирсэн гэсэн үг юм.

Тэнгэрэлч нар бодгаль чанартай. Тэд ярьж, ярилцах чадвартай (Лук 1:18-20). Тэд Бурханыг мөргөн хүндэтгэдэг бөгөөд энэ нь тэд Бурханы мөн чанарын талаар ямар нэг зүйлийг ойлгодог, үүнд нь бишрэлтэйгээр хариу үйлдэл үзүүлж чадна гэсэн үг юм (Еврей 1:6). Нүгэлтнийг гэмшихэд тэд баярладаг бөгөөд энэ нь тэд сэтгэл хөдлөлтэй болохыг харуулдаг (Лук 15:10, унших). Авралын төлөвлөгөөг ойлгохыг ихэд сонирхож байгаагаас харвал тэд оюуны чадавхитай (1 Петр 1:12, унших). Есүсийг мэндлэх талаарх мэдээг зарлахдаа тэд баярлан тэмдэглэж байсан (Лук 2:13-14).

Тэнгэрэлч нар өөр хоорондоо адилгүй. Зарим нь херуб (Дуулал 80:1), зарим нь серафууд (Исаиа 6:2) гэж нэрлэгддэг. Тэд зэрэг дэвтэй. Библид тэнгэрэлч нарын талаар болон хамгийн багадаа нэг тэргүүн тэнгэрэлчийн тухай дурдсан бол “Диавол болоод түүний тэнгэрэлч нарт” (Матай 25:41) гэж мөн өгүүлсэн байдаг. Дотор ч хаан ширээ, ноёрхол, ноёд гэх зэрэг эрх мэдлийн бүтэц бий (Ефес 6:12; Колоссай 1:16, унших).

Еврей болон христитгэлийн уламжлалд аль алинд нь тэнгэрэлч нарын талаар маш их зүйлийг бичсэн байдаг бөгөөд эдгээр нь Бичвэрээс бидний уншиж мэддэгээс ч хавьгүй их юм.


Тэнгэрэлч нарын ялгааны талаар Бичвэрт тийм ч ихийг илчлээгүй. *Тэргүүн тэнгэрэлч* гэсэн хэллэг Библид хоёр удаа гардаг. Михаелыг тэргүүн тэнгэрэлч гэж дуудсан байдаг бөгөөд тэрээр Есүсийг эргэж ирэх үед тэргүүн тэнгэрэлчийн дуу хоолой байх болно (1 Тесалоник 4:16; Иуда 9). *Тэргүүн тэнгэрэлч* нь шууд утгаараа “ахлах тэнгэрэлч” гэсэн утгатай. Хэдэн тэргүүн тэнгэрэлч байдгийг бид мэдэхгүй.

⁷ Чөтгөрүүдийг мөн “сүнснүүд” гэж нэрлэдэг. Матай 8:16, Матай 12:45; Үйлс 19:12 болон бусад хэсэгт.

Библийн Исаиа 6-р бүлэгт зөвхөн серафуудын талаар дурдсан байдаг. Тэд зургаан далавчтай байсан. Далавчийг нь эс тооцвол, тэд яг л хүн шиг харагдаж байсан болов уу. Учир нь тэдэнд гар, хөл, нүүр царай байв.

Адам Ева хоёрыг цэцэрлэгээс хөөгдсөний дараа херубууд болон галт илдийг Еден цэцэрлэгт байрлуулжээ (Эхлэл 3:24). Ийнхүү цэцэрлэгт ойртох боломжгүй болгожээ. Езекиел өөрийн харсан херубуудыг дүрсэлсэн байдал нь бидний мэддэг бусад амьтдаас тэс өөр байв. Тэд тус бүрдээ дөрвөн нүүр, дөрвөн далавчтай, хэд хэдэн гартай, гал мэт туяатай, аянгын гялбаа, аянга цахих адил хурдан байжээ (Езекиел 1:5-14, Езекиел 10:15).

Хоёр херубын дүрсийг Гэрээний авдрын төгсгөлд байрлуулсан бөгөөд тэдний хооронд Өршөөлийн суудал байв.⁸ Бурханыг херубуудын дээр залрагч⁹ хэмээн дахин давтан дуудсан байдаг. Энэ нь Сүмд мөргөн хүндэтгэдэг Израилын Бурхан гэдгийг тодорхойлж байгаа бөгөөд Түүний зааж өгсөн арга замаас өөр бусад тохиолдолд Түүнд ойртох боломжгүй гэдгийг харуулдаг.



Бурханы сүр жавхлан ба хүч чадал нь Түүнд үйлчлэгчдээс харагддаг. Херубыг харахдаа хүн Бурханыг харлаа гэж бодох, түүнд мөргөхийг завдаж болох ч энэ нь зөвхөн Бурханы үйлчлэгч юм.

Бурханыг үй түмэн тэнгэрэлч хүрээлэн байдаг нь Тэр ямар агуу сүр жавхлантай болохыг харуулдаг. Бурханы сэнтийн эргэн тойрон буй олон тэнгэрэлч нарыг Элч Иохан харахдаа "Тэдний тоо түм түмээрээ, мянга мянгаараа ажээ" (Илчлэл 5:11) гэж илэрхийлсэн байдаг.

Тэнгэрэлч хязгааргүй хүч чадалтай биш. Учир нь Даниелд зориулсан мэдээг дамжуулахдаа тэнгэрэлч зөрчилдөөний улмаас саатсан талаар бид уншдаг (Даниел 10:12-13, унших). Гэсэн хэдий ч тэдэнд даалгасан үүрэг даалгаврын цар хэмжээнээс шалтгаалж, 185,000 цэргийг устгаж байсны адил Бурхан хангалттай хүчийг тэдэнд өгдөг (2 Хаад 19:35).

Тэнгэрэлч нарт үүрэг даалгаврууд оногдсон бололтой. Библид тэднийг авралыг хүлээн авах хүмүүст үйлчлэхээр илгээгдсэн (Еврей 1:14, унших) гэж хэлдэг. Тэнгэрэлч нар Бурханд үйлчилдэг хүмүүсийг хүрээлж, хамгаалдаг (Дуулал 34:7). Олон тэнгэрэлч байнга бидэнтэй хамт байдаг гэж тааварлах боломжтой. Түүнчлэн хүүхдүүдийг харгалздаг тэнгэрэлч байдаг талаар Есүс хэлжээ (Матай 18:10, унших). Тэргүүн

⁸ Зураг: "Гэрээний авдар сийлбэр" *Illustrated Bible Dictionary* (1893), олны хүртээл болсон https://commons.wikimedia.org/wiki/File:Ark_of_the_Covenant_engraving.jpg сайтаас сэргээн ашиглав

⁹ Жишээлбэл, 2 Хаад 19:15, 1 Шастир 13:6; Исаиа 37:16

тэнгэрэлч Михаелыг Израил үндэстнийг хамгаалдаг ханхүү гэж нэрлэсэн байдаг (Даниел 12:1).

Тэнгэрэлчид хандан залбирах талаар Библид хэзээ ч хэлж байгаагүй. Бид тэдэнтэй харилцаатай байх оролдлого хийх талаар ч Библид юуг ч өгүүлдэггүй. Тэд Бурхан бидний хооронд зуучлагч биш. Тэнгэрэлч нарт мөргөж, өөрсдийнхөө сайн ойлгохгүй сүнсний ертөнцийн юмсад оролцдог хүмүүст сэрэмжлүүлэг өгөгдсөн байдаг (Колоссай 2:18, унших). Хэрэв бид Бурханы хүсээгүй арга замаар тэнгэрэлч нартай холбогдохыг оролдвол Бурханы тэнгэрэлч нар биш, харин бузар муу сүнснүүд бидэнд хариулах болно.

Сатан ба унасан тэнгэрэлч нар

► Бузар муу сүнснүүд хаанаас гаралтай вэ?

Бузар муу сүнснүүд нь Бурханы эсрэг тэрсэлсэн тэнгэрэлч нар юм. Энэ нь хүн төрөлхтөн бүтээгдэхээс өмнө тохиолдсон бөгөөд Библид энэ талаар тийм ч ихийг өгүүлдэггүй. Сатан бослогын удирдагч байсан бөгөөд тэнгэрэлч нарын гуравны нэг нь түүнийг дагажээ (Илчлэл 12:4). Анхны байр сууриа орхисон тэнгэрэлч нарын талаар Иуда өгүүлсэн байдаг (Иуда 6). Тэд аль хэдийн Бурханы шүүлтээр ялагдсан юм (Иохан 16:11; 2 Петр 2:4, унших).

Сатаны уналтын талаар эш үзүүллэгийн номууд дахь хоёр хэсэгт дурдсан байдаг (Исаиа 14:12-17 болон Езекиел 28:12-19). Хэсэг бүр нь хүн төрөлхтөн, газар дэлхийн хааны тухай өгүүлдэг ч хаадын уналтыг Сатаны уналттай харьцуулсан бололтой.

Сатан бардам болж, Бурханаас хараат бус байхыг хүссэн байж магадгүй юм. Хүн бардам болж, чөтгөртэй адил ялд унах боломжтой талаар Элч Паул сэрэмжлүүлсэн байдаг (1 Тимот 3:6, унших). Энэ нь Адам Ева хоёрыг “Бурхан шиг болж” хэмээн уруу татсан Сатаны сорилттой адил юм. Энэ нь Бурханы эрх мэдлийг үгүйсгэж, өөрийгөө бурхан болгох сорилт юм.

► Сатаны талаар бидний мэдэх зарим зүйл юу вэ?

Сатан Бурханы эсрэг тэрслэлийг одоо ч удирдсаар байна. Түүнийг агаарын хүчний ноёрхогч (Ефес 2:2) гэж дууддаг. Мөн Сатаныг ертөнцийн захирагч гэж нэрлэдэг. Учир нь энэ дэлхийн хүмүүс ихэвчлэн Бурханыг эсэгүүцдэг (Иохан 12:31). Тэрээр дэлхийн хаанчлалуудыг эзэмшдэг гэдгээ, түүнчлэн хүссэн хүндээ тэдгээрийг түр хугацаагаар олгодог гэдгээ илэрхийлдэг (Лук 4:4-6). Нүгэлтнүүд сайнмэдээг хүлээн зөвшөөрөхгүйн тулд тэр тэдний оюун бодлыг сохолдог (2 Коринт 4:4, унших). Гэмшдэггүй нүгэлтнүүд нь түүний хоригдлууд юм (2 Тимот 2:26). Тэр Бурханы Үгийг хүмүүсийн оюун бодлоос

“Сатан өөрийгөө нүгэлтний нүд, хэл, зүрх сэтгэлийнх нь эзэн болгодог. Түүний зүрхийг нүглийг хайрлах хайраар дүүргэж, өөрийг нь хүлээж буй гэм буруу болон сүйрлийг өөрт нь харуулахгүйн тулд нүдийг нь халхалж, хэл яриаг нь залбирлаас холдуулдаг.”

- Адам Кларк,
Христитгэлийн теологи,
“Сайн ба Муу Тэнгэрэлч нар”

зайлуулдаг бөгөөд ингэснээр энэ нь үр нөлөөгүй болдог (Марк 4:15, унших). Тэрээр чуулган болон Ариун Сүнсний өмнө худал ярих төлөвлөгөөг Ананиа, Сапфир хоёрын зүрхэнд суулгаж (Үйлс 5:3), Есүсээс урвах гэсэн хүсэлдээ хөтлөгдсөн Иудагт шүглэжээ (Лук 22:3). Тэр шашны буруу онол сургаалыг сэдэж, тэдгээрийг хүмүүс заахыг хөхүүлэн дэмждэг (1 Тимот 4:1, унших).

Сатан Бурханыг үзэн яддаг учраас хүмүүсийг ч үзэн яддаг. Учир нь хүмүүс Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд хамгийн агуу тааллыг Түүнээс хүлээн авдаг. Сатан аль болох олон хүнийг Бурханы эсрэг тэрслэхэд нь нөлөөлж, өөрт оногдсон ял шийтгэлийнхээ дор авчрахыг зорьдог.

Дэлхий дээр хамгийн их мэхлэгдсэн хүмүүс бол Сатанд ухамсартайгаар үйлчилдэг хүмүүс юм. Учир нь тэдний тэрслэл хэзээ ч амжилт олохгүй бөгөөд тэднийг үзэн яддаг, зөвхөн алж сүйрүүлэх сонирхолтой эзэнд тэд үйлчилдэг (1 Петр 5:8). Тэр биелүүлж чадахгүй гэдгээ мэдэж байгаа тийм амлалтуудыг өгдөг (Иохан 8:44).

Зарим хүмүүс нүгэлтэй амьдралаар амьдрахыг сонгохдоо Сатаныг мэдэлгүйгээр дагадаг (Ефес 2:2-3). Тийм ч учраас тэр уруу татахад болон хуурч мэхлэхэд их эрч хүч, цаг хугацааг зарцуулдаг (2 Коринт 4:4, 2 Коринт 11:3, 14). Тэр хүмүүсийг Бурханд итгэх итгэлээсээ няцаж, Бурханыг мөргөн хүндлэхийн оронд бүтээгдсэн зүйлсийг шүтээн болгохыг хүсдэг (Ром 1:25). Түүний сорилтууд нь хууран мэхлэх явдал юм. Учир нь түүнд Бурханы бүтээсэн зүйлийг гажуудуулахаас өөр бүтээж чадах зүйл үгүй. Чөтгөр ямар ч баяр хөөр, таашаалыг бүтээдэггүй. Харин Бурхан энэ бүгдийг бүтээсэн юм. Чөтгөр зөвхөн Бурханы хүслээс гадуурх хүчирхийлэл хэлбэрийн таашаалуудыг л өгч чадна. Үнэндээ Сатан юуг ч бүтээж чадахгүй. Тэр зөвхөн Бурханы бүтээсэн сайн сайхныг гажуудуулж чадна.

Зарим бузар муу сүнснүүд тодорхой газарзүйн бүс нутаг эсвэл хүмүүсийн бүлэгт анхаарлаа хандуулдаг байж магадгүй юм. Михаел тэнгэрэлчийг Израилыг хамгаалагч ханхүү гэж нэрлэдэг байсан шиг Перс, Грекийн ноёд гэж нэрлэгддэг бузар муу сүнснүүд ч байсан (Даниел 10:13, 20). Зарим сүнснүүд улс үндэстний бурхад болсон.

Сатан мөргөл хүндэтгэлийг хүсдэг (Матай 4:9, унших). Бузар муу сүнснүүд хуурамч шашнаар дамжуулан ажилладаг. Хүмүүс шүтээн шүтэх үедээ чөтгөрүүдийг мөргөн хүндэлж байдаг гэж Библид хэлсэн (Дэд хууль 32:17; 1 Коринт 10:20-21, унших). Чөтгөрүүд юуг шүтэж байгаагаа мэддэггүй тийм хүмүүсийн мөргөлд хариу үйлдэл үзүүлдэг. Бурханыг мөргөн хүндэлдэг хүн Бурхантай илүү адил болж, ариун байдлыг таашаадаг шиг, бузар муу сүнснүүдэд мөргөгч нь улам бүр бузар муу болж, бузар мууг таашаадаг. Хүмүүс өөрсдийн үр хүүхдүүдээ чөтгөрүүдэд тахил болгон өргөж байснаас илүү ёрын муу мөргөл гэж байхгүй биз ээ (Дуулал 106:37-38, унших).

Сатан ба бусад чөтгөрүүд хүмүүсийн оюун бодол, зан үйлийг бүрэн хянахыг оролдож байдаг. Үүнийг “чөтгөрт эзэмдүүлэх” гэж хэлдэг. Зарим хүмүүс ухамсартайгаар ийм төрлийн эзэмдүүлэлтэд буулт хийдэг байж болох юм. Харин бусад нь юу хийж байгаагаа мэдэхгүйгээр зөвшөөрдөг байж болно. Зарим хүмүүс өөрийн зорилгодоо хүрэх эрх

мэдлийг олж авлаа гэж бодон, алхам алхмаар ийм байдалд ордог. Чөтгөрт эзэмдүүлсэн хүн бузар муу сүнснүүдийн боол болж, өөрийгөө сүйрүүлэхэд хөтлөгдөн, оюун бодол, сэтгэл зүйн аймшигт тарчлалыг амсдаг (Марк 5:2-5, унших). Зөвхөн Есүс л хүнийг ийм боолчлолоос чөлөөлж чадна.

Бурханы ялалт

Сайнмэдээ өргөнөөр тунхаглагдсан улс орнуудад бузар муу сүнснүүдийн үйл ажиллагаа ихэвчлэн өнгөлөн далдлагдсан байдалтай байдаг. Хамгийн хачирхалтай нь эдгээр “соёл иргэншил хөгжсөн” орнуудын хүмүүс нь хамгийн шашингүй, аливаа ер бусын зүйлийг доог тохуу болгосон, сүнс байдаг гэдгийг үгүйсгэдэг. Ийм орчинд бузар муу сүнснүүд ил тод байдлаар ажилладаггүй. Учир нь тэд сайнмэдээг сонссон хүмүүсийг айлгачихвал тэдгээр хүмүүсийн олонх нь Бурханд эргэж, Түүнээс аврал, хамгаалалтыг хүсэх болно.

Сайнмэдээ бага тархсан газар орнуудад бузар муу сүнснүүд илүү нээлттэй ажилладаг. Тийм газрын хүмүүс Христэд хандаж, чөлөөлөгдөж чадна гэдгээ мэддэггүй тул чөтгөрүүдийн хүч тэднийг айлган сүрдүүлж, хүлцэнгүй байдалд оруулдаг. Хүмүүс сүнснүүдэд дуртай, хүсэлтэйдээ биш, харин айдастайгаар үйлчилдэг. Сайнмэдээ нь чөлөөлөлт, эрх чөлөөний гайхалтай мэдээ болон ирдэг.

Чөтгөрийн байнгын дайралтын улмаас бид сүнслэг тулаанд байгаа юм. Бидний тулаан бол бие махбодын дайснуудын эсрэг биш, харин сүнсний ертөнцөд болж байдгийг санаарай хэмээн анхааруулсан байдаг (Ефес 6:12, унших). Бид өөрсдийгөө хамгаалахын тулд сүнслэг хуяг дуулгаа өмсөх ёстой гэж хэлсэн (Ефес 6:13). Бид энэ тулаанд ялна гэдэгтээ итгэлтэй байж болно. Учир нь бидний дотор байгаа Бурханы хүчийг чөтгөр эсэргүүцэж чадахгүй бөгөөд бид чөтгөрийг эсэргүүцэх үед тэр биднээс зугтан оддог (Иаков 4:7).

► Чөтгөр Бурханы эсрэг тал мөн үү?

Чөтгөр одоогийн мөнх бус байдалд буй хүнтэй харьцуулбал хамаагүй илүү хүчтэй. Гэхдээ түүний хүчийг Бурханыхтай харьцуулах ямар ч боломжгүй. Түүнийг хүч чадлын хувьд Бурхантай адил тэнцүү хэмжээнд эсрэгцүүлж үзэж болохгүй юм. Зарим философичид дэлхий дээрх сайн муугийн хүч тэнцүү гэж үздэг. Энэ нь үнэнээс хэт хол байна. Сатан хаа сайгүй оршдоггүй, бүх зүйлийг мэддэггүй, алдаа гаргадаг. Харин Бурхан бол сүнснүүдийг Бүтээгч бөгөөд тэд Түүнийг ялж чадахгүй. Хүнийг шалгах сорилтын хугацаа дуусгавар болоход бүх бузар муу сүнснүүд нүгэлт хүмүүсийн хамт шүүгдэж, хоригдон, шийтгэгдэх болно.

Сатаны ялагдлыг эртнээс амласан байдаг. Бурхан могойн толгойг бяцлахын тулд Аврагчийг илгээнэ гэж амласан (Эхлэл 3:15). Есүс чөтгөрийн ажлыг устгаж, нүглийн дээгүүрх ялалтыг бидэнд өгөхөөр ирсэн (1 Иохан 3:8, унших). Есүс үхэл ба амиллаараа

“Хэрэв та эсэргүүцээр байвал чөтгөр таныг ялан дийлж чадахгүй. Тэр хүчтэй байж болох ч, түүнийг эсэргүүцээр байгаа хүнийг ялагдахыг Бурхан хэзээ ч зөвшөөрөхгүй. Тэр хүний хүслийг албадаж чадахгүй.”

- Адам Кларк,

Христитгэлийн теологи,

“Сайн ба Муу Тэнгэрэлч нар”

Сатанд үхлээс дээгүүрх эрх мэдэлтэй байхыг зөвшөөрөөгүй юм (Еврей 2:14; Илчлэл 1:18). Сатан болон бусад бузар муу сүнснүүдийн эцсийн бөгөөд мөнхийн хувь тавилан бол галт нуур билээ (Матай 25:41, унших).

Сатаны хийж чадах зүйлийг Бурхан аль хэдийн хязгаарласан (Иов 1:12, Иов 2:6). Энэ нь Сатан бидэнд юу ч хийж магадгүй гэсэн айдастай амьдрах шаардлагагүй гэсэн үг юм. Бурхан зөвшөөрөхгүй л бол юу ч тохиолдохгүй бөгөөд Тэр бидний хаа хүртэл явж чадахыг мэддэг (1 Коринт 10:13).

Бид Сатаны дайралтаас хамгаалагдсан төдийгүй Бурханы хаанчлалыг Сатаны хаанчлалын эсрэг тэлэх хүч бидэнд бий. Есүс зөвхөн элч нарт бус дагалдагч нартаа бузар муу сүнснүүдийг зайлуулах хүчийг өгсөн юм (Лук 10:17, унших). Бид сайнмэдээг номлох үед Бурхан Өөрийн үнэнд хүч өгч, сайнмэдээнд хариу үйлдэх хүмүүсийг Сатанаас чөлөөлдөг.

Алдаанаас зайлсхийх: Сүнсний ертөнцийг буруу байдлаар сонирхох

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ангийн нэг гишүүн энэ хэсгийг тайлбарлана уу.

Зарим хүмүүс сүнсний ертөнцийг ихэд сонирхдог. Тэд тэнгэрэлч нарыг судалж эхлэх, тэдэнтэй харилцахыг оролдож болох юм. Харин Библид тэнгэрэлч нарт хандан залбирах эсвэл тэдэнтэй харилцахыг хичээх талаар ямар ч зүйлийг хэлдэггүй. Тэднийг мөргөн хүндэтгэх эсвэл ойлгох чадвараас илүүг мэдэхийг оролдох хэрэггүй гэж Библи анхааруулдаг (Колоссай 2:18).

Хэрэв хүн бузар муу сүнснүүдийг хэт их сонирхдог бол энэ нь илүү аюултай. Зарим хүмүүс тэдний хүч чадал, хийж буй зүйлд нь татагддаг. Сүнстэй харьцдаг тоглоомууд ч бий. Сүнснүүдээс мэдээлэл авах аргатай хүмүүс ч байдаг. Бид Бурханы хүчээр тэднийг эсэргүүцэхээс бусад тохиолдолд бузар муу сүнснүүдтэй хэзээ ч холбогдох ёсгүй юм (Иаков 4:7, 1 Петр 5:8-9).

Зарим хүмүүс сүнсний ертөнцийн талаар болон энэ нь хэрхэн ажилладаг тухай нарийн ширийн, цогц тайлбарыг боловсруулсан байдаг. Гэсэн хэдий ч сүнсний ертөнцийн талаар бидний мэдэх ёстой бүх зүйлийг Бурхан Библид илчилсэн билээ.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Бурхан бүх сүнснүүдийг бүтээсэн. Ариун тэнгэрэлч нар Бурханыг мөргөн хүндэлж, итгэгчдийг хамгаалдаг. Тэнгэрэлч нь үхэшгүй мөнх, сэтгэн бодож, ярилцаж, мөргөн хүндэтгэх чадвартай бодгаль юм. Тэд ёс суртахууны сонголт гаргадаг. Сатан болон бусад тэнгэрэлч нар нүгэл үйлдэж, Бурхан болон хүн төрөлхтөнд дайсагнах болжээ. Бурхан Сатаны хүчийг хязгаарлаж, мөнхийн шийтгэл өгөхөөр ялласан юм.

6-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Матай 12:43-45
- Лук 8:27-35
- Үйлс 12:7-11
- 2 Коринт 11:13-15
- 1 Петр 5:8-9

(2) Сорил: Дараагийн хичээлийг 6-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

6-р хичээлийн сорил

- (1) Тэнгэрэлч нар ихэвчлэн бие махбодгүй байдгийг бид хэрхэн мэдэх вэ?
- (2) Тэнгэрэлч нарыг хэзээ бүтээсэн бэ?
- (3) Тэнгэрэлч нар үхдэг үү?
- (4) Тэнгэрэлч нар бодгаль шинжтэй гэдгийг мэдэх дөрвөн арга замыг нэрлэнэ үү.
- (5) Библид тэнгэрэлч нарыг нэрлэсэн дөрвөн нэрийг нэрлэнэ үү.
- (6) Бурханд үйлчилдэг хүмүүсийн төлөө тэнгэрэлч нар юу хийдэг вэ?
- (7) Бузар муу сүнснүүд хаанаас гаралтай вэ?
- (8) Шүтээн шүтэгч нь яг үнэндээ юуг мөргөн хүндэлдэг вэ?
- (9) Сатан болон бусад бузар муу сүнснүүдийн эцсийн хувь тавилан юу вэ?
- (10) Итгэгч хүн Сатаны дайралтаас өөрийгөө хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

7-р хичээл

Христ

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Есүс бол Мессиа гэдэг нь юу гэсэн утгатай вэ?
- “Эзэн Есүс Христ” гэсэн хэллэг дэх итгэлийн тодорхойлолт.
- Есүсийн хүмүүн чанарын нотолгоо ба үүний ач холбогдол.
- Есүсийн бурхан чанарын нотолгоо ба үүний ач холбогдол.
- Нүглийг уучлахад Христийн үхэл хангалттай болох нь.
- Христитгэл дэх амиллын ач холбогдол.
- Христийн талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь зарим шашны хүмүүс Христийн талаар юу өгүүлсэн байдгийг мэдэж авна.

Танилцуулга

► Илчлэл 5:11-14-ийг хамтдаа унших. Энэхүү багц эшлэлд Есүсийн талаар юу гэж хэлсэн бэ?

Хуурамч христүүд

Эцсийн өдрүүдэд хуурамч христүүд болон хуурамч эш үзүүлэгчид олныг хуурч мэхлэх болно гэж Библид урьдаас өгүүлжээ. Олон хүмүүс өөрсдийгөө аварч чадахгүй хуурамч, төсөөллийн христүүдэд итгэж найдсаар байна. Та магадгүй мормончууд болон Еховагийн гэрчүүдийн танилцуулсан эдгээр хоёр хуурамч христүүдтэй ч уулзаж болох юм.

Мормончуудын Есүс

Хэрэв мормон хүн таны хаалгыг тогшвол тэр танд Лусиферын сүнсний ах Есүсийг танилцуулах болно. Мормончуудын Есүс нь тэдний “Тэнгэрлэг Эцэг” болон “Тэнгэрлэг Эх”-ийн нэгдлээс энэ орчлонд авчирсан олон тэрбум сүнсний нялх хүүхдүүдийнх нь нэг юм. Мормончуудын хэлснээр, Есүс дэлхий дээр амьдарч байхдаа хэд хэдэн эхнэртэй байсан бөгөөд тэдний нэг нь Магдалын Мариа байв. Тэрээр нас барж, амилсныхаа дараа Америкт очиж, уугуул америкчуудад номлосон гэж заадаг.

Еховагийн гэрчүүдийн Есүс

Еховагийн гэрчүүд Есүсийг тэргүүн тэнгэрэлч Михаел гэж үздэг бөгөөд тэрээр анхны бүтээл төдийгүй хүн болж, загалмай дээр биш, харин шон дээр үхсэн гэж заадаг. Улмаар

тэр сүнслэг биет болон амилж, эргээд тэргүүн тэнгэрэлч Михаел болсон. Түүний бие нь хий болон замхарсан гэж заадаг.

Жинхэнэ Есүс

Эдгээр гаж сургаалтнууд Библийн Есүсээс өөр Есүстэй гэдгийг та мэдэх болов уу гэж би найдаж байна. Гэхдээ та Библийн жинхэнэ Есүсийг тодорхойлж чадах уу? Сая сая хүмүүс өөрсдийг нь аварч чадахгүй хуурамч христийн тухай ойлголттой явдаг.

Есүсийн талаарх итгэл үнэмшилдээ баттай байх нь чухал юм. Ингэснээр та мэхлэгдэхгүй бөгөөд бусдад Түүнийг танилцуулж чадна.

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Есүсийн талаар бусад шашнууд юу гэж заадаг тухай илүү ихийг мэдэхийг хүсвэл хичээлийн төгсгөлд буй "Бусад шашин юу хэлдэг вэ" хэсгийг үзнэ үү.

Есүс бол Мессиа

► Мессиагийн талаар Библид юу гэж урьдаас хэлэгдсэн байдаг вэ?

Сайнмэдээний дөрвөн номд Есүсийг Израилын хүсэн хүлээсэн Мессиа хэмээн танилцуулдаг. Мессиагийн талаарх хэд хэдэн зүйлийг урьдаас өгүүлсэн байдаг. Тэрээр Давид хааны удмын хүн байсан тул хаан байх шалгуурт тэнцэнэ. Тэр ард олноо дарлал, боолчлолоос аварна. Тэрбээр ирсэн зорилгоо биелүүлэхийн тулд Бурханаар тусгайлан тослогдох болно. *Мессиа* гэдэг нь "тослогдсон нэгэн" гэсэн утгатай бөгөөд Израилын хаадын нэр өргөмжлөл байжээ.

Хуучин гэрээнд гардаг Мессиагийн талаарх хамгийн чухал нарийн ширийн зүйлсийг Шинэ гэрээ бичигдэх хүртэл тодорхой тайлбарлаагүй юм. Түүний нэн тэргүүний зорилго бол ард түмнээ нүглээс нь чөлөөлөх байв (Матай 1:21; Лук 1:74-75, унших). Түүний хаанчлал нь газар дэлхийнх бус, харин сүнслэг бөгөөд тэнгэрийнх (Иохан 18:36, унших) боловч эцэст нь Түүний хаанчлал газар дэлхийг ч бүхэлд нь хамарна (Филиппой 2:10-11; Илчлэл 19:11-16; Илчлэл 20:6).

Мессиа нь еврей үг бөгөөд үүнтэй ижил утгатай грек үг нь *Христос* бөгөөд үүнээс Христ гэдэг үг үүсэлтэй. "Есүс Христ" гэсэн хэллэг нь Есүс бол Мессиа гэсэн утгатай нэр юм.

Есүс бол Эзэн

Эртний чуулган, хүн захирагдах ёстой хамгийн дээд эрх мэдэлтэй нэгэн бол Есүс гэж хэлэхийн тулд *Эзэн* гэсэн нэр томъёог ашиглажээ. Тэд "Есүс бол Эзэн" гэж хэлэхдээ Тэр бол бүхний Эзэн, орчлон ертөнцийг Бүтээгч ба Бурхан мөн

"Бүх ертөнцөөс өмнө
Эцэгтэйгээ хамт байсан
Бурханаас Бурхан, Гэрлээс гэрэл,
Жинхэнэ Бурханаас Жинхэнэ Бурхан
байсаар ирсэн, бий болоогүй,
бүхнийг бүтээсэн Эцэгтэйгээ
нэг мөн чанарт орших,
Бурханы цорын ганц Хүү,
нэг Эзэн Есүс Христэд
би итгэдэг."
- Никайн тунхаг

гэсэн санааг илэрхийлдэг байжээ. Энэхүү итгэлийн тунхаг нь Христэд итгэгчдийг ялгаж байсан. Учир нь Христэд итгэгчид л газар дэлхий дээр алхаж байсан хүмүүн Есүсийг бүхнээс дээгүүр нэг Бурхан гэдэгт итгэдэг байв.

“Эзэн Есүс Христ” гэдэг үг агуу тунхаглалыг илэрхийлдэг. Эдгээр нь Есүс бол Мессиа бөгөөд тэрхүү Есүс нь мөн Бурхан гэж хэлдэг. Энэхүү гурван үг Филиппой 2:10-11-д тэмдэглэгджээ. Эдгээр эшлэл бидэнд дэлхий ертөнц дээрх бүх хүн Есүс Христ бол Эзэн гэж хүлээн зөвшөөрөх цаг ирнэ гэдгийг хэлдэг.

Гурван онцгой өдөр

Есүсийн талаарх бидний үндсэн итгэл үнэмшлийг гурван онцгой өдөртэй холбож, гурав ангилах боломжтой.

Бид Христийн биежилтийн улмаас Христийн мэндэлсэн өдрийг тэмдэглэдэг

Христийн мэндэлсэн өдөр нь Есүс онгон эмэгтэйгээс төрснийг онцлон тэмдэглэдэг. Учир нь Есүс Ариун Сүнсээр эхийн хэвлийд бүрэлдсэн юм (Лук 1:34-35, унших). Хэдийгээр Есүс эмэгтэй хүнээс төрснийхөө хувьд хүн боловч Тэр мөн Өөрийн бүтээсэн дэлхий ертөнцдөө орж ирсэн Бүтээгч, Бурхан байсан юм. Есүсийг нялх байхад ээж Мариа нь өөрийг нь бүтээсэн Нэгэнийг тэвэрчээ. Энэ нь үнэхээр гайхалтай төдийгүй үнэн билээ.

Бурханы хөвгүүд гэсэн хэллэгээр итгэгчид болон тэнгэрэлч нарыг нэрлэдэг (Иохан 1:12; Иов 1:6) бол харин Есүс үүнээс маш онцгой тул Бурханы хүү юм (Иохан 3:16). Тэр Эцэгийн мөн чанарыг бүрэн хуваалцдаг цорын ганц Нэгэн. Тэрээр бүрэн дүүрэн Эцэгийн дүр төрх бөгөөд Эцэг шигээ Бурхан билээ (Еврей 1:2-3, унших).

Бурханы мөн чанар ба хүмүүн мөн чанар хамтдаа бодгаль Есүст нэгджээ. Үүнийг *биежилт* гэж нэрлэдэг. Энэ нь Бурхан хүний биеийг авч, хүн болсон гэсэн үг юм. Есүс орчлон ертөнц дээрх цорын ганц Бурхан-хүн учраас Тэр биднийг аварч чадах цорын ганц Нэгэн билээ.

Есүс бол Хүн

Шинэ гэрээний Есүсийг жинхэнэ хүн байсныг таних нь тийм ч хэцүү биш. Тэрээр эхийн хэвлийд бүрэлдэж, өсөж торнин, суралцаж, хүн болж төлөвшсөн (Лук 2:52, унших). Тэр ядарч, унтаж, соригдож үзсэн бөгөөд нүглээс бусад хүмүүсийн хийдэг бараг бүх зүйлийг хийсэн (Еврей 4:14-15). Тэр үхлийг хүртэл амссан. Тэрбээр бидний нэг болсноороо хүн төрөлхтөнтэй ижилссэн юм (Иохан 1:14, унших).

► Есүс хүн гэдгийг мэдэх нь бидний хувьд яагаад чухал вэ?

Есүс хүн учраас:

- 1. Тэр золиос болж зовж, үхэж чадах байв** (Ефес 5:2, Еврей 7:26-27). Хэрэв Тэр хүн биш Бурхан байсан бол бие махбодын хувьд зовж шаналах, үхэх боломжгүй байсан.

2. **Түүний зөвт байдал биднийг зөвт болгож, амийг өгч чадна.** Бүх хүн төрөлхтнийг төлөөлсөн анхны хүн Адам нүгэл үйлдэж, Бурханаас тусгаарлагдсан. Энэ нь бүх хүмүүст үхлийг авчирсан юм. Есүс нүгэлгүй амьдарч, Бурханы бүх шаардлагыг биелүүлэв. Өөртэйгөө нэгдсэн бүх хүнд Тэр мөнх амийг өгдөг. Түүнийг Бичвэрт сүүлчийн Адам гэж нэрлэсэн байдаг (1 Коринт 15:22, 45-49; Ром 5:17-19).
3. **Тэр биднийг Бурханы өмнө төлөөлөх тахилч байж чадна.** Биднийг зуучлагчийн хувьд Тэр зөвхөн бидний төлөө харилцаад зогсохгүй, биднийг жинхэнээсээ төлөөлдөг. Биднийг Бурхантай эвлэрүүлэхийн тулд Тэр хүн байх ёстой болжээ (Еврей 2:17, унших). Түүний тахилчийн үүрэг нь мөнхийн авралыг өгдөг (Еврей 5:9, Еврей 10:5-7). Есүсийн хүмүүн мөн чанар нь сайнмэдээний чухал хэсэг юм (1 Иохан 5:1, унших).

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Есүс хүн байсан талаарх Библийн баримтуудыг энэ хичээлийн төгсгөлд буй "Есүсийн хүмүүн чанарын талаарх Бичвэрийн нотолгоо" хэсгээс үзнэ үү.

Есүс бол Бурхан

Есүс Өөрийгөө Бурхан гэж хэлсэн.

Библийн Есүс нь хүн боловч зөвхөн хүн биш юм. Тэрээр мөн орчлон ертөнцийн цорын ганц хязгааргүй (хэмжээлшгүй) Бурхан билээ. Есүс Өөрийнхөө талаар тийнхүү хэлсэн байдаг. Тэрээр "Би болон Эцэг нэг юм" (Иохан 10:30) гэж хэлсэн. Түүнийг ингэж хэлэх үед иудейчүүд Тэр Өөрийгөө Бурхантай адил тэнцүү гэж хэллээ гэж ойлгосон тул Түүн уруу чулуу шидэцгээжээ. Харин Есүс тэдэнд "Үгүй, та нар намайг буруу ойлгож байна, Би үнэхээр Бурхан биш гэж" хариулсан уу? Үгүй. Есүс тэдний тайлбарыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Тэр Өөрийгөө Бурхан Эцэгтэй адил тэнцүү гэж заасан юм.

"Эцэг Би гэдэг хэллэгийг ашигласан шиг Христ ч мөн адил ашигласан юм. Учир нь энэ нь Тэр цаг хугацаанаас ангид, тасралтгүй оршоор байгааг илэрхийлдэг."
 - Иохан Хрисостом

Есүс "Абрахамаас өмнө ч Би байгаа" (Иохан 8:58) гэж хэлэхдээ Өөрийгөө бие даан Өөрөөрөө оршдог орчлон ертөнцийн Бурхан Гэтлэл 3:14 дэх "Би байгаа" юм гэж зарласан. Түүний энэхүү мэдэгдлийн төлөө иудейчүүд дахин чулуу шидэхээр оролджээ (Иохан 8:59).

Есүс газар дэлхий дээр тэнгэрлэг үйлсийг гүйцэтгэжээ

Есүс газар дэлхий дээр байхдаа тэнгэрлэг үйлсийг гүйцэтгэжээ. Тэр мөнхийн амьдралыг өгч (Иохан 10:28, унших), нүглүүдийг уучилсан (Марк 2:10). Эдгээр нь зөвхөн Бурханы хийж чадах зүйл юм.

Есүс саа өвчтэй хүнийг эдгээж, нүглийг нь уучилснаар газар дээр нүглүүдийг уучлах эрхтэй (Марк 2:5, 10-12) гэдгээ нотолсон. Нэг үйлдэл нөгөө үйлдлийнхээ нотолгоо болж

байсан нь Есүс Бурханаар тослогдсон жирийн нэг эш үзүүлэгчийн хувьд эдгээх гайхамшгийг үйлдээгүй болохыг харуулдаг. Есүст эдгээх болон уучлах тэнгэрлэг эрх мэдэл ба хүч байсан.

Есүс мөн "Амилал ба амь бол Би байгаа юм" (Иохан 11:25) гэж хэлснийхээ дараа Лазарыг амилуулсан юм. Энэ нь мөн л Бурхан гэдгийг нь харуулж байгаа бурханлаг үйлс байв. Зөвхөн Бурханы хүч л хүн бүрийг үхэгсдээс амилуулж чадах учраас зөвхөн Бурхан л Өөрийгөө амилал гэж хэлж чадна. Есүс Өөрийгөө Амь өгөгч гэж зарлаад дараа нь Лазарт амийг өгсөн нь Өөрийгөө хэн болохыг харуулж буй үйлдэл юм. Энэхүү үйл явдлаар Есүс Өөрийгөө бусад эш үзүүлэгчид болон Бурханы хүчээр хүмүүсийг үхэгсдээс амилуулсан элч нараас тодорхой ялгаж чадсан. Тэдний хэн нь ч өөрсдийгөө гайхамшгуудыг үйлдэх эрх мэдэлтэй гэж мэдэгдэж байгаагүй юм. Тэд зүгээр л Бурханы зэмсэг байв. Иохан 5:21-д Есүс, Эцэг үхэгсдийг амилуулдаг шиг Хүү ч бас амилуулдаг гэж хэлсэн.

Есүс гайхамшгуудаа үйлдэхдээ Өөрийн алдрыг илчилсэн (Иохан 2:11). Энэ нь Эцэгээс ирсэн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл, үнэнээр дүүрэн байв (Иохан 1:14). Эдгээр гайхамшгууд нь Бурханы Хүүгийн сүр жавхлант хүчийг харуулж, Тэр Бурхан гэдгийг баталжээ.

Есүс бол Бүтээгч бөгөөд Тэтгэгч.

Элч Иохан болон Паулын хэлснээр, Есүс бүх зүйлийг бүтээж, бүх зүйлийг хамтад нь байлгадаг бөгөөд бүх зүйл Түүний төлөө оршин байгаа юм (Иохан 1:3; Колоссай 1:17, унших). Үүнийг Бурханаас өөр хэн ч хэлж чадахгүй нь тодорхой.

► Есүс Бурхан гэдгийг мэдэх нь бидний хувьд яагаад чухал вэ?

Есүс Бурхан учраас,

1. Түүний золиос бүхий үхэл нь хязгааргүй үнэ цэнтэй бөгөөд дэлхийн нүглийг уучлахад хангалттай юм (1 Иохан 2:2).
2. Түүнд биднийг аврах хүч бий; Тэр бол зам, үнэн, амь мөн (Иохан 14:6).
3. Бид Эцэгийг мөргөн хүндэтгэдэг шигээ Түүнийг мөргөн хүндэтгэх ёстой (Иохан 5:23, унших).

Хэрэв бид Есүсийг Бурхан гэж харж чадахгүй бол Түүнийг Бурхан гэж хүндлэхгүй. Хэрэв бид Эцэг ба Хүүг хоёуланг нь Бурхан гэж хүндлэхгүй бол аврагдах боломжгүй.

Христитгэл нь зөвхөн Есүсийн сургаал ба үйлсээс гадна онцгой бодгаль Есүс дээр суурилдаг. Тэр зөвхөн авралын мэдээг дамжуулдаг багш биш юм. Тэр Өөрөө Аврагч, зөвхөн Тэр Бурхан-хүн бөгөөд Аврагч байж чадах байв.

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Есүс Бурхан гэдгийн Библийн баримтуудыг энэ хичээлийн төгсгөлд буй "Есүсийн Бурхан чанарын талаарх Бичвэрийн нотолгоо" хэсгээс үзнэ үү.

Есүс бол нэг бодгаль

Хэдийгээр Есүст Бурханы бүх мөн чанар болон хүний бүх мөн чанар байдаг ч Тэр хоёр бодгалийн нэгдэл биш юм. Хоёр мөн чанар нь Түүний дотор нэг бодгальд төгс зохицдог. Есүс бол цорын ганц Бурхан-хүн бөгөөд үйлс бүрийг нь Түүний бүрэн дүүрэн хүн, бүрэн дүүрэн Бурхан чанарынх нь үүднээс ойлгох ёстой юм. Чуулган Есүсийн доторх хоёр мөн чанарыг бие биенээс нь салгаж болохгүй гэж үргэлж сургасаар ирсэн хэдий ч тэдгээр нь мөн чанараа алдах хэмжээнд хоорондоо холилддоггүй.¹⁰

Есүсийн мөн чанарыг Ариун Бичвэрийн мөн чанартай харьцуулах нь тустай байж болох юм. Есүсийн адил, Библи нь бүрэн тэнгэрлэг мөн бүрэн хүний ном билээ. Хүний ном болохын хувьд энэ нь бусад номуудтай адил шинж чанарыг агуулдаг ч ямар ч алдаа мадаггүй гэдгээрээ онцлогтой. Харин тэнгэрлэг ном болохын хувьд өөр ямар ч номд байдаггүй тийм шинж чанаруудыг өөртөө агуулдаг. Үүнтэй адил, Есүс хүний болон Бурханы чанарыг хоёуланг харуулдаг. Библи нь тэнгэрлэг шинж чанарыг агуулдаг учраас бусад номуудаас доогуур гэж бид үздэггүй. Үүний нэгэн адил, Есүс Өөрийн Бурхан чанарын хүрээнд үйлдэх нь Түүнийг хүмүүн бус болгохгүй. Түүнчлэн Есүс хүмүүн чанараараа үйлдэх нь Түүнийг Бурхан бус болгодоггүй.

Онол сургаалын нийтлэг алдаанууд

Хүмүүс Христийн талаар ярихдаа гаргадаг онол сургаалын нийтлэг алдаанууд нь:

- Есүс Бурхан гэдгийг үгүйсгэх
- Есүс хүн гэдгийг үгүйсгэх
- Түүний хүмүүн болон Бурхан чанарын аль нэгийг багасгаж, чухал биш гэж үзэх
- Христийн бодгалийн нэгдмэл байдлыг үгүйсгэх

Дээрх алдаанууд бүгд Түүний биежилтийг үгүйсгэж байгаа юм. Биежилт нь бидний авралд зайлшгүй шаардлагатай байсан бөгөөд хэрэв хүн биежилтийг үгүйсгэвэл тэрээр худал сайнмэдээ, хуурамч авралд итгэхээс өөр замгүй болно.

Бусад шашнууд юу гэж хэлдэг вэ

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ангийн нэг гишүүн энэ хэсгийг тайлбарлана уу.

Еховагийн гэрчүүд Есүсийг хүн байсан гэж хэлдэг. Тэд Түүнийг хэзээ нэгэн цагт амьдарч байсан хамгийн агуу хүн байсан, хүн хэвээрээ л үлдсэн гэж үздэг. Тийм ч учраас Түүний үхэл нь бидний авралын төлөөх хангалттай тахил золиос гэдэгт тэд итгэдэггүй. Тэд үйлсээр аврагдах сайнмэдээнд итгэдэг. Тэд өөрсдийгөө Христэд итгэгч гэж ярьдаг ч тэд өөр шашинтай.

¹⁰ Калседоны тунхаг (НТ 451), 15-р хэсэгт Христийн хоёр мөн чанар нь өөрчлөгддөггүй, хуваагдалгүй, салшгүй, төөрөгдөлгүй гэж хэлсэн байдаг.

Мормончууд Есүсийг Лусиферын ах мэтээр анх Бурханаар бүтээгдэхдээ сүнс байсан гэж итгэдэг. Тэр түүнийг Есүс гэдэг хүн болгон дэлхийд илгээсэн гэж үздэг. Мормончууд Есүсийг Бурхан гэдэгт итгэдэггүй.

Муслимчууд Есүсийг Бурханаас илгээгдсэн эш үзүүлэгч байсан гэж итгэдэг. Тэд Түүнийг Бурхан, Гурвал гэдэгт итгэдэггүй. Тэд Түүнийг загалмайд цовдлогдсон эсвэл үхэгсдээс амилсан гэдэгт итгэдэггүй.

Хиндү болон Буддын шашинтнууд Есүсийг гайхамшгуудыг үйлдэж байсан ариун хүн гэж итгэдэг. Тэр тэдний шашинд тийм ч чухал биш. Тэд Бүтээгч, Эзэн Бурхан байдагт итгэдэггүй учраас Есүсийг биежсэн Бурхан гэдэгт итгэдэггүй.

Бид Түүний эвлэрүүллийн улмаас Сайн Баасан гарагийг тэмдэглэдэг

Сайн Баасан гараг нь Есүсийг цовдолсон өдөр юм. Энэ аймшигтай бөгөөд гайхалтай өдөр Есүс бидний нүглийг загалмайд үүрсэн билээ. Тэр бидний нүглийн төлөөх золиос болж үхсэн бөгөөд ингэснээр бид уучлагдсан юм.

Тахил золиос шаардлагатай байсан

Бурхан биднийг уучилж, биднийг зөвт, ариун байлгахын тулд тахил золиос шаардлагатай байсан юм. Энэхүү зарчмыг Хуучин гэрээнд Бурханы шаарддаг байсан тахилаар дамжуулан заасан юм (Еврей 9:22). Хэрэв Тэр нүглийг үндэслэлгүйгээр зүгээр л уучилсан бол энэ нь Бурхан шударга бус, нүгэл тийм ч ноцтой биш гэдгийг илтгэх байсан. Гэвч хэн ч Есүсийн загалмайд цовдлогдсон үхлийг харахдаа нүгэл нь ноцтой биш гэж хэлж чадахгүй юм. Түүний золиос бидний өршөөгдөх үндэс болсон.

Зөвхөн Есүс л хангалттай тахил золиос байж чадна

► Яагаад зөвхөн Есүс л нүглийн төлөөх тахил золиос байж чадах вэ?

Бурханы шударга ёс, нүглийн ноцтой байдал нь өөр ямар ч бүтээгдсэн зүйлсээс илүү их тахил золиосыг шаарддаг (Еврей 10:4, унших). Бид хязгааргүй Бурханы эсрэг нүгэл үйлдсэн бөгөөд энэ нь бидэнд хязгааргүй гэм бурууг авчирдаг. Тийм учраас зөвхөн Есүс л тахил золиос болж чадах байлаа. Тэр Бурхан бас хүн учраас шаардлагыг хангасан юм. Бурхан чанарынхаа улмаас Тэр нүгэлгүй байсан бөгөөд Түүний тахил золиос нь хязгааргүй үнэ цэнтэй байв. Хүмүүн чанарынхаа улмаас Тэр биднийг төлөөлж, бидний оронд үхэх боломжтой болсон юм.

Есүсийн цус Түүний золиос бүхий үхлийг төлөөлдөг

Тахил өргөх замаар эвлэрүүлэл хийгдэхийг Бурхан хүмүүст заасан байв. Тахилч нар амьтдыг алж, тэдний үхлийг төлөөлөх цусыг нь өргөдөг байжээ. Еврей номд цус урсахгүйгээр уучлал үгүй (Еврей 9:18-22) гэж бичигдсэн юм.

Цус нь амьтны амийг төлөөлдөг тул цустай онцгой байдлаар харьцахыг Бурхан хүмүүст тушаасан байдаг (Леви 17:11, 14). Цус урсах нь алах гэсэн утгатай (Эхлэл 9:5-6). Сүмд цусыг хэрэглэсэн гэдэг нь амьтны амь үрэгдсэн гэсэн үг юм.

Христийн үхэл нь бүх цаг үеийн, бүх хүмүүсийн авралыг боломжтой болгосон эцсийн тахил золиос байв (Еврей 10:4, 12, унших). Тэнгэрт өргөгдсөн Түүний цус золиос бүхий Түүний үхлийг төлөөлдөг (Еврей 9:12, 24, унших). Түүний үхлийг төлөөлдөг Түүний цус биднийг авралд хүргэдэг. Тэрээр тахил золиос болж үхсэн учраас л бид аврагдах боломжтой болсон.

Есүс яагаад өөр аргаар биш, загалмай дээр үхэх болсон юм бэ? Хуучин гэрээний цаг үед хүнийг модонд дүүжлэх нь Бурханы хараалын шинж тэмдэг байжээ (Дэд хууль 21:23). Элч Паул, Есүс модон дээр цовдлогдсоноор Бурханы хараалыг Өөр дээрээ авсан юм гэж хэлсэн байдаг (Галат 3:13).

Есүс, хүн Бурхан хоёрыг нэгдүүлсэн

Есүс, хүн ба Бурхан гэсэн хоёр тусгаарлагдсан талуудыг эвлэрүүлэхээр иржээ. Зуучлагчийн хувьд Есүс хоёр талыг нэгэн зэрэг төлөөлөх ёстой байв. Бурханы хувьд Тэрээр Бурханыг хүмүүст төлөөлсөн бол хүний хувьд Тэр хүнийг Бурханы өмнө төлөөлжээ. Хоёр талыг бүрэн төлөөлснөөр Есүс хүн ба Бурханыг нэгдүүлсэн. Эвлэрэхийн тулд хоёр талын хийх ёстой зүйлийг Тэр хийжээ.

Бид Түүний амиллын улмаас Христийн амилсан өдрийг тэмдэглэдэг

Христийн амилсан өдрийг тэмдэглэх олон уламжлалт аргууд байдаг ч маш олон хүн хийж буй зүйлийнхээ утга учрыг ойлгохгүйгээр тэмдэглэдэг. Магадгүй тэд Есүсийн амиллын талаар юу нь чухал болохыг мэддэггүй байж болох юм. Есүс цовдлогдсоныхоо дараа гурав дахь өдөр буюу амилуулагдсан өдрийнхөө өглөө булшнаас босжээ. Үүгээрээ Тэр нүгэл, үхэл, чөтгөрийг ялан дийлэх хүчтэй гэдгээ харуулсан юм. Тэр бидний үхлийг аваад зогсохгүй, амийг өгч ялан дийлсэн. Тэр ялалт байгуулсан учраас бид ч бас ялан дийлэх болно!

Есүс биеэр амилсан

Есүс нэг удаа иудейчүүдэд хандан “Энэ сүмийг нураа. Би үүнийг гурван өдрийн дотор босгоно” хэмээн хэлж байсан. Хэдийгээр иудейчүүд Түүнийг Херодын барьсан сүмийн талаар хэлж байна гэж бодсон ч Иоханы Сайнмэдээнд Есүс үнэн хэрэгтээ Өөрийн биеийн талаар өгүүлсэн болохыг тайлбарласан байдаг (Иохан 2:19-21). Сайнмэдээний бүх номд Есүсийг оршуулснаас хойш гурван хоногийн дараа Түүний булш хоосон байсан тухай тэмдэглэжээ. Есүс амилсныхаа дараа дагалдагч нартаа Өөрийгөө харуулж, “Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм” (Лүк 24:39) гэж хэлсэн. Тэрээр бие махбодоороо үхлээс амилсан гэдгээ батлан өгүүлжээ.

► Хэрэв Есүс үхлээс амилаагүй бол ямар ялгаа байх байсан бэ?

- 1. Есүс биеэр амилсан нь Тэр нүгэл ба үхлийг бүрэн ялсан гэдгийг харуулсан** (Колоссай 2:12-15; Илчлэл 1:17-18, унших).

2. **Есүс биеэр амилсан нь Тэр Өөрийнхөө талаар юу гэж хэлж байсныг баталсан** (Матай 17:22-23, Иохан 2:16-22). Тиймээс энэ нь сайнмэдээг ч мөн нотолсон. Есүсийг үхлээс амилсан гэдгийг үгүйсгэдэг хүмүүс сайнмэдээг ч мөн үгүйсгэдэг (1 Коринт 15:17, унших).
3. **Есүсийн амилал нь бид ч мөн үхлээс амилуулагдана гэдгийг баталдаг.** Есүс үхэгсдийг амилуулна гэж амласан юм. Хэрэв Тэр Өөрөө босож ирээгүй бол энэ амлалт нь итгэхийн аргагүй байх байсан (Иохан 5:28-29). Бид Есүсийн алдаршуулагдсан биетэй адил биетэй байхаар амилуулагдах болно (1 Иохан 3:2, унших).

Есүс хүн хэвээрээ

Амилал нь Христийн биежилт өөрчлөгдөшгүй гэдгийг бидэнд харуулдаг. Есүс үргэлж хүн хэвээрээ мөн Бурхан хэвээр байх болно. Есүс Бурхан-хүн хэвээрээ байгаа бөгөөд Тэр одоо ч Эцэгт хандан бидний төлөө зуучлан залбирдаг (Ром 8:34). Тэрээр хэзээ нэгэн цагт биднийг тэнгэрийн улсад аваачихаар эргэн ирэх болно (1 Тесалоник 4:16-17).

Есүс хэн болох, Түүний хийсэн зүйлийн улмаас бид Түүнийг түшдэг

Итгэгчид бид өдөр бүр Христтэй харилцаж амьдардаг. Тэр зөвхөн түүхэнд байсан хүн төдий биш, зөвхөн тэнгэрт байдаг Бурхан ч биш, харин бидэнтэй хамт байдаг Нэгэн. Тэрээр дагалдагч нартайгаа үргэлж хамт байгаа амласан (Матай 28:20).

Тэр онцгой байдлаар чуулганд оршдог. Тэрээр чуулганы Тэргүүн бөгөөд чуулганыг Түүний Бие гэж нэрлэдэг (Ефес 1:22-23). Тэрбээр чуулганыг удирдан чиглүүлж, хамтад нь тогтоон барьж, хангаж байдаг (Колоссай 2:19, унших).

Есүсийн тухай үнэнийг хүлээн авдаг хүн итгэл, дуулгавартай байдлаар хариу үйлдэх ёстой. Та бусдыг итгэгч болоход нь тусалж, дараах байдлаар дагуулан залбирч болно.

Аав аа, Та Өөрийн Хүү Есүсийг миний төлөө дэлхийд илгээж, намайг ийм ихээр хайрласанд баярлалаа. Есүс нүгэлгүй амьдарсан, Бурхан-хүн бөгөөд миний нүглүүдийг уучлахын тулд, Тантай харилцах харилцааг минь сэргээхийн төлөө нас барж, амилсан гэдэгт би итгэж байна. Би үйлдсэн бүх нүгэлдээ маш их харамсаж байна. Миний нүгэл Есүсийг загалмайд хадсан гэдгийг би мэдлээ. Яг одоо би буруу гэж мэдсэн бүх зүйлээсээ татгалзаж, Есүсийг Эзэн, Аврагч гэж хүлээн авч байна. Энэ өдрөөс намайг удирдаач. Би Таны төлөө үүрд амьдрах болно! Намайг уучилсанд баярлалаа. Би Танд хайртай. Амен.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Есүс нь Мессиа бөгөөд бүхний Эзэн, онгон эмэгтэйгээс төрсөн Бурханы Хүү, нэг бодгаль дотор хүмүүний бүх мөн чанар ба Бурханы бүх мөн чанарыг агуулдаг. Тэрээр нүгэлгүй амьдралаар амьдарч, бидний нүглийг уучлахын тулд золиос болон үхсэн. Тэр үхлээс

амилуулагдсан бөгөөд буцаж ирэхдээ бүх итгэгчдийг амилуулах болно. Түүний хаанчлал нь бүх орчлон ертөнцийг хамарсан бөгөөд төгсгөл үгүй юм.

Есүсийн хүмүүн чанарын талаарх Бичвэрийн нотолгоо

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Энэ хэсэг болон дараагийн хэсгийг сонгож суралцах боломжтой. Хэрэв ангийнхан эдгээр зүйлийн талаар Библийн нотолгоо авахыг хүсвэл тэдгээрийг нэмэлтээр үзэж болно.

Есүс Евагийн үр удам (Эхлэл 3:15), Абрахамын үр (Эхлэл 22:18-ыг Үйлс 3:25-тай харьцуул), эмэгтэйгээс төрсөн (Галат 4:4), Мариагаас төрсөн (Матай 1:21-25), Хүний Хүү гэж нэрлэгддэг (Матай 13:37) бөгөөд хүний өсөлт төлөвшилтийн ердийн үйл явцыг туулсан (Лук 2:40, 52).

Түүнийг төрөлх хотдоо эргэн ирэх үеийн хүмүүсийн хариу үйлдэл нь Түүний бага нас хэвийн байсныг харуулдаг (Матай 13:54-56).

Тэр хүний ёсыг дагахын тулд бие махбодтой байв (Еврей 10:5-9); Тэр мах цус болсон (Еврей 2:14); Тэр бидэнтэй адил зовж шаналахын тулд бидний адил бүтээгдсэн (Еврей 2:10-18); Тэрээр зовлонгоор дамжин төгс болгогдсон (Еврей 2:9-10); Мөн Тэрбээр хүнд тохиолддог сорилтуудыг ч туулсан (Еврей 4:15).

Тэр хүн төрхийг олсон (Филиппой 2:6-8).

Тэрээр Бурханы мөнхийн Үг байсан бөгөөд махбод болж, газар дэлхий дээр амьдарсан (Иохан 1:14).

Христитгэлийн чухал сургаал нь Есүсийн хүмүүн мөн чанар юм (Иохан 1:14; 1 Иохан 4:2-3).

Есүсийн Бурхан чанарын талаарх Бичвэрийн нотолгоо

Есүсийг Бурхан гэдгийг батлах гурван арга зам:

1. Түүнийг Бурхан гэж нэрлэдэг.
2. Тэр Бурханы шинж чанаруудыг харуулсан.
3. Тэр Бурханы үүрэг оролцоог харуулсан.

Есүсийг Бурхан гэж нэрлэдэг

- Иохан 1:1, 14-д Мөнхийн Үг нь Бурхан байсан гэж хэлжээ.
- Иохан 12:41-д Исаиа Есүсийг харсан гэж бидэнд хэлсэн.
- Үйлс 20:28-д Тэр Бурханы чуулганыг Өөрийнхөө цусаар худалдан авсан гэж айлдсан.
- Ром 9:5-д Христ ирсэн бөгөөд Тэр бол үүрд мөнхөд магтагдах Бурхан мөн хэмээжээ.

- Тит 2:13-д Түүнийг Бурхан ба Аврагч Есүс Христ гэж хэлсэн.
- Матай 1:23-д (Исаиа 7:14-өөс эш татсан) Түүний нэрийн утгыг “Бурхан бидэнтэй хамт” гэжээ.
- Исаиа 9:6-д Түүнийг Хүчит Бурхан гэж дуудах талаар өгүүлсэн.
- 1 Тимот 3:16-д Бурхан махбодоор илчлэгдсэн, үндэстнүүдийн дунд тунхаглагдсан, сүр алдраар дээш авагдсан гэжээ.
- Иохан 10:30, 33-д Би болон Эцэг нэг юм гэж Есүс хэлсэн байдаг.
- Иохан 5:17-18-д Есүс Өөрийгөө Бурхантай адилтгасныг иудейчүүд мэдэж байсан.
- Иохан 14:9-д “Намайг харсан нь Эцэгийг харсан” гэж Есүс хэлсэн.
- Иохан 20:28-29-д Томас Түүний сорви, ормыг харахдаа “Эзэн минь, Бурхан минь” гэхэд Есүс итгэсэн нь ерөөлтэй еэ гэж айлдсан.
- Иохан 8:58-д Тэр Өөрийгөө “Би байгаа” гэж хэлэхэд Тэр Өөрийгөө Бурхан гэж хэллээ гэдгийг иудейчүүд мэдэж байсан.
- Илчлэл 1:17, Илчлэл 2:8, болон Илчлэл 22:13-д Тэр Өөрийгөө Эхэн ба Эцэс гэж хэлсэн бол Исаиа 44:6-д энэ хэллэг нь Бурханд хамаатай байдлаар бичигдсэн.
- Еврей 1:2-3-д Тэр бол Эцэгийн бүрэн дүүрэн дүр төрх гэдгийг бидэнд хэлсэн.
- Еврей 1:8-д Хүүг Бурхан хэмээн хандан хэлсэн.

Есүст Бурханы шинж чанарууд бий

Хаа сайгүй оршдог. Матай 18:20-д хоёр эсвэл гурван итгэгч хамт цуглавал Есүс тэдний дунд байна гэж хэлсэн бол Матай 28:20-д итгэгчидтэй үргэлж хамт байна гэж Тэр амласан.

Бүгдийг чаддаг. Еврей 1:3-д Тэр бүх зүйлийг Өөрийн хүчээр барьж байдаг гэж хэлсэн. Филиппой 3:21-д Тэр бүх юмсыг Өөртөө захируулдаг гэж бичигдсэн.

Мөнхийн. Еврей 13:8-д Тэр мөнхөд хэвээрээ гэж хэлэгдсэн бол Еврей 1:12-д Түүнийг үүрд хэвээрээ гэж хэлсэн. Энэ эшлэлийг Дуулал 102:25-27-оос эш татсан бөгөөд энэ нь Бурханы талаар өгүүлдэг.

Бүхнийг мэддэг. Иохан 2:24-25-д Тэр бүх хүмүүсийг мэддэг бөгөөд тэдний зүрх сэтгэлд юу байгааг ч мэддэг тухай өгүүлсэн. Иохан 10:15-д Эцэг Түүнийг мэддэг шиг Тэр Эцэгийг мэддэг гэж хэлсэн байдаг.

Есүст Бурханы үүрэг оролцоо бий

- Есүс бол Бүтээгч (Колоссай 1:16; Еврей 1:10).
- Есүс нүглийг уучилсан (Лук 5:20-24, Лук 7:48).
- Эцсийн шүүлтэд Есүс шүүх болно (Матай 25:31-46; 2 Коринт 5:10).

- Эцэгийн адил Есүс мөргөл хүндэтгэлийг хүлээн авсан (Иохан 5:22-23; Еврей 1:6; Илчлэл 5:12-13).

7-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Марк 1:1-12
- Иохан 5:19-26
- Иохан 6:44-51
- Иохан 8:51-59
- Үйлс 2:22-36
- Илчлэл 1:12-18

(2) Сорил: Дараагийн хичээлийг 7-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

7-р хичээлийн сорил

(1) Мессиагийн нэн тэргүүний зорилго юу байсан бэ?

(2) Эртний чуулган “Есүс бол Эзэн” гэж хэлэхдээ ямар санааг илэрхийлдэг байсан бэ?

(3) Есүс ямар байдлаараа Бурханы онцгой Хүү нь вэ?

(4) Биежилт гэж юу вэ?

(5) Есүс хүн гэдгийг мэдэх гурван чухал шалтгааныг жагсаана уу.

(6) Есүс Бурхан гэдгийг мэдэх гурван чухал шалтгааныг жагсаана уу.

(7) Тахил золиос шаардлагатай байсан хоёр шалтгаан юу вэ?

(8) Есүс яагаад өөр аргаар биш, загалмай дээр үхэх болсон бэ?

(9) Есүс биеэр амилсан ач холбогдлын талаарх гурван шалтгааныг жагсаана уу.

8-р хичээл

Аврал

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Хүмүүс яагаад загалмайд дургүйцдэг вэ?
- Нүгэлт хүний нөхцөл байдал.
- Уучлалын төлөө эвлэрүүлэл хийх шаардлага.
- Гэмшлийн утга учир.
- Авралын итгэлийн бүрэлдэхүүн хэсэг.
- Эвлэрүүлэл яагаад бүх хүн, бүхий л нүгэлд хангалттай вэ?
- Хувь хүний авралын баталгааны үндэс.
- Бүх бүтээлийн чөлөөлөлт.
- Авралын талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь гэмшлийг онцолдоггүй шашны алдааны талаар ойлгож авна.

Танилцуулга

► Дуулал 85-ыг хамтдаа унших. Энэхүү багц эшлэлд авралын тухай юу өгүүлж байна вэ?

Загалмай

Загалмай бол христитгэлийн хамгийн чухал бэлгэдэл юм. Загалмай нь бүхий л түүхийн гол цөм болсон үйл явдлыг илэрхийлдэг. Загалмай нь христитгэл ба бусад шашны ялгааг харуулдаг.

Есүсийн үхлийн учрыг ойлгоогүй учраас олон хүний хувьд загалмай нь нууцлаг ойлголт байсаар байдаг. Түүгээр ч зогсохгүй Есүс биднийг хайрлаж, аврахыг хүссэндээ амиа өргөсөн гэдгийг сонслоо ч, тэр үйл явдал яагаад тохиолдох ёстой байсныг тэд сайн ойлгодоггүй. Тиймээс “Хэрэв Бурхан биднийг аврахыг хүссэн юм бол тэрийгээ зүгээр хийчихгүй яасан юм бэ?” гэж асуудаг.

Анхны итгэгчид ч сайнмэдээг тунхаглаж эхлэх үедээ эхэндээ загалмайн талаар будилсан ойлголттой байв (1 Коринт 1:22-23, унших). Еврейчүүдийн бодлоор Бурхан Өөрийгөө агуу хүчээр илэрхийлэх ёстой байлаа. Тэд харийн дарлалаас чөлөөлөгдөхийг аврал гэж үзэж байсан учраас тэдний хувьд загалмай нь сул дорой байдал, бүтэлгүйтэл байв. Грекчүүдийн бодлоор Бурхан Өөрийгөө мэргэн ухаанаар илэрхийлэх ёстой байлаа. Тэд хамгийн сайн сайхан амьдрахыг заасан тайлбарыг олох л аврал гэж үзэж байсан тул тэдний хувьд загалмай нь мунхаглал, бүтэлгүйтэл байжээ.

► Хүмүүс яагаад загалмайд дургүйцдэг вэ?

Олон хүний хувьд загалмай нь доромжлол мэт санагддаг. Олон ч хүн шашинлаг байхыг хүсдэг. Тэд ямар нэгэн харагдах юманд итгэж, шашны зан үйл хийж, зөвлөгөө авч байхыг хүснэ. Тиймээс нүгэлт хүнийг уучлахын тулд загалмай хэрэгтэй гэх санаанд тэд дургүйцэн уурсдаг аж. Тэд хүмүүний үйл хэрэг, зан авирыг Бурхан эсэргүүцэх ёсгүй гэж боддог. Загалмай нь хүн гэгч уучлал хэрэгтэй нүгэлтэн гэдэг утгыг илэрхийлдэг учраас хүмүүс загалмайд дургүйцдэг.

Есүс загалмай дээр золиос болж үхсэн гэдгийг ойлгохын тулд хүний нүгэлт нөхцөл байдал болон Бурханы ариун мөн чанарын дундах асар том мухардмал байдлыг ойлгох ёстой. Түүнчлэн эвлэрүүлэл яагаад Бурханы уучлалыг хүртэх боломж болохыг ойлгоно гэсэн үг.

Хүний нөхцөл байдал

Адамын нүглээс болж бүх хүн Бурханаас тусгаарлагдсан мөн чанартай төрдөг болжээ (Ром 5:12). Өөрөөр хэлбэл бүх хүн өөртөө төвлөрсөн, дурын замаараа явдаг болсон байна. Хүн сонголт хийж эхэлмэгцээ нүгэл үйлдэж эхэлдэг. Тиймээс **нүгэлтэн бүр олон нүгэлт үйлдлийнхээ улмаас гэм буруутай** (Ром 3:23, унших).

Бурханы хуулийг зөрчих нь нүгэл юм (1 Иохан 3:4; Иаков 2:10-11). Бурхан туйлын шударга учраас нүглийг зүгээр өнгөрүүлэхгүй бөгөөд хүн бүр хийсэн бүхнийхээ төлөө шүүгдэнэ (2 Коринт 5:10; Илчлэл 20:12-13). Хэн ч гэм буруу, хүртэх шийтгэлээсээ бултаж чадахгүй. Үл итгэгч хүн бүр хэдийн яллагджээ (Иохан 3:18-19, унших).

Нүглээ гэмшээгүй хүн Бурханы дайсан юм (Ром 5:10). Бурханы эсрэг үйлдсэн гэмт хэргээ арилгахгүй л бол нүгэлтэн Бурхантай харилцаатай байх боломжгүй.

Нүгэлтнийг нүгэлт нөхцөл байдал нь Бурхантай харилцаа тогтоох боломжгүй болгодог. **Нүгэлтэн хүсэл тачаалдаа ялзарсан байдаг** (Ефес 2:3). Тэрээр нүглийн боол учраас **өөрийнхөө нөхцөл байдлыг өөрчлөх хүчгүй** (Ром 6:20, Ром 7:23, унших).

Тиймээс нүгэлтэнд хэрэгтэй аврал гэж юу вэ? Нүгэлтэй хүн гэм буруутай учраас аврал нь уучлал гэсэн утгатай. Нүгэлтэн Бурханы дайсан учраас аврал нь эвлэрүүлэл юм. Хүн гажуудаж ялзарсан учраас аврал нь цэвэрлэх гэсэн утгатай. Түүнчлэн хүн хүчгүй учраас аврал нь чөлөөлөлт юм. Эдгээр нь нүгэлт хүнд хэрэгтэй авралын цөөн хэдэн талбар юм.

“Нүгэлт хүн Бурханы өмнө хэрхэн зөвд тооцогдох вэ? гэх асуулт хүн бүрийн хувьд чухал.

Учир нь бид Бурхантай дайсагнаж байгаа цагт түр зуур ба үүрдийн алинд нь ч бидэнд жинхэнэ амар тайван, баттай баяр хөөр гэж үгүй.”

- Жон Веслей

“Итгэлээр зөвд тооцогдох нь”
сургаалаас

Мухардал

Хүн нүглийнхээ төлөөсийг өөрөө төлж чадахгүй. Эхний шалтгаан нь бидэнд байгаа бүх зүйл угаасаа Бурханых юм. Үүнээс илүү чухал шалтгаан нь нүгэл бол хязгааргүй Бурханы эсрэг үйлдсэн гэмт хэрэг бөгөөд үүнийг төлж чадах хязгааргүй үнэ цэнтэй ямар нэгэн зүйл хүмүүст байхгүй аж.

Хүмүүс энэ хэрэгцээгээ хангах юу ч хийж чадахгүй төдийгүй, авралыг гүйцэлдүүлж чадах ямар ч болзол шаардлагыг тэдэнд зориулан тогтоож өгөх боломжгүй байсан (Галат 3:21). Хэрэв хүмүүс авралыг өөрсдөө олж авах боломжтой байсансан бол Есүс загалмай дээр үхэх ямар ч хэрэггүй байх байв (Галат 2:2, унших).

► Хэрэв Бурхан биднийг уучлахыг хүссэн юм бол загалмайгүйгээр шууд аварч яагаад болоогүй юм бэ?

Бурхан ариун бөгөөд шударга учраас үнэн ба шударга ёсны зарчмын дагуу шүүдэг (Ром 2:5-6). *Эвлэрүүлэл* гэдэг нь биднийг Бурхантай эвлэрүүлэхийн тулд Есүсийн өргөсөн тахил золиосыг илэрхийлсэн үг юм. Тэгэхээр Христийн тахил байгаагүй бол юу болох байсныг төсөөлж үзээрэй. Бурхан ямар нэг эвлэрүүлэлгүйгээр нүглийг зүгээр л уучилсан бол юу болох байсан бол?

Хэрэв Бурхан нүглийг зүгээр л уучилчихвал нүгэл ноцтой зүйл биш байх байсан. Тэгвэл Бурхан шударга биш, бас ариун ч биш гэсэн үг болно. Бүр цаашилбал аливаа хүн зөвийг эсвэл бурууг үйлдэж байгаа эсэх нь Бурханы мэлмийд онцын ялгаагүй харагддаг гэсэн утгатай болно.

Хэрэв эвлэрүүлэлгүйгээр уучлал өгөгдсөн бол Бурханыг шударга бөгөөд ариун гэж байгаагаар нь магтах боломжгүй болох байлаа. Эвлэрүүлэлгүй уучлал гэдэг нь Бурханыг хүндэтгэх бус харин огтоос үл хүндэтгэсэн хэрэг болох тул тийм байх боломжгүй юм.

Харин Бурхан бол хайрладаг, уучлахыг хүсдэг Бурхан. Хэдий хүн төрөлхтөн үүнийг хүртэх ёстой байсан ч, Бурхан нүгэлт нөхцөл байдалд нь орхихыг, мөнхөд хаягдаж хоцрохыг хүсээгүй юм.

Загалмай дээр Есүсийн өргөсөн тахил нь нүглээс болж нэхэгдэж байсан хязгааргүй үнэ цэнийг төлсөн юм. Яагаад гэвэл **(1) Есүс ямар ч нүгэлгүй** (төгс, Түүнд ямар ч аврал хэрэггүй, 2 Коринт 5:21), мөн **(2) Тэрбээр Бурхан бас хүн байв**.

Түүнчлэн уучлалыг хүртэх үндэс нь эвлэрүүлэл юм. Тиймээс гэмшиж, амлалтад нь итгэсэн хүнийг Бурхан уучлах боломжтой болжээ. Загалмай дээрх тахил золиосыг ухаарч байгаа бол нүгэл Бурханы хувьд ямар ноцтой зүйл гэдгийг ойлгож чадна.

Эвлэрүүлэл бол амлалтад нь итгэсэн нүгэлт хүнийг зөвт Бурхан Өөрөө зөвт хэмээн тооцох арга зам юм (Ром 3:26, унших). Ром 3:20-26-р эшлэлд эвлэрүүллийн логик учир шалтгааныг тайлбарласан байдаг.

Бурханаас өгөгдсөн авралыг авах цорын ганц арга зам бий гэдгийг Библи бидэнд заадаг. Хэрэв хүн Христэд итгэх нигүүлслээр ирдэг авралыг үгүйсгэвээс аврагдаж чадахгүй (Марк 16:15-16; Үйлс 4:12; Еврей 2:3, унших).

Тийм учраас аврал зөвхөн нигүүлслээр ирэх бөгөөд үүнийг итгэлээр хүлээн авах тухай сургаалыг ойлгох нь маш чухал юм. Аврал зөвхөн нигүүлслээр л ирнэ. Яагаад гэвэл авралыг олж авах, хүртэж болох өөр юу ч байхгүй. Үүнийг зөвхөн итгэлээр хүлээж авна. Бидний хувьд Бурханы амлалтад итгэхээс өөр хийж чадах зүйл үнэндээ байхгүй билээ.

Анхны нигүүлсэл

► Хувь хүний авралын анхны алхмыг хэн хийдэг вэ? Бурхан уу, тэр хүн өөрөө юу?

Нүгэлтэнд аврал авчрах анхны алхмыг Бурхан хийдэг. Тэрбээр хүмүүсийг уучлах хүслээ загалмай дээр Есүсийн өргөсөн тахилаар дамжуулан илэрхийлсэн юм. Тэгэхээр Бурханы нигүүлсэл нүгэлт хүний зүрхэнд хүрч, нүглийг нь ялладаг учраас хүн уучлагдахыг хүсдэг (Тит 2:11; Иохан 1:9; Ром 1:20, унших). Нүгэлтэн Бурханы тусламжгүйгээр нүглээ хаяж чадахгүй (Иохан 6:44). Тиймээс Бурхан сайнмэдээнд хариу үйлдэх хүчийг нүгэлтэнд өгдөг. Хэрэв хүн аврагдаагүй бол нигүүлсэл дутсаных бус, харин Бурханы нигүүлсэлд тухайн хүн хариу үйлдээгүйгээс болсон байдаг.

Есүс бүх дэлхий ертөнцийн нүглүүдийн төлөө амиа өргөсөн бөгөөд Бурхан хүн бүрийг аврахыг хүсдэг (2 Петр 3:9; 1 Иохан 2:2; 1 Тимот 4:10, унших). Бурханы нигүүлслээр сайнмэдээнд хариу үйлдэх чадвар бүх хүнд өгөгдсөн байдаг боловч Тэрбээр хэнийг ч албаддаггүй. Тиймээс Бурхан нүгэлтнийг дуудаж, гэмших бас итгэх сонголтыг өгдөг (Марк 1:15).

Гэмшил

► Гэмшил гэж юу вэ?

Гэмшил гэдэг нь буцаж эргээд эсрэг зүгт явна гэсэн үг. Теологийн хувьд нүгэлтэн өөрийнхөө гэм буруутай, шийтгэл хүртвэл зохих байдлыг ухамсарлаж, нүглээсээ эргэж буцна гэсэн утгатай.

Хорон муу нь замаа, Буруу нэг нь бодол санаануудаа орхиг. Өөрийг нь өрөвдөх ЭЗЭН өөд эргэг, Өгөөмрөөр уучлах Бурханд маань эргэг (Исаиа 55:7).

Гэмшил гэдэг бол нүгэлт хүн Бурханы уучлалыг хүртэхээс өмнө зам мөрөө засан Бурханы өмнө өөрийгөө зөвт болгоно гэсэн үг биш. Тэгэх ч боломжгүй. Харин нүгэлтэн өөрийг нь нүглээс чөлөөлж аврахыг Бурханаас хүсэх ёстой юм.

► Аврал зөвхөн нигүүлслээр өгөгдөх юм бол гэмшил ямар хэрэгтэй юм бэ?

Итгэл бол уучлалыг авах цорын ганц шалгуур боловч, гэмшилгүй аврал гэж байхгүй. Хэрэв хүн гэмшихийг хүсэхгүй байгаа бол тэр хүн нүглээс аврагдахыг хүсэхгүй байгаа хэрэг. Хэрэв Бурхан нүглээ үйлдсээр байгаа гэмших хүсэлгүй хүмүүсийг уучилбал газар дэлхийн зөвт шүүгчийн хувьд ингэх нь Түүнд ичгүүртэй явдал болно. Гэмшил заавал

шаардлагатай. Учир нь гэмшихгүй байгаа хүн нүглийн хорон муу чанарыг зөвшөөрөхгүй байна гэсэн үг. Хэрэв хүн нүглээс яагаад эргэх ёстойгоо ойлгохгүй байгаа бол түүнд уучлал яагаад хэрэгтэй гэдгийг ч бас ойлгохгүй байна.

Хэрэв хүн өөрийгөө гэм буруутай гэж үзэхгүй байгаа бол ерөөсөө гэмшээгүй байгаа хэрэг. Тийм учраас ямар ч шалтаг байхгүй, шийтгэл хүртэнэ. Хэрэв хүн өөрийгөө нүгэлтэн гэж хүлээн зөвшөөрсөн хэдий ч, нүглээ үргэлжлүүлсээр байхыг хүсэж байгаа бол тэрээр бүрэн гэмшээгүй гэсэн үг. Яагаад гэвэл тэр хүн хийхгүй гэсэн юмаа хийсээр байна шүү дээ.

Авралын итгэл

► Авралын итгэлтэй хүн юунд итгэдэг вэ?

Авралын итгэлтэй хүн дараах хэдэн зүйлд итгэдэг.

(1) Өөрийгөө зөвтгөх юуг ч хийж чадахгүй.

Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно (Ефес 2:8-9).

Аврагдахын тулд хийж чадах юм (үйлс) байхгүй, бүр өчүүхэн ч байхгүй гэдгийг тэр ухаарсан байдаг.

(2) Христийн тахил золиос түүнийг уучлахад хангалттай.

Тэр Өөрөө бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл бөгөөд зөвхөн бидний нүглийн учир төдийгүй, хамаг ертөнцийн нүглийн учир билээ (1 Иохан 2:2).

Эвлэрүүлэл гэдэг нь биднийг уучлал хүртэх боломжтой болгож буй тахил золиос гэсэн утгатай. Биднийг уучлахын төлөө Христийн өргөсөн тахил золиосоос өөр юуг ч нэмэх шаардлагагүй.

“Авралын итгэл нь түшдэг итгэл бөгөөд Аврагчид бүрэн найддаг итгэл юм.”
—Жон Стотт

(3) Есүс нүгэл, үхлийг ялан дийлж, үхлээс амилсан.

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно (Ром 10:9).

Нүгэл, үхлийг ялах цорын ганц зам нь Есүсийн амилал байлаа. Есүс эргэж амилснаараа нүгэл, үхлийн аль алиныг бүрэн ялсан гэдгээ баталсан юм.

(4) Бурхан түүнийг итгэлийнх нь үндсэн дээр л уучилсан.

Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ (1 Иохан 1:9).

Аврал авахад нэмэлт шаардлага бий гэж үзэх юм бол, хүн зөвхөн нигүүлслээр биш харин үйлсийн оролцоотой аврагдана гэж бодоход хүрнэ.

Баталгаа

► Аврагдсан гэдгээ хүн яаж баттай мэдэх вэ?

Зарим хүн мэдрэмжиндээ тулгуурладаг. Гэхдээ мэдрэмж өөрчлөгддөг, бас төөрөлдүүлдэг. Аврагдсан гэдгээ баттай мэдэж болно хэмээн Библи бидэнд хэлж байна (1 Иохан 5:13). Бурхан биднийг хүлээн авсан гэдэгт бид итгэлтэй байж болно. Бид айдастай амьдрах ёсгүй, яагаад гэвэл биднийг Бурханы хүүхэд болж үрчлэгдсэн гэдгийг Бурханы Сүнс бидэнд баталдаг. Биднийг Бурханы хүүхэд болсныг Ариун Сүнс бидний сүнстэй хамт гэрчилдэг хэмээн Элч Паул хэлжээ (Ром 8:15-16).

Энэ нь бүрэн баталгаатай тул бид Шүүлтийн өдрөөс айх ёсгүй юм (1 Иохан 4:17, унших). Зарим хүн өөрийгөө тэнгэрийн улсад хүлээн зөвшөөрөгдөх байх гэж би найддаг гэж хэлдэг. Гэхдээ бидэнд үүнээс илүү сайн баталгаа бий. Аврал хүн төрөлхтөнд чиглэгдсэн гэдэгт ерөнхийдөө итгэх нь хангалттай бус, харин аврагдсан гэдгээ хувь хүн өөрөө мэдэх ёстой юм.

Өөрчлөгдсөн амьдрал нь тухайн хүний аврагдсаны нотолгоо боловч, тэрхүү нотолгоо нь эхний мөчид харагдахгүй. Авралын үр дүн харагдахад хугацаа хэрэгтэй. Тиймээс гэмшсэн цаг мөчид өөрчлөгдсөн амьдрал нь авралын баталгааны үндэс болж чадахгүй. Авралд хүргэх Библийн арга замыг дагасан бол итгэгч хүн аврагдсан гэдэгтээ баттай байж чадна. Хэрэв хүн үнэхээр гэмшиж, Библид заасны дагуу итгэж л байгаа бол Бурханы уучлалыг хүртэж, Бурханы хүүхэд болсон гэдэгтээ итгэлтэй байх эрхтэй.

Хэрэв хүн үнэхээр гэмшээгүй мөртлөө аврагдсан гэдгээ мэдрэхийг хүсвэл тэр хүн төөрөлдөж, өөрийгөө хуурах болно.

Хэрэв хүн (1) үнэхээр гэмшвэл, (2) Бичвэр дэх Бурханы амлалтад итгэвэл, (3) Сүнсний гэрчлэлийг хүлээн авсан бол, тэр хүн хууртагдахгүй. Энэхүү баталгаа нь Бурханы Үгэнд суурилсан, туйлын найдвартай үг юм. Бурхан үргэлж амлалтаа сахидаг.

Авралын шинж чанарыг агуулсан 10 үгс

Эвлэрэл: Энэ үг өмнө нь дайснууд байсан бол одоо эв найрамдалтай болсон гэсэн санааг агуулдаг. Авралаар Бурхан биднийг Өөртэйгөө эвлэрүүлж, бид Түүнтэй эв найрамдалтай болсон (2 Коринт 5:19; Ром 5:1, унших). Эдгээр эшлэлд зөвтгөл болон эвлэрлийн талаар өгүүлдэг.

Цагаатгал: Энэ үг тэмдэглэгээг арилгасан гэсэн утгатай. Авралаар бидний нүглийн бүртгэл устаж арилсан юм (Еврей 8:12, унших).

Тайвшруулал: Энэ үг хэн нэгний уурыг намжаахын тулд ямар нэг юмыг өгсөн гэсэн утгатай. Аврал дахь Есүсийн өргөсөн тахил нь бидний эсрэг чиглэсэн Бурханы зөвт байдлын уур хилэнг намжаасан юм (1 Иохан 2:2, унших).

Чөлөөлөлт: Энэ үг нь хүн өөр хэн нэгний эрхшээлээс аврагдсан гэсэн утгатай. Авралаар бид Сатаны эрхшээл, нүглийн хүчээс чөлөөлөгдсөн юм (Лук 1:74; Ром 6:6, 12-18, унших).

Золин авах: Энэ үг хэн нэгнийг эрх чөлөөтэй болгохын тулд үнийг төлж авах гэсэн утгыг агуулдаг. Авралаар биднийг нүглийн боолчлол ба шийтгэлээс чөлөөлөх үнэ төлөөсийг Есүс үхлээрээ төлсөн юм (Ефес 1:7; Тит 2:14, унших).

Зөвтгөл: Энэ үг нь хэн нэгнийг зөвт, гэм буруугүй гэж зарласан гэсэн утгыг агуулдаг. Авралаар гэм буруутай нүгэлтний оронд Есүс зовж шаналсан учраас нүгэлтэн зөвт тооцогддог (Ром 5:1; 2 Коринт 5:19, унших). Эдгээр эшлэлд зөвтгөл ба эвлэрлийн талаар өгүүлдэг.

Ариусгал: Энэ үг нь хэн нэгнийг ариун болгох гэсэн утгатай. Авралаар гэм буруутай нүгэлтэн Бурханы хүүхэд болж өөрчлөгддөг. Шинэ гэрээний олон захидалд итгэгчдийг "ариун хүмүүс" хэмээн нэрлэсэн байдаг (Ефес 1:1, Филиппой 1:1, Колоссай 1:2, унших).

Үрчлэл: Энэ үг нь хэн нэгэн хүн өөр хүний хууль ёсны хүүхэд болно гэсэн утгатай. Авралаар бид Бурханы хүүхдүүд болсон (Иохан 1:12; Ром 8:15, унших).

Дээрээс төрөх / Шинээр төрөх: Энэ үг нь хүн амийг дахин эхлүүлэх гэсэн утгыг агуулдаг. Авралаар итгэгч нь өөрийнхөө доторх амилуулагдсан сүнслэг амьдрал бүхий шинэ амийг эхлүүлдэг (Ефес 2:1; Иохан 3:3, 5, унших).

Тамгалах: Энэ үг нь алив зүйлийг хэн өмчилж байгааг илэрхийлэх тэмдэглэгээ гэсэн утгатай. Авралаар бидний доторх Ариун Сүнс биднийг Бурханд хамаатай болсныг тодорхойлж өгдөг (Ефес 1:13-14, унших).

Алдаанаас зайлсхийх: Гэмшдэггүй шашин

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ангийн нэг гишүүн энэхүү хэсгийг тайлбарлана уу.

Аврал нь итгэлээр дамжуулан нигүүлслээр ирдэг гэдгийг сонсоод өөрийгөө аврагдсан гэж амарханаар боддог хүмүүс байдаг. Гэмших хэрэгтэй гэдгийг ойлгоогүй учраас тийм хүн жинхэнээсээ гэмшээгүй байдаг ба өөрийгөө Бурханы шийтгэл хүртэх ёстой нүгэлтэн гэдгээ огт олж хараагүй байдаг аж. Тийм хүн нигүүлслийг өөрийнхөө замаар явах гэж ойлгодог. Христитгэлийн үнэнийг хүлээн зөвшөөрсөн учраас тэр өөрийгөө Христэд итгэгч болсон гэж боддог боловч үнэндээ ямар ч өөрчлөлт байдаггүй. Тийм хүн хэзээ ч өөрийн хүслээсээ татгалздаггүй. Харин Бурханыг амьдралынхаа нэг хэсэг болгон хүлээн зөвшөөрсөн атлаа ихэвчлэн өөрийнхөө хүслийг дагаж амьдардаг. Бичвэрт заасан Бурхантай харилцах авралын харилцааны эхлэл ийм байдаггүй.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Есүс Христийн амьдрал, үхэл, амилал нь дэлхий ертөнцийн нүглийн төлөөсийг төлсөн юм. Хүн бүр нүглийн ял зэмтэй бөгөөд өөрийгөө аврах чадваргүй. Гэхдээ гэмшсэн хүн бүр итгэлээрээ Бурханы нигүүлслийг хүлээн авч болно. Итгэгч хүн уучлагдаж, нүглийн хүч ба шийтгэлээс чөлөөлөгддөг. Ариун Сүнс итгэгч хүнийг гэм буруутай нүгэлтнээс Бурханы ариун мөргөн хүндлэгч болгон өөрчилдөг. Авралын өөр арга зам гэж үгүй. Бүх бүтээл золин аврагдаж, эцэст нь Бурханаар сэргээгдэх болно.

Хуучин гэрээн дэх аврал

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Энэ болон дараагийн хэсгийг сонгож суралцах боломжтой. Хэрэв гишүүд эдгээр сэдвийг сонирхож байвал ангид үзэж болно.

Хуучин гэрээнд Бурхан мөргөл хүндэтгэл, тахилын тогтолцоог зааж өгчээ. Гэхдээ тахил өргөснөөр Есүсийн хийсэн шиг авралыг олж чадахааргүй байжээ. Учир нь Библид “бүх, ямааны цусаар нүглийг авч хаях боломжгүй юм” (Еврей 10:4) хэмээн хэлсэн байна. Тэгвэл яагаад тахил өргөдөг байсан бэ? Тахил өргөх нь мөргөл хүндэтгэлийн нэг хэлбэр байсан ба үүгээр хожим Христийн өргөх тахилыг бэлгэджээ (Еврей 10:1).

Гэхдээ энэ нь Шинэ гэрээний үе иртэл аврагдах боломжгүй байсан гэсэн үг биш юм. Элч Паул итгэлээр нигүүлслээр зөвд тооцогдох тухай сургаалаа тайлбарлахдаа Абрахам, Давид нараар жишээ авч, авралын тухай санаа нь шинэ зүйл биш гэдгийг илэрхийлжээ (Ром 4:1-8). Есүс ч Никодемийг Хуучин гэрээний багш учраас дээрээс төрөх тухай мэдэж байх ёстой гэсэн байдаг (Иохан 3:10). Паул Тимотод хандан Хуучин гэрээний бичвэрүүд нь түүнийг авралын талаар мэргэн ухаантай болгоно гэжээ (2 Тимот 3:15). Тиймээс Шинэ гэрээнийх шиг тодорхой үг хэллэгээр илэрхийлээгүй л болохоос, Хуучин гэрээнд ч сайнмэдээ байсаар иржээ.

Хуучин гэрээний үед ч нигүүлслийн тухай ойлгосон хүмүүс байв. Тэд эвлэрүүллийн нарийн учир болон яаж хэрэгжих талаар мэддэггүй байсан ч, Бурхан уучлалын үндсийг тавина гэж итгэж байв. Өргөл тахил бол өнөөгийн бидний мөргөл хүндэтгэлтэй адил итгэлээ илэрхийлэх хэлбэр (жишээлбэл, Эзэний зоог) байсан юм. Өнөөгийн бидний мөргөл хүндэтгэл нь Бурханд захирагдах сэтгэл ба амьдралгүй бол үнэ цэнгүй байдаг шиг тэдний өргөл тахил нь итгэл ба дуулгаваргүй бол үнэ цэнгүй байсан. Хуучин гэрээний үед гэмшил, итгэл чухал байсныг Дуулал 51 мөн Исаиа 1:11-18-аас харж болно.

Христийн эвлэрүүлэл болохоос олон жилийн өмнө Бурханы нигүүлслийн талаар болон нүглийг Бурхан хэрхэн уучлах тухай Дуулал 85-д сайхан дүрсэлжээ. Дуулал 85:10-д, “Энэрэл хайр ба үнэн хамтдаа уулзжээ. Зөвт байдал ба амар тайван бие биенээ үнсжээ” гэсэн байна. Эвлэрүүлээр аврал ирэхийг ийнхүү гайхалтай зураглажээ. Эвлэрүүлэл байхгүй бол бидний гэм буруутай байдлаас болж Бурханы өршөөл хязгаарлагдах байлаа. Бурханы шударга чанарын дагуу бид амар тайвныг авах бус, харин дайсан нь

болох учиртай байв. Гэвч эвлэрүүллээр дамжуулан төлөөс төлөгдөж, өршөөл ирсэн билээ.

Бүх бүтээлийн аврал

Аврагдсан, аврал гэх үгс Библид олонтоо гарах бөгөөд энэ хичээлд тайлбарласан хувь хүний авралаас илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Эдгээр үгс өнгөрсөнд юу болсон (Ефес 2:8), өнөө цагт юу болж байгаа (1 Коринт 1:18), ирээдүйд юу болох (Марк 13:13) тухай илэрхийлдэг. Энэхүү ойлголтод хувь хүний (энэ хичээлд онцолсон) авралаас гадна еврейчүүд (Ром 1:16), харь үндэстнүүд (Ром 11:11), айл хотол (Лук 19:9), гэр бүл (Еврей 11:7) гэх мэт хэсэг бүлэг хүмүүст хамаатай асуудал, эсвэл бие махбодын аюулд (Матай 14:30) орсон хүнийг аврах утга ч мөн хамаарна.

Анхны хүн нүгэл үйлдэхэд бүх бүтээлд хараал ирсэн (Эхлэл 3:17). Аврал бүрэн гүйцэд болоход бүтээл ч бас бүрэн сэргэнэ.

Аврал нь сүнслэг шинэчлэлээс эхэлдэг. Итгэгчид нүглээс аврагдаж, Бурханы ерөөлд амьдардаг. Гэхдээ нүглийн хараалаас болж бие махбодыг хамардаг асуудлуудаас тэд хараахан чөлөөлөгдөөгүй байна. Хүмүүс өтөлж, үхдэг хэвээрээ л байна.

Байгаль ч нүглийн хараал доор байсаар байна. Бурханы бүтээсэн ертөнцийг анх ямар байсныг бид үзээгүй хэвээрээ. Хор хөнөөлтэй амьтан, хоорондоо тэмцэлдсэн араатнаар дүүрэн байгалийг л бид харж байна. Манай дэлхий ертөнцөд нэг хэсэг нь амьд үлдэхийн тулд бусад олон амьтан үхэх ёстой болдог.

Бүтээл бүхэлдээ шинэчлэгдэх цаг айсуй (Илчлэл 21:1; Еврей 1:10-12). Тиймээс нүглийн хараалаас чөлөөлөгдөх христитгэлийн найдварын талаар Ром 8:18-25-д дүрсэлжээ.

8-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Дуулал 51
- Исаиа 1:11-18
- Ром 3:20-26
- Ром 8:19-25
- Ефес 2:1-10

(2) Сорил: Дараагийн хичээлийг 8-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

8-р хичээлийн сорил

(1) Хүмүүс яагаад загалмайд дургүйцдэг вэ?

(2) Гэмшээгүй нүгэлтэн бүрийн дөрвөн үнэн байдлыг жагсааж бичнэ үү.

(3) Эвлэрүүлэлгүй уучлал яагаад Бурханыг үл хүндэтгэсэн хэрэг болох вэ?

(4) Есүс тахил золиосын онцгой шаардлагыг ямар хоёр замаар хангасан бэ?

(5) Гэмшсэн нүгэлтэн юуг ухамсарлах ёстой вэ?

(6) Авралын итгэлтэй хүн юунд итгэдэг вэ?

(7) Аврагдсан гэдгээ хүн яаж баттай мэдэх вэ?

9-р хичээл

Авралын асуудлууд

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Нүглийг ялах итгэгчийн давуу эрх ба ач холбогдол.
- Ялгуусан амьдралыг өгдөг Бурханы нигүүлсэл.
- Христтэй харилцах харилцаанаас ирдэг сүнслэг амьдрал.
- Нигүүлслээ алдах тухай Бичвэрийн сэрэмжлүүлэг.
- Авралын тодорхой асуудлуудын талаарх христэч итгэл үнэмшил

(2) Суралцагч нь нүглийг ялж амьдрах өндөр хүлээлттэй болно.

Танилцуулга

► Ром 6-р бүлгийг хамтдаа унших. Энэ бүлэгт авралын нөлөөний тухай юу өгүүлж байна вэ?

Авралын нотолгоо

1 Иохан захидлын гол сэдвүүдийн нэг нь хувь хүний авралын баталгаа юм. Иохан энэхүү захидлаа бичих болсон шалтгаанаа “Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы Хүүгийн нэрд итгэдэг та нарт үүнийг бичлээ” (1 Иохан 5:13) хэмээн дурджээ.

► Аврагдсан эсэхдээ эргэлзэж байгаа хүн юу хийх ёстой вэ?

Итгэгч хүнд авралын баталгаа хэрэгтэй болох тийм цаг үе ирнэ гэдгийг Иохан мэдэж байлаа. Тэрээр итгэгч хүн авралын баталгааныхаа тулгуур болсон нотлох баримтыг хайх нь зөв гэдгийг үүгээр харуулсан байна. Энэ захидлын туршид Иохан зарим нотолгоог дурдахдаа “Үүгээр бид үнэнийх болохоо мэдэж”¹¹ хэмээн хэлсэн байдаг. Энэхүү нотолгоог ашиглан бид зүрх сэтгэлээ тайтгаруулж чадна хэмээн тэр мөн өгүүлжээ (1 Иохан 3:19).

1 Иохан захидлын туршид нүглийг ялан дийлэх итгэгч хүний шинжийг хамгийн их онцолсон байдаг. Тиймээс элч маань “Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийн та нарт бичиж байна” (1 Иохан 2:1) хэмээн өгүүлжээ. Энэхүү илэрхийллээр итгэгчдийг санаатайгаар үйлдэх нүглээс¹² ангид амьдрах ёстой

¹¹ 1 Иохан 2:3, 5, 29; 1 Иохан 3:10, 14, 19, 24; 1 Иохан 5:2, 18

¹² Санаатайгаар үйлдэх нүглийн талаар 5-р хичээл дээр үзсэн.

гэсэн санааг Иохан хэлж байна. Тэрээр ялалтын амьдралын ач холбогдлыг харуулах гэж энэ захидлаа бичжээ.

... Хэн нэг нь нүгэл үйлдвээс Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн. Тэр Өөрөө бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл бөгөөд зөвхөн бидний нүглийн учир төдийгүй, хамаг ертөнцийн нүглийн учир билээ (1 Иохан 2:1-2).

Нүгэл үйлдэх нь тохиолдох боловч тэгэх шаардлагагүй гэдгийг Иохан энд онцолжээ. Хэрэв итгэгч хүн нүгэл үйлдвэл Христийн төлөөс нүглийг нь цайруулж чадна гэдгийг тэр баталж байна. Гэхдээ итгэгч хүн нүгэлдээ буцаж орж, гэмшихгүйгээр шууд уучлагдана гэсэн үг биш. Энэ эшлэлд дэлхий дахины бүх нүглийг өршөөх тахил бий гэдгийг л хэлж байгаа юм. Дэлхий даяараа автоматаар аврагдахгүй гэдгийг бид мэднэ. Тиймээс итгэгч хүн нүгэл үйлдсэн бол Бурхантай харилцах харилцааныхаа төлөө гэмших ёстой.

Санаатайгаар үйлдэх нүглийг ялах нь итгэгчдийн хамгийн том ялгаа гэж 1 Иохан захидлын дараах эшлэлүүдэд хэлсэн байна. Нэмэлт тайлбарыг хаалтад оруулав.

Бид Түүний тушаалуудыг сахивал, үүгээрээ бид Түүнийг таньснаа мэднэ. [Бурханд дуулгаваргүй нэгэнд ийм баталгаа байдаггүй] “Түүнийг би мэднэ” гэж хэлээд, Түүний тушаалуудыг сахидаггүй нь худалч бөгөөд түүнд үнэн алга (1 Иохан 2:3-4).

Нүгэл үйлддэг хүн бүр бас ёс бусыг үйлддэг. Нүгэл бол ёс бус юм. Нүглийг зайлуулахын тулд Тэр илчлэгдсэнийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй (1 Иохан 3:4-6).

Бяцхан хүүхдүүд ээ, та нарыг хэн ч бүү мэхлэг. Зөвийг үйлдэгч нь Түүний зөвт байгаачлан зөвт юм. Нүгэл үйлддэг нь диаволынх юм. Диавол эхнээсээ нүгэл үйлдсэн. Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү үүнд илчлэгджээ (1 Иохан 3:7-8).

Бурханаас төрөгч бүр нүгэл эс үйлддэг. Учир нь Бурханы үр түүн дотор оршдог. Тэрээр Бурханаас төрсөн тул нүгэл үйлдэж эс чадна (1 Иохан 3:9).

Түүний тушаалуудыг сахигч нь Түүн дотор байж, Тэр ч түүний дотор байна. Бидний дотор Тэр байгааг Түүний бидэнд өгсөн Сүнсээр бид мэддэг (1 Иохан 3:24). [Христийн дотор байгаа бол Бурханы хуулийг зөрчих явдалтай нийцэхгүй]

Бид Бурханыг хайрлаж, тушаалуудыг нь сахихдаа Бурханы хүүхдүүдийг хайрладгаа үүгээр мэднэ. Бурханыг хайрлах нь Түүний тушаалуудыг сахих явдал юм (1 Иохан 5:2-3). [Жинхэнэ хайр дуулгавартай байдлыг төрүүлдэг. Дуулгаваргүй байдал нь хайрлахгүй байгааг харуулна].

Бурханаар төрсөн бүхэн ертөнцийг [үүний сүнс ба уруу татлагыг] ялдаг. Ертөнцийг ялсан ялалт нь бидний итгэл болой (1 Иохан 5:4).

Бурханаар төрсөн хэн боловч нүгэл үйлддэггүйг бид мэднэ. Тэднийг харин Бурханаар төрсөн Тэрээр хамгаалдаг [харгалздаг] бөгөөд ёрын муу нэгэн тэдэнд хүрэхгүй (1 Иохан 5:18).

► Итгэгч хүний ямар онцлог шинж чанар нь эдгээр эшлэлээс тодорхой харагдаж байна вэ?

Бурханд дуулгавартай амьдрах нь итгэгч хүний ялгарах шинж чанар гэдгийг эдгээр эшлэл илэрхий харуулж байна. Санаатайгаар үйлдэх нүглийг ялах нь итгэгч хүний маш том давуу тал юм.

1 Иохан 1:8 эшлэлийн тайлбар

Зарим хүн 1 Иохан 1:8-ын “Бид нүгэлгүй гэж хэлбэл өөрсдийгөө мэхэлж байгаа бөгөөд бидний дотор үнэн алга” гэсэн эшлэлийг эш татаж, итгэгч хүн санаатайгаар үйлдэх нүглийг ялж чадна гэдгийг үгүйсгэдэг. Тэгвэл нүгэл үйлдэх гэж юу вэ? Итгэгчид хүртэл санаатайгаар нүглээ үргэлжлүүлсээр байхыг хэлж байна уу? Тэгж үзвэл дээр дурдсан 1 Иохан 3-р бүлгийн санаатай зөрчилдөнө. Хэрэв Иохан өмнөх 1-р бүлэгтээ “Итгэгчдийг оролцуулаад хүн бүр нүгэл үйлдсээр байна” гэж хэлсэн гэж үзвэл тэр яаж 3-р бүлэгт дурдсан мэдэгдлийг хэлж чадах билээ? Утга авцалдахгүй болно.

Харин хам сэдвээс утга нь харагдаж байна. 1 Иохан 1:7-д нүглээс цэвэрлэнэ гэсэн амлалт байна. Энэхүү амлалт нь гэрлийн дотор явдаг буюу үнэний дагуу амьдарч, Бурханд дуулгавартай байдаг хүмүүст зориулагджээ. Бурханд дуулгавартай амьдардаг хүмүүс өнгөрсөн дэх нүглээс Христийн цусаар цэвэрлэгдсэн юм.

Гэхдээ нүгэл үйлдсэн гэдгээ үгүйсгэдэг, цэвэршүүлэг хэрэгтэй хүмүүс бий. Тэд бол өөрсдийгөө нүгэлгүй гэж үздэг, биеэ хуурч буй хүмүүс юм. Тэд хэзээ ч нүгэл үйлдэж байгаагүй, эсвэл Христгүйгээр нүглийн асуудлаа шийдчихсэн гэж хэлдэг.

1 Иохан 1:9-д мөн л уучлал, цэвэршүүлгийн аль алиныг нь амлаж байна. Тиймээс өөрсдийгөө нүгэлгүй гэж хэлдэг хүмүүс Бурханыг няцааж байгаа хэрэг гэдгийг 1 Иохан 1:10-д дурджээ. Христээс ирдэг уучлал, цэвэршүүлэг хэрэггүй, бүр аврал ч хэрэггүй гэж боддог хүмүүсийн алдааг засахын тулд Иохан үүнийг бичсэн юм. Тэрээр итгэгчдийг нүглээ үйлдсээр байна гэж хэлээгүй. Эс бөгөөс энэ нь түүний захидлын гол санаа, шууд хэлж буй илэрхийлэлтэй нь зөрчилдөнө.

Ялалтаар амьдруулагч Бурханы нигүүлсэл

Удамшсан завхрал гажуудал, хүмүүний сул талаас болж ялалтын амьдрал амархан байхгүй. Тиймээс санаатайгаар үйлдэх нүглийг хийхгүйгээр амьдрах боломжгүй гэж олон хүн боддог. Гэвч эдгээр асуудлын хариу Бурханы нигүүлсэлд бий.

► Удамшсан завхрал гажуудал гэж юу вэ?

Удамшсан завхрал гажуудал гэдэг нь хүн төрснөөс эхлээд нүгэлд татагддаг ёс суртахууны мөн чанарын гажуудал юм. Итгэснийхээ дараа хүн нүгэлд татагддаг хандлагатайгаа тэмцэлддэг. Харин Бурхан өдөр тутмын ялалтаар зогсохгүй, удамшсан завхрал гажуудлаас ангижрах нигүүлслийг соёрхдог (Үйлс 15:9; 1 Тесалоник 5:23; 1 Иохан 1:7).

Нүгэлт мөн чанар бол насан туршид маань биднийг эзэгнэх нөхцөл байдал биш. Гэхдээ ялж амьдрахын тулд итгэгч хүн зүрх сэтгэлээ Бурханд бүрэн даатгах хэмжээнд бууж өгөх ёстой (Ром 12:1). Ариун Сүнсээр дүүрэх үедээ итгэгч хүн Бурханыг бүрэн хайрлах сэтгэлтэй болдог.

► Хүмүүний сул тал гэж юу вэ?

Хүмүүний сул тал гэдэг нь бие ба оюун санааны хязгаарлагдмал байдал буюу дутагдал юм. Адамын нүглээс хойш хүн төрөлхтөн нүгэл үйлдсээр улам доройтсон тул бид оюун санаа, бие махбод, сэтгэл хөдлөлийн хувьд Бурханы бүтээсэн анхдагч байдлаасаа дорой болжээ.

Сул талуудаасаа болоод бид алдаа гаргадаг. Зарим нь нөхцөл байдалд яаж хариу үйлдэхээ мэддэггүй. Зарим нь хүн ард, угсаатны талаар буруу бодолтой явдаг мэт. Буруу бодол санаа гэдэг аврал авмагц автоматаар засагддаг зүйл биш. Буруу бодол санаа нь буруу үйлдэлд хөтөлдөг учраас хэрэв хүн хийх ёстой юмаа буруу ойлгосон бол буруу л хийнэ. Хүн сул талаасаа болж тэмцэлдэхэд хүрдэг хэд хэдэн шалтгаан бий. Магадгүй Бичвэрийн зарчмуудыг яаж амьдралд хэрэгжүүлэхийг сураагүй байж мэднэ. Эсвэл муу хүслээ хязгаарлах сахилга батыг хөгжүүлээгүй байж болно. Магадгүй өөрийгөө хүчирхэг байлгах өдөр тутмын дадал хэвшилд суралцаагүй байх ч боломжтой. Эсвэл Сүнсээр явахын чухлыг сайн ойлгоогүй байж ч мэднэ.

Бид бусдыг санаатайгаар нүгэл үйлдэж байгаа эсэхийг тэр бүр мэдэхгүй тул бусдыг шүүх гэж яарах ёсгүй юм. Хүмүүс ихэвчлэн мэдлэг дутмаг, оюун санааны төлөвшилгүйгээсээ болж алдаа гаргадаг. Хэнд ч тохиолдож байгаагүй мэт уруу таталт танд учирч байв уу? Үнэхээр нүглийг бүрэн ялж амьдрах боломжтой эсэхэд та эргэлзэж байсан уу? Бурхан бидэнд уруу таталтад ордог сул талыг маань нөхөхөөс илүүтэй нигүүлслээрээ хамгаална гэж амласан юм.

“Хүмүүс ариун байдалд тэмүүлдэггүй. Нигүүлслээр жолоодуулсан хүчин зүтгэлээс бусдаар бол хүмүүс бурханлаг зан чанар, залбирал, Бичвэрийн дагуух дуулгавартай байдал, Эзэнд баярлан баясах зэрэгт татагддаггүй. Бид бууж өгөх хандлагаа хүлцэл, дуулгаваргүй байдлаа эрх чөлөө, мухар сүсэгтэй байдлаа итгэл гэж нэрлэдэг. Бид биеэ захирахгүй сахилга батгүй байдалд автахаа амралт гэдэг. Бид залбирахаа больж, өөрсдийгөө хуулиас ангид болсон гэж төөрөлддөг бөгөөд бурханлаг бус байдал руу алгуур гулсаж орохдоо өөрсдийгөө эрх чөлөөтэй болсон гэж итгэцгээдэг.”

- Д.А. Карсон

Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл. Бурхан итгэмжтэй, Тэр та нарыг хэр чинь хэтэртэл соригдохыг зөвшөөрдөггүй, харин дааж гарахын тань тулд сорилттой хамт мөн гарцыг ч буй болгоно (1 Коринт 10:13).

► Энэ эшлэлд бидний мэдэх ямар ямар санаа байна вэ?

Энэ эшлэл бидэнд хэд хэдэн чухал зүйлийг хэлж байна.

1. **Бид хүн учраас сорилт бидэнд тохиолддог.** Тиймээс ганц та л тэмцэлдээд байгаа юм биш.
2. **Бурхан бидний хязгаарыг мэднэ.** Биднийг аль хүртэл тэсэхийг Тэр мэднэ. Хэр тэсэхээ бид мэдэхгүй, Тэр л мэднэ.
3. **Бурхан бидэнд учирч буй сорилтыг хязгаарладаг.** Тэрбээр биднийг ялж амьдраасай гэж хүсдэг юм. Энэ эшлэлд хэлснээр бүх үед ялах боломж бий.
4. **Ялалтад хэрэгтэй зүйлсийг маань Бурхан хангадаг.** Тэрбээр бидэнд зугтах гарцыг өгдөг. Бурхан биднийг ялж амьдруулах зорилготой бөгөөд ялж амьдрах нигүүлслийг соёрхдог.

Сүнс доторх амьдрал

► Одоо Ром 8-р бүлэг рүү буцаж, энэ хэсэгт дурдсан эшлэлүүдийг харцгаая.

Ром 8-р бүлэгт итгэгчийн амьдрал дахь Сүнсний гайхалтай ажлыг дүрсэлжээ. Ром 8:26-д бид хэрхэн залбирахаа ч мэддэггүй боловч Ариун Сүнс биднээр дамжуулан залбирдаг гэжээ.

Энэ бүлэг бидэнд хэрхэн ялж амьдрах тухай зааж байна. Бид махбодоо бус, харин Сүнсийг дагаж яваа бол яллагдахгүй (Ром 8:1, 4). Ариун Сүнсний хүч бидний дотор ажиллаж байгаа учраас бид Бурханы хүсэж буй зөвт байдлыг гүйцэлдүүлж чадах юм (Ром 8:4).

“Бурханд маш чухал учраас Тэрбээр ‘ариуслыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй болой’ (Еврей 12:14) гэж бидэнд хэлсэн. Ариун байдал гэдэг нь хийж болох, болохгүй зүйлсийн жагсаалт биш, харин Христтэй адил болох явдал юм.”
— Жим Симбала

Хэрэв хүн нүгэлт мөн чанартаа захирагддаг бол Бурханд таашаагдахгүй (Ром 8:8) бөгөөд яллагдаж (Ром 8:1), Бурханаар шүүгдэнэ (Ром 8:13-д “үхнэ” гэсэн). Харин Ариун Сүнсний хүч ба удирдлагаар бид нүгэлт үйлсүүдээ орхиж чадна (Ром 8:13-14).

Христ доторх амьдрал

Иохан 15:1-10 нь усан үзмийн мод ба мөчрийн тухай алдартай зүйрлэл юм. Энэ зүйрлэл зарим чухал асуултад хариулдаг.

Бид явал Христ дотор байх вэ? “та нар тушаалыг минь сахивал хайранд минь байх болно” (Иохан 15:10). Христ дотор байхаа болино гэдэг нь Түүнийг дагахаа болино гэсэн үг. Тэгвэл юу болох вэ?

“Хэн нэг нь Миний дотор эс байваас мөчир мэт хаягдаж, хувхайрна. Тэдгээр мөчрийг түүж, галд хаяж шатаана” (Иохан 15:6). Хэрэв хүн дуулгавартай байхаа боливол Христ дотор амьдрахаа больж, гологдоно. Галд хаягдаж буй үзмийн мөчрөөр гологдож байгаа хүнийг дүрсэлж байна.

“Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно” (Иохан 15:4). “Миний дотор байгч, жимс ургуулдаггүй мөчир бүрийг Тэр авч хаяна” (Иохан 15:2). Хэрэв бид Христ дотор дуулгавартай явахгүй бол биднээс үр жимс гарахгүй. Үр жимс гаргах гэдэг нь тухайн хүний амьдрал өөрчлөгдөж, ерөөгдөж, Бурханы нигүүлслээр удирдуулахыг хэлж байгаа юм. Хэрэв хүн Бурханд дуулгаваргүй байвал Бурханы хангадаг амийн урсгалаас өөрийгөө салгаж, Бурханы нигүүлсэлд цаашид амьдрах аргагүй болно. Үр жимсгүй хүн гологддог.

Бидний хувьд Христ амь өгөгч үзмийн мод (Иохан 15:6) юм. Авралыг харилцаагаар олж эзэмшинэ. Тэгвэл Христээс тусгаарлагдах нь авралаас тусгаарлагдана гэсэн үг. Бид Христтэй харилцах авралын харилцаагаа Бурханд итгэж, дуулгавартай дагах замаар хадгалдаг (Иохан 15:10).

Энэ санааг орчин үеийн гэрлийн чийдэн ба цахилгаанаар дүрсэлж болно. Цахилгаан гүйдэл урсаж байх үед чийдэн асаж байдаг. Хэрэв чийдэнг тэжээлийн үүсгэврээс салгавал гэрэл унтарна. Үүн шиг бид Христтэй харилцах харилцаагаараа мөнх амьтай болно (Иохан 17:3). Түүний амь бидэн рүү урсдаг бөгөөд хэрэв бид өөрсдийгөө Христээс тусгаарлавал амиа хадгалж чадахгүй.

Бичвэрийн сануулга

Зарим хүн амийн номд нэр нь нэгэнт бичигдсэн бол арилгах боломжгүй гэж үздэг. Гэхдээ нэр арилж болох ядаж нэг шалтгаан бий.

Хэн нэгэн нь энэхүү эш үзүүлэлийн номын үгсээс хасах аваас Бурхан энэхүү номд бичигдсэн амийн модноос болон ариун хотоос хувийг нь хасах болно (Илчлэл 22:19).

Шууд утгаараа Илчлэл номын хэсгээс хассан гэм буруутай хүн маш цөөхөн. Гэхдээ хүний нэр амийн номоос хасагдах боломжтой гэдгийг эндээс харж болно.

Есүс амлалт ба сануулгаа өгч, “Энэ мэт ялагч нь цагаан хувцас өмсөнө. Би түүний нэрийг амийн номоос баллахгүй” (Илчлэл 3:5) гэж хэлжээ.

Нэгэнтээ Паул ч Тесалоник хотын итгэгчид итгэлээсээ урвасан байх вий хэмээн санаа зовж байв. Хэрэв тэгсэн бол сайнмэдээ тараасан түүний хөдөлмөр дэмий хоосон болно (1 Тесалоник 3:5) гэж тэр хэлж байсан юм. Тэгэхээр итгэлээ бүрмөсөн хаясан итгэгч хүний анхны итгэл нь дэмий хоосон зүйл болно гэдгийг бид эндээс харж байна.

Бид 2 Петр 2:18-21-ээс хуурамч багш нар бидний Эзэн, Аврагч Есүс Христийг таньсан мэдлэгээр дамжуулан дэлхийн бузар булайгаас мултарсан зарим итгэгчдийг хууран мэхэлдэг байсан тухай уншдаг. Эдгээр итгэгчид зөвт байдлын замыг мэдсэн атлаа түүнийгээ орхижээ. Энэ хэсэгт тэднийг нүгэлт амьдралын хэв маяг руу буцсанаас анхнаасаа энэ замыг мэдээгүй байсан нь дээр гэж байна. Иймээс хүн нүгэл рүүгээ буцвал авралаа алдах боломжтой юм. Хэрэв хүн авралаа алдах боломжгүй байсан бол, аврагдахаас өмнөх байдлаасаа хэзээ ч дордохгүй байх байсан.

Хүүгийн эрх өөрчлөгдөж болно. Нэгэнтээ бид диаволын хүүхдүүд байсан (Иохан 8:44) бөгөөд бусдын адил уур хилэнг нь хүртэх хүүхдүүд (Ефес 2:3) байв. Гэвч Бурхан биднийг үрчилж авснаар бид Эцэгтэй болсон (Ром 8:15) юм. Харин төөрөлдсөн хүү эцгээсээ салж явахдаа хүүгийн эрхийг нь дагалдах бүх сайн сайхнаа алдсан байдаг. Буцаж ирэхэд нь эцэг нь түүнийг үхсэнд тооцсон байв (Лук 15:32).

Бурхан итгэгчдийг аюулгүй байдлаа мэдрээсэй гэж хүсдэг. Гэхдээ өөрсдийгөө бодит аюулд оруулах хуурамч мэдрэмжид бүү тулгуурлаасай гэж хүсдэг. Бид Бурханы амлаагүй зүйлийг итгэгчдэд амлах ёсгүй. Биднийг юу ч хийсэн бай, Бурхан бидний авралыг хамгаална гэж амлаагүй. Харин биднийг удирдан чиглүүлж, нүглийг ялж амьдрах боломжийг олгоно гэж амласан. Энэ нь биднийг айдсаас ангид байлгах хангалттай баталгаа юм.

Заримдаа итгэгчид авралдаа эргэлздэг. Тэд аврагдах үедээ итгэлтэй байсан ч, Бурхантай авралын харилцаатай гэдэгтээ эргэлзсэн хэвээр байх нь бий. Библи чухал асуултыг эргэлзээтэй хэвээр орхидоггүй. Итгэгч хүн Бурханы шалгалтыг давах эсэхдээ эргэлзэхгүйгээр Шүүлтийн өдөр итгэлтэй зогсож чадах (1 Иохан 4:17) авралын баталгаатай байх нь Бурханы хүсэл юм.

Итгэгч хүн аврагдсан гэдэгтээ итгэлтэй байхын тулд эргэлзэх үедээ үүнийг үл тоомсорлож болохгүй. Тиймээс та нар итгэлд байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө судал (2 Коринт 13:5) гэсэн байна.

Хэрэв хүн Бичвэрт заасны дагуу авралд хүргэх сүнслэг алхмуудыг дагаснаар аврагдсан гэдгээ мэдэж байвал, бас Христтэй дуулгавартай харилцаатай байснаараа Түүний дотор үлдэж байгаа гэдгээ мэддэг бол өөрийгөө сүнслэг амьдралтай гэдэгт итгэлтэй байж болно.

Алдаанаас зайлсхийх: Доогуур хүлээлт

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ангиас хоёр хүн энэ болон дараагийн хэсгийг тайлбарлана уу.

Хүмүүст нүглийг ялах боломжгүй мэт санагдуулдаг хоёр зүйл байдаг нь хүмүүний сул тал, удамшсан завхрал гажуудал юм. Бурхан биднийг хүний хязгаарлагдмал чанартай хэмээн буруутгадаггүйг санаарай. Бурхан хүслээ биелүүлэхийн тулд бидэнд Сүнсээрээ хүчийг өгдөг. Сул талтай байгаа нь нүгэлтэй гэсэн үг биш бөгөөд, хүн сул талаасаа болж нүгэл хийх ёсгүй.

Биднийг итгэсний дараа ч удамшсан завхрал гажуудлын нөлөө үргэлжилсээр байх болно. Гэвч Бурхан цэвэршүүлэх нигүүлслийг өгдөг. Бид удамшсан завхрал гажуудалтай төрсөндөө буруутгагдаагүй, гэхдээ бид үүнийхээ нөлөөнд автсан хэвээр байвал энэ нь бидний буруу болно. Тиймээс хүний сул тал ч, удамшсан завхрал гажуудал ч бидний ялалтын амьдралын итгэл найдварыг хөсөрдүүлэх ёсгүй.

Христэд итгэх итгэлээр бид Түүнтэй нэгддэг. Бид Түүний үхэл ба амиллаар Түүнтэй холбогддог бөгөөд бид нүглийн хувьд үхэж, шинэ амьдралд амилсан (Ром 6:3-11). Тэр бидний дотор, бид Түүний дотор. Христэд итгэгчдийн амьдрал нь Христийн жишээг дагахыг хичээх төдий бус, харин хамгийн ихээр хичээх явдал юм. Христ бидний дотор амьдарснаар бид христитгэлийн амьдралаар амьдардаг. Тэр дэлхий дээр амьдарч байхдаа нүглийг ялсан шигээ, одоо ч бидний дотор ялалтаар амьдардаг.

Яагаад хамаатай вэ?

Их хотын гудамжны хажуугийн хашлага дээр ноорхой хувцас өмссөн хөөрхий эмэгтэй сууж байв. Үс нь ширэлдэж бохирдсон, арьс нь хиртэй, заваан. Тэр найдваргүй, цөхрөлд автжээ. Гэнэт хүмүүс бужигналдаж, хаант улсын агуу ханхүү язгууртнуудтайгаа гудамжны булан тойрон гарч ирэв. Ханхүү царайлаг, хүчирхэг бас эелдэг хүн аж. Түүний сүйх тэрэг өнөө эмэгтэйн сууж буй газрыг дайран өнгөрөх үед ханхүү жолоочдоо "Зогс!" гэлээ.

Сүйх тэргийг зогсоход ханхүү зарц нартаа "Тэр хашлага дээр сууж буй эмэгтэй миний гэрлэхийг хүссэн хүн байна!" гэв.

Одоо үзэгдэл өөрчлөгдөж байна. Хуримын өдөр ордны байдал харагдана. Гэтэл юу харагдах нь тэр вэ? Нөгөө халтар эмэгтэй ноорхой хувцас, ширэлдсэн үстэй хэвээрээ. Түүний эргэн тойронд хуримын даашинз, саван, үнэртэй ус барьсан үйлчлэгч нар байгаа ч, сүйт бүсгүй хуримдаа бэлдэх сонирхолгүй сууна. Нэг хатагтай "Эзэгтэй минь, та хуримдаа бэлдэхгүй юм уу?" гэхэд сүйт бүсгүй "Тэр надтай гэрлэхийг хүсэх үед би ийм царайтай байсан. Тиймээс тэр чигээрээ байхад зүгээр гэж бодож байна" гэж хариулав.

Бид ийм хандлагад шууд цочирдоно. Ханхүү түүнд хайртай учраас ийм байдалтай байлгахыг хүсэхгүй шүү дээ. Эмэгтэйг дур булаам биш байхад нь ханхүү хайрласан бол, одоо эмэгтэй түүнд хамгийн сайхнаараа харагдахыг эрмэлзэх ёстой.

Биднийг нүгэлтнүүд байхад Бурхан биднийг хайрласан. Энэ нь нүгэл хамаагүй болсон гэсэн үг биш. Тэр бидэнд хайртай учраас нөхцөл байдлыг маань өөрчлөхийг хүсдэг. Тэр бидэнд хайртай учраас бид Түүнд таалагдах дүр төрх, зан чанарыг хүсэх ёстой.

Ялалтаар амьдрах практик заавар

Дэлхий даяар Христийн үнэнийг мухар сүсэгтэй хольж хутгаж байна. Зарим нь нүглийг ялах арга бол залбирал унших, сэтгэл хөдлөлийн мэдрэмж, муу сүнснүүдийг зэмлэх (зарим нүглийн шалтгаан болдог гэж үздэг хүмүүс), биеэ зовоох, ямар нэг сахиус зүүх, гэр орондоо сүнслэг бэлгэдлийн юмс байрлуулах, тусгай тосоор биеийг тослох гэх мэтээр зааж байна. Сүнслэг ид шидээс ялалт хүлээх нь алдаа юм.

Зарим нь нүглийг ялах талаар хэтэрхий хялбаршуулж заана. Аврал авч, Сүнсээр дүүрэх нь нүглийн хүчийг үүрд устгана гэгцгээнэ. Тэд сүнслэг өсөлт, сахилга бат, байнгын сэрэмжтэй байх хэрэгцээг онцолдоггүй. Дэлхийг болон нүглийг тууштай ялж чадахгүй байгаа хүмүүс дараах асуултуудыг өөрөөсөө чин үнэнээр асуух хэрэгтэй.

- 1. Би үнэхээр дээрээс төрсөн үү?** Би хуучин амьдралаа үхүүлсэн үү? Би гэмшиж, нүглээ ардаа орхисон уу? Христ доторх шинэ амьдрал буюу Бурханы юмсыг гэх шинэ хандлага, шинэ хүсэл, шинэ дур сонирхол, надад байна уу (2 Коринт 5:17)? Христ Ариун Сүнсээр миний дотор оршихоор ирсэн үү? Би нүглийг ялан дийлэх гэсэн хүслээрээ хичээж байна уу, эсвэл миний дотор оршдог Бурханы хүчинд түшиглэж байна уу (Галат 2:20)?
- 2. Би Бурханы хүслийг зүрхэндээ хадгалсан уу?** Дууллыг бичигч, “Таны эсрэг нүгэл хийхгүйн тулд Үгийг тань зүрхэндээ би хадгалав” (Дуулал 119:11) хэмээн гэрчилсэн байдаг. Шинээр төрсөн хүүхэд эхийнхээ сүүгээр хооллодог шиг бид Бурханы Үгээр хооллох ёстой (1 Петр 2:2).
- 3. Би өөрийгөө үнэхээр нүглийн хувьд үхсэн, Бурханы өмнө амьд гэж бодож байна уу?** “Түүнчлэн та нар өөрсдийгөө нүгэлд үхсэн боловч Бурханд Христ Есүсээр амьд байгаагаа тооц” (Ром 6:11). Би сорилтыг намайг эрхшээх хүчгүй хэмээн итгэлтэйгээр үгүйсгэж байна уу?
- 4. Би Бурханы ялалтад түшиглэж байна уу?** Бурханы гэр бүлд төрсөн хүн ертөнцийг ялна гэж Элч Иохан тунхагласан. “Ертөнцийг ялсан ялалт нь бидний итгэл болой” (1 Иохан 5:4). Ертөнцийн зүйлс биднийг татах, удирдах хүчээ загалмайгаас болж алдсан учраас Есүсийн загалмайгаас өөр зүйлд огт найдахгүй гэж Элч Паул хэлсэн (Галат 6:14) байна. Хэрэв бид бүх зөвт байдлын эх сурвалж болох Есүсийг мартвал байнга ялалтын амьдралаар амьдрах боломжгүй.

5. **Би өдөр бүр Эзэн Есүсийг итгэлээр өмсөж, нүглийг үл зөвшөөрч байна уу?** Бид итгэлийн ямар ч түвшинд хүрсэн бай, ялалт хэзээ ч автоматаар ирэхгүй. Би нүгэлд хандах Есүсийн хандлагыг ухамсартайгаар хүлээн авч, Түүнийг үлгэрлэн дуурайх ёстой (Ром 13:14; Ефес 4:24).
6. **Би Бурханы сүнслэг хуяг дуулгыг өмсөж байна уу?** Амьдралын тулааны талбарт олон итгэгч сүнслэг хамгаалалтдаа хайхрамжгүй хандсанаас болж Сатаны галт суманд шархаддаг (Ефес 6:11).
7. **Би сахилга батаа дасгалжуулж байна уу?** Бид итгэлдээ хэчнээн төлөвшсөн бай, сахилга батаа үргэлж хөгжүүлэх хэрэгтэй. Бид биеэ барьж, сахилга баттай байна уу? Бурханаас заяасан, төрөлх дур хүслүүдийг (идэх, унтах, бэлгийн харьцаанд орох гэх мэт) захирч, ингэснээр тэдгээр нь миний шинээр төрсөн сүнсний зорилгод үйлчлэх ёстой. Бие маань нүгэлд автсан учраас хүсэл минь тэнцвэргүй болдог. Бие махбод удирдлагыг авах бус, харин сүнс сэтгэлд минь үйлчлэх ёстой. Паул биеэ сахилгажуулж, дуулгавартай болговол сүнслэг уналтад орохгүй гэж хэлсэн (1 Коринт 9:25-27). Сахилга бат итгэгч бүрд хэрэгтэй.
8. **Би дуулгавартай амьдарч байна уу?** “Бид гэрлийн дотор явбал” гэж элч Иохан сануулжээ (1 Иохан 1:7). Мөнхийн улсад хүрэх замд урхи, бүдрэх чулуу, аюултай газар олон байдаг тул бид үргэлж Бурханы Үгийн гэрэл (Дуулал 119:105) болон Ариун Сүнсний оршихуйд явах ёстой (Иохан 14:26). Дуулгавартай байх нь Есүсийн цус биднийг цэвэр байлгана гэсэн амлалтыг агуулдаг. Гэрлийн зам руу буцахаас татгалзсан хүмүүс харанхуйд алхсаар нүгэлд бүдэрч, эцэст нь үхэлд хүрдэг.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Христэч ялалтын амьдралаар амьдрах нь итгэгч бүрийн үүрэг юм. Итгэгч хүн Христтэй харилцах харилцаагаараа амьтай болж байдаг. Бурханы хүслийг үгүйсгэж, нүгэл рүүгээ буцсан итгэгч хүн Бурхантай холбогдох холбоос болох итгэлээ сүйрүүлэх магадлалтай. Бурханы нигүүлсэл хүчтэй тул итгэгч хүн бүх сорилтыг даван туулж чадна.

9-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Матай 13:18-23
- Еврей 10:23-39
- Иаков 1:21-27
- 2 Петр 1:1-11
- Илчлэл 3:14-22

(2) Сорил: Дараагийн хичээлийг 9-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

9-р хичээлийн сорил

(1) 1 Иохан номын гол сэдэв юу вэ?

(2) 1 Иохан захидалд итгэгч хүний ямар шинжийг хамгийн их онцолсон бэ?

(3) 1 Коринт 10:13-р эшлэлээс бидний мэдсэн дөрвөн зүйл юу вэ?

(4) Итгэгч хүн яавал Христ дотор байх вэ?

(5) Бид Христтэй харилцах авралын харилцаагаа хэрхэн хадгалах вэ?

10-р хичээл

Ариун Сүнс

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Ариун Сүнсний бодгаль гэдгийг харуулах шинж чанарууд.
- Ариун Сүнсний бодгаль ба бурханлаг шинжийн талаарх Библийн нотолгоо.
- Ариун Сүнсний бодгаль ба бурханлаг шинжийн тухай сургаал яагаад чухал вэ?
- Ариун Сүнсний түүхэн болон одоогийн үйл хэрэг.
- Итгэгч хүний Ариун Сүнсстэй харилцах харилцааны практик талууд.
- Ариун Сүнсний талаарх христэд итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь сүнслэг бэлэг авьяасын зарим зарчмуудыг мэдэж авна.

Танилцуулга

► Дуулал 139-ийг хамтдаа унших. Энэ дуулалд Бурханы Сүнсний талаар юу өгүүлж байна вэ?

Зарим хүн Ариун Сүнснийг ердөө хүний сэтгэлийг хөдөлгөдөг зүйл, ашиглаж болох хүч, хувь шинж чанаргүй хүч, эсвэл зүгээр л оршихуй гэж боддог. Жишээ нь: Еховагийн гэрчүүд "Ариун сүнс нь бодгаль биш, Гурвалын нэг хэсэг ч биш. Ариун сүнс бол Бурханы хүслээ биелүүлэхийн тулд ашигладаг идэвхтэй хүч юм... Үүнийг ямар нэг байдлаар цахилгаантай зүйрлэж болно"¹³ гэж хэлдэг.

► Ариун Сүнсний талаарх Еховагийн гэрчүүдийн ямар ойлголт буруу байна вэ?

Еховагийн гэрчүүд нь Ариун Сүнснийг хувийн зан чанаргүй нэг хүч гэж үздэг. Бурханы тухай Библийн дагуух ойлголт байхгүй учраас тэд Ариун Сүнсстэй зөв харилцаатай байж чадахгүй юм.

Бид Ариун Сүнсний тухай бүгдийг ойлгож чадахгүй. Есүс ч Сүнсний ажиллах нь салхитай адил гэсэн юм. Бид салхийг сонсох ч, хаанаас ирээд, хааш явааг нь мэдэх боломжгүй (Иохан 3:8). Гэхдээ Сүнсний талаар мэдэж болох зарим зүйл бий. Тэдгээрийг мэдэх нь бидний Бурхантай харилцах харилцаанд чухал ач холбогдолтой.

"Эзэн ба Амийг өгөгч Ариун Сүнсэнд би итгэдэг. Тэрээр Эцэг ба Хүү Бурхантай хамт амьдарч ажиллан, Тэдний хамт мөргөл хүндэтгэл, алдрыг авдаг. Тэрбээр эш үзүүлэгчдээр дамжуулан ярьдаг."

- Никайн тунхаг, НТ. 325

¹³ "Та Гурвалд итгэх ёстой юу?" (*Should You Believe in the Trinity?*) New York: The Watchtower Bible and Tract Society, 1989

Ариун Сүнс ба чуулганы харилцааны талаар Үйлс номд хамгийн их дүрслэгддэг. Чуулган анх Ариун Сүнтэй хэрхэн харилцаж байсан загварыг бид тэндээс харж болох юм.

1. Тэд Ариун Сүнсийг Бурхан хэмээн хүндэлсэн (Үйлс 5:3-4, унших).
2. Тэд Ариун Сүнсний оршихуй, удирдамж, үйл ажиллагааны талаар ойлгож байсан (Үйлс 15:28, унших).
3. Тэд Ариун Сүнснээс хамааралтай байж, Түүнтэй харилцах үүрэг хариуцлагаа ухамсарлаж байсан (Үйлс 4:24, 31, унших).

Ариун Сүнтэй ийм харилцаатай байхын тулд бид Түүнийг бодгаль, мөн Бурхан гэдгийг ойлгох ёстой.

Хуулиар дамжуулан ярьж, эш үзүүлэгчдээр сургаж, Йордан дээр бууж ирсэн, Элч нараар дамжуулан хүүрнэж, ариун хүмүүсийн дотор амьдардаг Ариун Сүнсэнд бид итгэдэг. Тэрбээр Ариун Сүнс, Бурхан Сүнс, төгс Сүнс, Туслагч, бүтээгдээгүй харин Эцэг Бурханаас гарч бидний итгэдэг Хүүг хүлээн авсан тэрхүү Сүнсэнд бид итгэдэг.”

Епифаниусын тунхаг, НТ. 374

Ариун Сүнс бол бодгаль

Ариун Сүнсэнд Есүсийнх шиг махбод байхгүй боловч, Тэрээр хүн шиг бодгаль юм. Хүнд оюун ухаан, хүсэл зориг, сэтгэл хөдлөл гэх мэт шинжүүд бий. Ариун Сүнсэнд хүсэл зориг бий юу? Тэрбээр Христэд итгэгчдэд сүнслэг бэлгүүдийг хүссэнээрээ хуваарилдаг (1 Коринт 12:11). Ариун Сүнсэнд оюун ухаан бий юу? Тэрбээр бүх зүйлийг, тэр байтугай Бурханы гүн юмсыг ч гэсэн нягталдаг бөгөөд тэдгээрийг мэддэг (1 Коринт 2:10). Ариун Сүнсэнд сэтгэл хөдлөл бий юу? Бурханы Ариун Сүнсийг бүү гомдоо (Ефес 4:30) гэж бичигдсэн байдаг. Хэрэв Ариун Сүнс гашууддаг юм бол Түүнд сэтгэл хөдлөл байдаг гэсэн үг. Ариун Сүнсэнд оюун ухаан, хүсэл зориг, сэтгэл хөдлөл байдаг учраас бид Түүнийг бодгаль гэж мэддэг.

► Ариун Сүнсийг бодгаль гэдгийг ойлгох нь яагаад чухал вэ?

Хүнд бусадтай харилцах чадвар бий. Хэрэв Ариун Сүнс нь бодгаль бус зүгээр нэг хүч байсан бол бид Түүнтэй харилцаа тогтоох боломжгүй байх байлаа. Гэхдээ Филиппой 2:1 мөн, 2 Коринт 13:14-д Сүнсийг бидэнтэй нөхөрлөдөг гэж хэлсэн. Тиймээс Тэр бол бодгаль нэгэн мөн.

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ариун Сүнсний бодгаль чанарын талаарх Библийн баримтыг дэлгэрүүлж мэдэхийг хүсвэл энэ хичээлийн төгсгөлд буй "Ариун Сүнсний бодгаль чанарын талаарх Библийн нотолгоо" хэсгийг үзнэ үү.

Ариун Сүнс бол Бурхан

Ариун Сүнс бол бүхнийг мэддэг, бүгдийг хардаг, хаа сайгүй оршдог Бурхан юм. Ананиа, Сапфира хоёрын түүхийг санаж байна уу? Ананиаг үхэхээс өмнө Петр түүнд, “зүрх чинь яагаад Сатанд автаж... Ариун Сүнсэнд худал хэлэв?... Чи хүнд биш харин Бурханд худал

хэллээ гэв” (Үйлс 5:3-4) гэсэн байдаг. Эндээс Ариун Сүнсэнд худал хэлэх нь Бурханд худал хэлэхтэй адил гэдгийг бид харж байна. Тиймээс Ариун Сүнс бол Бурхан мөн.

Ариун Сүнс бүхнийг мэддэг. Бид 1 Коринт 2:10-11-ээс Тэр бол бүхнийг мэддэг Бурхан гэдгийг мэдэж авдаг. Түүнд хязгааргүй оюун ухаан байх учиртай. Тэрбээр Хуучин гэрээний бичвэрүүд болон бүхий л мэдлэг шаардагдах эш үзүүллэгт онгод оруулсан юм (2 Петр 1:21, унших). Бичвэрүүд Бурханы амьсгалаар ирсэн (2 Тимот 3:16). Тиймээс Ариун Сүнс бол Бурхан мөн.

Ариун Сүнс хаа сайгүй оршдог. Дуулал 139:7-10-д Бурханы Сүнсний оршихуйгаас зугтах газар байхгүй гэжээ. Ариун Сүнс итгэдэг хүн бүртэй хамт байдаг. Учир нь хэрэв хүнд Христийн Сүнс байхгүй бол тэр хүн Христийн харьяат биш гэж Библид хэлжээ (Ром 8:9). Хам сэдэв нь Христийн Сүнс бол Ариун Сүнс гэдгийг илэрхийлж байна.

Ариун Сүнсэнд бүхий л хүч бий. Тэрээр зөвхөн Бурханы хийж чадах зүйлийг хийдэг. Тиймээс энэ дэлхийг нүгэл, зөвт байдал хийгээд шүүлтийн (Иохан 16:8) талаар зэмлэдэг юм. Үүнийг хийхийн тулд Тэрбээр хүн бүрийн ухамсарт хүрч, тодорхой үнэнийг оюун санаанд нь хэлж ойлгуулдаг. Тэр бас итгэгчдэд дотоод хүчийг хайрладаг (Ефес 3:16, унших). Сүнс нь энэ дэлхийн хаа сайгүй итгэгчдийн амьдралд сүнслэг үр жимсийг бий болгож байдаг (Галат 5:22-23, унших). Тэнгэрлэг хүчнээс өөр хэн ч ийм зүйлийг хийж чадахгүй.

Ариун Сүнс доромжлолыг мэдэрдэг тухай Бид Лук 12:10-аас харж болно. Бурханыг доромжлох гэдэг үгийг ашиглан хэлсэн байгаа нь Ариун Сүнсийг Бурхан гэдгийг илэрхийлж байна.

Ариун Сүнс бол мөнх (Еврей 9:14).

Бидний бие махбодыг Ариун Сүнс амьдардаг **Бурханы** сүм (1 Коринт 3:16) гэжээ.

Библийн нотолгооноос бид Ариун Сүнс бол Бурхан, тэнгэрлэг Гурвалын гурав дахь бодгаль гэдгийг бид мэдэж болно.

► Ариун Сүнсийг Бурхан гэж итгэх нь яагаад чухал вэ?

Ариун Сүнсийг Бурхан гэж итгэдэг бол бид Түүнд алдар хүндлэлийг өгч чадна. Ариун Сүнсэнд мөргөл хүндэтгэл өргөхгүй байх нь ноцтой зүйл юм.

Ариун Сүнс нь Эцэг Хүү хоёроос ялгаатай

Ариун Сүнс нь Эцэг Хүү хоёроос ялгаатай гэж хэлэх нь Тэднийг хүмүүс шиг тусдаа бие даасан гэж хэлж байгаа хэрэг биш. Гурвалын гишүүн бүр бие биедээ орших бөгөөд бүгд нэг ижил Бурхан юм. Гэхдээ хоорондоо ярилцаж, бие биенээ хайрлах, бие биетэйгээ болон бидэнтэй жинхэнэ хувийн харилцаатай байж чадахуйц хангалттай ялгаа Түүнд бий.

Бичвэрт Гурвалын бодгалиудын ялгааны талаар мөн заадаг. Жишээлбэл, Иохан 14-16-р бүлэгт Есүс, Эцэг рүү буцахдаа нэгэн Туслагчийг явуулна гэдгээ дахин дахин дурдсан

байдаг (Иохан 14:16-17, 26; Иохан 15:26; Иохан 16:7, 13-15, унших). Энэ Туслагч дагалдагчдыг удирдан чиглүүлж, тэдэнд заах болно гэжээ. Хэрэв Есүс, Ариун Сүнс хоёр нэг бодгаль байсан бол Тэрбээр Ариун Сүнсийг өөр Туслагч гэж хэлэх нь утгагүй юм. Тиймээс Есүс энд өөр нэгэн бодгалийн талаар өгүүлжээ.

Ариун Сүнс Өөрийн эрх мэдлээр ярихгүй, харин Эцэгээс Христийн хүлээн авсан Христийн юмсыг илчилнэ гэж Есүс хэлсэн (Иохан 16:13-15). Хэрэв Есүс, Эцэг хоёр Ариун Сүнстэй адил бодгаль байсан бол ингэж хэлэх нь мөн л утгагүй юм.

Есүсийг баптисм хүртэх үед тэнгэрээс "Хайрт Хүү минь Чи билээ" гэсэн дуу гарч, Ариун Сүнс Есүс дээр тагтаа мэт буув (Марк 1:10-11) гэжээ. Энд Гурвалын гурван гишүүн нэгэн зэрэг, бие биенээсээ ялгаатай байдлаар оролцсон байна.

Ариун Сүнс онцгой бодгалийн хувьд Эцэг Хүү хоёртой өнө мөнхөд хайрын харилцаанд амьдарсаар иржээ. Бурхан биднийг энэхүү харилцаанд оролцуулахаар бүтээсэн юм. Бурхан биднийг Өөртэйгөө харилцаатай байж нөхөрлөхийг хүсдэг (1 Иохан 1:3-4). Гурвалын гишүүн бүр цаг хугацааны эхлэлээс өөр хоорондоо дотно нөхөрлөсөөр иржээ (Иохан 17:22-23, унших).

Ариун Сүнс идэвхитэй

Бүтээлийн эхнээс л Ариун Сүнс дэлхий дээр идэвхтэй ажилласаар ирсэн. Тэр газар дэлхийг бүтээхэд оролцсон (Эхлэл 1:2, 26). Тэрээр хүмүүст онцгой ажил хийх онцгой чадварыг өгдөг (Гэтлэл 35:30-31; Шүүгчид 3:9-10; Шүүгчид 15:14-15). Тэр бас эш үзүүлэгчдэд үг мэдээг дамжуулсан (Исаиа 61:1). Ариун Сүнс бичвэрүүдэд онгод оруулсан (2 Петр 1:21). Тэрбээр үргэлж хүмүүсийн зүрх сэтгэлд ажиллаж, Бурхан руу эргүүлэхийг хичээдэг (Үйлс 7:51).

Түүнийг амийн Сүнс гэдэг (Ром 8:2, унших). Тэр биднийг бүтээсэн, бидэнд амь өгсөн Сүнс билээ. Хэрэв Тэр энэ дэлхийг орхин одвол амьдрал бүхэлдээ зогсож, хүн төрөлхтөн буцаад шороо болж хувирна (Иов 33:4, Иов 34:14-15.)

Шинэ гэрээнээс Ариун Сүнсний ажлын шинэ мөн чанарыг харж болно. Баптисч Иохан Есүсийг хүмүүст Ариун Сүнсээр баптисм хүртээгч гэж хэлсэн байдаг (Матай 3:11). Есүс ч дагалдагч нартаа Эцэгийн амлалт буюу Пэнтекостын өдөр Ариун Сүнсний баптисм буухыг хүлээх тухай хэлсэн юм (Үйлс 1:4-5, 8).

Есүс дагалдагч нартаа Ариун Сүнс тэдэнтэй хамт байж, Есүсийн заасан зүйлсийг сануулан, үнэний зүг хөтөлнө гэж амласан (Иохан 14:26, Иохан 16:13). Есүс Ариун Сүнсийг өөр нэгэн Туслагч (Иохан 14:16, 26; Иохан 15:26; Иохан 16:7) гэж хэлсэн. Есүсийн ашигласан грек үг нь хамт байж, урамшуулж, тусалдаг нэгнийг заасан үг юм. Энэ үг төлөөлдөг нэгэн гэсэн утгыг ч агуулдаг. Тиймээс Ариун Сүнс Есүсийг төлөөлж, Есүсийн үгсийг бидэнд сануулдаг.¹⁴

¹⁴ Есүсийг Эцэг Бурханы өмнө биднийг төлөөлдөг хэмээн 1 Иохан 2:1-д хэлэхдээ адил үгийг ашиглажээ.

► Ариун Сүнс юу хийдэг вэ?

Дэлхий дээрх Ариун Сүнсний ажлыг бүрэн тайлбарлах боломжгүй ч Түүний зарим үйл хэргийг энд жагсаая.

1. Тэрээр нүглийг буруушаадаг (Иохан 16:8; 1 Коринт 2:4; 1 Тесалоник 1:5). Эс бөгөөс хүн гэмшиж, уучлагдах хэрэгцээгээ ухамсарлах боломжгүй байв.
2. Тэрээр нүгэлд үхсэн хүнд амь өгч, сэргээдэг (Тит 3:5; Ефес 2:1; Иохан 3:5).
3. Тэрээр итгэгчдэд аврагдсан гэдгээ мэдэх хувьчилсан баталгааг өгдөг (Ром 8:16).
4. Тэрээр итгэгч бүрийн дотор оршдог (аврагдсан хүн бүр Ариун Сүнсстэй) (Ром 8:9; 1 Коринт 6:19).
5. Тэрээр Бурханы үнэнийг ойлгуулдаг (1 Коринт 2:9-10, 13-14; 2 Коринт 3:14-17; Ефес 6:17).
6. Тэрээр хүмүүсийг онцгой үйлчлэлд дуудаж, үйлчлэлийн шийдвэрт дагуулдаг (Үйлс 13:2-4, Үйлс 15:28, Үйлс 16:6-10).
7. Тэрээр итгэгчийг ариусгаж, түүнийг ариун байлгахын тулд зүрх сэтгэлийг нь цэвэрлэдэг (Үйлс 15:8-9; 1 Петр 1:2).
8. Тэрээр нүглийг ялж амьдрах хүчийг өгдөг (Ром 8:1, 5, 13; Галат 5:16).
9. Тэрээр итгэгчийн амьдралд сүнслэг үр жимсийг ургуулдаг (Галат 5:22-23).
10. Тэрээр үйлчлэх бэлэг авьяас өгдөг (1 Коринт 12:4-10, 28-30; Ром 12:6-8; 1 Петр 4:10-11).
11. Тэрээр үйлчлэх онцгой тосолгоо өгдөг (Үйлс 1:8, Үйлс 13:9; Галат 3:5; 1 Петр 1:12).
12. Тэрээр итгэгч хүнд Бурханы хүслийн дагуу залбирахад нь тусалдаг (Ром 8:26-27; Ефес 6:18).
13. Тэр чуулганд эв нэгдэл, нөхөрлөлийг өгдөг (Ефес 4:3; Филиппой 2:1).

Сүнсний бэлэг авьяасын талаарх зарим зарчмууд

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ангийн нэг гишүүн энэхүү хэсгийг тайлбарлана уу.

1. Сүнс нь ялгаатай бэлэг авьяас, үйл ажиллагаа, удирдлагаар дамжуулан ажилладаг (1 Коринт 12:4-6).
2. Сүнслэг бэлэг авьяас нь сүнслэг байдлын дагуу бус, харин Бурханы хүслийн дагуу хуваарилагддаг (1 Коринт 12:11, 1 Коринт 4:7).
3. Хүн бүрд Сүнсний ямар нэг бэлэг авьяас өгөгдсөн байдаг (1 Коринт 12:7).
4. Итгэгч бүрийг адилхан бэлэг авьяастай гэж бодож болохгүй (1 Коринт 12:8-11, 14-30).
5. Бэлэг авьяас нь Бурханы алдрын төлөө бусдад үйлчлэхэд ашиглагдах ёстой (1 Коринт 12:21-22, 25; 1 Петр 4:10-11).

Хэлүүдээр ярих бэлэг авьяас

Христэд итгэгч хүмүүс хэлүүдээр ярих бэлэг авьяасын талаар тэр бүр санал нэгтэй байдаггүй. Зарим нь итгэгч хүн бүр Ариун Сүнсийг хүлээн авахдаа ер бусын хэлүүдээр ярьдаг гэж итгэдэг.

Бусад нь хэлний бэлэг авьяасыг өөр хэлээр ярьдаг хүмүүстэй харилцах зорилгоор зарим хүнд өгөгддөг гэж үздэг. Үүнийг Пэнтекостын өдөр итгэгчдийг олон янзын хэлээр ярих үед тэнд байсан хүмүүс ойлгож байсантай холбож тайлбарладаг (Үйлс 2:6). Бурхан энэхүү бэлэг авьяасыг төдийгүй бусад сүнслэг билгүүдийг хүссэн хүндээ өгдөг гэж тэд үздэг (1 Коринт 12:4-11). Итгэгч бүрд байх ёстой адилхан бэлэг авьяас гэж байхгүй (1 Коринт 12:29-30). Тиймээс итгэгч хүн бүр Ариун Сүнстэй (Ром 8:9) хэдий ч бэлэг авьяас нь итгэгч хүнийг баталгаажуулах ямар нэг зүйл биш (1 Коринт 14:22) гэж тэд итгэдэг.

Хэлүүдээр ярих бэлэг авьяастай холбоотой олон ялгаатай үзэл бодол нь үйлчлэлд хамтран ажиллахад саад болж мэдэх ч, итгэгчид энэ асуудал дээр бие биенийхээ үзэл бодлыг шүүмжилж болохгүй.

Ариун Сүнс итгэгч хүнтэй харилцдаг

Хэрэв та Бурхантай харилцдаг бол Ариун Сүнстэй ч мөн харилцдаг. Гурвалаас ганц бодгалийг л мэддэг, харин бусдыг нь мэдэхгүй байх боломжгүй юм (Ефес 2:18; Иохан 6:44, унших).

Хүн аврагдахаасаа өмнө Ариун Сүнсний тухай онол сургаалыг сайн ойлгохгүй байж болох юм. Дагалдагчид ч Сүнсний талаар сайн мэддэггүй байв. Харин Есүс тэдэнд тэд Сүнсийг мэдсэн, бас тэр Сүнс аль хэдийн тэдэнтэй хамт байсан гэдгийг хэлсэн юм (Иохан 14:17, унших).

Ариун Сүнсний тухай зөв онол сургаалыг мэдэх нь Түүнтэй зөв арга замаар харилцахад тусалдаг бөгөөд бидний амьдралд илүү ихийг хийх боломжийг Сүнсэнд олгодог. Тэр бодгаль нэгэн гэдгийг мэдсэнээр Түүнтэй харилцах боломжтой гэдгээ бид ойлгодог. Түүнтэй яривал Тэр бидэнтэй ярина. Тэрбээр ихэвчлэн сонсогдохуйц бус дуу хоолойгоор ярьдаг ч, Тэр бидэнд Бурханы хүсэл болон хайрыг ойлгоход тусалдаг. Хэрэв бид Бурханы хүслийг биелүүлэхийг хүсвэл, ихэвчлэн ингэж мэдэрдэггүй ч гэсэн Ариун Сүнс биднийг удирдан чиглүүлэх болно.

Түүнийг бодгаль гэдгийг мэдсэнээр бид Түүнтэй зүгээр нэг хүч, эсвэл мэдрэмж юм шиг хандахгүй гэсэн үг. Бид Бурханд мөргөл хүндэтгэл өргөхдөө оюун бодолгүй зөвхөн мэдрэмжээсээ таашаал авах бус, харин Түүнийг хэн болох, ямархуу зан чанартай гэдгийг эргэцүүлж тунгаадаг. Бид залбирах үедээ ухаанаар ярьж, Түүний харуулахыг хүсэж байгаа зүйлийг ойлгохыг хичээдэг болохоос бусад шашны хүмүүс шиг хувьчилсан яриагүй, ид шидийн төдий байдлаар ханддаггүй.

Ариун Сүнсийг Бурхан гэдгийг нь мэдсэнээр бид Түүнд хүндлэл бишрэлтэй ханддаг. Бид залбирч, Түүний удирдамжийг мэдрэх үедээ Ариун Сүнс биднийг хайрладаг, биднийг бүрэн мэддэг, ирээдүйг маань ч мэддэг Бурхан гэдгийг санах учиртай. Тэр туйлын эрх мэдэлтэй Нэгэн учраас бид Түүнд дуулгавартай байх ёстой юм.

Тэр бидэнтэй үргэлж хамт байдаг. Бичвэрт биднийг Сүнс дотор амьдарч, Сүнс дотор явах ёстой гэж заасан (Галат 5:25) билээ. Бид түүний оршихуйд байгаа мэт амьдрах ёстой бөгөөд зөвхөн чуулган дээр л Сүнсний оршихуй ирдэг гэж бодох ёсгүй юм. Тэрээр бидэнтэй хамт байгаад зогсохгүй бидний дотор амьдардаг билээ. Энэ л шалтгааны улмаас бид цэвэр ариун амьдрах ёстой юм (1 Коринт 6:19, унших).

Ариун Сүнс бидэнд нүглийг ялах ялалтыг өгч, цэвэр ариун зүрх сэтгэлтэй болгох нь Түүний нэн тэргүүний зорилго юм (Ром 8:13; Галат 5:16; Үйлс 15:8-9). Биднээр дамжуулан чухал зорилгоо биелүүлэхийг бид Сүнсэнд зөвшөөрч чадахгүй байгаа бол бусад зүйлийг ч гуйх ёсгүй. Бид итгэлээр залбирч, Тэр биднийг бүрэн ариусгана гэдэгт итгэх ёстой (1 Тесалоник 5:23, унших).

Амьдралын хүнд хэцүү үед Тэр бидэнд дотоод хүчийг өгдөг (Ефес 3:16). Тэр биднийг ойлгож, бидний нөхцөл байдлыг мэддэг учраас яг хэрэгтэй зүйлийг маань Тэр өгч чадна.

Үйлчлэх үедээ бид Түүнд болон удирдамжид нь түшиглэж, Үгээрээ хүч өгч, бусдын зүрх сэтгэлд сүнслэг үр дүнг гаргаасай хэмээн найдан үйлчлэх ёстой.

Та хэдийн Сүнсээр дүүрсэн байлаа ч, Түүнтэй харилцаар байх ёстойгоо мартаж болохгүй. Сүнсээр дүүр гэсэн тушаал нь *тасралтгүй* Сүнсээр дүүрэн байна гэсэн үг юм (Ефес 5:18, унших). Бид тасралтгүй дүүрсээр байх хэрэгтэй бөгөөд энэ нь Түүнтэй харилцах харилцаагаар тэтгэгдэж байдаг.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Ариун Сүнс бол Эцэг ба Хүүгийн адил бүрэн дүүрэн Бурхан бөгөөд Гурвалын нэг бодгаль юм. Тэр нүглийг буруушааж, итгэгчийг дахин төрүүлж, түүний дотор амьдардаг. Тэрээр итгэгч хүн бүрд нүглийг ялах ялалтыг соёрхон, зүрх сэтгэлийг нь цэвэршүүлдэг. Тэрбээр Сүнсний үр жимс, сүнслэг бэлэг авьяасаар үйлчлэлийг ерөөгч бөгөөд чуулганы нэгдмэл амь билээ.

Ариун Сүнсний бодгаль чанарын талаарх Библийн нотолгоо

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Энэ хэсгийг сонгон суралцах боломжтой. Хэрэв гишүүдэд энэ сэдвээр Библийн илүү их нотолгоо хэрэгтэй бол хамт судалж болно.

Зарим хүн Сүнсний бодгаль чанарыг үгүйсгэж, татах хүч эсвэл цахилгаантай адил, хувийн зан чанаргүй, зүгээр нэг хүч мэтээр үздэг. Гэвч Библид Ариун Сүнсийг дүрсэлсэн шиг тийм байдлаар зүгээр нэг хүчийг дүрслэх боломжгүй. Цахилгаан ярьдаггүй, учирладаггүй, татах хүчинд хүн худлаа хэлэх шаардлагагүй. Оюун ухаангүй хүч хэрхэн Бурханы хүслийг ойлгох билээ?

Зарим хүн бичвэрүүдийг хүншүүлэл гэж үздэг учраас бодгаль биш зүйлийг хүн мэтээр дүрслэн илэрхийлсэн гэж хэлдэг. Гэхдээ Сүнсийг Өөрийнхөө үг хэллэгээр ярьж, хүмүүс ч Түүнтэй бодгалийнх нь хувьд хариу өгч ярьсан тухай Бичвэрт өгүүлдэг шүү дээ. Библийн хэд хэдэн хэсэгт Сүнсийг шингэн зүйл мэтээр шилжсэн утгаар дүрслэхдээ асгаран буусан хэмээжээ (Үйлс 2:17). Библид Сүнсийг Өөрийн зан чанартай бодгаль гэж хэлдэг учраас эдгээр дүрслэлийг шилжсэн утгаар ойлгох хэрэгтэй.

Ариун Сүнсний бодгаль чанарын талаарх Библийн нотолгоо:

- Матай 28:19-д биднийг Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр баптисм хүрт гэсэн байна. Эндээс гурвуулаа эрх мэдэлтэй гэсэн санааг харж болно.
- 2 Коринт 13:14-д Ариун Сүнсний нөхөрлөлийн тухай дурдсан нь Түүний ухаалаг харилцаа холбоог илтгэдэг.
- Марк 13:11-д хавчлагын үед Ариун Сүнс итгэгчдээр дамжуулан ярих болно гэж амлажээ.
- Иохан 14:17, 26-д Ариун Сүнсийг зааж сургадаг, сануулдаг үнэний Сүнс гэж нэрлэжээ.
- Иохан 16:7-11-д Ариун Сүнс энэ дэлхийг нүгэл, шударга ёс, шүүлтийн улмаас зэмлэнэ гэж Есүс хэлсэн. Энэ бүхэнд ухаалаг харилцаа холбоо шаардлагатай.
- Иохан 16:13-15-д Ариун Сүнс Өөрийнхөө эрх мэдлээр ярихгүй, харин Христийн юмсыг тунхаглана гэжээ.
- Мөн 1 Коринт 12:11-д Ариун Сүнс сүнслэг бэлэг авьяасыг хэрхэн өгөхөө сонгодог тухай өгүүлсэн.

- Тэрээр биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг (Ром 8:16) бидний сүнстэй хамт гэрчилдэг.
- Тэрбээр Эцэгийн өмнө бидний төлөө зуучлан гуйдаг бөгөөд Бурханы хүслийг ойлгох оюун ухаан Түүнд бий (Ром 8:26-27).
- Ефес 4:30-д Түүнийг гашууддаг гэсэн байгаа нь Тэр бидний өгч буй хариу үйлдлийг ойлгодог, сэтгэл хөдлөлтэй гэдгийг харуулж байна.
- Түүнд худал хэлж байгаа үйл явдал нь Тэр харилцааг ойлгодог гэдгийг харуулдаг (Үйлс 5:3).
- Тэр ярьдаг, зааварчилдаг, хүмүүст хүслээ илэрхийлдэг (Үйлс 13:2-4).
- Тэрбээр элч нарыг сайнмэдээний аянд удирдан чиглүүлж, зарим газар руу явахгүй байхыг сануулж байсан (Үйлс 16:6).

10-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Үйлс 1:4-8
- Ром 8:1-14
- 1 Коринт 2:9-16
- 1 Коринт 12:1-13
- Галат 5:22-26

(2) Сорил: Дараагийн хичээлийг 10-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

10-р хичээлийн сорил

(1) Чуулган анх Ариун Сүнстэй харилцаж байсан гурван загварыг энд нэрлэнэ үү.

(2) Ариун Сүнсийг бодгаль гэдгийг бид хэрхэн мэдэх вэ?

(3) Ариун Сүнсийг Бурхан гэдгийг мэдэж болох таван арга зам юу вэ?

(4) Ариун Сүнсний үйл хэргээс есийг жагсааж бичнэ үү (Аль нь ч байж болно).

(5) Бидний амьдрал дахь Ариун Сүнсний нэн тэргүүний зорилго юу вэ?

11-р хичээл

Христитгэлийн ариун байдал

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Библи дэх *ариун* гэх нэр томъёоны хэрэглээ.
- Христитгэлийн ариун байдлын үндэс болох Бурханы ариун чанар.
- Мөргөл хүндэтгэл ба Бурхантай харилцах харилцаан дахь ариун байдлын ач холбогдол.
- Ариусгалын талаарх Библийн жишээ.
- Сүнслэг төлөвшилд хүргэх дасгал сургуулилтүүд.
- Ариун байдлын талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь Бурханы нигүүлслээр энэ дэлхий дээр ариун амьдарч чадна гэдэг итгэлийг олж авна.

Библийн нэр томъёо

Ариун байдал, ариусгал гэж орчуулдаг еврей үг Хуучин гэрээнд 600 гаруй удаа гардаг. Ариун гэсэн утгатай еврей болон грек үг хоёулаа үндсэндээ тусгаарлах, ямар нэг зорилгод зориулагдсан гэсэн утгатай. Ариусгасан зүйлийг тусгай шинэ зорилгоор хэрэглэхийн тулд өмнөх хэрэглээнээс нь тусгаарладаг. Хуучин гэрээнд хэд хэдэн тусгай зориулалтын, ариун юмсыг дурдсан байдаг.

- **Ариун газар.** Бурхан Мосетэй уулзсан газрыг ариун хэмээн онцолсон (Гэтлэл 3:5).
- **Ариун асар, Сүм.** Тахилчийн өмсгөл (Леви 16:32), тавиг талх (Гэтлэл 29:34), тавилгууд (Гэтлэл 40:9) гэхчлэн маш олон ариун эд юмс Эзэний өргөө, асартай холбоотой хэрэглэгддэг байжээ. Энэ бүхэн Бурханд мөргөл хүндэтгэл өргөхөд зориулагдсан тусгай эд хэрэгсэл байв.
- **Ариун өдрүүд.** Амралтын өдрийг мөн ариусган тусгаарлажээ (Эхлэл 2:3; Гэтлэл 20:8). Эвлэрүүллийн өдөр гэх мэт еврейчүүдийн баярыг мөн тусгай хэмээн үзсэн (Леви 23:26-29) байдаг. Эдгээр өдрүүдийг амрах, эргэцүүлэн бодох, мөргөн хүндэтгэхэд зориулж тусгаарладаг байжээ.
- **Ариун Бурхан.** Библи дэх хамгийн агуу ариун байдлын жишээ бол Бурхан Өөрөө юм. Бурханд хамаатай бүх зүйл ариун. Түүний нэр ариун (Леви 22:2), үгс нь

ариун (Иеремиа 23:9), арга зам нь ариун (Дуулал 77:13) билээ. Ариун гэдэг нь Бурхан Өөрөө бүхий л нүгэлтэй, цэвэр бус, нийтлэг, жирийн эсвэл Түүний тэнгэрлэг мөн чанар, байр сууринд үл нийцэх юмсаас бүрэн тусгаар гэсэн утгатай.

Шинэ гэрээнд Есүсийг ариун (Иохан 17:19; Үйлс 4:27, 30), мөн нүгэлгүй (2 Коринт 5:21) гэсэн байдаг. Тэнгэрэлч нар (Марк 8:38), элч нар, эш үзүүлэгчдийг бас (Ефес 3:5) ариун хэмээн тодорхойлсон байна. Эдгээр нь бүгд онцгой зорилгын төлөө тусгаарлагджээ.

Библид Бурханы хүмүүсийг ариун гэж дуудсан байдаг (Леви 11:44-45; 1 Коринт 1:2; 1 Петр 1:15-16). Энэ хичээлээр Бурханы хүсдэг ариун байдлын тухай тайлбарлана.

Бурханы ариун мөргөн хүндлэгчид

► Дуулал 119:33-40-ийг хамтдаа унших. Итгэгч хүнийг өөрчилдөг Бурханы арга замын талаар эдгээр эшлэлд юу гэж хэлсэн бэ?

Бурхан Өөрийгөө илчилж эхлэх үедээ ямар Бурхан болохоо харуулах нь Түүний анхны зорилго байжээ. Тэрээр юуны өмнө Өөрийгөө “ариун” хэмээн тодорхойлсон. Исаиа номд Бурханыг ихэвчлэн “Израилын Ариун Нэгэн” гэж нэрлэсэн байдаг.

Бурханы ариун байдал нь мөргөл хүндэтгэлийн гол сэдэв юм.

Таны аугаа, сүрдмээр нэрийг тэд магтан дуулаг. Тэр ариун. Бидний Бурхан ЭЗЭНийг өргөмжилж, Түүний хөлийн гишгүүрийн өмнө мөргөгтүн! Тэр ариун (Дуулал 99:3, 5).

Хүмүүнд тавигдах Бурханы шаардлагын үндэс нь Түүний ариун байдал юм. Тэр Өөрөө ариун учраас мөргөн хүндлэгчдийг ариун байхад уриалдаг. Тиймээс “Би ариун тул та нар ариун бай” (Леви 11:44-45, Леви 19:2, Леви 20:26, Леви 21:8) хэмээн хэлжээ.

Израилын Бурхан бусад үндэстний хуурамч бурхдаас өөр байсан төдийгүй, өөр маягаар мөргөл хүндэтгэл өргөхийг шаарддаг байв.

ЭЗЭНий уул өөд хэн авирч болох вэ? Ариун газарт нь хэн зогсож болох вэ? Цэвэр гартай, ариун зүрхтэй, хуурмаг хоосонд сэтгэлээ өргөөгүй, худал тангараг тавиагүй нь буюу (Дуулал 24:3-4).

Эндээс “Бурхан хэний мөргөл хүндэтгэлийг хүлээн авдаг вэ?” гэх асуулт гарч ирж байна. Бурхан хүн бүрийг мөргөн хүндлэгч гэж хүлээн авдаггүй. Тиймээс Түүнийг хүндлэгчид ариун байх ёстой юм.

Бурханы хүсэж буй ариун байдал нь зан үйлийн шинжтэй, дүр эсгэсэн бус, харин жинхэнэ ариун байдал юм. Бурханыг мөргөн хүндлэгчдийн ариун байдлын жишгийг Шинэ гэрээнд олон давтан өгүүлсэн байдаг.

Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм (1 Петр 1:15-16).

Зан байдал гэдэг нь хүний биеэ авч явах байдал амьдралын хэв маягийг бүхэлд нь илэрхийлдэг. Бурхан Өөрт нь мөргөн хүндлэгчийг зөвхөн зан үйлийг дагадаг, эсвэл ариун биш атлаа ариун гэж дуудуулдаг байхыг хүсдэггүй. Харин мөргөн хүндлэгчийг ариун амьдралаар амьдраасай гэж Тэр хүсдэг.

► Ариун байдал мөргөл хүндэтгэлтэй холбогддог ямар ямар шалтгаан байна вэ?

Мөргөн хүндэтгэхэд ариун байдал чухал юм. Учир нь:

- 1. Бид Бурханыг хайрладаг ба Түүнтэй адил байхыг хүсдэг.** Бурханыг мөргөн хүндэтгэх гэдэг нь Бурханыг оршин буй хамгийн гайхамшигтай бодгаль болохыг нь ойлгож, Түүнийг байгаагаар нь бишрэн хүндлэхийг хэлдэг. Мөргөн хүндэтгэх гэдэг нь Түүний мөн чанарыг үнэлж бахдах юм. Бурханы мөн чанар нь үндсэндээ ариун билээ. Тиймд бид үнэнээсээ Бурханы мөн чанарыг биширч байгаа бол нүгэл, ёс бусыг үзэн ядна. Өөрсдөөсөө үүнийг харсан байлаа ч үзэн ядах болно.
- 2. Бид Бурханыг хайрладаг ба Түүнийг баярлуулахыг хүсдэг.** Хэрэв мөргөл хүндэтгэл гэж юу болохыг ойлгодог бол Бурханы шаардлага биднийг гайхшруулахгүй. Бид айснаасаа болоод хүндэтгэл өргөдөг бус, Түүний ерөөлийг хүртсэн учраас ч бус, харин бид Түүнд хайртай учраас Түүнийг мөргөн хүндэтгэдэг.

Итгэлд ирэх үеийн ариусгал

Библид *ариусгал* гэдэг үгийг итгэгч бүрийн амьдралд тохиолдсон үйл явдлыг илэрхийлэхэд ашигладаг. Паул “Коринт дахь Бурханы чуулган хийгээд хаа сайгүй Эзэн Есүс Христийн маань нэрийг дуудагчдад болон ариун хүмүүс байхаар дуудагдсан, **Христ Есүс дотор ариусгагдсан хүмүүст**” (1 Коринт 1:2) гэж бичсэн байдаг. Тэрээр мөн “... Гэвч Эзэн Есүс Христийн нэрээр болон Бурханы маань Сүнс дотор та нар угаагдсан, **ариусгагдсан**, та нар зөвтгөгдсөн” хэмээн бичжээ (1 Коринт 6:11). Коринтчууд сүнслэг төлөвшилд хүрээгүй, Христ дотор нялх хүүхэд мэт, махбодын хүслээрээ явдаг хүмүүс байсан ч, тэд хэдийн ариусгагдсан байжээ (1 Коринт 3:1).

Энд коринтчуудын талаар ярихдаа *ариусгах* гэдэг үгийг хамгийн ерөнхий утгаар нь ашиглажээ. Коринтчууд нүгэлт амьдрал, ертөнцийн явдал дундаас дуудагдаж, Бурханд тусгаарлагдсан хүмүүс юм. Тэд ариусгалд төлөвшөөгүй байсан нь гарцаагүй боловч, хуучин амьдралаасаа тусгаарлагдаж, Бурханы гэр бүлийн нэг хэсэг болсон байлаа. Бурхантай анх уулзах үед бидний нүгэл Түүнтэй харилцах харилцаанд маань саад тотгор болдог. Тиймээс гэмшиж, уучлагдаж, зүрх сэтгэлээ шинэчлэх хүртлээ бид Бурхантай харилцаж чаддаггүй.

Бурхантай эвлэрэхийн зэрэгцээ бид бас өөрчлөгддөг (Тит 3:5). Сүнслэг байдлын хувьд бид шинэ бүтээл болсон. Бид нүглийн хүчнээс чөлөөлөгдөж, Бурханыг баярлуулах хүсэлтэй болдог. Хүн аврал авах үеэс христитгэлийн ариун байдал эхэлдэг.

Нэгэн хиндү өвгөн Еми Кармайклаас "Бид маш олон номлол сонссон. Та бидэнд Эзэн Есүсийнхээ амьдралыг харуулж чадах уу?" гэж асуужээ.

Аврал хүнийг ариун амьдрал руу хөтөлдөг гэдгийг Библи бидэнд зааж байна. Авралыг авчирдаг Бурханы нигүүлсэл нь эдүгээ үед биеэ цэнэдэг ба сүсэг бишрэлтэй амьдрахыг бидэнд сургадаг (Тит 2:11-12). Авралын зорилго нь биднийг нүглээс чөлөөлж, ариун болгох явдал бөгөөд ингэснээр бид Бурхантай харилцаатай амьдарч чадах юм (Лук 1:74-75, Ром 6:2, 11-16).

Ариусгал дотор өсөх нь

Бид Бурхантай харилцаатай амьдрах тусмаа Бурханы үнэнийг ойлгож, ариун байдалдаа өссөөр байдаг. Бурханы үнэний талаар илүү ихийг мэдэхийн хэрээр Бурханыг үргэлжлүүлэн дуулгавартай дагахыг гэрэлд алхах гэнэ (1 Иохан 1:7). Түүнд юу таалагддаг, юунд дургүйг нь илүү сайн ойлгох тусмаа Түүний үнэн ба Ариун Сүнсний хүчээр бид өөрчлөгддөг.

Бурханыг хайрладаг хүн бүрэн ариун байхыг хүснэ. Тийм хүн үйлдлээ өөрчлөөд зогсохгүй, санаа сэдлээ хүртэл цэвэр ариун байлгахыг хүсдэг. Давид нүглийг бүрэн ялж амьдрахын төлөө залбирч байгаад, улмаар үг хэлээр зогсохгүй зүрх сэтгэлийн бясалгал нь хүртэл Бурханыг баярлуулахын төлөө гүйсэн байдаг (Дуулал 19:12-14. Дуулал 119:7, 34, 36, 69, 80, 112).

Сүнслэг төлөвшлийн бүхий л үйл явцыг ариусгал гэнэ. Ариусгал нь нүгэл болон ертөнцийн хүслээс улам бүр салж, Бурханд өөрийгөө зориулах насан туршийн үйл явц юм. Паул энэ ертөнцийн хэв маягт автахаас сэрэмжлүүлж, "харин оюун санааныхаа шинэтгэлээр өөрчлөгдөж байгтун [тасралтгүй]!" (Ром 12:2) хэмээн ятгаж байсан. Дэлхийн явдлаас салж, оюун санаагаараа өөрчлөгдөх нь Христэд итгэгчдийн хувьд хэсэг хугацаанд хийгээд бүрэн болчихдог зүйл биш. Итгэгч хүн Эзэнтэй хамт алхаж л байгаа бол өсөлт хөгжлийг байнга мэдэрнэ. Энэ бүх ойлголт *арбусгал* гэдэг үгэнд багтсан байдаг.

Удамшсан завхрал гажуудал ба ариусгал

Удамшсан завхрал гажуудал гэдэг нь хүн төрснөөс эхлээд нүгэлд татагддаг ёс суртахууны мөн чанарын гажуудал юм. Үүнийг заримдаа "анхдагч нүгэл" гэж нэрлэдэг. Энэ нь Адамын нүглийн улмаас бидэнтэй хамт төрдөг нүгэлт мөн чанар юм.

Хүн бүр өөртөө төвлөрсөн, нүгэлд татагдах хүсэлтэй төрдөг. Бурхан бидэнд хүсэл, хүчийг өгөхгүй л бол бидний хүсэл зөвийг сонгох боломжгүй юм (Ром 6:16-17). Удамшсан завхрал гажуудал нь бардам зан, атаа жөтөө, үзэн ядалт, үл уучлал зэрэг дотоод нүглийг өдөөдөг. Улмаар энэ нь нүглийн үйлсийг ч өдөөнө.

► Аврагдсаны дараа ч удамшсан завхрал гажуудал арилахгүй хэвээрээ үлдэх үү?

Аврагдсан хүн удамшсан завхрал гажуудлын хяналтанд цаашид байхаа боино. Хэрэв удамшсан завхрал гажуудалдаа захирагдсан хэвээр байсан бол тэр хүн нүгэл дундаа амьдарч, аврал авахгүй байх байсан. Библид махбодын бодол санаанд захирагддаг хүн яллагдана гэж хэлсэн байна (Ром 8:6-8, 13). Аврагдсан хүн удамшсан завхрал гажуудлын хяналтаас гарсан учраас Ариун Сүнсний хүчээр нүглийг ялан дийлж амьдрах боломжтой (Ром 8:1, 9, 13).

Гэхдээ аврагдсан хүн удамшсан завхрал гажуудлаасаа цэвэрлэгдэх хүртлээ нөлөөг нь хадгалсаар байдаг. Паул Коринтын итгэгчдийг аврал авсан хүмүүс боловч махбодын хүслээ дагасан хэвээрээ, энэ дэлхийн хүмүүс шиг хандлагатай хэвээрээ байна гэжээ (1 Коринт 3:1-3, унших). Үүгээр шинэ итгэгчдийг ийм байдалд орох нь байдаг зүйл гэсэн санааг Паул илэрхийлжээ. Махбодын хүслээрээ амьдарч байгаа хүн Христийн дотор нялх хүүхэд адил гэжээ.

Ийм байдалд байгаа итгэгч хүн Бурханыг хайрлах боловч бүх зүрх, сэтгэл, оюун ухаан, хүч чадлаараа Бурханыг хайрлаж чаддаггүй (Матай 22:37). Тийм хүн Паулын адилаар Бурханы дуудлагыг дагах ганц л хүсэл тэмүүлэлтэй гэж хэлж чадахгүй (Филиппой 3:13-15) юм. Түүнчлэн зүрх сэтгэлийнх нь зарим бодол эргэцүүлэл Бурханд таалагдахгүй байгааг өөрөө ч мэддэг (Дуулал 19:14). Бурхан биднийг ийм байдалтай орхихгүй. Бүр эрт дээр үед ч Бурхан нигүүлслээ үзүүлж, израилчуудыг бүх зүрхээрээ Бурханыг хайрлах чадвартай болгоно хэмээн амлаж байв (Дэд хууль 30:6, унших).

Давид уучлалаас ч гүн гүнзгий нигүүлслийн ажлын төлөө залбирсан байдаг. Тэрээр нүгэл үйлдсэнийхээ дараа зүрх сэтгэлийнхээ угт байгаа асуудлаас болж ийм зүйлд орооцолдсон гэдгээ ойлгож байв. Нүгэл өөрийнх нь мөн чанарт байгаа гэдгийг ухаарч байсан ч, Бурхан түүнийг бүрэн ариун байхыг шаарддаг гэдэгт итгэж байв. Тиймээс Давид бүрэн цэвэр ариун болохын төлөө залбирчээ (Дуулал 51:5-10, унших).

Шинэ гэрээний үеийн итгэгчид итгэлд ирснийхээ дараа өөр нэг онцгой үйл явдалд дуудагджээ. Тесалоникийн итгэгчид бол сайнмэдээг хүлээн авч, шүтээнээ орхиж, хавчлагыг тэвчиж, Ариун Сүнсэнд баярлаж, Есүсийн эргэн ирэхийг хүлээж байсан итгэгчдийн гайхалтай жишээ юм (1 Тесалоник 1:6-10). Гэсэн хэдий ч тэдний итгэлд ямар нэг зүйл дутагдаж байв. Энэ дутагдсан зүйл нь удаан хугацааны үйл явц, эсвэл үхлийн дараа гүйцэлдэх зүйл биш, харин Паулыг тэдэн дээр очих үед ч гүйцэлдэж болох зүйл хэмээн тэр хэлсэн байдаг (1 Тесалоник 3:10, унших). Тиймд Паул ийнхүү залбирчээ.

“Ариусгал бол миний төлөө хийгээсэй хэмээн Бурханаас хүсэж буй миний хүсэл биш.

Ариусгал бол миний төлөө Бурханы хийхийг хүсэж буй тэр зүйл. Тэр намайг ямар ч үнээр хамаагүй бүхэлд нь ариусгахыг би Түүнд зөвшөөрөх тийм л сэтгэлгээ, оюун санааны хандлагатай болох ёстой юм.”

- Освальд Чемберс

Амар амгалангийн Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгатугай. Сүнс, сэтгэл, бие тань бүхлээрээ бидний Эзэн Есүс Христийг ирэхэд гэм зэмгүй хэвээр байх болтугай. Та нарыг Дуудагч нь итгэмжит бөгөөд Тэр мөн үүнийг биелүүлэх болно (1 Тесалоник 5:23-24).

Паул итгэгчдийг ариусгал дундуур явсаар байхын төлөө залбирсан. Ариусгалын үр дүнд итгэгчид Эзэнийг эргэн ирэх үед бие, сэтгэл, сүнсээрээ гэм зэмгүй байх юм. Пентекостын баяраар Есүсийн дагалдагчид онцгой нигүүлслийг хүлээн авчээ. Тэд түүнээс өмнө аль хэдийн аврагдсан байсныг бид мэднэ. Есүс ч тэднийг энэ дэлхийнх биш болж, Өөрт нь болон Эцэгт харьяалагддаг, нэрс нь тэнгэрт бичигдсэн хүмүүс болсон гэж хэлж байсан (Иохан 15:3, Иохан 17:14, 9-10; Лук 10:20). Гэвч тэд өөртөө төвлөрсөн, Бурханд чухал зүйлсийг ойлгож өөрийн болгоогүй хэвээрээ байв. Есүс тэдний нүгэлт хандлагыг дахин дахин залруулж өгдөг байлаа (Марк 9:33-34; Марк 10:35-41; Лук 9:54-55, унших).

Есүс амилсныхаа дараа тэнгэрт одохоос өмнөхөн дагалдагчдыгаа энэ дэлхий дэх Түүний гэрч нар болно гэж хэлсэн юм. Гэхдээ үүнээс өмнө дагалдагчид эхлээд Ариун Сүнсээр баптисм хүртэх ёстой байв (Лук 24:49; Иохан 20:22; Үйлс 1:2-5, 8, унших). Тэрээр Ариун Сүнсний үйл ажлын тухай тэдэнд олон удаа ярьсан бөгөөд энэ тухай Иохан 14-16-р бүлэгт онцгойлон өгүүлдэг.

Дагалдагчид Пентекостын өдөр Ариун Сүнсээр дүүрсэн (Үйлс 2:4). Энэ дүүрэлт тэдний хүсэл эрмэлзэл, эрхэмлэх зүйлс, үйлдлийг өөрчилсөн. Шинэ гэрээний үйл явдлын туршид дагалдагчид буруу ойлголттой явж, алдаа гаргаж байсан ч,

Христэй адил хандлага, эрхэмлэх зүйлтэй болсноо харуулж байв. Петр, Иохан нарын бичсэн захидалд Христийн үг сургаал, зүрх сэтгэл тусгалаа олсон байна. Ариун Сүнсээр дүүрсэн учраас тэд Бурхан Эзэнээ бүх зүрх, сэтгэл, оюун ухаан, хүч чадлаараа хайрлаж, хөршүүдээ өөр шигээ хайрлаж чадсан билээ (Матай 22:37-39). Тэд Ариун Сүнснээс бүрэн хамааралтай байсан учраас Ариун Сүнс Христээр дамжин амьдарсан шигээ тэднээр дамжин амьдарсан билээ (Лук 4:1, 14, 18; Үйлс 2:22).

Зарим итгэгч багш нар ариусгалын үйл явцад төвлөрдөг бол зарим нь хямралын үйл явдалд анхаарлаа хандуулдаг. Пентекостын баяраар болсон Ариун Сүнсний баптисм нь ариусгалын тодорхой үйл явдлыг мэдэрсэн хүмүүсийн жишээ юм. Аливаа зүйл бүрэн гүйцэд болох эсвэл бага багаар туршигдсаар байх гэдэг нь тухайн цаг хугацаанд хийгдсэн гэдгийг харуулдаг. Бид итгэлийн нэг хоромд ч бай эсвэл Бурханы өмнө бүрэн дүүрсэн бууж өгсөн үедээ ч сайнмэдээний хийж чадах зүйлийг хязгаарлахгүй байх нь

“Дэлхийтэй харилцах тал дээр чуулган давхар үүрэг хариуцлага хүлээдэг. Нэг талаар бид дэлхий дээр амьдарч, үйлчилж, гэрчлэх ёстой. Нөгөө талаар бид дэлхийгээс бохирдохгүй байхыг хичээх ёстой. Тиймээс ариун байдлаа хадгалах гэж дэлхийгээс зугтах, эсвэл дэлхийтэй нийцэж ариун байдлаа золиослохын аль нь ч бидэнд хэрэггүй.”

— Жон Стотт

чухал (Ром 12:1-2) юм. Тэгвэл Есүсийн үхэл ба амиллаараа дамжуулж өгсөн бүхнийг хүлээн авах боломжтой хүмүүс нь:

1. Өөрсдийгөө нүглийн хувьд Есүстэй хамт үхсэн гэж тооцдог (Ром 6:11)
2. Нүгэл бие махбодыг нь захирахыг зөвшөөрдөггүй (Ром 6:12)
3. Бие махбодоо зөвт байдлын зэвсэг болгодог (Ром 6:13) тэдгээр хүмүүс юм.

Түүхийн туршид Жон Бунян, Хадсон Тейлор, Дуайт Л. Мүүди, Сэмми Моррис, Освальд Чемберс, Френсис Ридли Хавергал, Эми Кармайл¹⁵ гэх мэт агуу итгэгчид Сүнсээр дүүрэн амьдарч, Бурхантай илүү гүнзгий харилцаатай байснаа гэрчилсээр иржээ. Бурхан хормын дотор хийж чадах зүйлийг бид хязгаарлахгүй байх ёстой. Үүнчлэн үйл явц бүхий Ариун Сүнсний ажлыг ч мартажгүй байх нь чухал. Ийм төрлийн ариусгалыг заримдаа бүрэн гүйцэд гэж үзэж болох боловч, тодорхой түвшинд хүрлээ гэдэг нь цааш хөгжих ёсгүй гэсэн үг биш. Жишээлбэл, франц хэлээр ярьж сурлаа гээд франц хэлээр бүр сайн ярьж сурах шаардлагагүй гэвэл өрөөсгөл болно. Ариусгалд өссөөр байгаа хүмүүс нэгэн цагт өмнө нь хүрч амсаж байгаагүй тодорхой түвшинд хүрсэн байх болно. Гэхдээ энэ нь туйлын төгс болчихсон гэсэн үг биш юм. Тиймээс итгэгч хүн ариун амьдралаа үргэлжлүүлэн хөгжүүлсээр байх ёстой.

Ариусгал ба христитгэлийн төлөвшил

Библид төлөвшсөн итгэгчийн амьдралыг харуулдаг. Христитгэлийн зан чанарыг хөгжүүлэхийн тулд Ариун Сүнс итгэгчдийн амьдралд ажилласаар байдаг ба итгэгчийг цэвэршүүлэх, тосолгоо өгөх онцгой мөчүүд болон алгуур үйл явц бүхий ажлууд нь бүгд Сүнсний үйл хэрэг юм. Тиймээс Библид дүрсэлсэн төлөвшсөн итгэгчийн хэмжээнд хүртлээ итгэгч хүн сүнслэг амьдралдаа сэтгэл ханаж болохгүй.

Еврей захидлыг бичсэн хүн зарим итгэгчдийг балчир хүүхэд шиг байна гэжээ (Еврей 5:12). Тиймээс тэрээр Христийн тухай балчир ойлголтыг орхиж, **төлөвшилд** (Еврей 6:1) тэмүүлэхийг ятгасан байдаг юм.

Итгэгчдийн төлөө залбирсан элч нарын залбирал ч бидэнд Бурханы хүслийг сануулж байна.

Хайр

Паул "Эзэн та нарыг бие биенээ болон бүгдийг гэсэн хайранд **өсгөн бялхуулах** болтугай..." (1 Тесалоник 3:12-13) хэмээн залбирчээ. Тэрээр бас ефесчүүдийн төлөө залбирахдаа:

...та нар хайр дотор үндэслэгдэн суурилагдаад, тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг бүх ариун хүний хамт ойлгох болтугай. Мэдлэгийг

¹⁵ Үүнтэй ижил олон түүхийг Shepherds Global Classroom -ын *Ариун Амьдралын Онол сургаал ба Хэрэгжүүлэлт (Doctrine and Practice of the Holy Life)* курс хичээлээс унших боломжтой.

давдаг **Христийн хайрыг мэдсэнээр** та нар Бурханы бүх дүүрлээр бялхах болтугай (Ефес 3:17-19) гэжээ.

Паул эдгээр итгэгчдийг хайранд өсгөн бялхуулах гэсэндээ тийнхүү залбирсан байна. Тэрээр мөн төлөвшсөн итгэгчийн хайр ямар байх ёстойг 1 Коринт 13-р бүлэгт тодорхойлжээ. Энгийнээр хэлэхэд Бурханыг бүх зүрх, сэтгэл, оюун ухаан, хүч чадлаараа хайрлаж, хөршөө өөр шигээ хайрлахыг ариусгалын амьдрал гэнэ (Лук 10:27). Ариун хүмүүсийн Бурхантай бас бусадтай харилцах харилцаа ийм байх ёстой.

Гэм зэмгүй байх

Паул тесалоникчуудын төлөө залбирахдаа Бурхан тэдний зүрхийг **ариун чанар дор гэм зэмгүй** (1 Тесалоник 3:12-13) байлгаасай хэмээн залбирчээ. Хоёр бүлгийн дараа тэрээр тесалоникчуудыг бүрэн ариусгагдаж, сүнс, сэтгэл, бие тань бүхлээрээ бидний Эзэн Есүс Христийг ирэхэд **гэм зэмгүй** хэвээр (1 Тесалоник 5:23) байх болтугай хэмээн дахин залбирсан байна. *Гэм зэмгүй байх* гэдэг нь бүх талаар төгс байна гэсэн үг биш. Итгэгчид алдаж болох хэдий ч, зан чанар ба биеэ авч явах байдлын хувьд гэм зэмгүй байх ёстой юм.

Дотоод хүч

Паул ефесчүүдийн доторх хүнийг **Сүнснийхээ хүчээр хүчирхэгжүүлж** өгөх болтугай хэмээн (Ефес 3:15-16) залбиралдаа дурджээ. Итгэлээр өсөх тусам дотоод зан чанар хүчирхэг болдог. Зөв сонголт хийж, буруу шийдвэрийг няцааж чадах чадварыг дотоод хүч гэнэ.

Христ бидний дотор нутаглах нь

Паул ефесчүүдийн төлөөх залбирлаа үргэлжлүүлж, **Христ тэдний зүрхэнд нутаглах болтугай** (Ефес 3:17) гэж хэлсэн байна. Энд дурдсан “нутаглах” гэдэг үг нь хаа нэгтээ түр байх бус харин байнга оршин суух гэсэн утгатай. Есүс бидэн дээр зөвхөн зочлоод зогсохгүй бидэнтэй хамт амьдрахыг хүсдэг. Есүс тогтвортой сүнслэг амьдралаар амьдардаг хүмүүсээс тухтай, нийцтэй байдлыг мэдэрдэг юм.

Бурханы дүүрэл

Паул ефесчүүдийн төлөөх залбирлынхаа хүсэлтийн хэсгийг **Бурханы бүх дүүрлээр бялхах болтугай** (Ефес 3:14-19) хэмээх үгээр төгсгөжээ. Энэ бол сүнслэг байдлыг илэрхийлэхийн тулд бодит юмсыг ашиглан дүрсэлж буй хэрэг. Бурхан бидний оюун ухаан, хүсэл эрмэлзэл, сэтгэл хөдлөл, үйл хэрэг, хандлага, дур хүсэл, хариу үйлдэл гээд бүх зүйлийг маань бүрэн захирахыг хүсдэг. Бурханлаг бус юм өчүүхэн ч байхгүй, бүрэн дүүрэн бурханлаг байдлыг дүрсэлсэн учраас энэ хэсэг бол Библид дурдсан ариун амьдралын тухай бүх дүрслэлээс хамгийн агуу нь биз ээ. Дараагийн хоёр эшлэлд уг залбирлыг ийнхүү дүгнэжээ.

Эдүгээ, дотор маань ажилладаг хүчний дагуу гуйх буюу бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд алдар нь чуулган дотор, бүх үеийнхэнд Христ Есүс дотор үеийн үед байх болтугай. Амен. (Ефес 3:20-21).

Энэхүү ерөөл нь Бурхан бидний гуйж, бодож байгаагаас илүү ихийг хийх чадалтай гэдгийг илэрхийлж байна. Паул санхүүгийн элбэг дэлбэг байдлын тухай биш, харин сүнслэг дүүрэн байдлын тухай энд ярьж байна. Бидний дотор ажиллаж, өсөхөд тусалдаг ариун байдал, төлөвшлийн зэргийг бид дутуу үнэлж болохгүй.

“Бидний өөрсдөдөө олгодог [төсөөллийн] нигүүлслийг хямдхан нигүүлсэл гэнэ. Гэмшихгүйгээр уучлагдах тухай номлол, чуулганы сахилга батгүй баптисм, нүглээ улайлгүй Эзэний зоог барих зэрэг нь хямдхан нигүүлсэл мөн. Хямд нигүүлсэл гэдэг нь дагалдуулалтгүй нигүүлсэл, загалмайгүй нигүүлсэл, амьд бөгөөд хүмүүн болсон Есүс Христгүй нигүүлсэл юм.”

— Диетрих Бонхофер

Христитгэлийн хэрэгжүүлэлтүүд

Ариун байдал, төлөвшилд ахиж дэвших арга замыг Шинэ гэрээнд заасан байдаг.

Сайн мөс чанараа сахь. Паул Тимотод хандаж, сайн тэмцлээр тэмцэгтүн (Христитгэлээр ялж амьдрахыг хэлж байна) гээд, итгэл, сайн мөс чанараа сахь (1 Тимот 1:18-19)¹⁶ гэж уриалжээ. Паул мөн, “Иймээс би Бурхан ба хүмүүсийн өмнө сайн мөс чанартай байхыг үргэлж хичээдэг билээ” (Үйлс 24:16) хэмээн дурдсан байна. Мөс чанараа сонсох нь биднийг гэмших, хохирлоо барагдуулах, эвлэрэх эсвэл биеэ авч явах байдлаа өөрчлөхөд хүргэж болох юм. Мөс чанар сайтай байна гэдэг нь хүн буруу зүйл хийснээ ухаарах бүртээ гэмшин эргэнэ гэсэн үг.

Өөрийгөө Бурханд зориул. Ром 12:1-д Паулын, “Иймд ах дүү нар аа, Бурханы өрөвч сэтгэлээр та нараас хичээнгүйлэн хүсье. **Өөрсдийн биеийг Бурханд тааламжтай, амьд, ариун тахил болгож өргө.** Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн” хэмээсэн хүчирхэг ятгалга бий. Ромын чуулганыхан итгэгч болмогцоо өөрсдийгөө Бурханд зориулсан хүмүүс болсон байв. Гэсэн ч Паул тэдэнд хандаж, өөрсдийгөө Бурханд бүр ихээр зориулахыг уриалжээ.

Энэ үеийн явдалд бүү нийц (Ром 12:2). Дэлхийтэй нийцнэ гэдэг нь үл итгэгч нийгмийн үзэл санааг дуурайж, үнэт зүйлсийг нь хүлээн авч, итгэдэггүй хүмүүс шиг авирлаж биеэ авч явахыг хэлнэ. Дэлхийн хүмүүс хувиа хичээсэн зангаа зөвтгөж, махбодын нүгэлт хүслээ гүйцэлдүүлж болох үндэслэлийг гаргаж ирдэг. Итгэгч хүн ийм байдаггүй (2 Коринт 10:3-4).

Оюун санаагаа шинэчил. Паул ромчуудад хандсан ятгалгаа үргэлжлүүлж,

¹⁶ Паул пастор хүний цэвэр мөс чанарыг чухалчилж байсан учраас Тимотод бичсэн пасторын захидалдаа энэ асуудлыг илүү онцолж “сайн мөс чанар” (1 Тимот 1:5), “цэвэр мөс чанар” (1 Тимот 3:8-9; 2 Тимот 1:3) гэх мэтээр гурван удаа онцлон хэлжээ.

... харин **оюун санааныхаа шинэтгэлээр** өөрчлөгдөж байгтун! Тэгвэл Бурханы сайн, тааламжит, төгс төгөлдөр таалал юу болохыг таних болно (Ром 12:2) гэсэн байна.

Хүн хэдий чинээ дэлхийлэг хүмүүс шиг бодохоос татгалзаж, Бурханы бодол оюуныг хүлээн авна, төдий чинээ их өөрчлөгддөг.

Гэрлийн дотор яв. Иохан бас “Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид **гэрлийн дотор явбал**, бид бие биентэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс цэвэрлэдэг ажээ” (1 Иохан 1:7) гэж бичжээ. Гэрэл гэх үг нь үнэнийг дүрслэн илэрхийлсэн үг юм. Тиймээс гэрэлд алхана гэдэг нь үнэнийг үргэлжлүүлэн сурч, дагана гэсэн үг.

Зовлонг итгэлээр тэвч. Петр 1 Петр 5:10-д бичсэн ерөөлийн залбиралдаа шинэчлэгдсэн, хүчтэй, тогтвортой итгэгч байх гайхамшигтай зорилго байгааг зааж өгсөн боловч түүнд хүрэхийн тулд тийм ч таатай биш замыг туулна гэсэн байна. Уг эшлэлд “бүх нигүүлслийн Бурхан Өөрөө, **түр зуур зовсны чинь дараа та** нарыг төгс болгож, бататгаж, бэхжүүлэн байгуулах болно” (1 Петр 5:10) гэжээ. Зовлон нь бидний хандлагыг ариусгаж, зан төлвийг засдаг. Тиймээс Бурхан биднийг хөгжүүлэхийн тулд зовлон зүдгүүрийг зөвшөөрч байгаа юм. Бид үүнийг хүлээн зөвшөөрч, Бурханы зааж буй зүйлийг сурахаар хичээх ёстой (2 Коринт 12:7-10).

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Хүн нүглээ гэмшиж, Бурханы нигүүлслээр өөрчлөгдөх үед христитгэлийн ариун байдал эхэлнэ. Итгэгч хүн Бурханы хүслийг таньж, дагах тусмаа сүнсээр өсдөг. Ариусгал бол итгэгчийг цэвэршүүлж, ариун зан чанар, ариун амьдралтай болгож буй Бурханы ажил юм.

11-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Исаиа 6:1-8
- Үйлс 2:1-18
- 1 Коринт 10:1-13
- 1 Тесалоник 5:14-24
- Тит 2:11-14

(2) Сорил: Дараагийн хичээлийг 11-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

11-р хичээлийн сорил

(1) *Ариун* гэх нэр томъёоны утга юу вэ?

(2) Бурханы хувьд ариун байдал гэж ямар утгатай вэ?

(3) Мөргөн хүндэтгэхэд ариун байдал яагаад чухал вэ?

(4) Христитгэлийн ариун байдал хэзээ эхэлдэг вэ?

(5) Гэрэлд алхах гэж ямар утгатай вэ?

(6) Насан туршийн ариусгалын үйл явцын дунд итгэгч хүн ямар болдог вэ?

(7) Удамшсан завхрал гажуудал гэж юу вэ?

(8) Итгэгч хүн яаж Эзэнийг ирэх хүртэл бие, сэтгэл, сүнсээрээ гэм зэмгүй байх вэ?

12-р хичээл

Чуулган

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Чуулганы үүсэл.
- Чуулган бол амьд тогтолцоо юм.
- Чуулган бол нутгийн, амьд бие бүрэлдэхүүн.
- Даяар чуулганы нэгдмэл байдлын үндэс.
- Нутгийн чуулганы нэгдмэл байдлын үндэс.
- Чуулганы ариун ёслолууд.
- Чуулганы зорилго.
- Чуулганы талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь нутгийн чуулганд зориулах үүрэг хариуцлагаа ойлгож мэднэ.

Чуулганы үүсэл

► Ефес 3:3-10-ыг хамтдаа унших. Энэ багц эшлэлд чуулганы тухай юу хэлж байна вэ?

Шинэ гэрээнээс өмнөх олон зууны туршид чуулган бүрэн илчлэгдээгүй, нууц зүйл байлаа. Бурханы нигүүлслийг мэдэрч, Түүнтэй холбоотой амьдарч байсан хүмүүс олон байсан ч (Ром 4:1-8), чуулган тэр үед хараахан байгуулагдаагүй байв.

► Чуулган хэзээнээс эхэлсэн бэ?

Есүсийн амьдрал, үйлчлэлийн үеэс чуулган эхэлж, Есүсийн өгсөн авралаар чуулган байгуулагджээ (Матай 16:16-18). Пэнтекостын өдрөөс чуулганы эрин үе эхэлсэн юм. Тэр өдрөөс эхлэн чуулган шууд бодитоор харагдахгүй боловч Христийн удирдлага дор Ариун Сүнсний хүчээр ажиллах болжээ (Иохан 16:7).

Есүс дагалдагч нартаа Өөрийнхөө сургаалыг дэлхий даяар түгээн дэлгэрүүлж, байгуулах эрх мэдлийг өгсөн (Матай 28:18-20) төдийгүй, Ариун Сүнс тэднийг бүхий л үнэнд хөтөлнө гэж амласан (Иохан 16:13) билээ. Элч нарын сургаал нь чуулганы үндсэн сургаал учраас чуулганыг элчийн хэмээн нэрлэж болно. Чуулганы үндсэн сургаалтай зөрчилддөг аливаа итгэл үнэмшлийг христитгэл гэж нэрлэх ёсгүй юм.

Чуулганы үүсэл нь:

1. Есүсийн үйлчлэл
2. Христийн өгсөн аврал
3. Пэнтекостын өдөр болсон үйл явдал
4. Элч нарын сургаалын хөгжил дээр тулгуурладаг.

Чуулган бол амьд тогтолцоо

Чуулганыг Бурхан Эцэг ба итгэгч ахан дүүсийн нэгэн том гэр бүлтэй зүйрлэдэг (Матай 12:48-50, Колоссай 1:2). Чуулганыг мөн арьс өнгө, угсаа гарал үл хамаарах нэгэн үндэстэн гэж нэрлэдэг (1 Петр 2:9-10). Чуулганыг хүний биетэй зүйрлэж ирсэн бөгөөд Христ энэ биеийн тэргүүн нь юм (Ефес 4:15-16, Ефес 5:30). Чуулганы гишүүд хамтдаа ажиллаж, нэг нэгнээ халамжилдаг (1 Коринт 12:14, 26).

Чуулганы гишүүн нь биеийн нэгэн эрхтний хувьд чуулганаас бие даан холдох ёсгүй. Түүнд бусад гишүүд, бусад гишүүдэд тэр хэрэгтэй (1 Коринт 12:21). Итгэгч хүн чуулганд хамрагдалгүй сүнслэг байдлаараа бие даан амьдрах буруу. Чуулганаас тусгаар байх нь дэлхий дээрх Христийн үйлсээс тусдаа байна гэсэн үг. Чуулганыг хүндэлж, хайрлахгүй байх нь Христийг хүндэлж, хайрлахгүй байгаатай адил.

Чуулган бол нутгийн, амьд бие бүрэлдэхүүн

Даяар чуулганаас гадна орон нутгийн чуулганууд гэж бий. Итгэгчид нэг дор хамтдаа байхгүйгээр Христийн биеийг ажиллуулах боломжгүй. Тиймээс Паул Коринтын итгэгчдэд Христийн биеийн хэсэг гэдгийг нь сануулсан (1 Коринт 12:27) байдаг. Эндээс нутгийн чуулган нь тухайн газартаа Христийн бие юм гэх санааг харж болно.

Бурхан нутгийн чуулганыг итгэлийн гэр бүл болгохоор шийдсэн нь дараах зорилготой. Үүнд:

1. Христийн биеийн төлөө сүнслэг бэлгүүдийг ашиглах,
2. Нөхөрлөлд нэгдсэн хүмүүсийн янз бүрийн хэрэгцээг хангах (хувийн болон сүнслэг хэрэгцээ),
3. Бурханы мэргэн ухааныг дэлхийд, амьдралын бүх талбарт харуулах,
4. Үл итгэгчдийг итгэлийн гэр бүлд нэгтгэхээр урих, гэх мэт.

Итгэлийн гэр бүлийнхэн амьдралаа хуваалцаж, бие биенийхээ хэрэгцээнд санаа тавьдаг учраас жинхэнэ нөхөрлөл нь санхүүгийн асуудлыг ч тойрохгүй (Иаков 2:15-16, Иаков 1:27). Хэрэв гишүүд нь чуулганы амьдралд оролцож, чадах чинээгээрээ хариуцлага хүлээж байгаа бол, тэдгээр ахан дүүсийн хэрэгцээ нь чуулганы үүрэх хариуцлага байх юм

Бурхан нутгийн чуулганыг байгуулж, хүчирхэгжүүлэхийн тулд сүнслэг бэлгүүд болон тусгай дуудлага өгдөг (Ефес 4:11-12).

Нутгийн чуулган нутгийнхандаа үйлчилдэг. Сүнслэг байх, сайнмэдээ тараах, бүх асуудал дээр Бурханы үнэнийг тусгах зэрэг нь чуулганы эрхэм зорилго юм. Чуулган нь нийгмийн материаллаг хэрэгцээний төлөө үйлчилдэг ч, чуулганы гишүүдийг анхаарах нь чуулганы нэн тэргүүний ажил мөн (Галат 6:10).

Чуулганы төгс байдал

Есүс чуулганыг ариун, өө сэвгүй байлгахын төлөө Өөрийгөө өгсөн билээ (Ефес 5:27). Чуулганыхан бусдыг уучлахад ямагт бэлэн байх ёстой ч, нүгэлтэй эвлэрэх ёсгүй юм. Удирдагчид ариун амьдралын жишээ болох ёстой (1 Тимот 3:2-3). Хэрэв чуулганы гишүүн нүгэл үйлдвэл удирдагч сөрөн зогсож, хэрэв гэмшихгүй байвал чуулганаас хөөх ёстой (1 Коринт 5:11-13).

► Чуулган яагаад төгс биш байна вэ?

Чуулганы хүмүүс олон талаар төгс биш. Яагаад гэвэл чуулганы тараасан сайнмэдээг сонсоод ирсэн хүмүүсийн дунд нүглээ гэмшээгүй хүмүүс ч бий. Аврагдсан хүмүүсийн дунд ч үнэнийг амьдралынхаа бүх нарийн ширийн асуудалд хэрхэн хэрэгжүүлэхээ хараахан ойлгоогүй хүмүүс байдаг тул амьдрал нь зохисгүй хэвээрээ яваа хүмүүс ч байгаа. Тэр ч бүү хэл төлөвшсөн зарим итгэгчдээс ч зохисгүй байдал, буруу хандлага харагдаж болно. Тэд ч бас сүнслэг өсөлтийнхээ нэгэн шатанд яваа шүү дээ. Хүмүүсийг сүнслэг төлөвшилд хүргэхийн төлөө Бурханы Үгийг тасралтгүй зааж, хэрэгжүүлэх нь чуулганы ажлын нэгэн хэсэг юм (Ефес 4:11-16; 2 Тимот 3:16-17).

Чуулганы тодорхойлолт

Даяар чуулган нь бүх цаг үеийн, бүх газар нутгийн бүх итгэгчдээс бүрдэнэ. Энэ чуулганыг захирах эсвэл гишүүдийг нь бүртгэх газар, байгууллага гэж дэлхий дээр байхгүй тул заримдаа даяар чуулганыг үл үзэгдэх чуулган гэдэг.

Нутгийн чуулган бол Христийн биеийн төлөө хамтдаа үйлчилдэг, нэг газарт байгаа итгэгчдийн нэгдэл юм. Хэсэг бүлэг хүмүүс арай хязгаарлагдмал зорилгоор нэгдсэн бол тэднийг чуулган гэж хэлэхгүй.

Нутгийн чуулганыг бусад бүлгүүдээс ялгахад тус болох илүү өргөн хүрээтэй тодорхойлолтыг дурдъя. “Чуулган нь мөргөл хүндэтгэл өргөх, сургаалд суралцах, үйлчлэх, нөхөрлөх, сайнмэдээ тараах, сүнслэг удирдлагыг хүлээн авах, Христийн биеийн янз бүрийн бэлэг авьяасаараа нийгмийн бүх хэсэгт үйлчлэхийг хүсэх, ариун ёслолуудыг тогтмол үйлддэг, баптисм хүртсэн итгэгчдийн бүлэг юм.”¹⁷

Даян дэлхийн чуулганы нэгдмэл байдал

Бүх газар, бүх цаг үеийн нэг л чуулган байдаг. Есүс “Би чуулганаа босгох бөгөөд” гэж хэлсэн болохоос “чуулгануудыг” гэж хэлээгүй. Элч Паул ч нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм (Ефес 4:4-6) байдаг шиг нэг бие, нэг Сүнс, нэг найдвар байна гэж хэлжээ.

¹⁷ Давид Докери (*David Dockery*), Өмнөдийн Баптист Шинэчлэл ба Зөвшилцөл: Библийн дагуу, Түүхэн, Теологийн Баримт бичиг (*Southern Baptist Consensus and Renewal: A Biblical, Historical, and Theological Proposal*) Nashville: B&H Publishing Group, 2008, 127

Анхны үеийн христитгэлийн тунхагт чуулганыг “католик чуулган” гэдэг байв. Энэ нь Ромын Католик чуулганыг хэлж байгаа бус, харин бүх жинхэнэ итгэгчдийг багтаасан даяар чуулганыг хэлж байгаа юм.

Даяар чуулганы нэгдмэл байдал нь нэг байгууллага, нэг төвлөрсөн захиргаанд байдаггүй. Христийг эргэж ирэхээс нааш хэзээ ч тийм зүйл болохгүй. Зарим хүн ийм байгаасай гэж хүсдэг боловч энэ нь Бурханы хүсэл биш. Яагаад гэвэл Есүсийн дагалдагчид бусад хүмүүсийг өөрсдийнх нь бүлгээс тусдаа үйлчлэл хийх ёсгүй гэж үзэх үед Есүс тэдний бодлыг зассан юм (Лук 9:49-50). Хэрэв Есүс даян дэлхийн чуулганыг нэгдсэн төв захиргаатай болгохыг хүссэн бол, Тэр Өөрөө газар дэлхий дээр биеэр үлдэж удирдах ёстой байсан болов уу. Хэрэв Есүс дэлхий дээр биеэр үлдсэн бол дэлхий даяар Ариун Сүнсний хийх янз бүрийн ажил явагдахгүй байх байсан гэдгийг Тэр мэдэж байлаа (Иохан 16:7).

► Даяар чуулганы нэгдмэл тал юунд суурилдаг вэ?

Даяар чуулганы нэгдмэл байдал нь:

1. Элч нарын онол сургаал
2. Хувьсган өөрчилдөг Христтэй харилцах харилцаанд суурилдаг.

Онол сургаалын нэгдмэл байдал нь Христэд итгэгчид бүх зүйл дээр, бүр чухал онол сургаал дээр ч санал нэг байна гэсэн үг биш. Харин Бурхан ба Христийн мөн чанар болон сайнмэдээний үндсэн санаануудыг заасан гол онол сургаал дээр санал нэгддэг байна гэсэн үг юм. Үүнгүйгээр нэг Бурханд мөргөн хүндэтгэж, нигүүлслийг мэдрэх боломжгүй.

Онол сургаал нь христитгэлийн нэгдмэл байдалд шаардлагатай цорын ганц зүйл биш. Христэд итгэгчид хувьсган өөрчилдөг Христтэй харилцах харилцааны ачаар бие биетэйгээ нөхөрлөж холбоотой болдог. Тэд нүглээ гэмшиж, Христэд итгэж, Ариун Сүнснээ болсон учраас өөр хоорондоо онцгой харилцаатай болсон. Итгэгчид олон талаараа ялгаатай ч тэд дэлхий даяар бие биенээ таньдаг.

“Хэрэв чиний сэтгэл чамайг гэсэн миний сэтгэл шиг чин үнэн бол, ах дүүгээс ч дотно найз шиг, Христ доторх ах дүү, шинэ Йерусалимын иргэн хөрш адил, авралыг соёрхогч нэг Ахмадын доор нэг тулаанд мөр зэрэгцэн яваа дайчин нөхөр мэт зөөлөн сэтгэлээр намайг хайрла.

Хаанчлалын хамтран зүтгэгч, Есүсийн тэсвэр тэвчээр, алдрынх нь өв залгамжлагчийн хувиар намайг хайрла.”

- Жон Веслей

“Даяар Сүнс” номлолоос

Нутгийн чуулганы нэгдмэл байдал

Христэд итгэл үнэмшлийн гол онол сургаалуудыг баримталдаг, хувьсган өөрчилдөг Христтэй харилцах харилцаанд буй хүнийг бид Христэд итгэгч гэж хүлээн зөвшөөрч

болно. Гэхдээ нутгийн чуулгануудын онол сургаалын зөвшилцөл нь илүү нарийвчилсан байх ёстой.

Орон нутгийн чуулган гэдэг нь хамтдаа Бурханыг мөргөн хүндэтгэж, сайнмэдээг түгээдэг, залуусыг болон итгэлд ирэгсдийг дагалдуулдаг, орон нутагтаа үйлчилдэг, христитгэлийн амьдралын практик нарийн ширийн зүйлсийг зааж сургахад өөрсдийгөө зориулдаг бүлэг хүмүүс юм. Эдгээр хүмүүс хамтдаа энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд онол сургаалын олон нарийн ширийн зүйлс дээр тохиролцох ёстой болдог.

Жишээлбэл, нутгийн чуулганы нэг гишүүн чуулганыхаа бүх залууст, бас шинэ хүмүүст хэлүүдээр ярих бэлэг авьяасыг гуйх ёстой гэж хэлдэг байсан байж болно. Гэтэл тус чуулганы бусад удирдагчид хэлүүдээр ярих бэлэг авьяасыг хүн бүрд өгөгдөх зүйл биш гэж үздэг байв. Тиймээс Бурханы хүсэл биш зүйлийг хүмүүс амсаж мэдрэхээр оролдох нь сүнслэг төөрөгдөлд хүргэнэ хэмээн тэдний санаа зовдог болжээ. Мэдээж ийм нөхцөлд нутгийн чуулганд хамтдаа үйлчлэх хэцүү. Тиймээс удирдагчид тухайн хүнийг итгэгч гэж хүлээн зөвшөөрч байгаа ч, чуулганд төөрөгдөл үүсгэж болзошгүй тийм сургаал заахыг тэр хүнд зөвшөөрөх ёсгүй юм.

Нутгийн чуулганыхан амьдралаа хуваалцаж, хамтдаа үйлчлэх замд нь нөлөөлж мэдэх онол сургаалын талаар зөвшилцөх хэрэгтэй. Чуулганууд баримталдаг онол сургаалынхаа талаар бичгээр тунхаглал гаргах нь зүйтэй. Энэ тунхаглал нь хэн нэгэн хүний итгэгч мөн эсэхийг тодорхойлоход ашиглагдахгүй. Харин энэ нь ойр дотно нөхөрлөж, байнга мөргөл хүндэтгэл, үйлчлэл хийдэг хэсэг бүлэг итгэгчдийг ямар онол сургаал нэгтгэж байгааг харуулахад тустай.

Чуулганы ариун ёслолууд

Есүс чуулганд хоёр ариун ёслолыг өгсөн юм. Тэдгээрийг ёс заншил эсвэл тусгай ёслол гэж нэрлэдэг.

Баптисм нь Христийн үхэл, амиллыг бэлгэддэг (Ром 6:3-4). Баптисм бол Христтэй холбогдсон итгэгч хүн нүглийн хувьд үхэж, Христийн дотор шинэ амьдрал эхэлж байгааг илэрхийлсэн гэрчлэл юм. Баптисм хүнийг аврахгүй, харин баптисм хүртэгчийг итгэгч болсныг олон түмэнд гэрчилж буй үйл явдал (Иохан 3:7-8).

Эзэний зоог барихыг Есүс загалмайд цовдлогдохоос өмнө дагалдагчидтайгаа сүүлчийн зоог барих үедээ тогтоож өгсөн юм (1 Коринт 11:23-25). Талх, дарс нь бидний авралын төлөө Өөрийгөө тахил¹⁸ болгон өргөсөн Есүсийн бие ба цусыг төлөөлнө. Амьд явахын



¹⁸ Зураг: Аллисон Естабрүүкийн “Эзэний зоог” бүтээл, 2022.10.14. <https://www.flickr.com/photos/sgc-library/52476662295/>, licensed under CC BY 4.0.

тулд бид махбодоо хооллодог шиг, сүнслэг амийнхаа төлөө Есүсийн тахил золиост түшдэг (Иохан 6:53-58).

Ариун ёслолуудыг "нигүүлслийн арга зам" гэж нэрлэх боломжтой. Итгэлгүй, дуулгаваргүй атлаа ариун ёслолыг үйлдвэл нигүүлсэл ирэхгүй. Эдгээр ёслолууд нь Бурханаас бидэнд өгсөн дасгал бөгөөд хэрэв бид итгэлтэйгээр ёслолыг үйлдвэл, эдгээр нь бидний хувьд Бурханаас нигүүлслийг хүлээн авах арга зам болдог.

► Чуулганы бусад зорилго юу вэ?

Шинэ гэрээнд дурдсан нутгийн чуулганы зарим зорилго

Чуулган дараах үйл ажиллагааг хийх ёстой. Үүнд:

1. Сайнмэдээ тараах (Матай 28:18-20)
2. Чуулганаараа мөргөл хүндэтгэл өргөх (1 Коринт 14:26)
3. Сургаалаа сахих (1 Тимот 3:15; Иуда 1:3)
4. Пасторыг санхүүгээр дэмжих (1 Тимот 5:17-18)
5. Илгээлтийн эздийг дэмжих, илгээх (Үйлс 13:2-4; Ром 15:24)
6. Тусламж хэрэгтэй гишүүдэд туслах (Ром 12:13; 1 Тимот 5:3)
7. Нүгэлд унасан итгэгчдийг сахилгажуулах (1 Коринт 5:9-13)
8. Баптисм, Эзэний зоогийн ёслолыг үйлдэх (Матай 28:19; 1 Коринт 11:23-26)
9. Дагалдагчдыг төлөвшилд сургах (Ефес 4:12-13)
10. Орон нутгийнхаа хэрэгцээнд үйлчлэх (Галат 6:10; Ефес 4:28; Еврей 13:16)

“Бурхан бидний чуулганы амьдралыг барилга байгууламж, үйлчилгээн дээр төвлөрүүлэхийг хүсдэг гэж би итгэдэггүй. Харин үүний оронд, чуулганууд маань ямар ч онцлог хэлбэрээр цугладаг бай, гол анхаарлаа идэвхитэй дагалдуулалт, үүрэг зорилго, нэгдмэл байдалд төвлөрүүлээсэй хэмээн Бурхан хүсдэг.”

- Френсис Чан

Эдгээр ажлын ихэнхийг хүн ганцаараа бие даан хийж чадахгүй. Харин итгэгчдийн бүлэг, удирдлагын бүтэц, хамтын ажиллагааг түшиглэн эдгээр зорилго хэрэгжих боломжтой.

Бурхан итгэгч бүрийг нутгийн чуулганд зориулалт гаргаж, тухайн чуулганыг энэ дэлхий дээрх зорилгоо биелүүлэхэд нь туслахыг уриалдаг. Гишүүд чуулгандаа үйлчлэхээс нааш Христийн биеийн гишүүн болсон зорилгоо биелүүлж чадахгүй юм.

Алдаанаас зайлсхийх: Сүнслэг салангид байдал

Ангийн удирдагчийн тэмдэглэл: Ангийн нэг гишүүн энэхүү хэсгийг тайлбарлана уу.

Зарим хүн нутгийн чуулганы нэг хэсэг болох зориулалт гаргадаггүй. Тэд Ням гарагт хүссэн чуулгандаа очдог бөгөөд чуулган тэдэнд түшиглэх аргагүй байдаг учраас тэд чуулганы ямар ч үйлчлэлд тусалдаггүй. Тэдэнд сүнслэг нөхөрлөл үүсгэж, хариуцлага хүлээх боломжийг олгодог харилцаа холбоо байдаггүй. Хэрэв бүх итгэгчид ийм болбол чуулган гэж байхгүй болох биз.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Өөрийн бие болох нутгийн чуулгануудаар дамжин харагддаг даян дэлхийн, ариун, нэг чуулганыг Христ байгуулсан билээ. Энэ чуулган элч нарын онол сургаалыг баримталж, бүхий л үнэнийг хамгаалдаг. Чуулган бол Бурханы гэр бүл, бүхий л хэрэгцээнд үйлчилдэг нөхөрлөл юм. Чуулган Бурханыг мөргөн хүндэтгэж, дэлхийд сайнмэдээ тараан, итгэгчдийг дагалдуулдаг.

12-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- 1 Коринт 5:1-13
- 1 Коринт 6:1-8
- 1 Коринт 12:14-31
- Ефес 4:11-16
- Иаков 2:1-9

(2) Сорил: Дараагийн хичээлийг 12-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

12-р хичээлийн сорил

(1) Чуулганы эрин үе хэзээ эхэлсэн бэ?

(2) Чуулганыг яагаад элчийн гэж нэрлэдэг вэ?

(3) Чуулганы үүссэн 4 шалтгаан юу вэ?

(4) Даяар чуулган гэж юу вэ?

(5) Нутгийн чуулган гэж юу вэ?

(6) *Католик чуулган* гэдэг нь анх ямар утгатай байсан бэ?

(7) Даяар чуулган ямар хоёр зүйлээрээ нэгдмэл вэ?

(8) Чуулганууд онол сургаалынхаа талаар бичгээр тунхаглал гаргах нь яагаад зүйтэй вэ?

(9) Нутгийн чуулганы зорилгуудаас зургааг жагсааж бичнэ үү (Аль ч зургаа байж болно).

13-р хичээл

Мөнхийн хувь тавилан

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Тэнгэрийн улсын үндсэн үйл хэрэг.
- Тэнгэрийн улсын шинж байдлын талаарх Бичвэрийн илэрхийлэл.
- Мөнхийн шийтгэлийн талаарх Бичвэрийн илэрхийлэл.
- Мөнхийн шийтгэлийг үгүйсгэдэг зарим шашнуудын жишээ.
- Мөнхийн шийтгэл шударга болох нь.
- Мөнхийн шийтгэлийн талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь зарим үйлдэл хэзээ ч өөрчлөгдөшгүй мөнхийн үр дагавартай гэдгийг мэдэж авна.

1-р хэсэг: Итгэгчийн мөнхийн хувь тавилан

► Илчлэл 21-р бүлгийг хамтдаа унших. Итгэгчийн ирээдүйн тухай энэ бүлэгт юу өгүүлж байна вэ?

Бүх бүтээл Бурханы алдрын төлөө оршдог бөгөөд тэнгэрийн улс бол орчлон ертөнцийн гол үйл явдал өрнөдөг газар юм. Тэнд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бүтээлүүд хамтдаа Бурханд хамгийн дээд мөргөл хүндэтгэлийг өргөдөг (Илчлэл 5:11-14, унших). Бурханы алдар тэнгэрт бүрэн дүүрэн илчлэгдэж, тэрхүү дүүрэл нь тэнгэрийн хотын гэрэл байх болно (Илчлэл 21:23). Тэнд л бид Бурханы талаар бүрэн мэдэж, царайг нь харна (Илчлэл 22:4).

Тэнгэрт итгэгчид Бурханыг мөргөн хүндэтгэхдээ бүрэн дүүрэн сэтгэл ханамж, баяр хөөрийг олж авна. Дуулал 16:11-д “Өөрийн тань оршихуйд л баяр хөөр дүүрэн Таны баруун мутарт баяр жаргал үүрд байдаг” гэсэн байна. Баяр хөөр, мөргөл хүндэтгэл холбоотой байх нь зохистой. Бурхан биднийг дүр төрхөөрөө бүтээсэн учраас бид Бурханыг хангалттай таньж, мөргөн хүндэтгэж чадна. Бидний сэтгэл хөдлөл, хайрлах чадвар, оюун ухаан бүхэлдээ Бурханыг мөргөн хүндэтгэхийн төлөө өгөгджээ.

Дагалдагч нартаа хандан Есүс,

“Зүрхээ бүү шаналга, Бурханд итгэ, мөн Надад итгэ. Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Тийм биш байсан бол Би та нарт хэлэх байсан. Би та нарт орон байр бэлдэхээр явна. Би явж, та нарт орон байр бэлдчихвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно” (Иохан 14:1-3) хэмээн өгүүлсэн байдаг.

Есүсийн энэ үг тэнгэрийн улсын талаар зарим зүйлийг илэрхийлдэг. Хамгийн чухал нь тэнгэрийн улс бол Бурханы гэр юм гэсэн чухал үнэнийг хэлжээ. Есүс тэнгэрийн улсыг Эцэг Бурханы гэр хэмээн нэрлэсэн. Тиймээс хэзээ нэгэн цагт бид Бурхантай хамт тэнд амьдарна гэдэг нь өөр нэг чухал баримт билээ.

Тэнгэрийн улсын талаарх амлалт нь дэлхий дээрх бидний амьдралын удирдамж юм. Үүрд мөнхийг үнэт зүйлээ болгосон хүн газар дэлхий дээр хамгийн сайн сайхныг хийж амьдардаг. Тэнгэрлэг шагналыг хүлээж байгаа хүн зовлон зүдгүүрийг даван туулж, Бурханы хүслийг биелүүлж амьдрах урам зоригтой байдаг. Есүс ч хавчлагад өртсөн хүнд, "Тэнгэр дэх шагнал чинь агуу учир баярлацгаа мөн хөөрөн баясацгаа" (Матай 5:12) хэмээн хэлсэн юм.

Тэнгэрийн улсын шинж байдал

► Тэнгэрийн улсын талаар бидний мэдэж болох зарим нарийн ширийн зүйлс юу вэ?

Заримдаа хүмүүс бид энэ дэлхий дээр хүссэн байшингаа худалдаж авч чадахгүй байх, эсвэл байшингаа хүссэнээрээ өөрчлөх боломжгүй байдаг. Харин Бурханд хязгааргүй хүч чадал, нөөц баялаг бий тул Түүний орон гэр Бурханы хүсэлд яг нийцсэн байх нь гарцаагүй. Тэнгэрийн улс нь Бурханы мөн чанартай төгс зохицох газар юм.

Тэнгэрт ямар ч нүгэл байхгүй. Тэнгэрэлч, хүн, бусад амьтад гэхчлэн тэнгэрийн бүх бүтээл бүрэн ариун байх болно (Илчлэл 21:8, 27, унших).

Нүглийн үр дагавар болох өвчин, шаналал, тэмцэл, аюулаас тэнгэрийн улс ангид оршино (Илчлэл 21:4, унших). Тэр цагт бүтээл дахин өвчин, хөгшрөл, үхэл зэрэг хараалыг амсахгүй (Илчлэл 22:3, унших).

Тэнгэрийн гоо үзэсгэлэнг дүрслэхийн аргагүй юм. Бид одоогоор хаш чулуун хана, сувдан хаалга, эрдэнийн чулуун суурь, алтаар хийсэн гудамжных нь тухай л мэдэх боломжтой (Илчлэл 21:18-21, унших).

Хэн бас Хэзээ?

Тэнгэрийн улсыг нүглээ гэмшиж, Есүс Христийг Аврагч, Эзэн гэж итгэдэг хүмүүст зориулж бэлтгэжээ (Иохан 3:16). Хэрэв бид мөнхийн юмсыг амьдралынхаа үнэт зүйлс болгож амьдарвал тэнгэрт үүрдийн хөрөнгө оруулалт хийж, найдвартай хөрөнгөө хурааж байгаа хэрэг юм (Матай 6:20, унших). Тэнгэрт сая сая золин аврагдсан хүмүүс, бас тэнгэрэлч нар оршин суух болно (Илчлэл 5:8-11).

"Хэрэв надад энэ дэлхийн юу ч хангаж чадахгүй тийм хүсэл тэмүүлэл байдаг бол би өөр ертөнцийнх байхаар бүтээгдсэн гэдэг нь хамгийн магадлалтай тайлбар юм...

Магадгүй газар дэлхийн таашаал тэр хүслийг хэзээ ч хангаж чадахгүй байгаа нь зөвхөн үүнийг сэрээж, бодит зүйлийг санал болгох зорилготой мэт... Би тэрхүү өөр улс руу зүтгэхийг амьдралынхаа зорилго болгож, бусдыг ч тийм байхад нь туслах ёстой."

- Си.Эс. Льюис,

"Эгэл христитгэл"

Хүн хэзээ тэнгэрт очдог вэ? Есүс загалмай дээр дэргэдэх цовдлуулсан дээрэмчинд хандан түүнийг яг тэр өдөр диваажинд очно гэж хэлсэн байдаг (Лук 23:43). Паул ч Эзэнтэй хамт байхын тулд бие махбодоос хол байх болно гэж хэлжээ (2 Коринт 5:8). Тиймээс итгэгч хүн нас барах үедээ тэнгэрт очдог гэдгийг мэдэж болно. Харин Есүсийг эргэн ирэх үед амьд байх итгэгчид үхлийг үзэлгүйгээр тэнгэрт шууд очих болно (1 Коринт 15:51-52; 1 Тесалоник 4:13-18, унших).

2-р хэсэг: Үл итгэгчийн амсах мөнхийн хувь тавилан

Газар дэлхий дээрх аливаа шийтгэл хэзээ нэгэн цагт дуусгавар болдог. Хэрэв шийтгүүлж буй хүн нь үхвэл шууд л дуусна. Харин Есүс мөнхийн шийтгэлийн талаар ийнхүү хэлжээ.

Тэгээд Тэр зүүн талд байгсдад хандан “Хараагдагсад аа, Надаас зайл. Дявол болоод түүний тэнгэрэлч нарт бэлтгэсэн мөнх галд ор... тэд мөнх шийтгэлд, харин зөвт нь мөнх аминд орох юм гэж айлдлаа (Матай 25:41, 46).

Есүс ч, элч нар ч бидэнд там, галт нуур, мөнхийн шийтгэл байдаг гэдгийг баталсан. Тэрхүү аймшигтай газраас зайлсхийхийг Есүс бидэнд анхааруулдаг. Есүс ба элч нар ийнхүү хэлжээ.

Үеийн төгсгөл ч мөн ийм байх болно. Тэнгэрэлч нар ирж, зөвтийн дундаас ёрын мууг ялгаж, тэднийг галтай зууханд хаяна. Тэнд уйлаан, шүд хавирах нь буй (Матай 13:49-50).

Есүс фарисайчуудад хандаж, “Могойнууд аа, хорт могойн удам аа, тамын шийтгэлээс та нар яаж зугтаах вэ?” (Матай 23:33) гэсэн байдаг.

Нэгэн удаа Есүс нэг фарисай хүнтэй ярьж байгаад Үхэгсдийн оронд очсон хүний тарчлааны тухай ийнхүү дүрслэн ярьжээ.

Тийнхүү тэр Үхэгсдийн оронд тарчлан байхдаа хараагаа дээшлүүлж, тэртээд байгаа Абрахамыг болон Түүний өвөр дэх Лазарыг харав. Тэгээд тэр “Абрахам эцэг ээ, намайг өршөөгөөч. Лазарыг нааш нь явуулаач. Тэр хурууныхаа үзүүрийг усанд дүрээд хэлийг минь сэрүүцүүлэг. Учир нь би энэ галд амь тэмцэн зовж байна” гэж хашхирчээ (Лук 16:23-24).

Элч Паул Есүсийн тухай,

... тэнгэрээс илчлэгдэх... Бурханыг мэддэггүй ба бидний Эзэн Есүсийн сайнмэдээг дагадаггүй хүмүүсээс дүрэлзэх галд өшөө авах аж. Тэд мөнх сүйрлийн төлөөсийг төлж, Эзэний оршихуй ба Түүний хүчний алдраас сална (2 Тесалоник 1:7-9) хэмээн өгүүлсэн.

Петр ч бас,

...хэрэв нүгэл үйлдсэн тэнгэрэлч нарыг Бурхан хэлтрүүлэлгүй, харин тэднийг тамд хаяад, харанхуйн гинжинд тушааж, шийтгэл хүртэл хадгалсан (2 Петр 2:4) гэжээ.

Иохан мөн,

Тэднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байх агаад тэд үеийн үед өдөр шөнөгүй тарчилна... Мөн амийн номд нэр нь бичигдсэн нь олдоогүй бүхэн галт нуурт хаягдав (Илчлэл 20:10, 15) гэж бичсэн байна.

Энэхүү газрыг дүрслэхдээ "гал, тарчлал, өс хонзон, сүйрэл, харанхуй, гинж, шүүлт, уйлах, шүдээ хавирах" гэх мэт үгсийг хэрэглэсэн байгааг анзаараарай.

Есүс хэлэхдээ,

Баруун нүд чинь чамайг бүдрүүлбэл ухаж аваад хая. Учир нь бүтэн бие чинь тамд хаягдсанаас эрхтний чинь нэг байхгүй нь чамд дээр. Баруун гар чинь чамайг бүдрүүлбэл тастаад хая. Учир нь бүтэн бие чинь тамд хаягдсанаас эрхтний чинь нэг байхгүй нь чамд дээр (Матай 5:29-30).

Хоёр нүд, хоёр гартайгаа тамд хаягдсанаас баруун нүдээ ухаж, баруун гараа тасдсан нь дээр гэж Есүс хэлжээ. Энэ бол биеэ зэрэмдэглэхийг бидэнд уриалж байгаа хэрэг биш, харин дэлхий дээр хичнээн үнэ цэнтэй харагдаж байвч нүгэлд унагаж, тамд хүргэж чадах үйлдлийг зогсоохыг уриалж байгаа хэрэг юм.

► Тамын талаар буруу онол сургаалтай ямар шашнууд байдаг вэ?

Библи бидэнд үхэл хүний сорилтыг эцэслүүлдэг бөгөөд там бол (1) мөнхийн, (2) буцах замгүй, (3) зовлонтой газар хэмээн заадаг. Библийн энэхүү үнэнийг үхлийн дараа юу ч байхгүй гэж үздэг үл итгэгчид, там байгүй гэж үздэг Еховагийн гэрчүүд, Мормончууд болон Универсалистууд үгүйсгэдэг юм. Ромын Католик чуулган үхлийн дараа хүний нөхцөл байдлыг засах боломжтой гэж үздэг учраас үхлээр хүний хугацаа дуусгавар болно гэдгийг үгүйсгэдэг.

Там орших нь шударга бус зүйл гэж үзээд, үүнийг үгүйсгэдэг хүмүүс байдаг. Тэдний бодлоор хэрэв нүгэл цаг хугацааны хязгаарлагдмал орон зайд тохиолдсон юм бол үүнд мөнхийн шийтгэл оноох нь шударга бус хэрэг гэж үздэг. Гэгээн Августин энэхүү эсэргүүцэлд эрүүгийн хуулийн жишээг ашиглан хариулт өгсөн байдаг. Хэдхэн минутын дотор дээрмийн хэрэг гарвал хэдхэн минутын дотор л шийтгэх ёстой юу? Агшин зуурын аллага нь нөхөж баршгүй хохирол учруулдаг. Тиймээс Библид мөнхийн, хязгааргүй Бурханы эсрэг нүгэл үйлдэх нь түр зуурын цаг хугацааны дотор үйлдэгдсэн байлаа ч, мөнхийн шийтгэл дагуулдаг гэжээ.

► Там яагаад мөнх байдаг вэ?

Яагаад гэвэл,

1. Нүгэл бол хязгааргүй Бурханы эсрэг тэрслэл.
2. Гэмшээгүй нүгэлтнүүд Бурханд мөнхөд үйлчлэх өртэй гэдгээ үгүйсгэдэг.
3. Бид мөнхийн бүтээл учраас хэрэв Бурханаас салахыг сонговол бидэнд өөр очих газар байхгүй.

Газар дэлхий дээр бид шийдвэрээ өөрчлөх дуртай боломжтой байдаг. Гэвч сонголт мөнхийн үр дагаварт хүргэж болзошгүй байгаа нь хэтэрхий хатуу санагдах байх. Бид зориудын сонголт хийх үедээ ирээдүйд хоёр дахь боломж гарч ирнэ гэж бодох дуртай. Гэвч Бурхан бидний сорилтын хугацааг энэ амьдралаар хязгаарлаж байгаа нь үндэслэлгүй зүйл биш.

Зарим хүн Библид Бурханыг хайраар дүүрэн гэж дүрсэлсэн байтал Бурхан хүнийг яаж тийм аймшигтай газар илгээж чадах юм бэ? хэмээн гайхаж, тамд итгэхээс татгалздаг. Бурхан хэнийг ч төөрөлдүүлэхийг хүсдэггүй бөгөөд хүн бүрийг гэмшиж, аврагдаасай гэж хүсдэгийг бид санаж байх ёстой. Үүнийг Библид хэд хэдэн газар дурджээ (2 Петр 3:9; 1 Тимот 2:4; Үйлс 17:30, унших). Тамд очих хүмүүс тэр аймшигт газар очих сонголтоо өөрсдөө хийсэн. Хэн ч там руу санамсаргүйгээр бүдрэхгүй. Тийшээ явж буй хүмүүс Бурханыг болон зөвт байдал, авралыг үгүйсгэж, тэр газрыг сонгосон хэрэг.

Бүх сайн зүйл Бурханаас ирдэг тул Бурханыг үгүйсгэх нь сайн бүхнээс татгалзана гэсэн үг. Тайван байдал, айдас, өвдөлтөөс хамгаалагдсан, тав тухтай газрыг зөвхөн Бурхан өгч чадна. Бурханаас бүрмөсөн сална гэдэг нь сайн сайхан бүхнээс сална гэсэн үг. Энэ нь там юм.

Есүс Христийн гаргасан золиосын ачаар Бурханы хайрыг хүртэж, ирэх уур хилэнгээс (1 Тесалоник 1:10) зугтах боломжийг бидэнд өгсөн Бурханд талархъя. Бид тамын зовлонгийн оронд авралын баяр баясгалан, тэнгэрийн улсын гайхамшгийг амсах болно. Бид Бурханы өмнө гэмшиж, Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг сонгох үедээ тэнгэрийн улсыг өөрсдийнхөө хувь тавилан болгон сонгодог билээ (Филиппой 3:20, Үйлс 20:21).

Алдаанаас зайлсхийх: Мөнхийн үр дагаварыг мартаx

Газар дэлхий дээрх амьдрал дунд олон шийдвэр эцсийнх биш юм шиг санагдана. Хангалттай цаг хугацаа байвал олон алдааг засах боломжтой мэт. Гэхдээ олон шийдвэр мөнхийн үр дагавартай байдгийг бид санаж явах ёстой. Бид хэзээ үхэх, түр хугацаа

“Тамын тухай сургаалын эсэргүүцэж байгаа хүн эцсийн эцэст “Та Бурханаас өөр юу хүсэж байгаа юм бэ? гэх асуулттай тулах ёстой. Өнгөрсөн нүглийг арилгаж, шинэ эхлэлийг өгч, хүнд үед нь дэмнэж, гайхамшигтай тусламжийг өгөх үү? Бурхан үүнийг хийж өгье хэмээн аль хэдийн санал болгосон. Тэгвэл тэднийг уучлах үү? Тэд уучлагдахаас татгалзсан. Тэгэхээр тэднийг зүгээр орхи гэж үү? Ай халаг, би Түүний хийх зүйлээс айж байна.”

- Си.Эс. Льюис

“Өвдөлтийн асуудлууд” номоос.

маань хэзээ дуусахыг мэдэхгүй. Нэгэнт үхвэл мөнхийн хувь тавиландаа нөлөөлсөн үйлдлүүд болон бусдын шийдвэрт нөлөөлсөн үйлдлүүдээ өөрчлөх ямар ч боломж бидэнд гарахгүй.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Хүн бүр тэнгэрийн улс эсвэл тамын аль нэгэнд мөнхөд оршино. Итгэгчид Бурхантай хамт амьдарч, Бурханыг баяр хөөртэйгээр мөргөн хүндэтгэх газар бол Бурханы гэр, тэнгэрийн улс билээ. Тэнгэрт ямар ч нүгэл, үүнээс үүдэлтэй зовлон зүдгүүр байхгүй. Харин там нь нүглээ Христээр уучлуулаагүй, аврагдаагүй хүмүүст зориулагдсан мөнхийн, эргэлт буцалтгүй, зовлонг шийтгэлийн газар юм. Хязгааргүй Бурханы эсрэг санаатайгаар нүгэл үйлдсэний шударга шийтгэл нь там байх болно.

13-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Исаиа 5:11-16
- Матай 5:27-30
- Лук 16:19-31
- Илчлэл 22:1-5
- Илчлэл 22:10-17

(2) Сорил: Дараагийн хичээлийг 13-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

13-р хичээлийн сорил

(1) Тэнгэрийн улсын үндсэн үйл хэрэг юу вэ?

(2) Тэнгэрийн улсад байхгүй дөрвөн зүйлийг нэрлэнэ үү (аль ч дөрөв байж болно).

(3) Тэнгэрийн улсыг хэнд зориулж бэлтгэсэн бэ?

(4) Хүн хэзээ тэнгэрт очдог вэ?

(5) Гараа тасд гэж хэлсэн Есүсийн үг ямар утгатай вэ? (Матай 5:30).

(6) Тамын талаар Библид дурдсан гурван зүйл?

(7) Там мөнх байдаг гурван шалтгааныг нэрлэнэ үү.

14-р хичээл

Эцсийн үйл явдал

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Эцсийн үйл явдлын талаарх сэдвийн ач холбогдлыг эрэмбэлэх нь.
- Христийн эргэн ирэлт ба христитгэлийн амьдрал дахь үүний утга учир.
- Бүх хүний амилал ба биеийн үнэ цэн.
- Ёс суртахуунт бүх бүтээлийг шүүх эцсийн шүүлт.
- Бурханы мөнхийн хаанчлал.
- Эцсийн үйл явдлын талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь газар дэлхийн амьдралыг өнө мөнхийн үүднээс харахын ач холбогдлыг мэдэж авна.

Танилцуулга

► Даниел 7:9-14-ийг хамтдаа унших. Энэ хэсэгт ирээдүйн талаар юу өгүүлж байна вэ?

Библийн эш үзүүллэгийн сэдэвт араатны тэмдэг, бүрээ, агуу гамшиг, антихрист, долоон жил, 1000 жил, цагаан өнгөтэй агуу сэнтий, дээрээс бууж ирэх хот, галт нуур зэрэг сэдвүүд дурдагддаг.

► Библийн эш үзүүллэгүүдийн талаар та юу гэж бодож байна вэ?

Ач холбогдлыг эрэмбэлэх нь

Эш үзүүллэгийн талаарх хэлэлцүүлгүүд ихэвчлэн гол сургаал дээр бус туслах чанарын асуултуудад төвлөрдөг. Эш үзүүллэгийн сэдвүүд ач холбогдлоороо бүгд адилхан биш. Тиймээс бид энэ хичээлээр эш үзүүллэгийн талаар нэг бүрчлэн ярихгүй.

Заримдаа хүмүүс араатны тэмдэг ямар харагдах, антихрист ямар улсаас гарч ирэх, хоёр гэрч нь хэн байх гэхчлэн гайхан боддог. Эдгээрийн хариулт Библид тодорхой байдаггүй бөгөөд ийм сэдвээр маргах нь тийм ч ач холбогдолтой зүйл биш.

Гэхдээ Библид зарим сэдвүүдийг илүү тайлбарласан байдаг. Жишээлбэл, Есүс агуу гамшгийн цаг үеийн эхэн, дунд, төгсгөлийн аль үеэр нь буцаж ирэх, мөн мянган жил нь шууд утгаараа мянган жил мөн үү, үгүй юу гэх мэт сэдвүүдийг дурдаж болно. Гэхдээ эдгээр сургаал нь сайнмэдээний үндсэн чухал сургаал биш. Тиймд энэ мэт асуудал дээр санал зөрсний улмаас хэн нэгэнтэй нөхөрлөлийн холбоогоо таслах ёсгүй юм.

Зайлшгүй шаардлагатай зарим үнэнийг Библийн эш үзүүллэгт дурдсан байдаг. Эдгээр үнэн нь Библид итгэдэг хүн бүрийн хүлээн зөвшөөрдөг маш тодорхой сургаал юм.

Христитгэлийн амьдрал, христитгэлийн онол сургаалын бүхэл системд эдгээр сургаал нөлөөлдөг. Одоо эцсийн үйл явдлын талаарх Библийн эш үзүүлэлгээр илчлэгдсэн дөрвөн чухал үнэнийг авч үзье.

Есүс биеэрээ эргэж ирнэ

Есүс энэ дэлхийд үзэгдэх байдлаар ирнэ. Хэдийгээр одоо Тэр газар дэлхий дээрх итгэгчдийн дунд сүнслэг байдлаар байгаа ч, бүх дэлхийн өмнө сүр жавхлантай, амилсан биеэрээ эргэн ирнэ (Илчлэл 1:7, унших).

► Есүсийг эргэн ирэхэд юу юу тохиолдох вэ?

Христийн эргэн ирэх нь дэлхийн түүхийн оргил үе байх болно. Тэр цагт дэлхийн хаанчлалууд Христийн хаанчлал болсон байна. Түүнд үнэнч байсан хүмүүс шагнал, хүндэтгэлийг хүртэнэ. Харин Түүнийг эсэргүүцэж байсан хүмүүс дарагдана. Бүх эсэргүүцлийг ялан дийлэх хүч, эрх мэдэл Түүнд байх болно (Матай 26:64, унших). Өвдөг бүр сөгдөж, хэл бүр Есүсийг Эзэн хэмээн өчих болно (Филиппой 2:10-11).

Нас барсан итгэгчид Христтэй хамт хаанчлахаар амилах болно (2 Тимот 2:12). Тэд амьд байгаа итгэгчдийн хамт Эзэнийг гарч ирэх үед Түүнтэй уулзахаар дээш өргөгдөнө (1 Тесалоник 4:16-17).

Есүсийн эргэн ирэлт бол бүх Христэд итгэгчдийн ерөөлт найдвар юм (Тит 2:13, унших). Есүсийн эргэн ирэх нь бидний хувьд ямар утгатай вэ? Энэ бол хавчлага, зовлон зүдгүүр, үй гашуугийн төгсгөл, ариун хүмүүс ба итгэгчид хайртай хүмүүстэйгээ уулзах цаг, бидний итгэл дэмий хоосон байгаагүйн нотолгоо, Есүсийг нүдээр үзэх цаг, тэнгэрийн улсад орж, Бурхантай хамт мөнхөд бүрэн дүүрэн амьдрах амьдрал юм. Эдгээрийн аль нь ч Есүсийн буцаж ирэх цаг хугацаанаас хамаарахгүй боловч, Тэр амласныхаа дагуу эргэн ирнэ гэдэг нь гарцаагүй үнэн билээ.

“Үхэл ба эцсийн амиллын өдрийг баяртайгаар хүлээдэггүй хэн ч Христийн сургуульд олигтой сураагүй гэсэн үг. Бүгдээрээ Эзэний ирэхийг тэсэн ядан хүлээцгээе. Яагаад гэвэл энэ нь хамгийн аз жаргалтай зүйл билээ. Тэр бидэн дээр Золин Аврагч болон ирж, Өөрийнхөө амь ба алдрын ерөөлт өв рүү хөтлөх болно.”

- Жон Калвин “Христийн шашны тогтолцоо”

Есүс хүч ба сүр жавхлан дунд буцаж ирнэ гэж хэлсэн (Матай 24:30). Тэрээр эргэж ирээд ард түмэнтэйгээ амьдарна гэж амласан (Иохан 14:3) юм. Тэнгэрэлч нар ч Есүсийг тэнгэрт дээш одсон шигээ тийнхүү буцаж ирнэ гэж хэлсэн байдаг (Үйлс 1:11). Элч нар энэ ертөнцөд зориулсан Бурханы эцсийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд Христийн эргэн ирэхийг хүлээх зуураа хүмүүст гэмшлийн тухай сургаж байв (Үйлс 3:19-21,

унших). Есүс энэ дэлхий дээр хүч чадал, суу алдраар эргэн ирнэ гэдгийг Шинэ гэрээнд дахин дахин дурдсан байдаг.¹⁹

Есүсийн хоёр дахь ирэлтийн өмнө зарим шинж тэмдгүүд тохиох боловч бид Түүнийг яг хэзээ эргэж ирэхийг нарийн хэлж чадахгүй. Итгэгчдийн хувьд Түүний эргэн ирэхийг хүсэн хүлээж, үүнийхээ дагуу амьдрах нь сайн хэрэг юм (Марк 13:33-37, унших).

► Есүс яагаад эргэж ирэх вэ?

Ихэнх хүмүүс Бурханыг эсэргүүцэн буй дэлхийд бид амьдарч байна. Бүтээл бүхэлдээ нүглийн хараал доор зовж байна. Дэлхий хэзээ ч улс төрийн үйл хэрэг, нийгмийн шинэчлэл, өндөр чанартай боловсрол, эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн хүчээр төгс болохгүй. Харин Есүс энэ бүхнийг засахаар эргэн ирж буй хаан мэтээр бүтээлийн ертөнцдөө эргэн ирэх болно.

Бүх хүн нүгэлтэй боловч хэн Бурханы хаанчлалд сайн дураараа нэгдэнэ, тэр хүн айсуу шүүлтээс мултарч чадна. Гэмшиж, итгэсэн хүмүүсийн дунд Бурханы хаанчлал хэдийн үйл ажиллагаагаа явуулж байгаа (Марк 1:14-15, Марк 9:1). Есүсийг буцаж ирэхэд тэр хаанчлал бүрэн бөгөөд ил тод болон гарч ирнэ.

► Есүсийн эргэн ирэхийг мэдэж байгаа бид хэрхэн амьдрах ёстой вэ?

Бид эртний итгэгчид юуг чухалд тооцож байсныг санах ёстой. Бид итгэлээ сахиж (1 Коринт 16:13), эцэс хүртэл тэвчих (Матай 24:13) учиртай. Таашаал болон энэ ертөнцийн юмсад автаж, Христийн эргэн ирэхийг мартаж вий хэмээн бидэнд сэрэмжлүүлсэн байдаг (Лук 21:34-36). Энэ ертөнцийн юмс өнгөрөн одох тул бид мөнхийн үнэт зүйлсэд тэмүүлж амьдарна (2 Петр 3:11-13). Биднийг тэнгэр рүү Түүний төрхийг дэмий ширтэн хүлээх биш, харин сүнслэг байдлаа хамгаалан, Түүнийг ирэхэд бэлтгэлтэй байхыг сануулсан билээ (Марк 13:33-37). Бид Есүс шиг байхыг хүсдэг тул ариун байдлын төлөө залбирч, ариун амьдралаар амьдардаг (1 Иохан 3:3).

Есүсийг ирэхгүй юм шиг амьдарч байгаа хүмүүс Түүнийг эргэн ирэх цагт бэлтгэлгүй сууж байх болно. Яагаад гэвэл Есүсийн ирэлт аянга мэт (Матай 24:27; 1 Коринт 15:52), гэнэтийн байх тул хэн ч Түүнийг үзэгдэх үед ямар нэг зүйлийг өөрчилж амжихгүй. 1 Тесалоник 5:1-6-д харанхуйд байгсад, энэ дэлхийн юмсыг хөөж амьдрагсад Эзэнийг ирэх цагт гүн цочролд орно гэж хэлж байна. Тэдний хувьд Христийн эргэн ирэлт нь хулгайчийн гэнэтийн ирэлттэй адил байх болно. Итгэгчдийн хувьд Христийн эргэн ирэлт нь айдас бус харин сүйт бүсгүй рүүгээ сүйт залуу ирж буй мэт тийм их баяр хөөрийг авчирна (Иохан 14:2-3).

Бид Есүсийн ирэхийг,

¹⁹ 1 Тесалоник 4:15-16; 2 Тесалоник 1:7, 10; Тит 2:13; Еврей 9:28; Иаков 5:7-8; 1 Петр 1:7, 13; 2 Петр 1:16, 2 Петр 3:4, 12; 1 Иохан 2:28

1. Мөнхийн үнэ цэнтэй зүйлсээ хадгалж,
2. Цэвэр ариун амьдарч,
3. Залбирч, өөрсдийгөө сүнслэгээр хамгаалж хүлээдэг.

Бүх хүний биеийн амилал

Библид бүх хүн амилна гэж заадаг учраас бидний бие үнэ цэнтэйг бид ойлгодог. Амиллын сургаал үнэхээр хэрэгтэй сургаал юм. Яагаад гэвэл Элч Паул 1 Коринт 15-р бүлгийг бүхэлд нь энэ сургаалыг өмгөөлөхөд зориулжээ. Тэрээр амиллыг үгүйсгэх нь сайнмэдээг үгүйсгэнэ гэсэн үг хэмээн тайлбарласан юм. Хэрэв амилал гэж байхгүй бол Есүс Христ амилаагүй гэсэн үг болно (1 Коринт 15:13). Хэрэв Есүс үхлээс амилаагүй юм бол сайнмэдээ үнэн биш, бас хэн ч аврагдахгүй болж таарна (1 Коринт 15:17).

Бүх хүн амилах боловч бүгдээрээ нэгэн зэрэг амилахгүй. Есүс эргэж ирээд нас барсан итгэгчдийг босгож, бүх итгэгчдийг Өөртөө авна (1 Тесалоник 4:16-17; Илчлэл 20:6). Нүгэлтэйгээ үхсэн хүмүүс анхны амиллаар босгогдохгүй. Харин хожим шүүлт болох цагт тэднийг амилуулна (Илчлэл 20:13).

Христэд итгэгчид Есүсийнх шиг сүр жавхлантай биеэр амилна (1 Иохан 3:2). Үл итгэгч нүгэлтнүүдийг мөнхийн шийтгэл хүртэх өөр биеэр амилуулна (Иохан 5:28-29).

► Хэрэв та биеэр амилна гэдэгт итгэдэггүй бол амилал танд ямар хамаатай вэ?

Хэзээ нэгэн цагт дахин амилах болно гэсэн итгэл бидний амьдралын хэв маягт нөлөөлдөг. Энэхүү сургаалыг үгүйсгэдэг хүмүүсийн жишээнээс бид энэ сургаалын бодит үр нөлөөг харж болно. Коринт чуулганы зарим итгэгчид биеийн амиллыг үгүйсгэсэн. Энэхүү алдаатай үзэлд итгэсэн хүмүүс хоёрдмол байр суурьтай болсон байна.

Зарим нь бүр, **“Нэгэнт бие хэзээ ч амилахгүйгээс хойш, сүнс л хамгийн чухал.** Тиймээс биеэрээ хийсэн нүгэл ноцтой зүйл биш гэсэн үг. Энэ бие нэгэнт муудаж ялзраад дуусахаас хойш энэ биеэрээ садар самууныг ч үйлдсэн болно” гэж хэлдэг байжээ.

“Үхэл ээ, чиний хатгуур хаа байна?
 Үхэгсдийн орон, чиний ялалт хаана байна?
 Христ амилсан, чи хүчгүй болсон.
 Христ амилсан, чөтгөрүүд хаягдсан.
 Христ амилсан, тэнгэрэлч нар баярласан.
 Христ амилсан, амьдрал чөлөөлөгдсөн.
 Христ амилсан, булш нь үхэгсэд үгүй
 хоосорчээ.
 Үхлээс амилсан Христ
 унтсан хүмүүсийн Удирдагч, Сэргээгч болжээ
 Үүрд мөнхөд алдар, хүч нь Түүнд байх
 болтугай. Амен.”
 - Хрисостом, "Амилал баярын сургаал"

Зарим коринтчууд “Хоол нь ходоодонд, ходоод нь хоолонд зориулагджээ” гэсэн уриатай байсан бололтой. Энэ үгэнд хүслээ дур зоргоор нь тавина гэхээс өөр утга алга. Паул тэдний тухайд, биеэ буруугаар ашигласан хүмүүс шүүгдэнэ гэж хэлсэн (1 Коринт 6:13).

Бие нь Эзэнийх бөгөөд Бурхан Есүсийн биеийг амилуулсан шигээ бидний биеийг амилуулна гэж Паул хэлсэн байдаг (1 Коринт 6:14).

Өөр зарим нь “Амилахгүй учраас энэ бие үнэ цэнгүй, бузар муу зүйл байж таарна. Бид бие махбодын бүх хүслийг дарж, тааламжтай амтыг амсуулахгүй, гэрлэлтийн таашаалыг эдлүүлэхгүй байх ёстой” гэж үздэг байв.

Амиллыг үгүйсгэсэн учраас дээрх хоёр алдаа гарчээ. Ер нь амиллыг үгүйсгэх нь бие махбодыг үнэгүйдүүлдэг. Харин амиллын талаарх христитгэлийн онол сургаал нь бие махбодыг үнэ цэнтэй болгодог.

► 1 Коринт 6:14, 15, 19-20-ийг унших.

Эдгээр эшлэлд итгэгчийн бие үнэ цэнтэй болохыг өгүүлсэн. Учир нь,

- Золин аварсан
- Ариун Сүнсний сүм болсон
- Христийн биеийн эрхтэн болсон
- Амилуулагдаж, алдарших учраас үнэ цэнтэй

Амиллын талаарх онол сургаал үнэ цэнтэй. Учир нь:

- Есүс үхлээс амилсан.
- Бүх хүнийг амилуулна.
- Бие махбод мөнхийн үнэ цэнтэй.
- Сайнмэдээ үнэн юм.

Шүүлт

Амийн номд нэр нь байхгүй хүмүүсийн хувьд шүүлтийн өдөр үнэхээр төгсгөл байх болно. Энэ нь зөвхөн оршин байхын төгсгөл биш, харин сонголт хийх боломжийнх нь хувьд төгсгөл юм. Үүний араас залгах өнө мөнхөд хүмүүс хэзээ ч буцааж болохгүй шийдвэрийнхээ үр дагаврыг амсах болно.

Зөвхөн шууд харагдах үр дүнгээсээ гадна бидний сонголт шүүлтэд чухал ач холбогдолтой байх болно. Зарим хүн үйлдлийнхээ үр дүнг хянаж л чадвал өөр санаа зовох зүйл юу ч байхгүй гэж боддог. Тэд сүртэй хор хөнөөл учруулахгүй л бол нүгэл нь нүгэл биш гэж бодохыг хүсдэг. Энэ амьдралд хор хөнөөл учруулахгүй байлаа ч, шүүлт байгаа учраас нүгэл нь ноцтой зүйл юм. Хүмүүс үйлсээрээ шүүгдэнэ гэж Бурханы Үгэнд хэлж байна (2 Коринт 5:10; Ром 2:6-11, унших).

Шүүлтийн үеэр зарим нь мөнхийн шийтгэл рүү, зарим нь мөнхийн шагнал руу илгээгдэх болно. Бичвэрт нүгэлт үйлсийнхээ төлөө яллагдахаар амилсан, гэмшээгүй нүгэлтнүүдийн шүүлтийг дүрсэлсэн хэсэг бий (Илчлэл 20:11-15, үз). Христэд итгэгчдийн хувьд өөр нэг шүүлт байгаа. Тэр үед итгэгчид үнэ цэнтэй, удаан хугацааны үр дүнгийн төлөөх хийсэн ажилдаа шагнал хүртэнэ (1 Коринт 3:14-15, унших).

Шүүлт байгаа нь хэзээ нэгэн цагт нүгэл байхгүй болно гэсэн утгатай. Нүгэлгүй ертөнцийг төсөөлөхөд бэрх боловч хэзээ нэгэн цагт Бурханы эсрэг бүх тэрслэлд төгсгөл ирнэ.

Бурхан биднийг байнгын айдастай, эсвэл айдас нь зөв амьдрах сэдэл төрүүлдэг тийм амьдралаар амьдруулахыг хүсдэггүй. Гэсэн хэдий ч, бидний өмнө байгаа шүүлтийг ухамсарлах нь бидэнд хариуцлагатай амьдрахыг ойлгуулдаг.

Бид шүүлтийн талаар мэдсэнээр,

1. Нүглийн үр дагавар
2. Бурханы өмнө хүлээх бидний хариуцлага
3. Бидний сонголтын ач холбогдол
4. Бүх нүгэл төгсгөлтэй гэдгийг ойлгодог.

Бурханы мөнхийн хаанчлал

Зарим гүн ухаан, шашин шүтлэгийн дагуу цаг хугацааг эхлэл төгсгөл, үүрдийн өөрчлөлт авчрах ямар ч үйл явдалгүй, мөнхөд эргэлдэх тойрог хэмээн үздэг. Харин Библийн дагуу цаг хугацаа нь эхлэлтэй, төгсгөл хүртэл үргэлжилдэг цуврал үйл явдлуудтай. Библид бүтээлийн үе, дараа нь хүмүүний эмгэнэлт уналт, тэгээд хүн төрөлхтний түүхэнд олон зуун жилийн туршид хэрэгжүүлж буй Бурханы авралын төлөвлөгөөний талаар өгүүлдэг.

Эхлэл 3-р бүлгээс бид нүгэл эхэлсэн тухай уншдаг. Илчлэл номд Бурханы мөнхийн хотод нүгэл үгүй болсныг харж болно (Илчлэл 21:27). Түүнчлэн Эхлэл номоос бид амийн модноос холдсон хийгээд үхлийн ялыг авсан тухай уншдаг бол (Эхлэл 3:22-24), харин Илчлэл номоос амийн мод, амийн номд бичигдсэн нэрс, амийн ус руу очих урилгын талаар уншдаг (Илчлэл 22:1-2, 19).

Бурханы бүрэн дүүрэн байдал, мөнхийн хаанчлал ирж, Бурханы төлөвлөгөө гүйцэлдэнэ. Хэдийгээр Бурхан үргэлж орчлон ертөнцийн хаан байсаар ирсэн ч хүн төрөлхтний уналтаас хойш хүмүүсийн олонх нь Бурханы хаанчлалын эсрэг тэрсэлсээр байгаа юм. Тэрхүү тэрслэл агшин зуурт дуусгавар болж, Бурхан сэргэлдөгчгүйгээр мөнхөд захирна. Дэлхий ертөнц Бурханы хүссэнчлэн, тэнгэр мэт төгс байх болно.

Алдаанаас зайлсхийх: Газар дэлхийн амьдралд төвлөрөх

Хүн ер нь амьдрал мөнхөд үргэлжлэх юм шиг хандлагатай амьдардаг. Нөхцлөө сайжруулж, асуудлаа шийдэж, сэтгэл хангалуун байх орчинг бүрдүүлэхийг хичээнэ. Майханд сууж, байнга нүүж амьдрах зуураа мөнхийн улсыг хүлээж байсан Абрахам шиг тийм хандлагатай хүн болохыг бид хичээх учиртай юм (Еврей 11:8-10, 14-16). Барьж буй байшин, эдэлж буй эд юмс, амьдарч буй нөхцөл бүгд түр зуурынх гэдгийг санаж явах хэрэгтэй. Тиймд хүн мөнхийн үнэ цэнийг авчрах зүйлийн төлөө хөдөлмөрлөх ёстой.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Есүс амласан ёсоороо эргэн ирж, өнгөрсөн үеийн итгэгчдийг амилуулан, Өөрийн хаанчлалдаа бүх итгэгчдийг оруулан Тэрээр захирна. Хүн бүрийг хийсэн үйлийнх нь дагуу шүүхийн тулд үхэгсдээс амилууна. Тэгээд нэг бол мөнхийн шагнал, эсвэл мөнхийн шийтгэлийг хүртээнэ. Бурханы хаанчлал бүрэн дүүрнээр ирж, Бурхан мөнхөд хаанчлах болно.

14-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- Даниел 2:31-45
- Матай 25:31-46
- 1 Коринт 15:51-58
- 2 Петр 3:1-14
- Илчлэл 20:11-15

(2) Сорил: Дараагийн хичээлийг 14-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

14-р хичээлийн сорил

(1) Библийн эш үзүүлэгийн дагуу, эцсийн үйл явдлын тухай дөрвөн үнэн юу вэ?

(2) Есүсийг эргэн ирэхэд юу юу тохиолдох вэ?

(3) Есүсийн эргэн ирэхийг бид хэрхэн хүлээх вэ?

(4) Амиллын талаарх онол сургаал яагаад үнэ цэнтэй вэ?

(5) Шүүлтийн талаар бидний мэдэх ёстой дөрвөн зүйл юу вэ?

15-р хичээл

Эртний тунхгууд

Хичээлийн зорилго

(1) Суралцагч нь дараах санаануудыг тайлбарлаж чаддаг болсон байна. Үүнд:

- Итгэл үнэмшлээ тодорхойлох итгэлийн тунхгийн зорилго, хэрэглээ.
- Библи дэх зарим тунхгуудын жишээ.
- Түүхэн гурван тунхгийн үүсэл, агуулга.
- Орчин цагийн итгэгчид яагаад түүхэн христитгэлийг баримтлах ёстой вэ?
- Тунхгийн талаарх христэч итгэл үнэмшил.

(2) Суралцагч нь эртний чуулганы итгэл үнэмшлийн суурь нь христитгэлийн анхдагч онол сургаал гэдгийг үнэлж ойлгоно.

Танилцуулга

► 2 Иохан захидлыг хамтдаа унших. Энэ хэсэгт чуулганы анхдагч онол сургаалын ач холбогдлыг юу гэж өгүүлж байна вэ?


Тунхгуудын үүсэл

Тунхаг нь христэч итгэл үнэмшлийн хураангуй юм. Эртний чуулганыхан Библийн онол сургаалыг хураангуйлах шаардлагатай хэмээн үзжээ.²⁰

► Чуулганд яагаад тунхаг хэрэгтэй вэ? Библи байхад хангалттай биш үү?

Библид итгэдэг гэж хэлдэг ч Библитэй зөрчилдсөн сургаал заадаг хүмүүс үргэлж байдаг. Тиймээс чуулганыхан христитгэлийн үнэнийг хуурамч сургаалаас ялган харуулж чадах Библийн онол сургаалын тунхгийг боловсруулжээ.

Онол сургаалын анхны тунхаглал нь **“Есүс бол Эзэн”** гэсэн тунхаг бөгөөд энэ нь Есүс бол Бурхан мөн гэсэн утгатай. Түүнчлэн **Эзэн Есүс Христ** гэсэн илэрхийлэл ч тунхаг бөгөөд Есүс бол Мессиа (Христ) гэж хэлэх нь Тэр бол Бурхан мөн гэсэн санааг



*Атанасиус (ойр. НТ. 296-373)
“Хүмүүн болж ирсэн нь” хэмээх
алдартай зохиолыг бичсэн
бөгөөд Есүс бүрэн дүүрэн
Бурхан, бүрэн дүүрэн хүн байсан
нь христэч итгэл үнэмшилд
яагаад чухал болохыг уг бүтээлд
тайлбарлажээ. Тэрээр Никайн
тунхаг гарсан Никайн зөвлөлд
нөлөөтэй хүн байв.*

²⁰ Зургийн нэр: "Гэгээн Атанасиус", Гэгээн Женевийн номын сангаас авав. <https://archive.org/details/EST84RESP8A>

илэрхийлдэг. Үл итгэгчид Есүс бол Эзэн гэж хэлэхээс татгалзах, эсвэл *Эзэн Есүс Христ* гэдэг үгийг ашиглахаас татгалздаг байжээ. Хожим нь өөрсдийгөө Христэд итгэгч гэж зүтгэдэг боловч **Есүсийг жинхэнэ хүн байсан** гэдэгт итгэдэггүй итгэгчид гарч ирсэн байна. Тийм учраас 1 Иохан захидалд "Есүс Христ махбодоор ирснийг хүлээн зөвшөөрөгч сүнс бүр Бурханаас бөгөөд Есүсийг хүлээн зөвшөөрдөггүй сүнс бүр Бурханаас бус" (1 Иохан 4:2-3) хэмээсэн мэдэгдэл бүхий тунхаг бичигдсэн юм. Хэрэв хүн Христийн талаарх үндсэн онол сургаалыг няцааж байгаа бол тэр хүн нүгэл үйлдэж байгаа төдийгүй, Бурханаас биш гэдгийг элч Иохан ийнхүү илэрхийлжээ (2 Иохан 1:9).

Хэд хэдэн тунхаглал агуулсан, хамгийн эртний тунхгийг 1 Тимот 3:16-аас үзье.

[Бурхан] махбодоор илчлэгдсэн Тэр Сүнс дотор зөвтгөгдсөн. Тэнгэрэлч нарт үзэгдсэн Тэр Харийнханд ч тунхаглагдсан. Ертөнцөд итгэгдсэн Тэр Сүр алдраар дээш авагдсан.

Ямар ямар асуудлыг шийдэхээр 1 Тимот номд энэхүү тунхаг бичигдсэнийг бид нарийн мэдэхгүй. Гэхдээ энэ тунхагт "Бурхан махбодоор илчлэгдсэн" гэж хэлэхдээ Есүсийг хүмүүн бас Бурхан байсныг онцолсон байна.

Итгэл үнэмшилтэй холбоотой эдгээр богино тунхаглалууд нь тодорхой зорилготой байжээ. Эртний итгэгчид Есүст итгэдэг өөр хүнтэй тааралдвал "Та Есүсийг Эзэн гэдэгт итгэдэг үү?", эсвэл "Есүс бол махбодоор ирсэн Бурхан гэдэгт итгэдэг үү?" гэж асуудаг байв. Хэрэв "үгүй" гэж хариулбал энэ хариултаас нь тэд уг хүнийг Есүс болон элч нарын заасан сургаалыг ер мэддэггүй, эсвэл хүлээн зөвшөөрдөггүй хүн байна гэж таньдаг байжээ.

"Хүн мөнхийн авралд хүрэхийн тулд Эзэн Есүс Христийг махбодоор төрсөн гэдэгт зөв итгэн хүлээн зөвшөөрдөг байх ёстой. Бидний Эзэн Есүс Христ бол Бурханы Хүү, Бурхан ба Хүн мөн гэдэгт итгэж, хүлээн зөвшөөрөх нь зөв итгэл юм."
- Атанасиусын тунхаг

Пентекостын дараах эхний хэдэн зууны туршид чуулганыхан Гурвал, Христийн биежилтийн тухай, мөн Ариун Сүнсний мөн чанарын талаар тодорхой тунхаглал гаргах шаардлагатай болохыг ойлгосон байна. Тиймээс тэд гаж сургаалаас хамгаалах үүднээс онол сургаалын жишгийг тогтоожээ. Тунхгууд нь Христэд итгэдэг хүн бүрийн түшиглэх суурь үнэнүүдийг хураангуйлах зорилгоор бичигдсэн юм.

Эдгээр тунхгууд нь бүх асуудлыг хамруулдаггүй хэдий ч эдгээр тунхаглалыг үгүйсгэсэн хүн Христэд итгэгч гэж тооцогддоггүй байжээ. Энэ нь христэд итгэл үнэмшлийг тодорхойлох гэсэн оролдлого байсан юм.

Одоо эртний чуулганы гурван тунхгийг авч үзье.

Элч нарын итгэлийн тунхаг

Элч нарын итгэлийн тунхгийг элч нар өөрсдөө бичээгүй, харин элч нарын онол сургаалыг тодорхой илэрхийлэх зорилгоор НТ II зуунд бичжээ.

Би газар тэнгэрийг бүтээгч аугаа хүчирхэг

Бурхан Эцэгт итгэдэг.

Ариун Сүнсээр бүтээгдэж, онгон Мариас мэндэлсэн,

Понти Пилат захирагчийн үед зовж явсан, цовдлогдон нас барж оршуулагдаад,
гурав хоногийн дотор үхлээс дахин амь орсон, тэгээд тэнгэрт одож, аугаа
хүчирхэг Бурхан Эцэгийнхээ баруун гарын хүндэт суудалд заларсан,

дахин ирж үхсэн амьд бүх хүнийг шүүх Түүний цорын ганц хүү бидний Их Эзэн
Есүс Христэд би итгэдэг.

Би Ариун Сүнсэнд итгэдэг.

Би Ариун нэгдмэл цуглаан, ариун хүмүүсийн нөхөрлөл, гэмд үзүүлэх уучлал,
дахин амилалт болон мөнхийн амьдралд итгэдэг. Амен.

Энэхүү тунхаг нь Есүсийг үнэхээр хүн байсан, онгон эмэгтэйгээс төрсөн гэдгийг
үгүйсгэдэг хүмүүсийн алдааг илчлэх зорилготой байжээ. Тэр үед Есүсийн үхсэнийг
эсвэл үхэгсдээс биеэр амилсныг үгүйсгэдэг хүмүүс олон байсан.

Элч нарын итгэлийн тунхагт Ариун Сүнсний тухай маш бага дурддаг. Энэ нь чуулган
Ариун Сүнснийг таниагүйгээс болсон хэрэг бус, харин хуурамч сургаалтнууд Ариун
Сүнсний мөн чанарын талаарх чуулганы үзэл баримтлалыг хараахан эсэргүүцээгүй
байсантай холбоотой.

Католик гэдэг нь "даяар" гэсэн утгатай үг бөгөөд нэг жинхэнэ чуулган байдаг гэсэн
санаа юм.

"Нүглийн уучлал" гэдэг нь ажил үйлс, зан үйлээр бус, харин нигүүлслээр өршөөл хүртэн
аврагдахыг хэлж байна.

Никайн тунхаг

Никайн тунхаг анх НТ 325 онд хуралдсан чуулганы зөвлөлөөс гарчээ. Энэ тунхгийг
Христийн Бурхан мөн чанар болон Ариун Сүнсний тухай онол сургаалыг хамгаалах
зорилготой гаргасан байна. Улмаар 381 оны зөвлөлөөр өөр хэдэн санааг нэмж
оруулсан байдаг. Энэхүү тунхаг нь өмнө нь гарч байгаагүй зарим маргаантай
асуудлыг цэгцлэх үүднээс бичигджээ.

Бид тэнгэр, газар, үзэгдэх ба үл үзэгдэх бүхнийг бүтээсэн

Цорын ганц Бурхан, Төгс хүчит Эцэгт итгэдэг.

Бид бүх цаг үеэс өмнө Бурхан Эцэгтэй хамт байсан, Бурханы цорын ганц Хүү, нэг
Эзэн Есүс Христэд итгэдэг.

Тэрээр Бурханаас Бурхан, Гэрлээс Гэрэл, жинхэнэ Бурханаас жинхэнэ Бурхан бөгөөд Тэрбээр бүтээгдээгүй, харин Бурхан Эцэгтэй адил мөн чанартай Бурхан мөн.

Түүгээр дамжуулан бүх зүйл бүтээгдсэн. Тэрээр бидний төлөө, биднийг аврахын төлөө тэнгэрээс бууж ирсэн бөгөөд Тэр Ариун Сүнсээр бүрэлдэж, онгон Мариас мэндэлсэн, махбод дотор хүмүүн болж бүтээгдсэн. Тэрбээр бидний төлөө Понти Пилатын дор цовдлогдсон бөгөөд зовлон амсаж, оршуулагдсан. Тэр Бичвэрийн дагуу гурав дахь өдөртөө дахин амилсан бөгөөд тэнгэрт одож, Эцэгийн баруун талд заларсан юм. Тэрээр амьд ба үхэгсдийг шүүхээр сүр жавхлантайгаар эргэж ирнэ. Түүний хаанчлал хэзээ ч төгсөхгүй.

Бид Эзэн бөгөөд Амь өгөгч Ариун Сүнсэнд итгэдэг. Тэрбээр Эцэг ба Хүүтэй хамт байж, Эцэг ба Хүүгийн адил алдар хүндлэлийг хүлээн авагч Нэгэн бөгөөд эш үзүүлэгчдээр дамжуулан ярьсан.

Бид нэг ариун католик чуулган болон элч нарын чуулганд итгэдэг. Бид нүглийн уучлалын төлөө нэг баптисм хүртдэг. Бид үхэгсдийн амилал болон айсуй дэлхий ертөнцөд амьдрахыг тэсэн ядан хүлээдэг.

Амен.

► Элч нарын тунхагт байхгүй ямар санаануудыг та энэ тунхгаас харж байна вэ?

Эндээс бид Гурвалын гурван бодгалийн талаар дэлгэрэнгүй өгүүлснийг харж байна. Есүсийг Бурхан хэмээн итгэдэг атлаа бурхан мөн чанарыг нь үл ойшоодог хүмүүсийн эсрэг Христийн бурхан мөн чанарыг онцгойлон дурдсан байна. Есүс бүх цаг үеэс өмнө байсан, мөнхийн, бүтээгдээгүй, мөн Бурхан Эцэгийн бүхий л мөн чанарыг агуулсан бодгаль гэж хэлсэн байна. Тиймээс Бурханыг Бурхан Эцэг гэж үзэж буйтай адилаар Есүсийг Бурхан хэмээн үзэх ёстой.

Ариун Сүнсийг Эцэг, Хүү хоёрын адил мөргөн хүндэтгэх зохистой. Энэ санаа нь Тэр ч мөн Бурхан гэдгийг батлан харуулж байна.

Калседоны тунхаг

Калседоны тунхаг нь НТ 451 онд бичигдсэн бөгөөд Христийн биежилтийн талаарх онол сургаалыг хамгаалах зорилгоор бичигджээ. Энэ тунхгийг бичигчид Христийг бүрэн дүүрэн Бурхан, бас бүрэн дүүрэн хүмүүн байсныг батлах онол сургаалыг хамгаалахад гол санаагаа чиглүүлжээ. Яагаад гэвэл Христийн энэ хоёр шинжийн аль нэгийг нь багасгаж үзэх нь Христийн тухай сургаалыг бүхэлд нь утгагүй болгож байгаа хэрэг юм.

Төгсгөлд нь бичигчид эдгээр онол сургаалыг Библи болон чуулганы уламжлалын аль алин дээр нь суурилсан гэдгийг илэрхийлжээ. Тэд шинэ санаа дэвшүүлээгүй, харин чуулганы үргэлж итгэж ирсэн итгэл үнэмшлийг хамгаалсан юм.

Тиймээс, ариун эцгүүдийн сургасанчлан нэг бөгөөд адил Хүү бидний Эзэн Есүс Христийг хүлээн зөвшөөрсөн сургаал дээрээ бид бүгд нэгдэж байна.

Тэрбээр Бурханы нэгэн бодгаль ба төгс хүмүүн, төгс Бурхан ба оюун ухаан, бие махбодтой жинхэнэ хүн байсан. Бурхан чанарынхаа хувьд Тэрбээр Бурхантай яг адилхан шинж чанартай, хүмүүн чанарынхаа хувьд нүглээс бусдаар бүх талаараа бидэнтэй яг адилхан байсан.

Бурханы хувьд Тэрээр цаг хугацаанаас өмнө Эцэгтэй хамт байсан.

Эцсийн өдрүүдэд Тэрбээр бидний төлөө, биднийг аврахын төлөө хүмүүн болж, хүмүүний хувьд Бурханы эх болсон онгон Мариагаас мэндэлсэн юм.

Тэрээр нэг Христ, Хүү, Эзэн, Эцэгтэй хамт байсан цорын ганц Нэгэн. Түүнд хоёр мөн чанар байдаг бөгөөд тэдгээрийг хооронд нь хольж андуурах ёсгүй. Яагаад гэвэл тэдгээр мөн чанар өөрчлөгдөшгүй, хуваагдашгүй, бас салшгүй.

Түүний хоёр мөн чанар нэгдмэл боловч, тэдгээр нь хоорондоо ялгаатай. Мөн чанар бүрийн шинжүүд нь тус бүртээ хадгалагдаж, нэг бодгаль дотор нэгэн зэрэг оршдог бөгөөд хоёр тусдаа салаагүй, хоёр бодгаль болж хуваагдаагүй юм. Харин Тэрээр цорын ганц Хүү бөгөөд Бурхантай хамт байсан, Үг Бурхан, Эзэн Есүс Христ мөн.

Эш үзүүлэгчид Түүний талаар анхнаасаа ийн ярьж байсан, мөн Есүс Христ ч Өөрөө бидэнд ийнхүү зааж сургасан, чуулганы эцгүүдийн зөвлөл бидэнд энэхүү итгэлийг дамжуулж өгсөн билээ.

► Энэ тунхагт онцлон дурдсан ямар ямар санаануудыг та анзаарсан бэ?

Христийн бурхан мөн чанар нь Есүсийг газар дээр байхад байгаагүй харин зөвхөн тэнгэрт байхад нь байсан зүйл биш ээ. Анхны итгэгчид Есүсийг хүмүүний махбодод оршсон жинхэнэ Бурхан хэмээн итгэдэг байсан юм. Тэрээр газар дэлхий дээр амьдарч байхдаа Бурхан ба хүний шинж чанарын аль алиныг Өөртөө хадгалсан байв. Тэд Христийн энэхүү мөн чанарыг Аврагч мөн гэдгийг батлах онцгой шалгуур хэмээн үздэг байжээ.

Итгэлийн тунхаг өнөөдөр

Чуулган үүссэнээс хойш олон зуун жил өнгөрчээ. Дэлхий олон талаараа өөрчлөгдөж, шашны олон янзын итгэл үнэмшлүүд бий болсоор байна.

Зарим хүн ямар ч сургаал нэг хэвээрээ үлдэх ёсгүй хэмээн үздэг. Тэд хүссэн зүйлдээ чөлөөтэй итгэхийг хүсдэг боловч, өөрсдийгөө Христэд итгэгч гэж нэрлэсэн хэвээр байна.

► Бид анхны чуулганы итгэлийн тунхагт итгэх шаардлагатай юу?

Эртний тунхагт дурдаж буй Библийн Бурхан өөрчлөгдөөгүй. Түүнд итгэсэн итгэлийнх нь хариуд Бурхан тэднийг аварсан гэдгийг анхны итгэгчид мэддэг байсан. Бурханы мөн чанар ба авралын арга замын тухай өгүүлсэн эдгээр тунхгууд нь анхнаасаа христэч итгэл үнэмшлийн суурь үнэн байжээ.

Эдгээр онол сургаалыг бүгдийг нь зөв ойлгож мэдэхгүй байлаа ч хүн аврагдах боломжтой. Эдгээр онол сургаал нь бүгд сайнмэдээнд шаардлагатай биш. Итгэсэн хүн үнэн гэж ойлгож мэдсэн сургаалаа үгүйсгэсэн атлаа өөрийгөө Христэд итгэгч хэвээрээ гэж хэлж чадахгүй шүү дээ. Гэхдээ хүн зарим зүйл дээр андуурч алдаж болно.

Энэхүү хичээлд яригдаж буй эртний тунхгууд нь христитгэлийн үндсэн онол сургаалыг л тодотгодог. Хэрэв ямар нэг чуулган Бурханы тухай

эдгээр ойлголтоос өөр үзэл санааг гаргаж ирж байгаа бол тэд өөр сайнмэдээ буюу авралын өөр арга замыг мөн зохиож олох ёстой болно. Хэрэв ийм байдалд хүрсэн бол тэд шинэ шашин үүсгэж байгаа учраас өөрсдийгөө Христэд итгэгч гэж хэлэх ёсгүй юм.

Мэдээж, хүн бүр хүссэн зүйлээ бодох эрх чөлөөтэй боловч христэч итгэл үнэмшил байхгүй бол тэр хүн Есүсийн жинхэнэ дагалдагч байж чадахгүй.

Чуулганы эхний хэдэн зууны турш одоогийнх шиг урсгал чиглэл гэж байсангүй. Харин нэг л чуулган байв. Тиймээс итгэлийн тунхаг нь нийт чуулганыг төлөөлдөг тунхаглал байжээ. Өнөөдөр чуулганууд олон асуудлаар санал зөрөлддөг ч эдгээр тунхгийн итгэл үнэмшлийн суурь болсон Библийн эрх мэдлийг хүндэтгэдэг.

Бурхантай харилцах харилцаа хамгийн чухал гэдгийг анхны чуулганыхан мэддэг байжээ. Тэд Бурхантай харилцах харилцаагаараа аврагдсан гэдгээ мэдэж байлаа. Учир нь ямар Бурханд итгэдгээ мэдэх нь тэдний хувьд маш чухал зүйл байв.

Чуулганд анх хүрсэн тэрхүү жинхэнэ итгэлийг бид хамгаалах ёстой хэмээн Иуда захидал бидэнд анхааруулдаг (Иуда 3). Биднийг сайнмэдээ итгэмжтэйгээр тарааж, итгэгчдийг дагалдуулан, үйлчлэлд дуудагдсан хүмүүсийг сургах үед Бурхан Өөрийнхөө үнэнээр бидний үйлчлэлийг тослох болтугай.

Алдаанаас зайлсхийх: Урсгал чиглэлүүдийн ихэрхэл

Нэг байгууллагад нэгдсэн хэсэг бүлэг чуулгануудыг урсгал чиглэл гэнэ. Өөрсдийгөө Христийн шашинд хамруулж үздэг олон мянган урсгал байдаг. Түүнчлэн ямар ч урсгалд харьяалагддаггүй олон мянган бие даасан чуулган бий.

Заримдаа шашны урсгалууд сайнмэдээг түгээх ажлаас үүссэн байдаг. Ямар нэг бүс нутагт олон хүн итгэгч болж, тэдэнд анхаарал тавих урсгал чиглэл байхгүй бол шинэ

“Аливаа шинэ онол сургаал нь буруу, харин анх байсан хуучин сургаал нь зөв байх ёстой. Анхнаасаа байсан сургаалтай адилхан биш л бол ямар ч шинэ онол сургаал зөв байж чадахгүй.”
- Жон Веслей,
"Итгэгчдийн доторх нүглийн тухай" номлолоос

урсгал үүсэж болно. Түүнчлэн ямар нэг илгээлтийн байгууллагын ажлаас үүдэн урсгал чиглэл бий болох боломжтой.

Зарим чуулганууд чухал онол сургаалыг үгүйсгэх эсвэл үл ойшоох үед тухайн чуулганы зарим хүмүүс шинэ бүлэг үүсгэн тусгаарласнаар урсгал чиглэл үүсэх тал ч бий. Тэд шинэ урсгалаа зөв онол сургаал дээр суурилан хөгжүүлэх сэтгэлээр эхэлдэг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд нөгөө онол сургаалаа улам хөгжүүлнэ. Тэд Библийн зарим хэсгийг бусад христитгэлийн бүлгүүдээс өөрөөр ойлгож байгаа учраас тэдний зарим онол сургаал нь бусад урсгалынхаас өөр байдаг.

Урсгал чиглэлүүд нь мөргөл хүндэтгэлийн зөв хэв маяг, христитгэлт амьдралын нарийн ширийн зүйлийн талаарх уламжлалыг хөгжүүлдэг. Тиймээс тэд уламжлалаараа бие биенээсээ ялгардаг.

Христитгэлийн ихэнх урсгал чиглэлүүд өөрсдийгөө цорын ганц жинхэнэ чуулган гэж хэлдэггүй. Хэрэв тухайн байгууллага дангаараа дэлхий даяарх Бурханы чуулганыг төлөөлдөг гэж хэлвэл түүнд итгэх ёсгүй.

Үл итгэгчид христитгэлийг хуваагдал, олон янз байдлаас нь болж эсэргүүцдэг. Тэд христитгэлийн янз бүрийн бүлгүүд нь бүгд хоорондоо зөрчилддөг гэж боддог ажээ. Дэлхий дээр маш олон хүн Христэд итгэгчдийн дунд эв нэгдэл бага байдаг гэж боддог.

Итгэлийн эртний тунхагт буй онол сургаалд итгэдэг урсгал чиглэл, чуулганууд л жинхэнэ христитгэлт хүмүүс юм. Энэ нь мөн христитгэлт бүх байгууллагуудыг нэгтгэдэг онол сургаал юм. Харин онол сургаалын талаарх жижиг асуудал, уламжлалаасаа шалтгаалан чуулганууд олон янз байдаг тул бид жижиг сажиг ялгаанаас болж бусад чуулгануудыг Христийнх биш гэж үзэх ёсгүй.

Алдаанаас зайлсхийх: Буруугаар ойлгогддог хувийн итгэл үнэмшлүүд

Итгэгч хүн Бурхантай харилцаж амьдрах явцдаа Библийн үнэнүүдийн талаарх хувийн ойлголтоо хөгжүүлж байдаг. Тиймээс бусдынхтай адил дүгнэлтэд хүрэхгүй байж болно. Хүн өдөр тутмын амьдралдаа Библийн үнэнийг хэрэгжүүлэх явцдаа бусад итгэгчдийн хийдгээс өөр зарчим, дүрмийг өөртөө бий болгож болох юм.

Итгэгч хүний хувийн итгэл үнэмшил нь эртний христитгэлийн үндсэн онол сургаалаас гадуур байх ёсгүй. Христэд итгэгч байхаа болих шийдвэр гаргаагүй л бол, үндсэн сургаалаас татгалзах эрх чөлөө гэж байхгүй.

Христэд итгэгч хүн чуулганыгаа тогтож хэвшсэн сургаалд итгэх чадвартай байх ёстой. Хэрэв тухайн хүн чуулганыгаа сургаалыг буруу гэж бодож байгаа бол чуулганы гишүүний хувьд чуулгандаа үнэнчээр зориулалт гаргахад хэцүү байх болно.

Христэд итгэгч хувь хүн чуулганыгаа сургаалаар удирдуулах боловч чуулганы бусад гишүүдээс ялгаатай хувийн үзэл бодолтой байж болно. Хувийн итгэл үнэмшил гэдэг нь Библид шууд заасан зүйл биш, харин Библийн аливаа үнэнийг тодорхой асуудал дээр хэрэгжүүлэх гэсэн хувь хүний оролдлого юм.

Итгэгч хүн бүр Библийн үнэнийг нөхцөл байдалдаа шударгаар хэрэгжүүлэх ёстой боловч өөрийнхөө дүгнэлтэд түшиглэн бусдыг яаран шүүх ёсгүй. Бүх итгэгчдийг эртний тунхагт өгүүлж буй онол сургаалыг баримтлах ёстой гэсэн хүлээлттэй байх нь зөв. Түүнчлэн чуулганахаа гишүүдийг чуулганахаа онол сургаалыг дагах ёстой гэж бодох нь ч зөв юм. Гэхдээ бусдыг өөрийнхөө итгэл үнэмшилтэй санал нийлэх ёстой гэж бодож болохгүй.

► Итгэлээ шалгах хэсгийг хамгийн багадаа хоёр удаа хамтдаа уншаарай.

Итгэлээ шалгах

Библи бидэнд христитгэлийн анхдагч онол сургаалыг баримталж, хамгаалахыг даалгажээ. Анхны үеийн итгэгчид сайнмэдээ болон Бурхантай харилцах харилцааны талаарх чухал итгэл үнэмшлийг тунхаглажээ. Эдгээр тунхгууд нь христитгэлийн үндэс байсан хэвээр байна.

15-р хичээлийн даалгаврууд

(1) Эшлэл унших: Суралцагч тус бүр дараах эшлэлүүдээс нэгийг сонгоно. Дараагийн хичээл эхлэхээс өмнө эшлэлийг уншиж, энэхүү хичээлийн сэдвийн талаар тус эшлэлд юу гэж хэлснийг багцлан бичнэ.

- 1 Тимот 3:16
- 1 Тимот 4:1-7
- Тит 1:7-14
- 1 Иохан 4:1-3, 14-15; 1 Иохан 5:12
- Иуда 1:3-13

(2) Сорил: Дараагийн хичээлийг 15-р хичээлийн сорилоор эхэлнэ. Сорилд бэлтгэж, асуултыг сайн судлаарай.

(3) Бусдад заах: Ангиас гадуур заах хуваарь гаргаж, тайлагнахаа мартуузай.

15-р хичээлийн сорил

(1) Тунхаг гэж юу вэ?

(2) Есүсийн талаарх анхны хоёр тунхаглалыг нэрлэнэ үү.

(3) Хэд хэдэн тунхаглал агуулсан, хамгийн эртний тунхаг Библийн аль хэсэгт байдаг вэ?

(4) Элч нарын итгэлийн тунхаг ямар зорилгоор бичигдсэн бэ?

(5) Никайн тунхаг ямар зорилгоор бичигдсэн бэ?

(6) Калседоны тунхаг ямар зорилгоор бичигдсэн бэ?

Санал болгож буй эх сурвалжууд

Энэ номд өгүүлсэн сэдвүүдийг илүү судлах хүсэлтэй бол дараах эх сурвалжуудыг үзээрэй.

Бурханы ном

Dockery, David S. *Christian Scripture*. Nashville: Broadman and Holman, 1995.

Бурханы шинж чанарууд

Purkiser, W.T., ed. *Exploring Our Christian Faith*. Kansas City, MO: Beacon Hill Press, 1960.

Tozer, A. W. *The Knowledge of the Holy*. New York: Harper and Row, 1961.

Гурвал

Morey, Robert. *The Trinity: Evidence and Issues*. Iowa Falls: Word Bible Publishers, 1996.

White, James. *The Forgotten Trinity: Recovering the Heart of Christian Belief*. Minneapolis: Bethany House Publishers, 1998.

Хүн төрөлхтөн

Purkiser, W.T., ed. *Exploring Our Christian Faith*. Kansas City, MO: Beacon Hill, 1978. (10-р бүлэг: "Хүн гэж хэн бэ?", үз)

Нүгэл

Wesley, John. "The Doctrine of Original Sin," in *The Complete Works of Wesley. Vol. 9*.

Wilcox, Leslie. *Profiles in Wesleyan Theology*. Salem, OH: Schmul Publishing, 1985. (7-р бүлэг: "Нүглийн гарал үүсэл ба Мөн чанар" 141-170, үз)

Сүнснүүд

Lewis, C. S. *The Screwtape Letters*. New York: Macmillan Co., 1968.

Wesley, John. "Satan's Devices." *Wesley's 52 Standard Sermons*. Salem, OH: Schmul Publishing, 1988.

Христ

Strobel, Lee. *The Case for Christ*. Grand Rapids: Zondervan, 1998.

Zacharias, Ravi. *Jesus Among Other Gods*. Nashville: Word Publishing, 2000.

Аврал

Purkiser, W. T., ed. *Exploring Our Christian Faith*. Kansas City, MO: Beacon Hill Press, 1960.
(XI, XII бүлэг: "Хүний асуудал" ба "Эвлэрүүллийн онол сургаал" үз)

Wilcox, Leslie. *Profiles in Wesleyan Theology*. Salem, OH: Schmul Publishing, 1985. 9-10-р
бүлэг: "Цагаатгал" ба "Эвлэрүүллийн нөхцөл" 171-214, үз.

Wiley, H. Orton and Culbertson, Paul T. *Introduction to Christian Theology*. Kansas City,
MO: Beacon Hill Press, 1946.

Авралын асуудлууд

Shank, Robert. *Life in the Son*. Minneapolis: Bethany House Publishers, 1989.

Wiley, H. Orton and Culbertson, Paul T. *Introduction to Christian Theology*. Kansas City,
MO: Beacon Hill Press, 1946.

Ариун Сүнс

Carter, Charles. *The Person and Ministry of the Holy Spirit: A Wesleyan Perspective*. Grand
Rapids: Baker Book House, 1974.

Murray, Andrew. *Andrew Murray on the Holy Spirit*. New Kensington: Whitaker House, 1998.

Чуулган

Noll, Mark. *Turning Points*. Grand Rapids: Baker Academic, 1997.

Oden, Thomas. *Life in the Spirit*. Peabody: Prince Press, 2001.

Мөнхийн хувь тавилан

Lewis, C. S. "The Weight of Glory," in *The Weight of Glory and Other Addresses*. New York:
Macmillan Publishing, 1980.

Purkiser, W.T., ed. *Exploring Our Christian Faith*. Kansas City, MO: Beacon Hill Press, 1967.
(XXVIII бүлэг: "Ирээдүйн амьдрал" хэсгийг үз)

Wesley, John. "The Great Assize." *Wesley's 52 Standard Sermons*. Salem, OH: Schmul
Publishing, 1988.

Эцсийн үйл явдал

Ladd, George Eldon. *The Blessed Hope*. Grand Rapids: Eerdmans, 1992.

Wiley, H. Orton & Culbertson, Paul T. *Introduction to Christian Theology*. Kansas City, MO:
Beacon Hill Press, 1949.

Эртний тунхгууд

Gonzalez, Justo L. *The Story of Christianity, Vol. I*. New York: Harper, 2010.

Noll, Mark. *Turning Points: Decisive Moments in the History of Christianity*. Grand Rapids: Baker, 2012.

Даалгаврын тэмдэглэл

Суралцагчийн нэр: _____

Даалгавар бүрийг дуусгасны дараа гарын үсгээ зураарай. Суралцагч нь 70% ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд шалгалтад “тэнцсэн” гэж үзнэ. Бүх даалгаврыг амжилттай гүйцэтгэсний дараа Shepherds Global Classroom байгууллагаас гэрчилгээг олгоно.

Хичээл	Эшлэл	Сорил	Ангиас гадуур бусдад заах	
			Огноо	Орчин
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
11				
12				
13				
14				
15				

Shepherds Global Classroom байгууллагаас төгсөлтийн гэрчилгээ авах хүсэлтээ манай дараах www.shepherdsglobal.org вэб хуудсаар явуулж болно. Суралцагчдынхаа өмнөөс хүсэлт явуулсан багш, сургагч нарт SGC байгууллагын ерөнхийлөгч гэрчилгээг цахим хэлбэрээр илгээнэ.